




МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САН
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA



MILLENNIUM
CHALLENGE CORPORATION
UNITED STATES OF AMERICA



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



УС ХЭРЭГЛЭГЧДИЙН ТӨЛБӨР ТӨЛӨХ ЭРМЭЛЗЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТЫН УС ХАНГАМЖИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРДАЛ НӨХӨХӨД ЧИГЛЭСЭН
ТЕХНИКИЙН ТУСЛАЛЦАА

2021 ОН

Энэхүү судалгааг Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн хооронд байгуулсан II Компакт гэрээгээр хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд УСУГ-ын Зардал нөхөх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хийж гүйцэтгэсэн болно. Тус судалгааны тайланг олон нийтэд тараах зорилгоор бус, усны салбарын оролцогч талуудын бодлогын хэлэлцүүлэгт зориулан хэвлэв.

Судалгааг санхүүгийн болон ашиг олох зорилгоор ашиглах, түгээх, сурталчлах хориотой. Энэхүү судалгааны агуулгыг худалдах, хуулбарлах, арилжааны зорилгоор ашиглахыг хатуу хориглоно.

ГАРЧИГ

1. Судалгааны тайлангийн хураангуй	11
1.1 Зорилго, зорилтууд	11
1.2 Судалгааны арга зүй.....	11
1.3 Ус хэрэглэгчдийн төрөл, ангилал	11
1.4 Судалгааны үр дүн.....	12
1.5 Зөвлөмж.....	20
2. Оршил.....	22
2.1 Танилцуулга	22
2.2 Судалгааны зорилго, зорилтууд.....	23
2.3 Судалгааны арга зүй.....	24
2.4 Нөхцөл байдал	26
2.5 Тайлангийн бүтэц.....	29
3. Хэрэглэгчдийн төрөл ба нийгэм эдийн засгийн төлөв.....	31
3.1 Өрхийн нийт орлого болон нэг хүнд ногдох өрхийн орлого	31
3.2 Өрхийн ам бүлийн тоо	32
3.3 Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй , хараат байдлын харьцаа өндөр өрхүүд 33	33
3.4 Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх ба хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрх	33
3.5 Зөвхөн өндөр настан бүхий эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүд .	34
3.6 Өрхүүдийг өрхийн тэргүүний боловсролоор нь ангилсан байдал	35
3.7 Ядуу өрхүүд.....	35
3.8 Сонгогдсон нийгэм эдийн засгийн бүлгүүд	38
4. Өрхийн ус хангамжийн хүртээмжтэй байдал ба өрхийн усны хэрэглээ	39
4.1 Усны хүртээмж болон хэрэглээний тэгш бус байдал	39
4.2 Усны эрэлт хэрэгцээ	52
4.3 Хэрэглэгчдийн үндсэн усны хэрэгцээг хангах нь	56
4.4 Амьжиргаа тэтгэх тарифын түвшин.....	59
5. Өнөөгийн цэвэр, бохир усны үйлчилгээний талаарх хэрэглэгчдийн ойлголт.....	61
5.1 Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин.....	61
5.2 Нэн түрүүнд сайжруулалт хийх шаардлагатай чиглэлүүдийн талаарх хэрэглэгчдийн санал бодол	69
5.3 Хэрэглэгчийн мэдээллийн эх сурвалж	76
6. Өрхийн ус хангамжийн үйлчилгээний хэрэгцээ, төлбөр төлөх эрмэлзэл	78
6.1 Үзэл баримтлал, судалгааны аргачлал.....	78
6.2 Ухаалаг УТБ эсвэл үйлчилгээ сайжирсан ухаалаг УТБ-нд төлбөр төлөх эрмэлзэл	81
6.3 Хэрэглэгчдийн ус хэмнэх хандлага	87

6.4	Орон сууцны хэрэглэгчдийн усны хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл.....	92
6.5	Гэр хорооллын хэрэглэгчдийн усны хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл.....	96
6.6	Төлбөр төлөх эрмэлзлийг тодорхойлох хүчин зүйлс.....	99
7.	Төлбөрийн чадвартай холбоотой асуудлууд.....	113
7.1	Санхүүгийн дарамт, төлбөр төлөхөд тулгарах бэрхшээлүүд болон тарифын талаарх үзэл бодол.....	113
7.2	Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн танилцуулга.....	125
8.	Зөвлөмж.....	127
8.1	ОСНААУГ болон хувийн конторуудад зориулсан зөвлөмж.....	127
8.2	УСУГ-д зориулсан зөвлөмж.....	128
8.3	ХСУХАТАУЗЗ-д зориулсан зөвлөмж.....	129
ХАВСРАЛТ 1.	Мэдээлэл цуглуулалтын арга.....	132
ХАВСРАЛТ 2.	Судалгааны хэрэгжилт.....	134
ХАВСРАЛТ 3.	Төлбөр төлөх эрмэлзлийн судалгааны асуулга-Эцсийн хувилбар.....	140
ХАВСРАЛТ 4.	Цаашид судлах асуудал.....	158
ХАВСРАЛТ 5.	Ашигласан материалын жагсаалт.....	160
ХАВСРАЛТ 6.	Ярилцлагад хамрагдсан гол оролцогч талуудын төлөөлөл.....	161
ХАВСРАЛТ 7.	Түүврийн стратеги ба судалгааны хэрэгслүүдийн сайжруулсан хувилбар.....	163

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1:	Тарифын бүтэц.....	28
Хүснэгт 2:	Хэрэглэгчийн төрлөөр өрхийн сарын орлогын түвшин (төгрөгөөр).....	31
Хүснэгт 3:	Ядуу өрхүүдийн нийгэм эдийн засгийн шинж чанаруудын талаарх пробит шинжилгээ.....	36
Хүснэгт 4:	Өрхийн сарын усны хэрэглээ (m^3).....	39
Хүснэгт 5:	Нэг хүнд ногдох өдрийн дундаж усны хэрэглээ (литр).....	40
Хүснэгт 6:	Нэг гишүүнтэй орон сууцны усны тоолууртай өрхийн усны хэрэглээ (хоногт нэг хүнд ногдох литр).....	43
Хүснэгт 7:	Усны тоолууртай, тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн усны төлбөрийн санхүүгийн дарамт.....	45
Хүснэгт 8:	Гэр хорооллын өрхүүдийн ус авахад зарцуулдаг цаг, авдаг усны хэмжээ, ус авах давтамж болон УТБ хүртэлх зай (өрхөд эзлэх %)......	48
Хүснэгт 9:	Сард ус авахад зарцуулдаг хугацааг усны гол эх үүсвэрээр болон эх үүсвэр хүртэлх зайгаар харуулав.....	50

Хүснэгт 10: Гэр хорооллын хэрэглэгчид нэг м ³ ус авахад зарцуулах цагийн алдагдсан боломжийн өртөг (төгрөгөөр).....	51
Хүснэгт 11: Усны эрэлт хэрэгцээний тооцоолол.....	53
Хүснэгт 12: Нэг хүнд ногдох бага усны хэрэглээтэй өрхүүдийн нийгэм эдийн засгийн шинж байдал	58
Хүснэгт 13: Орон сууцны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин, сарын усны хэрэглээний түвшингээр	64
Хүснэгт 14: Усны хэрэглээний түвшнээс хамааран цэвэр ус, бохир усны төлбөрийн өрхийн орлогод үзүүлэх дарамт	65
Хүснэгт 15: Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн дундаж түвшин	67
Хүснэгт 16: Гэр хорооллын хэрэглэгчдийн шаардаж буй дөрвөн төрлийн үйлчилгээ, ундны усны эх үүсвэрээр	74
Хүснэгт 17: Гэр хорооллын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, ундны усны эх үүсвэрээр ..	75
Хүснэгт 18: Гэр хорооллын хэрэглэгчдийн сайжруулсан ухаалаг УТБ-нд үзүүлэх ТТЭ. 85	
Хүснэгт 19: Усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны өрхийн дундаж ба хамгийн их ТТЭ, хэрэглээний түвшнээр	95
Хүснэгт 20: Гэр хорооллын хэрэглэгчдийн усны хомстолоос сэргийлэхэд үзүүлэх дундаж болон хамгийн их ТТЭ.....	96
Хүснэгт 21: Гэр хорооллын хэрэглэгчдийн дундаж ТТЭ.....	98
Хүснэгт 22: Дундаж ТТЭ-ийн тодорхойлогч хүчин зүйлс.....	103
Хүснэгт 23: Гэр хорооллын сайжруулсан үйлчилгээнд дундаж ТТЭ-ийг тодорхойлогч хүчин зүйлс.....	105
Хүснэгт 24: Гэр хорооллын сайжруулсан үйлчилгээний дундаж ТТЭ-ийн түвшинг тооцоолоход ашигласан хамаарлыг тайлбарлав	107
Хүснэгт 25: Хомстолоос сэргийлэхэд дундаж ТТЭ-ийг тодорхойлогч хүчин зүйлс.....	107
Хүснэгт 26: Тайланд дурдагдсан гэр хороололд хомстолоос сэргийлэхийн тулд ТТУ-ийн дундаж түвшинг тооцоолоход ашигласан хамаарал	109
Хүснэгт 27: Орон сууцанд хомстолоос сэргийлэхэд дундаж ТТЭ-ийг тодорхойлогч хүчин зүйлс	110
Хүснэгт 28: Тайланд тайлбарласнаар хомстолоос сэргийлэхийн тулд ТТЭ-ийн дундаж түвшнийг тооцоолоход ашигласан хамаарал	111
Хүснэгт 29: Хэрэглэгчийн төрлөөр сар бүрийн усны зардал (төгрөгөөр)	114
Хүснэгт 30: Өрхийн орлогод эзлэх сарын усны зардлын хувиар илэрхийлсэн санхүүгийн дарамт	114
Хүснэгт 31: Гэр хорооллын хэрэглэгчдийн ус авахад зарцуулсан цагийн алдагдсан боломжийн өртөг (төгрөг/м ³)	115
Хүснэгт 32: Өрхийн орлогод эзлэх сарын усны зардал болон алдагдсан боломжийн өртгийн хувиар (%) илэрхийлсэн гэр хорооллын хэрэглэгчдийн санхүүгийн дарамт ..	115

Хүснэгт 33: Хэрэглэгчийн төрлөөр 5 хувиас дээш санхүүгийн дарамттай өрхүүдийн эзлэх хувь	116
Хүснэгт 34: Хэрэглэгчийн төрлөөр 5 хувиас дээш санхүүгийн дарамттай өрхүүдийн эзлэх хувь	119
Хүснэгт А35: ТТЭ-ийн судалгаанд оролцогчид, хүйсээр	136
Хүснэгт А36: Улаанбаатар хотын ус хэрэглэгчдийн ангиллын төлөөлөл, холболтын төрлөөр	136
Хүснэгт А37: ТТЭ-ийн судалгааны уны хэрэглээний төлөөлөл чадвар	138

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Хэрэглэгчдийг нэг хүнд ногдох орлогын аравтын ангиллаар болон усан хангамжийн холболтын төрлөөр харуулав	32
Зураг 2: Хэрэглэгчдийг өрхийн ам бүлийн тоогоор харуулав.....	32
Зураг 3: 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийн хэрэглэгчид	33
Зураг 4: Хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрхийн хэрэглэгчид.....	34
Зураг 5: Зөвхөн өндөр настантай өрхийн хэрэглэгчид	34
Зураг 6: Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн хэрэглэгчид	34
Зураг 7: Хэрэглэгчдийг өрхийн тэргүүний боловсролоор ангилсан байдал	35
Зураг 8: Ядуу өрхийн хэрэглэгчид	36
Зураг 9: Хэрэглэгчдийн төрлөөр сонгогдсон хэрэглэгчийн бүлгүүд (хэрэглэгчийн төрөл бүр дээр өрхүүдийн эзлэх хувь).....	38
Зураг 10: Усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн бүлгийн (өрхийн сарын усны эрэлтээр) усны эрэлтийн эзлэх хувь	41
Зураг 11: Усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн нэг хүнд ногдох өдрийн усны хэрэглээ (өрхийн түвшний сарын усны эрэлтээр)	41
Зураг 12: Өрхийн түвшний сарын усны хэрэглээгээр харуулсан усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн өрхийн хүн ам зүйн байдал.....	42
Зураг 13: Өрхийн түвшний сарын усны хэрэглээгээр харуулсан усны тоолууртай орон сууцны зөвхөн өндөр настантай болон ядуу өрхүүд	42
Зураг 14: Орон сууцны усны тоолууртай, тоолуургүй хэрэглэгчдийн төрлөөр усны зардлын дундаж эзлэх хувь (өрхийн орлогод эзлэх %)	45
Зураг 15: Ус авах ажлыг хариуцдаг хүний нас, хүйс.....	49
Зураг 16: Өрхийн гол ундны эх үүсвэр хүртэлх зай	50
Зураг 17 : Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгүүдээр болон хэрэглэгчийн төрлөөр сарын усны эрэлт хэрэгцээ (m^3 -ээр)	55
Зураг 18: Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгээр болон хэрэглэгчийн төрлөөр нэг хүнд ногдох өдрийн усны хэрэглээ (литр/хүн/өдөр).....	55

Зураг 19: Улаанбаатар хотын усны хэрэглээний албан ёсны стандартууд.....	56
Зураг 20: Хэрэглэгчийн төрлөөр ДЭМБ-ын босгоос дээгүүр болон доогуур хэрэглээтэй өрхүүд	57
Зураг 21: Усны үйлчилгээ, чанарын талаарх хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин	63
Зураг 22: Орон сууцны тоолууртай хэрэглэгчдийн усны үйлчилгээ, усны чанарын талаарх сэтгэл ханамжийн түвшин, өрхийн усны хэрэглээний түвшинээр.....	64
Зураг 23: Орон сууцны усны тоолууртай болон тоолуургүй хэрэглэгчдийн усны үйлчилгээ, усны чанарын талаарх сэтгэл ханамжийн түвшнийг харьцуулсан байдал	66
Зураг 24: Гэр хорооллын хэрэглэгчдийн усны үйлчилгээ, усны чанарын талаарх сэтгэл ханамжийн түвшин, ундны усны гол эх үүсвэрээр	67
Зураг 25: Усны үйлчилгээ, чанарын талаарх өрхийн сэтгэл ханамжийн дундаж түвшин (-2 ба +2), хэрэглэгчдийн зарим дэд ангилал, хэрэглэгчийн төрлөөр	69
Зураг 26: Усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн ус хангамжийн үйлчилгээг сайжруулах эрэлт хэрэгцээ	70
Зураг 27: Гэр хорооллын бүх хэрэглэгчдийн үйлчилгээг сайжруулах шаардлага, ундны усны гол эх үүсвэрээр	74
Зураг 28: Гэр хорооллын хэрэглэгчдийн хамгийн их шаардаж байгаа үйлчилгээг сайжруулах дөрвөн чиглэл, ундны усны гол эх үүсвэрээр.....	74
Зураг 29: Хэрэглэгчдийн усны сэдвээр мэдээлэл авдаг эх сурвалж, хэрэглэгчдийн ангиллаар.....	77
Зураг 30: Гэр хорооллын хэрэглэгчдийн сайжруулсан үйлчилгээнд үзүүлэх хамгийн их болон дундаж ТТЭ (төгрөг/м ³).....	85
Зураг 31: Улаанбаатарын өнөөгийн усны хомстолын талаарх хэрэглэгчдийн бодол	88
Зураг 32: Ирээдүйд усны хомстол үүсэх, үүнтэй холбоотойгоор тарифыг нэмэгдүүлэх шаардлагатай эсэх талаар гэр хорооллын болон орон сууцны хэрэглэгчийн санал бодол.....	89
Зураг 33: Орон сууцны усны тоолууртай болон тоолуургүй өрхийн хувилбарт асуултуудад хариулсан тархалт, цэвэр, бохир усны төлбөрийн нэмэгдлийг хүлээн зөвшөөрсөн хувиар	93
Зураг 34: Орон сууцны усны тоолууртай өрхийн дундаж болон хамгийн их ТТЭ, усны хэрэглээний түвшинээр	94
Зураг 35: Орон сууцны усны тоолууртай болон тоолуургүй өрхийн ирээдүйд ус хомстохоос сэргийлэхэд үзүүлэх дундаж болон хамгийн их ТТЭ, хэрэглээний түвшинээр	94
Зураг 36: Өрхийн хамгийн их ТТЭ (тарифын өсөлтийн %), орон сууцны хэрэглэгчдийн сонгогдсон дэд ангиллаар.....	96

Зураг 37: Гэр хорооллын хэрэглэгчдийн хомстолоос сэргийлэхэд үзүүлэх дундаж болон хамгийн их ТТЭ, ундны усны эх үүсвэрийн төрлөөр	97
Зураг 38: Хамгийн их ТТЭ-ийн тархалт, гэр хорооллын хэрэглэгчдийн үйлчилгээг сайжруулах, хомстолоос сэргийлэх хувилбаруудаар.....	98
Зураг 39: Гэр хорооллын сонгогдсон дэд бүлгийн хэрэглэгч өрхийн дээд ТТЭ, 1 м ³ тутамд	99
Зураг 40: Сонгогдсон хэрэглэгчдийн бүлгүүд болон хэрэглэгчийн төрлөөрх өрхийн орлогод эзлэх хувиар (%) илэрхийлсэн өрхийн усны хэрэглээний санхүүгийн дарамт	116
Зураг 41: Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгүүд болон хэрэглэгчийн төрлөөр усны зардлын санхүүгийн дарамт нь 5 хувиас илүү өрхүүдийн хувь	117
Зураг 42: Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгүүд болон орон сууцны хэрэглэгчийн төрлөөр цэвэр, бохир усны зардлын санхүүгийн дарамт нь 5%-иас илүү өрхүүдийн хувь	118
Зураг 43: Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгүүд болон хэрэглэгчийн төрлөөр 20 л/хүн/өдөр усны хэрэглээ нь 5 хувиас илүү санхүүгийн дарамт учруулах өрхийн хувь	119
Зураг 44: Орон сууцны ядуу болон ядуу биш хэрэглэгчдийн төлбөрөө хоцроох шалтгаан болон төлбөрийн бэрхшээл.....	121
Зураг 45: Орон сууцны хэрэглэгчдийн одоогийн төлбөр төлдөг арга хэлбэр	122
Зураг 46: Одоогийн усны тарифын талаарх хэрэглэгчдийн үзэл бодол	124
Зураг 47: Урьд нь тариф нэмэгдэхэд анзаарсан хэрэглэгчдийн хувь.....	124
Зураг 48: Одоогийн усны тарифын талаарх хэрэглэгчдийн үзэл бодол, хэрэглэгчийн төрлөөр.....	124
Зураг A49: ҮСХ-ны нэг хүнд ногдох хэрэглээ ба ТТЭ-ийн судалгааны нэг хүнд ногдох орлого	137
Зураг A50: ТТЭ-ийн судалгааны ус хэрэглэгчдийн төлөөлөх чадвар, усны хэрэглээний түвшнээр.....	139

ШИГТГЭЭ

Шигтгээ 1: Ганцаарчилсан ярилцлагаас – Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь орон сууцанд амьдардаг усны тоолуургүй хэрэглэгчдийн ам бүлийн тооны өөрчлөлтийг авч үздэггүй.....	44
Шигтгээ 2: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс - Тоолууржилт	45
Шигтгээ 3: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс– Гэр хорооллын усны хэрэглээ	47
Шигтгээ 4: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Усны үргүй зарцуулалт	71
Шигтгээ 5: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Мэдээллийн эх сурвалж.....	76

Шигтгээ 6: Нэмэгдсэн тарифаар төлбөр төлөх эрмэлзлийг тодорхойлох судалгааны асуултууд	80
Шигтгээ 7: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Ухаалаг УТБ ба усны хэрэглээ	82
Шигтгээ 8: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс–Ухаалаг УТБ ба үйлчилгээний чанар	83
Шигтгээ 9: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс –Зөөврийн ус хангамжтай УТБ болон ухаалаг УТБ-аар үйлчлүүлэхэд тулгардаг асуудлууд	86
Шигтгээ 10: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Ухаалаг УТБ-ны усны даралт бага байх асуудал	86
Шигтгээ 11: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Орон сууцны хэрэглэгчдийн ус хэмнэх хандлага	90
Шигтгээ 12: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Усны хэмнэлтийг сайжруулах шийдэл	90
Шигтгээ 13: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Гэр хорооллын хэрэглэгчдийн ус хэмнэх хандлага	91
Шигтгээ 14: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Гэр хорооллын хэрэглэгчдийн ус хэмнэх шийдэл.....	92
Шигтгээ 15: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Төлбөр төлөх арга, хэлбэрийн талаарх үзэл бодол	123
Шигтгээ 16: Боломжит Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрүүдийн (ХДХ) сонголт ба Ажлын даалгавар 2-ын зах зээлийн нөхцөл байдлыг боловсруулахад ашиглах хувилбарууд болон ХДХ-ийн хувилбарууд	125

Товчилсон үгсийн жагсаалт

АХБ	Азийн хөгжлийн банк
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БТЧОА	Боломжит төлбөрийн чадварын арга
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗНТТ	Зардал нөхөхөд чиглэсэн техникийн туслалцаа
м ³	Куб метр
Монголын МСС	Монголын Мянганы сорилтын сан
МСК	Мянганы сорилтын корпорац
МҮОНТ	Монголын үндэсний олон нийтийн телевиз
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
ТАШН	Түүврийн анхан шатны нэгж
ТТЭ	Төлбөр төлөх эрмэлзэл
УТБ	Ус түгээх байр
УТЧХ	Уламжлалт төлбөрийн чадварын харьцаа
ҮОА	Үлдэгдэл орлогын арга
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ФБХ	Фокус бүлгийн хэлэлцүүлэг
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХДХ	Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөр
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл

ТТЭ-ийн судалгааны нэр томьёоны тайлбар

Дундаж ТТЭ: Танилцуулсан хувилбарын хүрээнд санал болгосон тарифын түвшин эсвэл өрхийн цэвэр, бохир усны төлбөрийн өсөлтийн хувь хэмжээнд үндэслэн өрхийн дундаж төлбөр төлөх эрмэлзлийн эконометрик тооцоолол

Хэрэглэгчийн төрөл : Орон сууцны тоолууртай хэрэглэгч, орон сууцны тоолуургүй хэрэглэгч, гэр хорооллын хэрэглэгч

Хараат байдлын харьцаа: Өрхийн нийт гишүүдийн тоо болон ажил эрхэлж буй хүмүүсийн тооны харьцаа

1 м³ усны бодит зардал: Усны үнэ болон өрхийн ус авахад зарцуулсан хугацааны алдагдсан боломжийн өртгийн нийлбэр. Хувьсагчийг зөвхөн гэр хорооллын оршин суугчдад тооцно.

Зөвхөн өндөр настан бүхий өрх: Зөвхөн 60-аас дээш насны гишүүдтэй өрх

Санхүүгийн дарамт: Өрхийн усны зардал болон нийт орлогын хоорондох харьцааны хувь

Өрхийн тэргүүний боловсролын түвшин (эзэмшсэн боловсролын дээд түвшин): Өрхийн тэргүүний боловсролын гурван түвшнийг - бага ба бүрэн бус дунд, бүрэн дунд болон техникийн, дээд боловсрол

Өрхийн нийт орлого: 2019 оны Арванхоёрдугаар сарын өрхийн нийт орлого

КОВИД-19 цар тахал нөлөөлсөн өрх: 2019 оны Арванхоёрдугаар сарын нийт орлогод эерэг эсвэл сөрөг нөлөө үзүүлсэн гэж мэдээлсэн өрх

Нэг хүнд ногдох өрхийн орлого: 2019 оны Арванхоёрдугаар сарын өрхийн нийт орлогыг өрхийн гишүүдийн тоонд хуваасан

Усны чанар, хангамжийн талаарх өрхийн сэтгэл ханамжийн үнэлгээ: Усны үйлчилгээнд өрхийн сэтгэл ханамжийн түвшин тооцсон үнэлгээ буюу оноо нь дараах үзүүлэлтүүдийн өрхийн сэтгэл ханамжийн түвшинд (маш муу, муу, дунд зэрэг, сайн, маш сайн) үндэслэдэг:

- Усны чанар (бүх төрлийн хэрэглэгчдийн хувьд усны зэв, үнэр, амт болон гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд усны өнгө)
- Даралт (орон сууцанд усны даралт, гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд УТБ-ны ус гоожих хэмжээ)
- Үйлчилгээний тасалдалгүй байдал (орон сууцанд эвдрэл гэмтлийн давтамж, засварлах хугацаа, гэр хороололд УТБ-ны үйл ажиллагааны доголдол, тасалдал)
- Хүртээмж (УТБ ажиллах цаг, хүлээх хугацаа, УТБ хүртэлх зай, УТБ орчмын цэвэрлэгээ).
- Сэтгэл ханамжийн дундаж түвшнээс бага —“муу” ба “маш муу”—тус тус нэг болон хоёр сөрөг оноо өгсөн. Нэг эсвэл хоёр эерэг оноотой бол сэтгэл ханамжийн түвшин дунджаас их, сэтгэл ханамж дундаж бол ямар нэгэн оноо өгөөгүй. Сэтгэл ханамж сайн эсвэл муу нь бие биеэ нөхдөг: усны үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгаа өрхийн дундаж оноо эерэг (2 хүртэл), харин усны үйлчилгээнд сэтгэл ханамжгүй өрхийн дундаж оноо хасах (-2 хүртэл) байна.

Тэтгэвэр авагч гишүүнтэй өрх: Тэтгэврийн орлоготой өрх

ТТЭ-ийн дээд хэмжээ: Танилцуулсан хувилбарын хүрээнд өрхийн төлөхийг зөвшөөрч буй тарифын түвшин эсвэл цэвэр, бохир усны төлбөрийн хэмжээний тухай нээлттэй асуултын хариултад үндэслэсэн хэмжээ

ТТЭ-ийн судалгааны нэр томъёоны тайлбар

Ядуу өрх: Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос ядуурлын шугамаар тодорхойлсны дагуу нэг хүнд ногдох орлого Улаанбаатар хотын 2019 оны амьжиргааны доод түвшнээс доогуур өрх (217 900 төгрөг, 76ам.доллартой тэнцэх хэмжээ, 2021 оны 2 дугаар сарын 2-ны Мягмар гарагийн ханшаар 1 төгрөг = 0.00035 ам.доллар).

Усны эрэлтийн үнийн мэдрэмж: тариф 1 хувиар өөрчлөгдөхөд усны хэрэгцээ өөрчлөгдөх хувь.

Оршин суугч: Улаанбаатар хотод гэр хороолол эсвэл орон сууцанд амьдардаг өрхийн гишүүн

Ундны усны эх үүсвэр: шугамд холбогдсон УТБ гэж төвлөрсөн шугамд холбогдсон, зөөврийн ус хангамжтай УТБ гэж машинаар усаа зөөдөг, бусад эх үүсвэрт ойролцоох УТБ, хамаатны орон сууц гэх мэт нь бусад эх үүсвэрт орно.

Өрх толгойлсон эмэгтэй: Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх

Усны хэрэглээ м³-ээр: гэр хорооллын хэрэглэгчдийн худалдан авсан буюу хэрэглэсэн, орон сууцны хэрэглэгчдийн төлбөр төлсөн усны хэмжээ

Нэг хүнд ногдох хоногийн усны хэрэглээ: өрхийн сарын нийт усны хэрэглээг өрхийн гишүүдийн тоонд болон гучид хувааж гарсан хэмжээ

1. СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Улаанбаатар хотын орон сууцны болон гэр хорооллын өрхүүдийн усны үйлчилгээний Төлбөр төлөх эрмэлзэл (ТТЭ)-ийн судалгааг 2020 оны 9 дүгээр сард гүйцэтгэсэн бөгөөд уг судалгааны үр дүнг зөвлөмжийн хамт энэхүү тайланд тусгав. Улаанбаатар хотын ус хангамжийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн Зардал нөхөх техникийн туслалцааны (ЗНТТ) хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (ХСУХАТАУЗЗ)-д цэвэр, бохир усны үнэ тарифын бүтцийг нарийвчлан тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор тус судалгааг хийсэн болно. Энэхүү техникийн туслалцааг Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээний хүрээнд үзүүлж байна.

1.1 Зорилго, зорилтууд

Судалгаа нь дараах үндсэн хоёр зорилготой. Үүнд:

1. Тарифын бүтэц, хэмжээ болон өрхийн хэрэглэгчийн бүлэг тус бүрийн төлбөрийн чадварыг үнэлэхэд шаардлагатай тоон мэдээллээр ХСУХАТАУЗЗ-ийг хангах,
2. Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээний зорилтот түвшин, түүнд холбогдох хөрөнгө оруулалт, төлөвлөлт хийх шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр усны салбарын эрх бүхий байгууллагуудыг хангах болно.

Дээрх хоёр зорилгын хүрээнд 7 зорилтыг дэвшүүлсэн ба судалгааны үр дүнг зорилт тус бүрээр бүлэглэн доорх хэсэгт хураангуйлан танилцуулж байна.

1.2 Судалгааны арга зүй

Тус судалгааг тоон болон чанарын судалгааны аргуудыг хослон ашиглан гүйцэтгэсэн. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ноос зохион байгуулсан 4,975 ус хэрэглэгч (өрх)-ийн судалгаа, 55 хэрэглэгчтэй хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлэг, мөн оролцогч талуудтай хийсэн ярилцлагуудаар судалгааны мэдээллийг цуглуулж, боловсруулав. Эдгээр мэдээллийг эконометрикийн дүн шинжилгээ болон бусад олон шинжилгээний аргыг ашиглан боловсруулсан.

1.3 Ус хэрэглэгчдийн төрөл, ангилал

Улаанбаатар хотын ус хэрэглэгчдийг ус хангамжийн эх үүсвэртэй холбогдсон байдлаар нь ангилахад тал орчим хувь нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны хэрэглэгч, үлдсэн хувь нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын хэрэглэгч гэсэн үндсэн хоёр бүлэгт багтаж байна. Орон сууцны хэрэглэгчдийн дийлэнх нь тоолууртай бөгөөд тоолуургүй хэрэглэгчид цөөн хувийг эзэлж байна. Иймд судалгаанд хэрэглэгчдийг дараах үндсэн 3 төрлөөр авч үзэв. Үүнд:

- *Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон усны тоолууртай хэрэглэгч* – Тоолуурын заалтын дагуу цэвэр усны метр куб тутамд 710 төгрөг, бохир усны метр куб тутамд 580 төгрөг, мөн сарын суурь хураамж болох 3,000 төгрөг төлдөг хэрэглэгчид.
- *Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон усны тоолуургүй хэрэглэгч* – Сарын суурь хураамж 3,000 төгрөгөөс гадна, усны тоолууртай хэрэглэгчидтэй харьцуулахад өрхийн гишүүдийн тооноос хамаарч цэвэр усны метр куб тутамд 46% илүү буюу 1,040 төгрөг, бохир усны метр куб тутамд 31% илүү буюу 760 төгрөг төлдөг хэрэглэгчид.

- *Гэр хорооллын хэрэглэгч* – Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон эсвэл зөөврийн усаар хангагддаг ус түгээх байр (УТБ) буюу түгээгчтэй эсвэл ухаалаг картаар ажилладаг УТБ-аас ус авдаг хэрэглэгчид. Энэ ангиллын хэрэглэгчид нэг метр куб усыг 1,000 төгрөгөөр худалдан авдаг.

1.4 Судалгааны үр дүн

Энэхүү судалгааны тайлангийн хураангуйд тус судалгаанаас гарсан гол үр дүнг долоон зорилт тус бүрээр ангилан харуулав.

1.4.1 Зорилт 1: Сайжруулсан ус хангамжийн үйлчилгээнд Улаанбаатар хотын орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийг тооцож, усны үйлчилгээний эрэлт хэрэгцээг үнэлэх.

Оролцогч талуудтай хийсэн уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан гэр хорооллын хэрэглэгчдээс үйлчилгээг сайжруулах (тухайлбал УТБ-ыг шинээр барих эсвэл ухаалаг болгох), усны хомстолоос сэргийлэх гэсэн хоёр хувилбар бүхий асуулгаар судалгааг хийсэн. Одоогоор орон сууцны ус хангамжийн үйлчилгээг сайжруулах тодорхой арга хэмжээ төлөвлөөгүй байгаа тул орон сууцны хэрэглэгчдийн хувьд зөвхөн ойрын ирээдүйд усны хомстолд орохоос сэргийлэхэд тэдний төлбөр төлөх эрмэлзэл ямар байгааг судалсан.

Орон сууцны хэрэглэгчид

Хэдийгээр судалгаанд хамрагдсан орон сууцны хэрэглэгчийн ихэнх нь ямар нэгэн арга хэмжээ авахгүй бол ирэх жилүүдэд усны хомстолд учирч болзошгүй талаар сайн мэдэж байсан боловч 41.4% нь (усны тоолууртай хэрэглэгчдийн 41.3%, тоолуургүй хэрэглэгчдийн 42.2%) усны тариф нэмэгдүүлэхийг дэмжихгүй байв.

Цэвэр, бохир усны үйлчилгээнд сард төлөх боломжит дээд хэмжээг асуухад орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн 51.6%, тоолуургүй хэрэглэгчдийн 63.4% нь одоогийн тарифын түвшнийг өсгөөгүй дүнгээр хариулсан. Судалгаанд хамрагдсан хэрэглэгчдийн олонх нь тарифын өсөлтийг хүлээн зөвшөөрөхгүй байсан. Харин ирэх 20 жилд усны хомстолоос сэргийлэхийн тулд усны тоолууртай хэрэглэгчид цэвэр, бохир усны төлбөрөө хамгийн ихдээ 32.3%, тоолуургүй хэрэглэгчид ихдээ 10.8%-иар нэмэгдүүлэх боломжтой гэж хариулсан. Орон сууцны хэрэглэгчдийн тарифын өсөлтийн хүлээн зөвшөөрч буй дундаж хэмжээ усны тоолууртай хэрэглэгчдийн хувьд 59.3% байсан бол тоолуургүй хэрэглэгчдийн дунд 55.3% байв. Судалгааны тайлангийн 5.3.3-т дэлгэрэнгүй харуулсанчлан усны хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл нь орон сууцны усны тоолууртай болон тоолуургүй хэрэглэгчдийн хувьд ялгаатай байв.

Гэр хорооллын хэрэглэгчид

Гэр хорооллын хэрэглэгчдийн гуравны хоёр нь ирээдүйд усны хомстолоос сэргийлэхийн тулд тарифыг өсгөхтэй санал нийлж байв. Гэр хорооллын хэрэглэгчид ус хангамжийн үйлчилгээг сайжруулах болон усны хомстолоос сэргийлэх хувилбаруудад төлбөр төлөх эрмэлзэл өндөртэй байв. Тэд одоогоор УСУГ-ын УТБ-наас 1 метр куб ус худалдан авахад төлдөг 1000 төгрөгийг дунджаар 5-6 дахин нэмэгдүүлж төлөхөд бэлэн байна. Ус хангамжийн үйлчилгээг сайжруулах хүрээнд (шинэ, сайжруулсан ухаалаг УТБ-наас ус авах) төлбөр төлөх эрмэлзлийн дундаж хэмжээ нь 5,404 төгрөг байгаа бол төлбөр төлөх эрмэлзлийн дээд хэмжээ нь 6,692 төгрөг байна. Гэр хорооллын хэрэглэгчдийн ус авахтай холбоотой гардаг өндөр хэмжээний мөнгөн бус өртөг (ус авахад зарцуулдаг цаг хугацаа, аюулгүй байдал, ус зөөхөд хүндрэлтэй байх, өвлийн хүйтэнд ус авахаар гадаа гарах зэрэгтэй холбоотой, энэ тухай тайлангийн 3.1.3.3-аас үзнэ үү), ойролцоогоор нэг

метр куб тутамд 5,068 төгрөгийн (1.78 ам доллар¹) алдагдсан боломжийн өртөг² гарах магадлалтай байгаа нь шинжилгээгээр харагдав. Гэр хорооллын хэрэглэгчид ус авахад сард дунджаар 3.4 цаг зарцуулдаг бол усны эх үүсвэрээс хол амьдардаг зарим хэрэглэгчийн хувьд сард дунджаар 7 цаг зарцуулж байна.

Харин усны хомстолоос сэргийлэхийн тулд гэр хорооллын хэрэглэгчид нэг метр куб ус авахад дунджаар 4,877 төгрөг, хамгийн дээд хэмжээ нь 6,281 төгрөг төлөхөд бэлэн байв. Энэ нь одоогийн төлбөр болон төлбөр төлөх эрмэлзлийн талаарх өмнө гаргаж байсан таамаглалаас харьцангуй өндөр байв³.

Гэр хорооллын хэрэглэгчдийн бүлгүүдийн дунд ус хангамжийн үйлчилгээг сайжруулахтай холбоотой төлбөр төлөх эрмэлзэл нь ялгаатай байсан. Энэ талаар 5.4.3-т дэлгэрэнгүй танилцуулав.

1.4.2 Зорилт 2: “Амьжиргаа тэтгэх тариф” (lifeline tariff)-д тохирсон усны хэрэглээний хэмжээний талаар санал боловсруулах.

Дийлэнх хэрэглэгчдийн усны хэрэглээ Монгол улсын Засгийн Газрын А/333 тоот тушаалаар батлагдсан ундны болон ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээнээс бага байна. Тухайлбал орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн 57.3 % нь нэг хүний хоногийн хэрэглээний зохистой хэмжээ болох 200 литрээс бага хэрэглээтэй байсан бол гэр хорооллын хэрэглэгчдийн 95.3% нь төвлөрсөн бус ус хангамжаас ахуйн усаа авдаг нэг хүний хоногийн хэрэглээний зохистой хэмжээ болох 50 литрээс бага хэрэглээтэй байна. Улаанбаатар хотын хэрэглэгчдийн 41.5 % нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас зөвлөсөн нэг хүний хоногийн 20 литрээс доогуур хэрэглээтэй байна. ДЭМБ-аас зөвлөсөн хэмжээнээс бага хэрэглээтэй хэрэглэгчдийн 98.3% нь гэр хороололд амьдарч байгаа бөгөөд энэ нь гэр хорооллын нийт хэрэглэгчдийн 74%-ийг эзэлж байна.

“Амьжиргаа тэтгэх тариф” (тодорхой суурь хэрэглээнд бага тариф тогтоож, тухайн тогтоосон хэмжээнээс хэтрэх тохиолдолд ялгаатай тарифаар тооцох шаталсан тарифын тогтолцоо) тогтоох нь усны хэрэглээний одоогийн түвшин нь хангалтгүй байгаа хэрэглэгчдийг дэмжих зохистой бодлого биш болохыг судалгаагаар тогтоолоо. Усны хэрэглээний түвшин багатай хэрэглэгчдийн дийлэнх нь гэр хороололд амьдардаг ба эдгээр хэрэглэгчдийн ус авахтай холбоотой гарах мөнгөн бус зардал нь УТБ-наас ус худалдан авдаг үнээс их байгаагийн зэрэгцээ усны хүртээмжийг нь хязгаарлаж байна. Эдгээр зардал болон бусад мөнгөн бус зардлаас (аюулгүй байдлын асуудал, ус зөөхөд хүндрэлтэй байх, өвлийн хүйтэнд ус авахаар гадаа гарах гэх мэт) болж усыг үнэгүй болгосон ч гэр хорооллын бүх айл өрх ДЭМБ-аас зөвлөсөн нэг хүн хоногт 20 литр ус хэрэглэх зохистой хэмжээнд хүрэх эсэх нь эргэлзээтэй байна. Учир нь энэ тохиолдолд

¹ 2021 оны 2 дугаар сарын 2-ны Мягмар гарагийн валютын ханш 1 төгрөг = 0.00035 ам.доллар байсан бөгөөд уг ханшийг тайланд ашиглав

² Судалгаагаар ус авахад зарцуулдаг цагийн (УТБ-наас ус авдаг давтамж, нэг удаа ус авахад гэрээсээ УТБ очиж эргэж ирэхэд дунджаар зарцуулдаг цаг) алдагдсан боломжийн өртгийг чөлөөт цагийн ахиу үнэ цэнээс (ҮСХ-ноос амьжиргааны доод түвшнийг сард 230,000 төгрөг буюу 81 ам. доллар байхаар тогтоосон. Улаанбаатар хотын 2020 оны ядуурлын түвшин) тооцоолон гаргав.

³ А.Бямбадорж, Х.С, Ли нар (2019). Улаанбаатар хотын гэр хорооллын өрхүүдийн бохир ус цэвэрлэх, ус хангамжийн системийг сайжруулахад төлбөр төлөх эрмэлзэл, Монгол улс. Ус сэтгүүл, 11(9), 1856; 2016 он; Түргэвчилсэн үнэлгээ, Их сургуулийн судалгаа ХХК (URC), Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп ХХК, 2016

усны хэрэгцээ ердөө 8.9%-иар нэмэгдэхээр байна (4.2 дахь хэсгийг үзнэ үү). Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл (КОВИД-19 цар тахлын эсрэг авах арга хэмжээний хүрээнд) ус түгээх байрнаас ус үнэгүй түгээх тухай шийдвэр гаргасан нь дээрх бодлогын бодит туршилт юм. УСУГ нь ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг усны карт эзэмшигчдийн хэрэглээний мэдээллийг ашиглан энэхүү туршилтын үр дүнд дүн шинжилгээ хийх боломжтой.

Орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн хувьд амьжиргаа тэтгэх тарифын тогтолцоо нь ам бүл олонтой, усны хэрэглээ ихтэй ядуу өрхүүдэд сөргөөр нөлөөлж болзошгүй. ДЭМБ-аас тогтоосон зохистой хэмжээнээс нэг хүн хоногт дунджаар 6.5 литрээр бага ус хэрэглэж байгаа асуудлыг шийдвэрлэхийн тулд хамгийн багадаа сард 1 метр куб усаар суурь хэрэглээг тогтоох, эсвэл 1.6 метр куб усыг 40 хувийн хямдралтай тарифаар хангах шаардлагатай болно. Улмаар их хэрэглээний тарифыг нэмэгдүүлэх замаар суурь хэрэглээний тарифын алдагдлыг нөхөх нь усны хэрэглээ их, олон ам бүлтэй ядуу өрхүүдэд сөрөг нөлөө үзүүлнэ. Сард 5 метр кубээс бага хэрэглээтэй орон сууцны 5 хэрэглэгчийн 4 нь *ядуу хэрэглэгч биш* гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Тиймээс үндсэн хэрэглээний багцын тариф нь ядуу өрхүүдийн усны хэрэглээг дэмжихээс илүүтэйгээр ядуу бус өрхүүдийг татаасаар дэмжсэн тарифын тогтолцоо болох эрсдэл байна. Үндсэн хэрэглээний багцын тарифын талаарх иж бүрэн дүн шинжилгээг 3.4 дэх хэсгээс үзнэ үү.

1.4.3 Зорилт 3: Одоогийн цэвэр, бохир усны үйлчилгээний талаарх хэрэглэгчдийн ойлголт, сэтгэл ханамжийг үнэлэх.

Орон сууцны хэрэглэгчид

Гэр хорооллын хэрэглэгчид усны үйлчилгээ, чанартай холбоотой ихэнх үзүүлэлтийг сэтгэл ханамжийн хувьд "сайн" гэсэн үнэлгээтэй тэнцэх ойролцоогоор 1 гэсэн үнэлгээг өгч байна. Нөгөөтээгүүр, орон сууцны хэрэглэгчдийн өгч буй дундаж оноо 1-ээс доогуур буюу сөрөг оноо тоо их байгааг харуулж байна. Тайлангийн 4.2-т Зураг 21-т харуулсанчлан эдгээр хэрэглэгчид зэвтэй ус, ус тасарсны дараа усны зэвийг арилтал ус гоожуулах эсвэл усыг халуун болтол нь хүлээж ихээр гоожуулан цаг алддаг, ус их үрдэг зэрэгт сэтгэл ханамж багатай байсан. Орон сууцанд амьдардаг усны тоолууртай хэрэглэгчид төлбөр төлөх арга, тоолуурын нарийвчлал, тоолуурыг баталгаажуулах гэсэн гурван үзүүлэлтэд хамгийн өндөр оноо өгсөн байна. Усны тоолуургүй хэрэглэгчдийн хувьд төлбөр төлөх арга, үнэр, эвдрэл гарсан тохиолдолд засвар хийх хугацаа зэрэг гурван үзүүлэлтэд хамгийн өндөр оноо өгсөн байна.

Орон сууцанд амьдардаг усны тоолуургүй хэрэглэгчид усны тоолууртай холбоотой сэтгэл ханамжийн хоёр асуудлыг гарган ирсэн нь тоолуурын баталгаажилт хийлгэх болон тоолуурын заалтын нарийвчлал зэрэг асуудлууд байв. Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон тоолуургүй хэрэглэгчид болон ганцаарчилсан ярилцлага өгсөн холбогдох мэргэжилтнүүд тоолуурын гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд зарим хэрэглэгчид сунгуулаагүй, тоолуургүй байдаг хэмээн тайлбарлаж байсан. Түүнээс гадна ихэнх тохиолдолд усны тоолуургүй хэрэглэгчид тоолуур авахад бэрхшээлтэй тулгардаг байна. Эдгээр хоёр шалтгааны улмаас тоолуур суурилуулах нь тоолуургүй хэрэглэгчдийн хувьд чухал асуудал болж байна. Усны тоолуургүй хэрэглэгчдийн тоолууртай холбоотой үнэлгээний түвшин доогуур байгаа нь усны хэрэглээг хэмждэг өнөөгийн байдалд сэтгэл дундуур байгааг харуулж байна. Учир нь 2017 онд баталсан

A/333 тушаалд⁴ заасан ундны болон ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээг (1.4 хэсэгт дэлгэрэнгүй үзнэ үү) үндэслэж усны тоолуургүй хэрэглэгчид бодит хэрэглээнээсээ өндөр төлбөр төлж байх магадлалтай юм.

Үйлчилгээг сайжруулах талаар хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага болон фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон хэрэглэгчдийн өгч буй хариулт нь ижил байв. Орон сууцны усны үйлчилгээнд хэрэглэгчдийн өгсөн дундаж оноо 0.4⁵ буюу “сайн” гэж үзэхээс илүү дундаж үнэлгээний хувьд усны чанар, усны даралт, хэрэглэгчийн үйлчилгээ зэрэгт сэтгэл ханамж бага байгааг харуулж байна. Орон сууцны хэрэглэгчдийн зүгээс сайжруулах шаардлагатай хамгийн чухал гурван асуудал нь 1) ус тасарсны дараа зэв арилтал усаа гоожуулах (хэрэглэгчдийн 44%), 2) зэвийг багасгах (37%), 3) ус халуун болтол гоожуулах (32%) гэж үзэж байна. Хамгийн их усны хэрэглээтэй орон сууцны хэрэглэгчид хэд хэдэн зүйл дээр сэтгэл ханамж хамгийн бага байсан бөгөөд үүнд тоолуурын нарийвчлал, тоолуур баталгаажуулах үйл явц, усны даралт, усны үнэр, амт, эвдрэл гэмтлийг засах хугацаа, төлбөр төлөх арга болон хэрэглэгчийн үйлчилгээ багтжээ (4.2.1-т Зураг 26-гаас үзнэ үү).

Фокус бүлгийн хэлэлцүүлгээр хэрэглэгчийн сэтгэл ханамж бага байгаа байдалд нөлөөлж буй хамгийн том хүчин зүйл нь ус гоожуулж, үрэх явдал байсан бөгөөд энэ нь нийлүүлэгчийн зүгээс өгдөг ус хэмнэх уриалгын ач холбогдлыг бууруулж байна. Энэ нь орон сууцны хэрэглэгчид ирэх жилүүдэд усны хомстол үүсэж болзошгүйг хүлээн зөвшөөрсөн ч усны үнэ тарифыг нэмэгдүүлэхийг дэмжихгүй байсны нэг шалтгаан байж болох юм.

Гэр хорооллын хэрэглэгчид

Гэр хороололд амьдардаг хэрэглэгчид ус хангамжийн үйлчилгээ болон чанарт харьцангуй сэтгэл ханамж өндөртэй байна. Ус хангамжийн эх үүсвэрээр ангилан дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн гарлаа. Үүнд:

Зөөврийн ус хангамжтай УТБ-ны хэрэглэгчдийн (гэр хорооллын хэрэглэгчдийн 57%) УТБ дээр хүлээх хугацаа, УТБ хүртэлх зай, усны чанар (зэв, амт, үнэр), төлбөр төлөх арга, хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмж, хэрэглэгчдийн санал гомдлыг шийдвэрлэх байдал зэрэгт сэтгэл ханамжийн түвшин хамгийн бага байна.

Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон ухаалаг картаар ажилладаг УТБ-ны хэрэглэгчид (гэр хорооллын хэрэглэгчдийн ойролцоогоор 22.1%) хоногийн 24 цагийн байнгын ажиллагаатай УТБ-аар үйлчлүүлж, ухаалаг картаар төлбөрөө төлдөг тул сэтгэл ханамж өндөртэй байна. Гэвч эвдрэл гэмтэл байнга гардаг, усны даралт бага байдаг зэрэг нь үйлчилгээний давуу талын ач холбогдлыг багасгаж байна.

Түгээгчтэй, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон УТБ-ны хэрэглэгчид (ойролцоогоор хэрэглэгчдийн 13.4%) УТБ хүртэлх зай, УТБ-ны усны гоожих хэмжээ, эвдрэл гэмтлийг засах хугацаанд хамгийн өндөр сэтгэл ханамжтай байна.

Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох, ухаалаг картаар төлбөр хийдэг болохыг гэр хорооллын хэрэглэгчид хамгийн их шаардаж байна (энэ хариулт тус тус 41% болон 40% байна). Ухаалаг УТБ-ны хэрэглэгчдийн тухайд төвлөрсөн шугамд холбогдох хүсэлт нь

⁴ Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаал. Ундны болон ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээг батлах тухай

⁵ Үнэлгээний оноо: “муу” (-2), “боломжийн” (-1), “дундаж” (0), “сайн” (1), “маш сайн” (2).

хамгийн өндөр байсан бол (ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн 21%, гэр хорооллын нийт хэрэглэгчдийн 14%) үүний дараа гэрээр ус хүргэлтийн үйлчилгээ авах хүсэлт (ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн 55%, гэр хорооллын нийт хэрэглэгчдийн 41%) нь хоёрт орж байна. Түүнээс гадна гэр хорооллын хэрэглэгчдийн 43% нь УТБ-наас ус авах үе тохиолдох тав тухгүй байдал, зарцуулдаг цаг зэрэг бусад мөнгөн бус өртгийг бууруулахыг (гэрт ойр УТБ барих, УТБ-ны үйлчилгээний цагийн хуваарийг уртасгах, гэрээр ус хүргэлтийн үйлчилгээ авах) хүсэж байна (4.2.2-т Хүснэгт 16-гаас үзнэ үү). Ийм хүсэлттэй байгаа хэрэглэгчдийн дунд зөөврийн усан хангамжтай УТБ-ны үйлчлүүлэгчид (49%) хамгийн өндөр хувь эзэлж байгаа бөгөөд төлбөрийг илүү хялбар аргаар төлөхийг эдгээр хэрэглэгчид (57%) илүү их хүсэж байсан.

Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин, тэдний хэрэгцээ шаардлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг орон сууцны хэрэглэгчдийн усны хэрэглээ болон гэр хорооллын хэрэглэгчдийн УТБ-ны төрлөөр авч үзсэн дэлгэрэнгүй үр дүнг судалгааны Дөрөвдүгээр бүлгээс үзнэ үү.

1.4.4 Зорилт 4: Хэрэглэгчийн худалдан авах чадварыг нарийвчлан судлахад шаардлагатай өрхийн орлогын болон нийгэм, хүн ам зүйн мэдээллийг цуглуулах (Ажлын даалгавар 2 – Худалдан авах чадвар болон Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн судалгаа).

Улаанбаатар хотын нийт оршин суугчдын дөрөвний нэгээс илүү (26.5%) хэсэг нь Улаанбаатар хотын 2010 оны амьжиргааны доод түвшин болох 217,900 төгрөгөөс доогуур орлоготой өрхүүд байгаа ба үүнийг энэхүү судалгаанд ядуу өрхийг тодорхойлоход ашигласан. Судалгаагаар ам бүл олонтой, гурав ба түүнээс дээш тооны хүүхэдтэй, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өрхийн зөвхөн нэг гишүүн нь орлоготой болон хүүхэдтэй өрхүүд тус бүлэгт багтаж байна. Ядуу байх магадлал багатай өрхүүдэд зөвхөн өндөр настнаас бүрддэг өрх, ажил хийдэг олон гишүүнтэй, дээд боловсролтой өрхийн тэргүүнтэй, эсвэл орон сууцанд амьдардаг усны тоолууртай болоод тоолуургүй өрхүүд багтаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх ядуу байна гэдгийг шууд батлах нотолгоо байхгүй байна.

Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүд аль нэгэн ангилал эсвэл хэрэглэгчдийн төрөлд олноороо харьяалагдахгүй байна. Өрх толгойлсон ганц бие эцэг/эх бүхий өрхийн тоо харьцангуй бага (3.8%), гэхдээ нийт өрхийн 16.6% нь хүүхэдтэй, ганц тэжээгчтэй өрх байна.

Гэр хорооллын хэрэглэгчидтэй харьцуулбал орон сууцны хэрэглэгчид илүү орлоготой байна. Орон сууцны хэрэглэгчдийн хувьд 2019 оны 12 дугаар сарын дундаж орлого нь 1.7 сая төгрөг (ойролцоогоор 588 ам.доллар) байсан бол гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд сарын орлого дунджаар 1 сая төгрөгөөс арай бага (348 ам.доллар) байв. Гэхдээ нэг хүнд ногдох орлого хамгийн их болон хамгийн бага өрх орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдийн аль алинд нь байна (3.1 дэх хэсэг, Зураг 1-т үзүүлэв).

Орон сууцанд амьдардаг өрхүүд гэр хорооллын өрхүүдээс ам бүлийн хувьд бага байгаа боловч 5 болон түүнээс дээш ам бүлтэй өрхийн бараг гуравны нэг (33.7%) нь усны тоолууртай орон сууцанд амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй эсвэл зөвхөн өндөр настнаас бүрдсэн өрхүүд ихэвчлэн гэр хороололд байгаа бол орон сууцанд амьдардаг усны тоолуургүй хэрэглэгчдийн 30.8% нь зөвхөн өндөр настан бүхий өрх байна.

Хэдийгээр усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны хэрэглэгчид нийгэм, эдийн засгийн шинж байдлын хувьд ойролцоо, усны тоолуургүй өрхүүд харьцангуй цөөн ам бүлтэй байгаа боловч усны тоолуургүй өрхийн усны хэрэглээний төлбөр тооцох хэмжээ нь тус хэрэглэгчдэд санхүүгийн хувьд ихээхэн дарамт (өрхийн орлогод усны төлбөрийн эзлэх хувь) үүсгэдэг буюу усны тоолууртай хэрэглэгчээс хоёр дахин өндөр байна. Өрхийн орлогынхоо 5-аас дээш хувийг усны төлбөрт зарцуулдаг хэрэглэгчдийн эзлэх хувь орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн дунд харьцангуй их байна. Өрхийн орлогын түвшин, хэрэглэгчдийн нийгэм, эдийн засгийн шинж байдлын талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хоёрдугаар бүлэгт тусгав.

1.4.5 Зорилт 5: Төлбөр төлөх эрмэлзэлд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн болон сэтгэл ханамжийн гол үзүүлэлтүүдийг тодорхойлох.

Судалгаагаар ирээдүйн усны хомстол, усны хязгаарлалт тогтоохоос урьдчилан сэргийлэх үүднээс ус хангамжийн үйлчилгээг сайжруулан УТБ-ыг 24 цагийн турш тасралтгүй ажиллагаатай ухаалаг болгоход өрхийн хэрэглэгчийн төлөхөд бэлэн байгаа хамгийн дээд ба дундаж ТТЭ-ийг тодорхойлсон.

- *Ирээдүйн усны хомстолоос урьдчилан сэргийлэх хийгээд орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдийн ус хангамжийн үйлчилгээг сайжруулах хоёр хувилбарын аль алны хувьд:*

Урьдчилан таамаглаж байсанчлан дундаж ТТЭ нь дараах үзүүлэлттэй эерэг хамааралтай байна. Үүнд:

- Хэрэглэгчийн өрхийн орлогын түвшин ба түүнтэй хамааралтай хүчин зүйлс. Эдгээрт даарах зүйлс багтаж байна. Үүнд:
 - Нэг хүнд ногдох орлогын хэмжээ; ба
 - УБ хотын орлого өндөртэй гурван дүүргийн нэгд амьдарч байгаа.
- Хэрэглэгчийн усны чанарт өгч буй дундаж үнэлгээ.

Дундаж ТТЭ нь дараах үзүүлэлттэй сөрөг хамааралтай байна. Үүнд:

- Хэрэглэгчийн өрх ядуурлын байдалд байгаа эсвэл өрхийн орлого нь эрс буурснаас болж хүндрэлтэй нөхцөлд орсон. Эдгээрт даарах зүйлс багтаж байна:
 - Ядуу буюу амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрх; ба
 - КОВИД-19 цар тахлын улмаас өрхийн орлого буурсан байх.
 - Өрхийн гишүүдийн насжилттай холбоотой онцлог, тухайлбал:
 - Өрхийн тэргүүний нас
 - Өрх өндөр насны тэтгэвэр авагч гишүүнтэй байх.
 - Усны тариф өндөр эсвэл боломжийн түвшинд байгаа гэсэн өрхийн үзэл бодол.
- *Орон сууцны хэрэглэгчдийн хувьд усны хомстолоос урьдчилан сэргийлэх хувилбар:*

Дундаж ТТЭ нь дараах үзүүлэлттэй эерэг хамааралтай байна. Үүнд:

- Ирээдүйн усны хомстолын талаар хэрэглэгчид санаа зовниж байгаа;
- Ирээдүйд усны хязгаарлалт тогтоохоос зайлсхийхийн тулд хийх хөрөнгө оруулалтыг дэмжсэн тарифын өсөлтийг хүлээн зөвшөөрөх байдал.

Дундаж ТТЭ нь дараах үзүүлэлттэй сөрөг хамааралтай байна. Үүнд:

- Усны тоолуургүй орон сууцанд амьдардаг байх;
- Дээд боловсролтой өрхийн тэргүүнтэй өрхөд амьдардаг байх;
- Хэрэглэгчийн өрхийн ам бүлийн тоо;
- Усны хэрэглээ ихтэй өрх байх.
- *Гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд усны хомстолоос урьдчилан сэргийлэх хувилбар:*

Дундаж ТТЭ нь дараах үзүүлэлттэй эерэг хамааралтай байна. Үүнд:

- Дээд боловсролтой өрхийн тэргүүнтэй өрхөд амьдардаг байх;
- УТБ хаасан тохиолдолд хэрэглэгчдийн усаа авдаг ундны усны бусад эх үүсвэрийн тоо.

Дундаж ТТЭ нь дараах үзүүлэлттэй сөрөг хамааралтай байна. Үүнд:

- Ундны усны гол эх үүсвэр нь түгээгчтэй УТБ байх;
- Нэг куб метр ус авахад зарцуулах цаг хугацааны алдагдсан боломжийн өртөг (6.6.3-т хэрэглэгчийн төрлүүдийн хоорондын ялгааг авч үзэв).

- *Гэр хорооллын хэрэглэгчдэд үзүүлэх усны үйлчилгээг сайжруулах хувилбар:*

Дундаж ТТЭ нь дараах үзүүлэлттэй сөрөг хамааралтай байна. Үүнд:

- Дээд боловсролтой өрхийн тэргүүнтэй өрхөд амьдардаг байх;
- Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхөд амьдардаг байх;
- Нэг куб метр ус авахад зарцуулах цаг хугацааны алдагдсан боломжийн өртөг.

Өрхийн төлбөр төлөх эрмэлзлийн тухай дэлгэрэнгүй дүн шинжилгээг Зургаадугаар бүлгээс үзнэ үү.

1.4.6 Зорилт 6: Ус түгээх байрыг гар ажиллагаанаас ухаалаг горимд шилжүүлснээр нийгмийн зарим бүлгийн хэрэглэгчдэд ус авахад тулгарч болзошгүй хүндрэл бэрхшээл болон тэдгээрийг бууруулах арга хэмжээг тодорхойлох.

Ус хангамжийн үйлчилгээг сайжруулах талаар хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ (Зорилт 3-ыг үзнэ үү), мөн фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр хэрэглэгчдийн гаргаж буй санал хүсэлт нь 24 цагийн ажиллагаатай, төлбөр тооцоо хийх арга нь хялбар гэх мэт ухаалаг УТБ-ны онцлогуудыг хэрэглэгчид өндөр үнэлж, бусад хэрэглэгчдийн дунд ч эрэлт хэрэгцээ их байгааг нотолж байна. Гэвч ухаалаг УТБ-нд гэмтэл, саатал их гардаг, усны даралт багатай гэж хэрэглэгчид үзэж байна. Тэтгэвэр авдаг хэрэглэгчид болон хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүд ухаалаг УТБ-д төлбөр төлөх хүсэл бага байгаа нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд ухаалаг УТБ-аар үйлчлүүлэхэд төдийлөн хялбар биш байж магадгүй юм. Картаар төлбөр хийдэг нь буяны ажлын хүрээнд ус үнэгүй түгээдэг уламжлалд саад учруулж болзошгүй юм (5.2.4 дэх хэсэг болон фокус бүлгийн хэлэлцүүлгийн хамаарах мэдээллийг үзнэ үү).

Эдгээр хүндрэл бэрхшээлийг бууруулахад ухаалаг УТБ-ны найдвартай ажиллагааг хангах, эвдрэл, саатал гарах тохиолдолд хурдан засварлах зэрэг арга хэмжээнүүд багтаж байна. Ухаалаг УТБ-ны хүртээмж, орчны аюулгүй байдлыг сайжруулах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настнуудад тулгардаг хүртээмжийн бэрхшээлүүдийг арилгах нэг арга юм. Судалгаагаар эдгээр боломжит саад бэрхшээлүүдийн талаар тодорхой нотолгоо тогтоогоогүй ч тус тайланг боловсруулсан судлаач үүнийг цаашид судлах шаардлагатай чиглэл гэж үзсэн (Хавсралт 4-ийг үзнэ үү).

1.4.7 Зорилт 7: Төлбөр төлөх өнөөгийн арга, сайжруулах боломжит хувилбарууд болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн талаарх хэрэглэгчдийн санал бодлыг тодорхойлж, дараагийн шатны судалгаанууд болох Ажлын даалгавар 2- “Худалдан авах чадвар болон Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн судалгаа”, Ажлын даалгавар 3- “Тарифын хувилбарын судалгаа”-г шаардлагатай мэдээллээр хангах.

Төлбөр төлөх аргууд

Судалгааны үр дүнгээс харахад орон сууцанд амьдардаг өрхүүдийн 18.2% нь судалгаа авахаас өмнөх 12 сарын хугацаанд усны үйлчилгээний төлбөрөө хоцорч төлж байжээ. Энэхүү төлбөрийн хоцролт нь ядуу өрхөд хамаарах өрхийн дунд 22.3% байв (6.1 хэсгийг үзнэ үү). Энэ нь үндсэндээ төлбөр төлөх мөнгөгүй (ядуу өрхөд хамаарах хэрэглэгчдийн 55.3%), төлбөр төлөхөө мартсан (ядуу ангилалд хамаарах хэрэглэгчдийн 10.7%) зэрэг шалтгаанаас үүджээ. Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид цахимаар төлбөр төлөхийг сайшааж, банканд дугаарлахыг хүндрэлтэй хэмээн үзэж байсан бол тоон судалгаагаар орон сууцны хэрэглэгчдийн 56% нь төлбөрөө банканд төлдөг байна. Судалгаанд оролцогч зарим хэрэглэгч цахимаар төлбөрөө төлөхөд НӨАТ-ийн сугалаанд оролцох боломжгүй болдог (энэ нь буруу ойлголт юм) гэсэн шалтгааныг дурдаж байв. Хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах, цахимаар төлбөрөө төлөх хувилбарыг улам хялбар болгох нь банканд очиж төлбөр төлөх байдлыг бууруулж, төлбөрөө хоцроох явдлыг багасгах боломжтой.

Судалгааны Зорилт 3 болон Зорилт 6-д дурдсанчлан, ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдээс бусад гэр хорооллын хэрэглэгчид төлбөр төлөх илүү сайн аргуудыг хүсэж байна. Төлбөр төлөх илүү сайн аргуудын сонголтыг бий болгохыг зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчид хамгийн ихээр хүсэж байна.

Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр (ХДХ)

Фокус бүлгийн хэлэлцүүлгээр ихэнх оролцогчид тариф нэмэгдвэл хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр (ХДХ) байх хэрэгтэй гэдэгтэй санал нийлж байв (6.2 хэсэгт дэлгэрэнгүй танилцуулав). Оролцогчдын зүгээс “Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийг сайтар боловсруулахгүй бол зорилтот бүлэгтээ хүрэхгүй, дэмжлэг туслалцаанд шаардлагагүй өрхүүд хамрагдах эрсдэлтэй хэмээн үзэж байв. Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжит аргуудын хувьд ихэнх оролцогчид тухайн хөтөлбөрийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцах нь зүйтэй хэмээн үзэж байсан. Гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд зорилтот өрхүүдэд чиглэсэн дэмжлэгийг ухаалаг карт хэлбэрээр, эсвэл сар тутам дэмжлэг үзүүлдэг байхыг санал болгож байв. Орон сууцны хэрэглэгчид усны эрхийн бичиг (купон) олгох, эсвэл усанд зарцуулах мөнгийг нь хэмнэх бусад арга, төлбөр хоцроосны алдангийг тэглэх зэрэг саналыг тус тус гаргаж байсан. Усны тоолуургүй, ядуу өрхүүдийн хувьд Гуравдугаар бүлэгт дурдсанчлан төлбөр тооцооны аргыг шинэчлэх нь нэн тэргүүний асуудал байна. Гэр хороололд усны хэрэглээг дагалдан их хэмжээний мөнгөн бус зардал гардаг тул эдгээр зардлыг бууруулахад чиглэсэн дагалдах бодлогогүйгээр хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь ядуу өрхүүдийн усны хэрэглээнд төдийлөн нөлөө үзүүлэхгүй нь судалгаанаас ажиглагдав. Хэрэглэгчдийн худалдан авах чадварын талаар дэлгэрэнгүй дүн шинжилгээг судалгааны тайлангийн Зургаадугаар бүлэгт тусгав. Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн үндэслэл, хувилбарын талаар иж бүрэн судалгааг дараагийн шатны судалгаа болох Ажлын даалгавар 2 “Худалдан авах чадвар болон Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн судалгаа”-ны хүрээнд хийнэ.

1.5 Зөвлөмж

1.5.1 ОСНААУГ болон орон сууцны хувийн конторуудад зориулсан зөвлөмж

1. **Орон сууцны хэрэглэгчдэд тулгарч буй усны үр ашиггүй зарцуулалттай холбоотой асуудлыг анхааралдаа авч, хариу арга хэмжээ авах.** Өрхүүдийн усны алдагдлын бодит хэмжээ тодорхойгүй бөгөөд тус алдагдал нь ОСНААУГ-ын орлогод шууд сөргөөр нөлөөлөхгүй хэдий ч уг асуудалд анхаарлаа хандуулахгүй байж болохгүй. Энэ нь хэр чухал байгаа нь ядуу хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин, усны үйлчилгээг сайжруулах талаар өгсөн хэрэглэгчдийн санал хүсэлт болон их хэрэглээтэй хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзэл бага байгаа зэргээс харагдаж байна. Дэд бүтэц, усны үйлчилгээг сайжруулж усыг үр ашиггүй зарцуулдаг асуудлыг шийдэхгүй бол усны хомстолоос сэргийлэхийн тулд үнэ тарифыг нэмэгдүүлэхийг дэмжихгүй байх магадлалтай гэдгийг шийдвэр гаргагчид, үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд харгалзан үзэх хэрэгтэй байна. Хэрэглэгчид энэхүү зөрчилтэй асуудлыг шийдэх хүртэл цаашид тарифыг байнга нэмэгдүүлэхийг хүлээн зөвшөөрөхгүй байх хандлага ажиглагдлаа.
2. **Усны үйлчилгээний төлбөрийг цахимаар хэрхэн төлөх, цахимаар төлөхдөө НӨАТ-ийн сугалаанд хэрхэн оролцох талаар хэрэглэгчдийг илүү их, тодорхой мэдээллээр хангах.** Ингэснээр хэрэглэгчид банканд дугаарлан цагаа үрэх байдлыг багасгахын зэрэгцээ ядуу өрхүүд болон бусад бүх хэрэглэгчдийг төлбөрөө хугацаанд нь төлөх боломжийг бий болгох сайн талтай.

1.5.2 УСУГ-д зориулсан зөвлөмж

3. **Гэр хорооллын усны үнийг нэмэгдүүлэхийн тулд зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн усны хүртээмж, үйлчилгээг сайжруулах шаардлагатай.** Түгээгчтэй УТБ-ыг ухаалаг картын горимд шилжүүлэхийг хэрэглэгчид дэмжиж байсан. Ухаалаг УТБ-ны хүртээмж, орчны аюулгүй байдлыг сайжруулах нь хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай иргэдэд тулгарч буй хүртээмжтэй холбоотой хүндрэлийг шийдвэрлэх нэг арга юм. Өөр нэг чухал асуудал бол гэр хорооллын хэрэглэгчдийн 57% эзэлдэг зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн дунд ухаалаг картаар төлбөр хийх эрэлт хэрэгцээ их байгаа бөгөөд МСК-ийн хөрөнгө оруулалт нь зөөврийн ус хангамжтай УТБ-ыг ухаалаг УТБ болгон хувиргахад чиглээгүй тул түгээгчтэй УТБ-ыг ухаалаг болгон сайжруулснаас эдгээр хэрэглэгчид төдийлөн үр өгөөж хүртэхгүй юм. Гэр хорооллын бүх хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзэл өндөр байгаа хэдий ч хөрөнгө оруулалтаас зөвхөн цөөн тооны иргэд л өгөөжийг нь хүртэх юм бол усны тарифыг нэмэгдүүлэхийг хүлээн зөвшөөрөхгүй байх магадлалтай байна. Шугам сүлжээнд холбогдсон түгээгчтэй УТБ-ыг ухаалаг горимд шилжүүлэхэд бий болсон хэмнэлтээс зөөврийн ус хангамжтай УТБ-ны ажиллах цагийг уртасгахад зарцуулах аргыг хэрэглэгчидтэй хамт туршиж болно. Ухаалаг картаар төлбөрөө хийдэг болох хүсэлтэй байгаа хэрэглэгчид төлбөр тооцооны шинэ, илүү хялбар аргыг (жишээ нь мессежээр эсвэл гар утасны аппликейшнээр) нэвтрүүлэхийг дэмжих магадлалтай. Зорилт 3 болон Зорилт 6 гэсэн хэсэгт дурдсанчлан, ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдээс бусад гэр хорооллын хэрэглэгчид төлбөр төлөх илүү дэвшилттэй аргуудыг хүсэж байна.

1.5.3 ХСУХАТАУ33-д зориулсан зөвлөмж

4. Хэрэглэгчдийн худалдан авах чадварын асуудлыг шийдэх үүднээс **орон сууцанд амьдардаг тоолуургүй хэрэглэгчдийн усны хэрэглээг тооцох аргачлалыг эргэн харах шаардлагатай**. Усны тоолууртай хэрэглэгчдийн дөнгөж 4% өрхийн нийт орлогынхоо 5-аас дээш хувийг цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрт зарцуулж байгаа бол усны тоолуургүй өрхүүдийн 23% нь буюу үндсэндээ ахмад настнаас бүрдсэн цөөн ам бүлтэй өрхүүд нийт орлогынхоо 5-аас дээш хувийг зарцуулж байна. Усны тоолуургүй өрхүүдийн хувьд нэг хүн хоногт 200 литр ус (сарын төлбөр тооцоход ашигладаг суурь хэмжээ) хэрэглэж байгаа гэсэн нотолгоо байхгүй. Долоодугаар бүлэгт дурдсанчлан, энэ бодлогыг ус хангамжийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын орлого буурах эрсдэлийг нэмэхгүйгээр хэрэглэгчдийн оролцоотойгоор эргэн харах боломжтой.
5. **Дээрх Зорилт 2-т дурдсанчлан шаталсан тариф/амьжиргаа тэтгэх тарифыг** өрхийн усны хэрэглээний үндсэн хэрэгцээг хангахад туслах зохистой бодлого болгон **нэвтрүүлж** хэрэгжүүлэхийг **санал болгохгүй**. Энэ нь усны хэрэглээ нь хангалтгүй, бага хэрэглээтэй, гол төлөв гэр хороололд амьдардаг хүмүүсийн ус авахад гаргаж буй их хэмжээний мөнгөн бус зардлыг шийдвэрлэхгүй бөгөөд орон сууцанд амьдардаг амьжиргааны доод түвшнээс дээгүүр орлоготой өрхийн хэрэглээнд татаас болох эрсдэлтэй.
6. **Дээрх Зорилт 7-д дурдсанчлан усны тарифыг их хэмжээгээр нэмэгдүүлэх тохиолдолд Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрт гэр хорооллын өрхийн усны хэрэглээг даган гарах их хэмжээний мөнгөн бус зардлыг бууруулах бодлогыг авч үзэх шаардлагатай**. Гэр хорооллын хэрэглэгчийн мөнгөн бус зардал их байгаа тул уг зардлыг бууруулах дагалдах бодлого баримтлахгүйгээр хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зөвхөн санхүүгийн дэмжлэг үзүүлбэл усны тариф нэмэгдсэн тохиолдолд ядуу өрхүүдийн усны хэрэглээнд маш бага нөлөө үзүүлнэ.

2. ОРШИЛ

2.1 Танилцуулга

Монгол Улсын Засгийн газар болон МСК нь эдийн засгийн өсөлтийг дэмжих замаар ядуурлыг бууруулах зорилгын хүрээнд АНУ-ын Засгийн газрын 350 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.8 сая хүртэл ам.долларын хөрөнгө оруулалтаар хэрэгжих Мянганы сорилтын хоёр дахь Компакт гэрээнд 2018 оны 7 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурж, Монгол Улсын Их Хурал Компакт гэрээг 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр соёрхон баталсан юм. Компакт гэрээний хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд хөтөлбөрийн хүрээнд харилцан уялдаа бүхий дараах гурван томоохон төсөл, үйл ажиллагаанд хөрөнгө оруулна.

Үүнд:

1. Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах үйл ажиллагаа буюу Улаанбаатар хотын баруун доод хэсэг Биокомбинат, Шувуун фабрик орчимд газрын доорх усны шинэ эх үүсвэрүүдийг холбогдох дэд бүтэц, усан сан болон ус цэвэршүүлэх дэвшилтэт технологи бүхий үйлдвэрийн хамт байгуулах төсөл.
2. Хаягдал ус дахин боловсруулах үйл ажиллагаа буюу шинэ Төв цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал усыг дахин боловсруулж, гурав болон дөрөвдүгээр ДЦС-д нийлүүлэх үйлдвэрийг холбогдох дэд бүтцийн хамт байгуулах төсөл.
3. Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа буюу Улаанбаатар хотын ус хангамжийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн бодлого, хууль эрх зүйн орчин, институтын чадавхыг сайжруулах төсөл.

Компакт гэрээний Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Засгийн газар УСУГ-ын зардал нөхөх нарийвчилсан төлөвлөгөө батлах үүрэг хүлээсэн юм. Энэхүү төлөвлөгөөгөөр ус, бохир усны тариф, хураамж, татаасаас олох орлогоор 2023 он гэхэд хотын ус, ариутгах татуургын шууд ашиглалтын зардлыг бүрэн нөхөхийг зорьж байна. Уг төлөвлөгөөний зорилго нь ус хангамжийн системийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үйлчилгээний чанар, түвшин, эмзэг бүлгийн хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг хадгалахад оршиж байна.

Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (ХСУХАТАҮЗЗ)-д тогтвортой байдлыг хангасан цэвэр, бохир усны тарифын бүтцийг нарийвчлан судлах Зардал нөхөх техникийн туслалцаа (ЗНТТ) үзүүлж байна. Уг техникийн туслалцааны хүрээнд ус хангамжийн сайжруулсан үйлчилгээнд ус хэрэглэгчдийн төлөх төлбөрийн чадвар, төлбөр төлөх эрмэлзлийг нарийвчлан үнэлж, уг үнэлгээнд тулгуурлан цэвэр, бохир усны тарифын хувилбаруудыг боловсруулж, хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зохистой хувилбаруудыг боловсруулах юм. Зардал нөхөхөд чиглэсэн техникийн туслалцаа, түүний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар ЗНТТ-ны Даалгавар 1: Эхлэлийн тайлан-д дэлгэрэнгүй тусгасан болно⁶.

⁶ ТТЭ-ийн судалгааны Эхлэлийн тайлан. Улаанбаатар хотын ус хангамжийн системийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн Зардал нөхөх техникийн туслалцааны төсөл.

Энэхүү тайланд ЗНТТ-ны Даалгавар 1-ийн дэд үйл ажиллагаа болох Төлбөр төлөх эрмэлзэл (ТТЭ)-ийн судалгааны үр дүнг танилцуулж байна. Даалгавар 2: “Худалдан авах чадвар болон Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн судалгаа”-ны хүрээнд ТТЭ-ийн судалгаагаар цуглуулсан өрхийн орлогын мэдээллийг ашиглан орон сууцны болон гэр хорооллын УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн усны одоогийн үнэ, тарифын боломжит байдал, тарифын янз бүрийн таамагласан түвшнийг судлахаар төлөвлөсөн юм. Монголын болон бусад орны шилдэг туршлага дээр үндэслэн төлбөр төлөхөд бэрхшээлтэй тулгарч буй, эсвэл тулгарах магадлалтай хэрэглэгчдийн тодорхой дэд бүлгүүдийг дэмжих зорилгоор Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрөөр дамжуулан зорилтот хэрэглэгчдэд үзүүлэх татаасны хувилбаруудыг санал болгох юм. Даалгавар 3: “Тарифын хувилбаруудын судалгаа”-гаар тарифын загварчлалын загварыг боловсруулж, Ус сувгийн удирдах газар (УСУГ), Улаанбаатар хотын захиргаа, Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар (ОСНААУГ), ХСУХАТАУ33, мөн Мянганы сорилтын сан (МСС)-аас тодорхойлсон бусад оролцогч талуудтай тохиролцсон гүйцэтгэлийн шалгуурын дагуу хэрэглэгчдийг дэмжих тарифын болон бусад хувилбаруудыг үнэлэх болно.

2.2 Судалгааны зорилго, зорилтууд

ТТЭ-ийн судалгаа нь бодлогын дараах үндсэн хоёр зорилготой. Үүнд:

- (i) Тарифын бүтэц, хэмжээ болон өрхийн хэрэглэгчийн бүлэг тус бүрийн төлбөрийн чадварыг үнэлэхэд шаардлагатай тоон мэдээллээр ХСУХАТАУ33-ийг хангах,
- (ii) Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээний зорилтот түвшин, түүнд холбогдох хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр УСУГ, ОСНААУГ, Улаанбаатар хотын Захиргааг хангах.

Судалгаа дараах тодорхой зорилтуудтай. Үүнд:

- i. Улаанбаатар хотын орон сууцны болон гэр⁷ хорооллын хэрэглэгчдийн сайжруулсан ус хангамжийн үйлчилгээнд төлбөр төлөх эрмэлзэл дээр үндэслэн усны үйлчилгээний өрхийн эрэлт хэрэгцээг тодорхойлох;
- ii. "Амьжиргааг тэтгэх тариф"-тай тэнцэх усны хэрэглээний хэмжээний талаар зөвлөмж гаргах;
- iii. Одоогийн цэвэр, бохир усны үйлчилгээний талаарх хэрэглэгчдийн ойлголтыг үнэлэх;
- iv. Хэрэглэгчдийн худалдан авах чадварт нарийн дүн шинжилгээ хийхэд шаардлагатай өрхийн түвшний нийгэм, эдийн засгийн болон хүн ам зүйн тоон мэдээлэл цуглуулах (Даалгавар 2: “Худалдан авах чадвар болон Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн судалгаа”);
- v. Төлбөр төлөх эрмэлзлийн нийгэм, эдийн засаг, сэтгэл ханамж зэрэг үзүүлэлтэд хамааралтай хүчин зүйлсийг тодорхойлох;
- vi. Түгээгчтэй ус түгээх байруудыг ухаалаг картаар ажилладаг болгоход хэрэглэгчийн зарим бүлгүүдэд тулгарч болох саад бэрхшээлийг олж тогтоох, улмаар саад бэрхшээлийг бууруулах арга хэмжээг тодорхойлох;
- vii. Ажлын даалгавар 2: “Худалдан авах чадвар болон Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн судалгаа” болон Ажлын даалгавар 3: “Тарифын хувилбаруудын судалгаа” хийхэд шаардлагатай одоогийн болон таамаглаж буй төлбөр тооцоог

⁷ Гэр- тайлангийн англи хувилбарт Монгол гэрийг тайлбарлаж тодотгосон байв

гүйцэтгэх арга хэрэгсэл, механизмыг илүүд үзсэн хэрэглэгчдийн сонголт болон хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох.

2.3 Судалгааны арга зүй

ТТЭ-ийн судалгааг хийхэд хосолмол арга зүйг ашигласан. Тоон болон чанарын мэдээллийг оролцогч талуудын холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн 18 ярилцлага⁸ 55 хэрэглэгчтэй (орон сууцны 26 хэрэглэгч болоод гэр хорооллын 29 хэрэглэгч) хийсэн найман фокус бүлгийн хэлэлцүүлэг (ФБХ), мөн Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ноос зохион байгуулсан Улаанбаатар хотын 4,975 ус хэрэглэгч (өрх)-ийн судалгаа зэргээр дамжуулан цуглуулсан. Түүврийн хэмжээ нь Улаанбаатар хотын бүх өрхийн хэрэглэгчийг⁹ (Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор¹⁰ ойролцоогоор 411,400 өрх), тэр дундаа ус хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдардаг 205,200 хэрэглэгч, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй гэр хороололд амьдардаг 206,200 гаруй хэрэглэгчдийг төлөөлөхөд хангалттай байв.

Судалгааны асуулгын хуудсыг Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Монголын Мянганы сорилтын сан, МСК-тай хамтран боловсруулсан. Асуулгын хуудсыг боловсруулах ажлын хүрээнд УСУГ, ОСНААУГ, ХСУХАТАУЗЗ, Улаанбаатар хотын захиргаа, Барилга, хот байгуулалтын яам, хувийн конторуудтай мөн зөвлөлдөж саналыг нь авсан юм. 2019-2020 онд судалгааны асуулгын хуудсыг боловсруулж фокус бүлгийн хэлэлцүүлгүүдийг хийв. Асуулгын хуудаст өрхийн ам бүлийн тоо, сууцны төрөл, орлогын эх үүсвэр болон хэмжээ, усны төлбөрийн хэмжээ, өрхийн сарын зарлагын дундаж хэмжээ зэрэг асуултаас гадна одоогийн усны үйлчилгээний үнэ тариф, усны чанар, нийлүүлэгч байгууллагын үйлчилгээний талаарх хэрэглэгчдийн ойлголт, усны хомстол, ус хангамжийн үйлчилгээг сайжруулах болоод ирээдүйд усны хомстол, усны хязгаарлалтаас сэргийлэхийн тулд ихээхэн хөрөнгө оруулалт хийхэд хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзэл зэрэгтэй холбоотой бүлэг асуултыг багтаасан 450 орчим асуулт багтсан болно. Судалгааны асуулгын хуудсыг Хавсралт 3-т оруулав.

Өрхийн судалгааг ойролцоогоор ижил тооны эрэгтэй, эмэгтэй оролцогчдоос авахыг ҮСХ болон Мянганы сорилтын сан зөвшөөрсөн тул үүний дагуу тоологчид өрхийн тэргүүн эсвэл өрхийн тэргүүний эхнэр / нөхрийг судалгаанд оролцогчоор сонгосон. Өргөтгөсөн гэр бүлийн өрхийн тэргүүн өрхийнхөө төсвийн талаар сайн мэддэггүй байх эсвэл өрхийн тэргүүн, эсвэл түүний эхнэр / нөхөр нь гэртээ байхгүй байсан бөгөөд судалгаа дуусахаас өмнө эргэж ирэхгүй байх тохиолдолд насанд хүрсэн хүүхэд эсвэл өрхийн өөр хүнийг судалгаанд оролцогчоор сонгож асуулга авсан юм¹¹.

Тоон мэдээлэлд хийсэн дүн шинжилгээгээр судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс 1.6 дахин их байгааг харуулж байна. Монголд эмэгтэйчүүд өрхийн

⁸ Хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асран хамгаалагч эсвэл гэр бүлийн бичил бизнес эрхлэгчидтэй хийсэн дөрвөн ФБХ; ХСУХАТАУЗЗ, УСУГ, ОСНААУГ, хувийн конторууд, Улаанбаатар хотын Захиргаа болон ОСНААУГ-ын конторуудын орлого хариуцсан байцаагч нар зэрэг янз бүрийн оролцогч талуудтай хийсэн 14 ФБХ.

⁹ Энэхүү тайлангийн 1.2. Судалгааны тодорхой зорилтууд гэсэн хэсэгт заасанчлан судалгаанд зөвхөн орон сууцны болон гэр хорооллын өрхийн хэрэглэгчдэд анхаарлаа хандуулсан болно.

¹⁰ Монгол Улсын хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Нэгдсэн дүн, 2020 оны 6 дугаар сар, ҮСХ.

¹¹ Судалгаа авахаар тоологчид тухайн өрхөд дахин очсон тохиолдлын хувьд 375 өрхөд хоёр удаа, 124 өрхөд гурван удаа тус тус очсон бол 66 өрх судалгаанд оролцохоос татгалзсан.

зардал, төлбөрийн талаар эрэгтэйчүүдээс илүү сайн мэддэг тул судалгаанд оролцогчоор сонгогдох магадлал өндөр байдаг гэж ҮСХ энэхүү жендерийн ялгааг тайлбарлаж байна.

2.3.1 КОВИД-19 цар тахлын нөлөө

Өрхийн судалгааг анх 2020 оны эхээр хийхээр төлөвлөж байсан боловч коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахлын улмаас хойшлогдсоноор 2020 оны 9 дүгээр сарын 14-нөөс 10 дугаар сарын 12-ны хооронд хийсэн. 2020 оны 1 дүгээр сард Монгол Улсын Засгийн газраас коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээг үндсэндээ цуцалж, ерөнхий боловсролын сургуулиуд 9 дүгээр сарын 1-нд танхимаар хичээллэх болсон боловч нийгмийн амьдрал, эдийн засаг хараахан идэвхжээгүй байв. Тээвэрлэлт/транзит тээвэр болон жижиглэн худалдаа идэвхэжсэн боловч ажлын байранд биечлэн ирж ажиллах нь буурсан хэвээр байв. Энэ нөхцөлд тоологчид томоохон саад бэрхшээлгүйгээр өрхийн судалгааг авах боломжтой байв.

КОВИД-19-ын цар тахлаас үүдсэн хямралын улмаас хэрэглэгчдийн зан төлөвт гарсан өөрчлөлт нь судалгааны үр дүнд нөлөөлсөн байж магадгүй юм. Гэсэн хэдий ч судалгаагаар Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь орлого багатай өрхүүдийн амьжиргаанд цар тахлын үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлснөөс бусад нотолгоог тогтоогоогүй бөгөөд ҮСХ-ны судалгаа үүнийг мөн баталж байна.¹² ТТЭ-ийн судалгаагаар цар тахлын өрхийн орлогод үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэл цуглуулсан. Энэ нь өрхийн орлогод эергээр нөлөөлсөн гэж мэдээлсэн өрхүүд ядуу байх магадлал өндөр байгаа нь санаандгүй үр дүн байв. Энэ нөхцөл байдал нь цар тахлын улмаас нийгмийн хамгаалалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас цуврал арга хэмжээг авч хэрэгжүүлсэнтэй холбоотой юм. Тухайлбал, Хүүхдийн мөнгөний хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмсэн, хүнсний талоны хэмжээг нэмсэн, мөн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн тэтгэмж зэрэг бусад арга хэмжээг дурдаж болно. Хамгийн ядуу бүлэгт хамаарах өрхүүд цар тахлын өмнөх өрхийн орлогынхоо дунджаар 40%-тай тэнцэх орлогын дэмжлэг авсан нь судалгаагаар тогтоогдсон.¹³ Харин эсрэгээр тогтвортой ажил эрхэлдэг, байнгын орлоготой байх магадлал өндөр, ядуу байх магадлал багатай цалинтай ажилчид эдийн засгийн хямралд хамгийн ихээр өртсөн байна. **2020 оны эхний улиралд таван өрхийн бараг хоёр нь цалингийн орлогоо алджээ.**¹⁴

2.3.2 Судалгаагаар цуглуулсан усны хэрэглээний хэмжээтэй холбоотой мэдээллийн нийцтэй байдлыг шалгасан байдал

Тоон өгөгдлийн хязгаарлагдмал байдлын хувьд ТТЭ-ийн судалгаагаар зөвхөн усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн усны бодит хэрэглээтэй холбоотой мэдээллийг цуглуулсан. Учир нь усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн усны тооцоолсон төлбөрт тухайн өрхийн гишүүдийн тоог л дурдсан байдаг тул эдгээр өрхийн усны бодит

¹² “Корона вирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”- гуравдах шатны үр дүн. Дэлхийн банк –ҮСХ.

¹³ “Корона вирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”- гуравдах шатны үр дүн. Дэлхийн банк –ҮСХ.Дэлхийн банк –ҮСХ.

¹⁴ Дээрх судалгаанд

хэрэглээг судалгаагаар авах боломжгүй байсан юм. Тиймээс орон сууцанд амьдардаг усны тоолуургүй өрхүүдээс сард хэрэглэдэг усны хэмжээг аль болох бодитоор хариулахыг тоологч нар судалгаа авахдаа асууж байсан. Иймд эдгээр хэрэглэгчийн зарим нь бодитоор хэрэглэдэг гэж үзсэн усны хэмжээгээ хэлсэн бол зарим нь байрны төлбөрийн баримтад нэхэмжилсэн усны хэмжээг мэдээлсэн байх магадлалтай юм.

Тиймээс усны үйлчилгээний тариф нь усны хэрэглээний тайлагнасан хэмжээтэй уялдаж байгаатай холбогдуулан уг шинжилгээгээр тухайн өрхийн усны төлбөрийн дүн хэрэглэгчийн тайлагнасан усны хэрэглээний түвшинтэй тохирч байгаа эсэхийг шалгасан.

Усны тоолууртай орон сууцанд амьдардаг өрхийн усны хэрэглээний түвшнийг тухайн өрхийн төлсөн усны төлбөрөөс авсан тул тоолууртай орон сууцанд амьдардаг өрхийн 93.9 гаруй хувьд нь дээрх хоёр хувьсагч нийцэж байна. Усны тоолуургүй орон сууцанд амьдардаг нийт өрхийн 36.7%-д л дээрх хоёр хувьсагч мөн нийцэж байна. Тухайлбал эдгээр өрхийн 43.2% нь усны нэхэмжилсэн төлбөрөөс¹⁵, доогуур хэрэглээтэй гэж хариулсан бол 20.1% нь нэхэмжилсэн хэмжээнээс өндөр хэрэглээтэй гэж хариулсан байна.

Гэр буюу сууц нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй, УТБ эсвэл бусад эх үүсвэрээс ус авдаг гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд зун, өвлийн саруудад хэрэглэгчдийн худалдан авсан усны дундаж хэмжээнд үндэслэн шинжилгээ хийсэн. Үүний зэрэгцээ ТТЭ-ийн судалгаагаар гэр хорооллын хэрэглэгчдийн долоо хоногт хэрэглэдэг усны хэмжээг ус авахаар хэдэн удаа УТБ-руу явдаг, нэг удаагийн явалтаар хэдий хэмжээний ус авдаг зэрэг мэдээлэл дээр үндэслэн мэдээлэл цуглуулсан. Үүний үр дүнд сар бүр худалдаж авсан усны хэмжээг тухайн жилд худалдан авсан дундаж хэмжээтэй харьцуулж үзсэн бөгөөд эдгээр өрхийн 13.4% нь долоо хоногт авдаг усны хэмжээнээс илүү их ус худалдан авдаг гэж хариулсан бол 26.4% нь одоогийн хэмжээнээс бага хэмжээгээр ус худалдан авдаг гэж хариулсан.

Гэр хорооллын усны хэрэглээ гэдэг нь өрхийн усны шууд хэрэглээг судалгаанд оролцогчдын баримжаалж тооцсон хэмжээг илэрхийлж байгаа бөгөөд үүнд өрхүүдийн халуун усанд орох, хувцас угаах газраар дамжуулан хэрэглэж болох усны хэмжээ тооцогдоогүй болно. Тиймээс гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээг усанд орох, хувцас угаах зэрэгт зарцуулж буй усны хэмжээг багтаасан орон сууцны хэрэглэгчдийн усны хэрэглээтэй шууд харьцуулах боломжгүй юм.

Судалгааны мэдээлэл цуглуулах арга, хэрэгжилт, тоон мэдээллийн нийцтэй байдлыг хэрхэн шалгасан талаар Хавсралт 1, 2-оос дэлгэрэнгүй үзнэ үү.

2.4 Нөхцөл байдал

Улаанбаатар хотын ус хангамжийн хүртээмж нь тухайн өрх хаана амьдарч байгаагаас ихээхэн хамаардаг. Өөрөөр хэлбэл хотын төвийн дүүрэгт, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон сууц (ихэвчлэн орон сууц), эсвэл хотын захад ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон эсвэл зөөврийн ус хангамжтай ус түгээх байраар ундны усаар хангадаг гэр хороололд амьдардаг эсэхээс хамаарч өөр өөр байдаг. Хүн ам, орон

¹⁵ Энэ нь зарим тохиолдолд төлбөрөө хойшлуулсны улмаас тухайн сар болон өмнөх сард хэрэглэсэн усны төлбөрөө төлсөн хэрэглэгчид байж магадгүй юм.

сууцны 2020 оны ээлжит тооллогын¹⁶ дүнгээр Улаанбаатар хотын нийт сууцны тал хувь (50.1%) нь цэвэр усны шугам сүлжээнд холбогдоогүй байна. Шугам сүлжээнд холбогдоогүй сууцанд амьдардаг өрхүүд усанд орох, хувцас угаахдаа нийтийн халуун усны газар, угаалгын газар ашигладаг бөгөөд ихэвчлэн ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдоогүй нүхэн жорлонтой байна.

2.4.1 Ус хангамжийн үйлчилгээг хариуцах хоёр байгууллага

Ус сувгийн удирдах газар (УСУГ) болон Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар (ОСНААУГ) нь Улаанбаатар хотын өрхийн хэрэглэгчдийг ундны усаар хангадаг. УСУГ нь бөөний усаар хангахын зэрэгцээ УТБ-аар гэр хорооллын хэрэглэгчдэд ус түгээх үйлчилгээг хариуцдаг бол ОСНААГ нь орон сууцны хэрэглэгчдэд цэвэр, бохир усны үйлчилгээг үзүүлдэг. Дээрх хоёр байгууллагаас гадна тус салбарт 81 хувийн аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. ХСУХАТАУЗЗ-ийн тоон мэдээллээс харахад хувийн конторууд буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагууд нийт орон сууцны хэрэглэгчдийн 52.8%-ийг (126,672 хэрэглэгч) ундны усаар хангаж байна. Ихэнх тохиолдолд эдгээр аж ахуйн нэгжүүд нь хэрэглэгчдэд цэвэр, бохир усны үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч үл хөдлөх хөрөнгийн буюу барилгын компаниуд байдаг. Хувийн контор болоод ОСНААУГ-ын хэрэглэгчийн үйлчилгээний төвүүд (хоёуланг нь *контор* гэж нэрлээд хэвшсэн) нь хэрэглэгчидтэй шууд харьцаж, хэрэглэгчдээс төлбөр цуглуулах, мөн засвар хийх зэрэг үйлчилгээ үзүүлдэг. Нийт салбарыг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (ХСУХАТАУЗЗ) зохицуулдаг бөгөөд чиг үүрэгт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох зэрэг нь багтаж байдаг. Эцэст нь Улаанбаатар хотын захиргаа, Барилга, хот байгуулалтын яам, аймаг, дүүрэг усны системийн менежментэд тус тусын чиг үүргийн дагуу оролцдог.¹⁷

2.4.2 Усны тариф ба тооцооны арга

Орон сууцны хэрэглэгчийн ахуйн усанд төлдөг үнэ хэрэглэгчийн орон сууц төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон эсэхээс хамаардгаас гадна сүлжээнд холбогдсон тохиолдолд усны хэрэглээг тоолуураар хэмжиж байгаа эсэхээс хамаарч гурван түвшинтэй байдаг (Хүснэгт 1-ээс үзнэ үү).

Иймээс энэхүү судалгаагаар хэрэглэгчийн хоёр ангилалд (ус хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон болон холбогдоогүй) багтах **хэрэглэгчийн** гурван ялгаатай **төрлийг** авч үзсэн. Эдгээрийг хялбаршуулсан байдлаар Хүснэгт 1-т үзүүлэв. Судалгааны тайланд эдгээр хэрэглэгчдийг дараах байдлаар ангилав. Үүнд:

- Ус хангамжийн төвлөрсөн **шугам сүлжээнд холбогдсон** усны **тоолууртай** хэрэглэгчдийн тоонд төвийн усны системд холбогдсон сууцанд (уг судалгааны хүрээнд гол төлөв орон сууцыг авч үзсэн) амьдардаг, усны хэрэглээг нь тоолуураар хэмждэг орон сууцны өрхийн хэрэглэгчдийг багтаасан. Товчлох үүднээс тайланд "усны тоолууртай орон сууц" гэсэн нэр томъёог ашиглав.
- Ус хангамжийн төвлөрсөн **шугам сүлжээнд холбогдсон** усны **тоолуургүй** хэрэглэгчдийн тоонд төвийн усны системд холбогдсон сууцанд (уг судалгааны хүрээнд гол төлөв орон сууцыг авч үзсэн) амьдардаг, усны хэрэглээг нь

¹⁶ Монгол Улсын хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого. Нэгдсэн дүн, 2020 оны 6 дугаар сар, ҮСХ.

¹⁷ Монгол Улсын усны нөөцийн систем, менежментийн тойм. 2020 оны 6 дугаар сар. Азийн хөгжлийн банк.

тоолуураар хэмждэггүй орон сууцны өрхийн хэрэглэгчдийг багтаасан. Товчлох үүднээс тайланд "усны тоолуургүй орон сууц" гэсэн нэр томъёог ашигласан.

- **Гэр хорооллын хэрэглэгчдийн тоонд** төвийн усны системд ус хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй сууцанд амьдардаг өрхийн хэрэглэгчдийг багтаасан. Товчлох үүднээс тайланд "гэр хороолол" гэсэн нэр томъёог ашиглав.

Хүснэгт 1: Тарифын бүтэц

Хэрэглэгчийн төрөл	Сарын тогтмол төлбөр (төгрөг, сард)	Нэгжийн тариф (төгрөг/м ³)	
		Цэвэр ус	Цэвэр ус
Гэр хорооллын хэрэглэгч	Хамаарахгүй	990	-
Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгч	3,000	1,040	760
Усны тоолууртай орон сууцны хэрэглэгч	3,000	710	580

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа.

Тайлбар: Эдгээр тарифт 10%-ийн НӨАТ багтаан ногдуулдаг. Гэр хорооллын иргэд бохир усны төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй.

Ус хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны хэрэглэгчдийн хувьд тариф хоёр хэсгээс бүрддэг, тухайлбал, усны үйлчилгээний сар тутмын тогтмол хураамж болоод ашигласан усны эзлэхүүнээр тооцдог тарифаас бүрддэг.

Хэдийгээр ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон бүх хэрэглэгч ижил төстэй усны үйлчилгээг авдаг боловч усны тоолуургүй хэрэглэгчдийн хувьд тогтоосон цэвэр усны тариф 46 орчим хувиар, бохир усны тариф 31 орчим хувиар өндөр байдаг нь тарифын бүтцийн нэг онцлог байна. Усны тоолуургүй хэрэглэгчдийн хэрэглэсэн усны хэмжээг Эрүүл мэндийн сайд болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан А/333/А/245 тушаалаар ¹⁸ баталсан ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээ болох нэг хүн хоногт 200 литр (200 литр/хүн/хоног буюу өрхийн нэг гишүүн сар тутам 6 куб метр ус хэрэглэсэнтэй тэнцэнэ) хэрэглэнэ гэсэн стандарт хэрэглээг нийлүүлэгч байгууллагын бүртгэлд байгаа тухайн өрхийн гишүүний тоо, тухайн сарын өдрөөр үржүүлэн тооцож гаргадаг. ХСУХАТАУ33-ийн холбогдох албан тушаалтны тайлбарласнаар “хэрэглэгчдийн тоолууржуулсан усны хэрэглээг хангах, цэвэр усны бодит хэрэглээг үнэн зөв тодорхойлох, тоолуур хэрэглэсэн хэрэглэгчдийг урамшуулах”-д ¹⁹ уг бодлогын зорилго оршиж байна. Энэхүү практик нь орон сууцны хэрэглэгчдийн ус хэтрүүлэн хэрэглэсэн тохиолдолд нийлүүлэгч байгууллагыг орлогын томоохон алдагдлаас урьдчилан сэргийлдэг байна. Учир нь зарим нь орон сууцны хэрэглэгчид гэр хороололд амьдардаг хамаатан саднаа хувцас угаах, усанд орохоор гэртээ урьдаг хэмээн фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр дурдсан.

¹⁸ Эрүүл мэндийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаал Дугаар А/333/А/245 (2017 оны 8 дугаар сарын 30). Уг тушаалд ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээг “төвлөрсөн ус хангамжтай өрхийн хувьд нэг хүн хоногт 200 литр, төвлөрсөн бус ус хангамжтай өрхийн хувьд нэг хүн хоногт 50 литр... байхаар тогтоосон бөгөөд ингэхдээ нийт усны хэмжээг хоол хүнс бэлтгэх, сав суулга угаах, хувийн ариун цэвэр сахиу, угаалга, цэвэрлэгээ, султуурт” зэргээр задалж нарийн заасан байдаг. ЗНТТ Даалгавар 2.1: Бодлогын болон тоо мэдээллийн тойм судалгаа.

¹⁹ ХСУХАТАУ33-ийн Үнэ тариф, судалгааны газрын дарга Ж. Гэрэлчулууны тайлбарласнаар

ОУСНААУГ-аас ХСУХАТАУ33-д гаргаж өгсөн тайлангаас харахад ОУСНААУГ нь 2020 оны 12 дугаар сард 88,643 усны тоолууртай хэрэглэгч, 23,169 усны тоолуургүй хэрэглэгчдийг ахуйн усаар хангажээ. Эдгээр тооноос харахад ОУСНААУГ-ын хэрэглэгчдийн амьдардаг орон сууцны 26% нь, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцны хэрэглэгчдийн 11.2% нь (Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр нийт 205,200 сууцаас 23,169 сууц шугамд холбогдсон байна) усны тоолуургүй байна. УСУГ усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийг мөн адил цэвэрлүндны усаар хангадаг тул бодит хувь хэмжээ арай өндөр байна.

Гэр хорооллын оршин суугчид УТБ-аар үйлчлүүлж ус авахдаа хэрэглэсэн хэмжээгээр төлбөрөө тухай бүр төлж байдаг. Үйлчилгээний түвшин, өртөг нь УТБ-ны төрлөөс буюу төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон эсвэл зөөврийн ус хангамжтай, мөн эсвэл ухаалаг картаар ажилладаг эсвэл түгээгчтэй зэргээс хамаарч өөр өөр байдаг хэдий ч нэг литр усны тариф ижил түвшинд буюу 1 төгрөг байдаг.

КОВИД-19 цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний хүрээнд саяхан Монгол Улсын Засгийн газар бүх өрхийн цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг төрөөс хариуцан төлөх шийдвэр гаргаж²⁰ 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл УТБ-д үнэгүй ус түгээхээр болсон.

2.5 Тайлангийн бүтэц

Тайлан долоон бүлгээс бүрдэнэ. Эхний хоёр бүлэгт Судалгааны зорилго, зорилтууд, судалгааны арга зүй, цэвэр ус хангамжийн өнөөгийн нөхцөл байдал, Улаанбаатар хотын хэрэглэгчдийн нийгэм, эдийн засгийн үндсэн шинж байдлыг танилцуулсан болно. Нийгмийн тусламжийн буюу хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрт хамрагдах боломжтой ядуу буюу хүн амын амьжиргааны баталгаажих түвшнээс доош орлоготой эсвэл КОВИД-19 цар тахлын улмаас сөрөг нөлөөлөлд өртсөн хэрэглэгчдийн дэд ангиллуудыг мөн тодорхойлсон болно. Гуравдугаар бүлэгт өрхийн түвшин дэх хэрэглэгчийн усны хэрэглээний хэв маяг, мөн нэг хүний хоногийн хэрэглээг тодорхойлох хүчин зүйлүүдэд дүн шинжилгээ хийв. Тайланд ус хангамжийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдардаг хэрэглэгчид болон усны УТБ-наас ундны усаа авдаг гэр хорооллын хэрэглэгчдийн дунд байдаг хэт ялгаатай байдлыг харуулав. Түүнээс гадна тус судалгаагаар орон сууцанд амьдардаг усны тоолуургүй хэрэглэгчид төлбөр нэхэмжилсэн хэмжээгээр ус хэрэглэж байгаа эсэхийг судалж, алдагдсан боломжийн өртөг нь гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээнд хэрхэн нөлөөлж байгааг судалж үзсэн. Энэ бүлэгт усны хэрэглээ нь хангалтгүй байгаа эмзэг бүлгийн хэрэглэгчдийн тоо үнэлж, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн онцлог шинж чанарыг тодорхойлохын зэрэгцээ амьжиргаа тэтгэх тарифыг нэвтрүүлэх боломжийг авч үзсэн.

Дөрөвдүгээр бүлэгт усны үйлчилгээ, чанар, үйлчилгээг сайжруулах тухай хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг тайлбарласан болно. Шинжилгээнд усны хэрэглээний сарын түвшнээр тодорхойлсон орон сууцны хэрэглэгчдийн дөрвөн бүлэг, мөн ундны усны гол эх үүсвэр болгон ашиглаж буй УТБ-ны төрлөөр тодорхойлсон дөрвөн бүлгийн өрхийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг илүү нарийвчлан судалсан. Тавдугаар бүлэгт хэрэглэгчдийн ус хэмнэх хандлагыг танилцуулахын зэрэгцээ ус хангамжийн үйлчилгээний чанарыг сайжруулахад гэр хорооллын хэрэглэгчдийн ТТЭ-ийн түвшин

²⁰ Өмнөх оны тухайн сард хэрэглэгчийн төлсөн мөнгөн дүн хүртэлх хэмжээгээр.

болон тодорхойлох хүчин зүйлс, мөн гэр хорооллын болон орон сууцны хэрэглэгчдийн усны хязгаарлалт тогтоохоос зайлсхийхэд ТТЭ-ийн түвшин болон тодорхойлох хүчин зүйлсийг тодорхойлов. Дөрөвдүгээр бүлэгт тодорхойлсон хэрэглэгчдийн бүлгүүдээр үр дүнг сарын усны хэрэглээний түвшин, ундны усны гол эх үүсвэр болгон ашигладаг УТБ-ны төрлөөр илүү нарийвчлан судалж үзэв. Зургаадугаар бүлэгт цэвэр, бохир усны төлбөрийн өрхийн орлогод үзүүлж буй санхүүгийн дарамттай холбоотой хэд хэдэн үзүүлэлтийг авч үзэхийн зэрэгцээ тарифын бүтэц, тооцооны аргаас үүдэх магадлалтай хэрэглэгчийн худалдан авах чадварын асуудлыг авч үзэв. Түүнчлэн төлбөр төлөхөд тулгарч буй бэрхшээл, тарифын түвшний тухай хэрэглэгчдийн санаа бодлыг тусгахын сацуу хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн талаарх тэдгээрийн санал бодлын талаар энэ бүлэгт мөн тусгасан. Долоодугаар бүлэгт холбогдох талуудад гаргаж буй зөвлөмжийг тусгав.

Хавсралт 1-д мэдээлэл цуглуулах аргыг тайлбарласан бол Хавсралт 2-т өрхийн судалгааны хэрэгжилтийг (тэр дундаа судалгааны түүвэрлэлт, өгөгдлийн нийцтэй байдлын шалгалтыг багтаан) нарийвчлан тусгав. Хавсралт 3-д ТТЭ-ийн судалгааны асуулгын хуудсыг бүрэн эхээр харуулав. Хавсралт 4-т энэхүү тайланд танилцуулсан таамаглалууд, цаашид судлах боломжтой гэж үзсэн сэдвийг жагсаав. Хавсралт 5-т тайланд ашигласан эх сурвалжийн жагсаалтыг оруулав.

3. ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨРӨЛ БА НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ

Энэхүү бүлэг нь Ажлын даалгавар 1-ийн Зорилт 4-т чиглэсэн болно: Хэрэглэгчийн худалдан авах чадварыг нарийвчлан судлахад шаардлагатай өрхийн орлогын болон нийгэм, хүн ам зүйн мэдээллийг цуглуулах (Ажлын даалгавар 2 – Худалдан авах чадвар болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн судалгаа).

Ажлын даалгавар 2 – Худалдан авах чадвар болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн судалгааны хэсэг болох худалдан авах чадварыг нарийвчлан судлахад шаардлагатай хэрэглэгчдийн **өрхийн орлогын түвшин болон нийгэм хүн ам зүйн** шинж чанартай холбоотой түүвэр судалгааны үр дүнг энд танилцуулна. Энэ хэсэг нь хэрэглэгчдийн төрөл, тэдгээрийн хоорондын онцлог шинж чанарын талаар нарийвчилсан дүр зургийг өгөх болно. Ингэснээр тайланд бүлгүүдийн зан төлөв, нөхцөл байдлын талаар дурдагдахад эндээс мэдэх боломжтой. Усны хэрэглээг өрхийн түвшинд хэмжиж, тооцдог тул бид “хэрэглэгч”, “өрх” гэсэн нэр томъёог ижил утгатайгаар ашиглаж байгааг анхаарна уу.

3.1 Өрхийн нийт орлого болон нэг хүнд ногдох өрхийн орлого

Гэр хорооллын хэрэглэгчдийн орлого нь орон сууцны хэрэглэгчдийн орлогоос дунджаас бага байна. Хүснэгт 2-т үзүүлсэн ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс харахад **орон сууцны хэрэглэгчдийн өрхийн сарын дундаж орлого нь 1.7 сая төгрөг (ойролцоогоор 588 ам.доллар²¹) байгаа бол гэр хорооллын хувьд 1 сая төгрөг (348 ам.доллар)-өөс арай бага байна.** Энэ нь бүх орон сууцны оршин суугчид гэр хорооллын оршин суугчдаас илүү өндөр орлоготой эсэн үг биш юм. Орон сууцны өрхийн сарын нийт орлогын тархалт орлогын дээгүүр түвшний нэгдүгээр аравны нэгээсээ доогуур түвшний аравдугаар аравны нэг хүртлээ гэр хорооллын өрхийн орлогын хүрээтэй давхцаж байна (Хүснэгт 2 болон Зураг 1-ийг харна уу). Зураг 1-т харуулснаар дээгүүр түвшний өрхийн орлого нь өрхийн усан хангамжийн эх үүсвэртэй холбогдсон байхтай хамааралтай байгаа бол доогуур түвшний орлоготой өрхүүд нь холбогдсон байх магадлал багатай буюу өрхүүдийн хамгийн бага орлоготой аравны нэг хэсгийн 20 хувиас бага нь төвийн усан хангамжид холбогдсон байна.


Хүснэгт 2: Хэрэглэгчийн төрлөөр өрхийн сарын орлогын түвшин (төгрөгөөр)

Хэрэглэгчийн төрөл	Дундаж	Медиан	Доод хязгаар ¹	Дээд хязгаар ¹
Гэр хорооллын хэрэглэгч	994,351	780,000	320,000	1,860,000
Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгч	1,438,666	1,000,000	350,000	2,528,000
Усны тоолууртай орон сууцны хэрэглэгч	1,707,671	1,200,000	490,000	3,000,000

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: 1. Доод болон дээд хязгаарыг орлогын бодит хязгаарыг төлөөлөх чадвар багатай орлогын хамгийн доод болон дээд түвшний 10%-ийг хассаны дараа тооцоолов.

²¹ 2021 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 1 төгрөг = 0.00035 ам.доллар гэсэн ханшаар тооцов. Тайланд бүхэлд нь энэ ханшийг ашигласан болно.




Зураг 1: Хэрэглэгчдийг нэг хүнд ногдох орлогын аравтын ангиллаар болон усан хангамжийн холболтын төрлөөр харуулав

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

3.2 Өрхийн ам бүлийн тоо

Олон ам бүлтэй өрхүүд нь илүү их хэмжээний ус хэрэглэж байна. Орон сууцны өрхүүд нь ихэнхдээ гэр хорооллын өрхүүдээс ам бүл цөөн байна. ТТЭ-ийн судалгаагаар гэр хорооллын өрхийн дундаж ам бүлийн тоо 2.9 байгаа бол орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийнх 2.3, тоолууртай хэрэглэгчдийнх 2.7 байна²². Зураг 2-т танилцуулж буй үр дүнгээс харахад орон сууцны усны тоолуургүй өрхүүд нь ихэвчлэн цөөн ам бүлтэй буюу ганц хоёр гишүүнтэй бол гэр хорооллын өрхийн ам бүл нь тав эсвэл түүнээс олон гишүүнтэй байх магадлал өндөр байна. Гэхдээ тав болон түүнээс олон гишүүнтэй өрхүүдийн гуравны нэг нь (33.7%) нь орон сууцны усны тоолууртай өрхүүд байгааг анхаарууштай.




Зураг 2: Хэрэглэгчдийг өрхийн ам бүлийн тоогоор харуулав

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

²² Эдгээр үр дүн нь Улаанбаатар хотын өрхүүд нь дунджаар ҮСХ 2020 Хүн ам, орон сууцны улсын тооллогын дагуух улсын дундаж өрхийн ам бүлийн тоо болох 3.9-өөс бага ам бүлтэй болохыг харуулж байна.

3.3 Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй 23 , хараат байдлын харьцаа өндөр өрхүүд

Илүү олон хүүхэдтэй ба тэднийг тэжээх орлого олдог харьцангуй цөөн хүнтэй өрхүүд нь гэр хороололд амьдрах магадлал өндөр байна. Ядуурал нь хүүхдийн тоо, хараат байдлын харьцаатай их уялдаатай бөгөөд энэ нь гэрт байгаа хүүхдүүдийг дэмжих орлоготой хүмүүсийн тоо хангалтгүй байгааг харуулж байна²⁴. ТТЭ-ийн судалгаагаар Улаанбаатар хотын нийт өрхийн тал хувь нь гэртээ хүүхэдгүй байна. Дунджаар нэг орлого олдог хүн 2.7 өрхийн гишүүнийг тэтгэдэг. Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийн эзлэх хувийг хэрэглэгчийн төрлөөр Зураг 3-т үзүүлэв. Ийм гэр бүл гэр хороололд илүү түгээмэл байдаг. Гэсэн хэдий ч гурваас дээш хүүхэдтэй өрхийн 35% нь усны тоолууртай орон сууцанд амьдардаг.




Зураг 3: 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрхийн хэрэглэгчид

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

3.4 Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх ба хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрх

Эмэгтэй өрхийн тэргүүнтэй эсвэл нэг тэжээгчтэй өрхийн аль нь ч хэрэглэгчийн аливаа нэг ангилал, бүлэгтэй хамааралтай биш бөгөөд аль ч бүлгийг төлөөлөхгүй байна. ТТЭ-ийн судалгаагаар Улаанбаатар хотын өрхүүдийн гуравны нэг нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх (33.9%) боловч ганц бие эцэг, эхтэй өрхүүд харьцангуй цөөн (3.8%) байна. Харин өрхүүдийн 16.6% нь хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрхүүд байна (Зураг 4-ийг харна уу).



²³ Судалгаагаар гурав болон түүнээс дээш хүүхдийг онцолж байгаа нь өрх толгойлсон эх, эцгийн нийгмийн халамжид хамрагдах хүүхдийн тоотой уялдаж байгаа юм (Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль).


²⁴ Ядуурлын дүр төрх 2018 тайлан (Дэлхийн банк, ҮСХ 2020).

Зураг 4: Хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрхийн хэрэглэгчид

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа


3.5 Зөвхөн өндөр настан бүхий эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүд

Зөвхөн өндөр наснаас бүрдсэн өрхүүд нь ихэнхдээ усны тоолуургүй орон сууцанд амьдарч байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүд нь гэр хороололд амьдарч байх нь элбэг байна. Хөгжлийн бэрхшээл болон өндөр нас нь ядууралд өртөх эрсдэл өндөр байхтай холбоотой бөгөөд энэ нь зардал өндөр, орлогын чадвар бага байгааг илэрхийлж байна. Зураг 5, 6-д зөвхөн өндөр настантай өрх (60 болон түүнээс дээш насны хүмүүсээс бүрдсэн) болон хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх (зөвхөн өндөр настантай өрхүүдийг оруулахгүйн тулд 50-аас доош насны хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүдийг тооцсон, учир нь хөгжлийн бэрхшээлийн тархалт нас ахих тусам нэмэгддэг)-үүдийн хэрэглэгчдийн эзлэх хувийг харуулав. **Орон сууцны усны тоолуургүй өрхүүд зөвхөн өндөр настантай өрхүүд байх илүү магадлалтай. 50-иас доош насны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэр хороололд оршин суудаг байх илүү магадлалтай байна.**



Зураг 5: Зөвхөн өндөр настантай өрхийн хэрэглэгчид

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа




Зураг 6: Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн хэрэглэгчид

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

3.6 Өрхүүдийг өрхийн тэргүүний боловсролоор нь ангилсан байдал

Орон сууцанд амьдарч буй өрхийн тэргүүнүүд нь гэр хороололд амьдарч буй өрхийн тэргүүнүүдээс ихэнхдээ илүү өндөр түвшний боловсрол эзэмшсэн байна. Зураг 7-д өрхийн тэргүүний боловсролын түвшнийг хэрэглэгчийн төрөл бүрээр харуулав. **Орон сууцанд амьдарч буй усны тоолууртай болон тоолуургүй өрхийн тэргүүд илүү дээд боловсрол эзэмшсэн байх магадлалтай байхад дийлэнх гэр хороололд амьдарч буй өрхийн тэргүүдийн хамгийн дээд түвшний эзэмшсэн боловсрол нь бүрэн дүнд боловсрол байна.** Гэр хорооллын өрхийн тэргүүдийн бараг таван хүн тутмын нэг нь зөвхөн бага эсвэл дунд боловсрол эзэмшсэн байна.



Зураг 7: Хэрэглэгчдийг өрхийн тэргүүний боловсролоор ангилсан байдал

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

3.7 Ядуу өрхүүд


Таван ядуу өрх тутмын дөрөв нь гэр хороололд амьдардаг бөгөөд тэд гэр хорооллын нийт өрхийн хүн амын дөрөвний нэгээс илүүг эзэлдэг. Улаанбаатар хотын албан ёсны ядуурлын шугамыг ҮСХ тодорхойлдог. Энэ нь Улаанбаатар хотын амьжиргааны доод түвшинтэй²⁵ уялдаатай бөгөөд 2020 онд нэг хүний 230,000 төгрөг, 2019 онд 217,900 төгрөг байв. ТТЭ-ийн судалгаа нь өрхийн амьжиргааны түвшнийг шууд хэмждэггүй. Гэсэн хэдий ч Хавсралт 2-т тайлбарласны дагуу 2019 оны 12 дугаар сард нэг хүнд ногдох өрхийн орлогын талаар цуглуулсан мэдээлэл нь нэг хүнд ногдох хэрэглээний түвшинд үндэслэсэн өрхийн амьжиргааны түвшний талаарх ҮСХ-ны мэдээлэлтэй нийцэж байна. Үүний дагуу **энэхүү судалгаанд нэг хүнд ногдох орлого нь 2019 оны амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхүүдийг ядуу гэж тодорхойлов.**

Төлбөр төлөх эрмэлзлийн судалгаагаар цуглуулсан мэдээллээр 2019 оны 12 дугаар сарын Улаанбаатар хотын ядуурлын хэмжээ 26.55 байсан (хэдийгээр түүвэр судалгааг 2020 онд хийсэн ч судалгаанд оролцогчдын КОВИД-оос өмнөх орлогын түвшнийг

²⁵ Монгол Улсын хүн амын амьжиргааны доод түвшинг тогтоох тухай хуулийн (1998 оны) 3 дугаар зүйлд зааснаар үндсэн хэрэгцээг хангах мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн хэрэглээний доод түвшинг хэлнэ гэжээ. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооноос нэг хүнд ногдох 2100 калорийн үндсэн дээр хүнийг эрүүл, идэвхтэй амьдрал, хүнсний энерги, үндсэн бараа, үйлчилгээгээр хангахад шаардагдах зардлын доод хэмжээг тодорхойлдог.

тодорхойлох зорилгоор тэдний 2019 оны орлогыг асуусан). Энэ нь нэг хүнд ногдох орлогын түвшин 2019 оны амьжиргааны доод түвшнээс доогуур байгаа хүн амын (өрхийн бүх гишүүд) эзлэх хувьтай нийцэж байна. Энэ түвшин нь өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгаанд үндэслэн ҮСХ-ны тооцоолсон 25.9%-ийн түвшинтэй ойролцоо байна.

Мөн ижил төрлийн мэдээлэлд үндэслэн ТТЭ-ийн судалгаанаас харахад **Улаанбаатар хотын ядуу өрхийн эзлэх хувь 2019 онд 18.9% байсан**. Доорх Зураг 8-д хэрэглэгчдийн төрлөөр ядуу өрхийн эзлэх хувийг харуулав. **Ядуу таван өрх тутмын дөрөв нь гэр хороололд амьдарч байна**. Сүүлийн жилүүдэд гэр хорооллын ядуурлын түвшин өндөр байгаа мөн хот суурин газрын орлогын өсөлтийн тэгш бус байдал нь бага орлоготой гэр бүлүүд орон сууцанд амьдрах боломжгүй болж, эдгээр хоёр ангиллын хэрэглэгчдийн амьжиргааны түвшний зөрүү улам бүр нэмэгдэх асуудал үүсгэж байна.²⁶



Зураг 8: Ядуу өрхийн хэрэглэгчид

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

3.7.1 Ядуурлын хамаарал

Доор тайлбарласан пробит шинжилгээ нь ядуурлын нийгэм эдийн засгийн хамаарлыг тодруулж өгсөн болно. Ам бүл олонтой өрхүүд, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрхүүд, эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүд, болон хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрхүүд нь ядуу байх магадлал илүү өндөр байна. Зөвхөн өндөр настантай өрхүүд, ажилтай хүн ба өрхийн ам бүлийн харьцаа илүү өндөр өрхүүд, дээд боловсролтой өрхийн тэргүүнтэй өрхүүд, болон орон сууцанд амьдардаг усны тоолууртай болон тоолуургүй өрхүүд нь ядуу байх магадлал илүү бага байна. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүдийн ядуу байх магадлалтай холбоотой нотолгоо байхгүй байна.

Хүснэгт 3: Ядуу өрхүүдийн нийгэм эдийн засгийн шинж чанаруудын талаарх пробит шинжилгээ

Тайлбар: Тод үсгээр бичсэн эерэг коэффициент нь бусад бүх зүйл ижил байхад ийм шинж чанартай өрхүүд ядуу байх магадлал өндөр байгааг харуулж байна. Тод үсгээр бичсэн сөрөг коэффициент нь бусад бүх зүйл ижил байхад ийм шинж чанартай өрхүүд ядуу байх магадлал бага байгааг харуулж байна. Бусад тохиолдолд шинжилгээ нь тодорхой үр дүнд хүрээгүй байна.

²⁶ Uochi, Ikuko болон бусад (2020) Ядуурлын дүр төрх 2018: “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2018”-ны үндсэн тайлан. <https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/532121589213323583/mongolia-poverty-update-2018>.

Хувьсагч	Коэф.	Ст. хазайлт.	P>z
Өрхийн ам бүлийн тоо	0.20	0.0213	0.00
3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.13	0.0763	0.10
Зөвхөн өндөр настантай өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-1.85	0.2086	0.00
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.09	0.0793	0.24
Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.26	0.0615	0.00
Хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.25	0.0575	0.00
Ажилтай хүний тоо ба өрхийн ам бүлийн тооны харьцаа	-1.61	0.1273	0.00
КОВИД-19 хямралын улмаас орлого нь буурсан (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.46	0.0693	0.00
КОВИД-19 хямралын улмаас орлого нь нэмэгдсэн (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.25	0.0587	0.00
Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгч (гэр хорооллын хэрэглэгчтэй харьцуулахад)	-0.54	0.1337	0.00
Усны тоолууртай орон сууцны хэрэглэгч (гэр хорооллын хэрэглэгчтэй харьцуулахад)	-0.68	0.0580	0.00
Өрхийн тэргүүн бүрэн дунд боловсрол эзэмшсэн (бага болон дунд боловсрол эзэмшсэнтэй харьцуулахад)	-0.05	0.0846	0.56
Өрхийн тэргүүн дээд боловсрол эзэмшсэн (бага болон дунд боловсрол эзэмшсэнтэй харьцуулахад)	-0.48	0.0928	0.00
Тогтмол утга	-0.48	0.1286	0.00
Ажиглалтын тоо	4,199		
LR chi2(13)	1,325.4		
Prob > chi2	0.0000		
Pseudo R2	0.284		


3.7.2 КОВИД-19 хямралын орлогод үзүүлэх нөлөө

Засгийн газрын дэмжлэг нь КОВИД-19 хямралын ядуу өрхүүдэд үзүүлж буй нөлөөллийг бууруулж байна. ТТЭ-ийн судалгаа нь цар тахлын өрхийн орлогод үзүүлж буй нөлөөллийн талаарх мэдээллийг цуглуулсан. Хачирхалтай нь орлогод нь *зэрэг* нөлөө үзүүлсэн гэж мэдээлсэн өрхүүд илүү ядуу байх магадлалтай байна. Энэхүү нөхцөл байдал нь Монгол улсын Засгийн газраас цар тахлын нөхцөл байдлын нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор хэрэгжүүлсэн хэд хэдэн нийгмийн халамжийн арга хэмжээнүүдтэй холбоотой юм. Үүнд Хүүхдийн мөнгө хөтөлбөр, хүнсний талон, мөн бусад ажилгүйдлийн болон нийгмийн халамжийн тэтгэмжийн дүн нэмэгдсэн зэрэг багтана. Дунджаар хамгийн ядуу өрхүүд цар тахлын өмнөх үеийн орлогынхоо 40%-тай тэнцүү

хэмжээний орлогын дэмжлэг авсан.²⁷ Харин тогтмол цалингаа үргэлжлүүлэн авч, ядуу байх магадлал багатай цалинтай ажилчдад эдийн засгийн хямрал илүү их нөлөөлсөн. **2020 оны эхний улиралд бараг таван өрх тутмын хоёр нь цалингийн орлого нь буурсантай тулгарсан.**²⁸

3.8 Сонгогдсон нийгэм эдийн засгийн бүлгүүд

Энэхүү тайланд ядуу өрх, нийгмийн онцгой хэрэгцээтэй хэрэглэгчид, КОВИД-19 цар тахал сөргөөр нөлөөлсөн хэрэглэгчдэд тарифын өсөлтөөс үүдэн үүсэж болох сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой нийгмийн халамж эсвэл хэрэглэгчид дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт хамрагддаг (3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх, хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрх, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх, зөвхөн өндөр настантай өрх, хүнсний талон авдаг²⁹) эсвэл хамрагдах магадлалтай хэрэглэгчдийн (ядуу өрх, КОВИД-19 хямралын улмаас орлого нь багассан өрх) дэд бүлгүүдээр ТТЭ-ийн судалгааны үр дүнг танилцуулж байна. Зураг 9 нь хэрэглэгчийн төрөл бүрд эзлэх бүлгүүдийн хувийг харуулж байна. Эдгээр бүлгүүдийн зарим нь харьцангуй бага хувь эзэлж буй тул бүлгүүдийн үр дүнг бусад бүлэгтэй харьцуулах, болон хэрэглэгчийн төрлөөр нийт өрхийн хүмүүстэй харьцуулахдаа эдгээр үр дүн нь түүврийн тархалтын алдаатай байх магадлалтай гэдгийг санах нь зүйтэй.



Зураг 9: Хэрэглэгчдийн төрлөөр сонгогдсон хэрэглэгчийн бүлгүүд (хэрэглэгчийн төрөл бүр дээр өрхүүдийн эзлэх хувь)

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

²⁷ “Корона вирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа”- гуравдах шатны үр дүн. Дэлхийн банк –ҮСХ.

²⁸ Дээрх судалгаанд.

²⁹ Энэ хөтөлбөр нь өрхүүдийн хамгийн ядуу 5%-ийг хамруулдаг. Ядуурлын дүр төрх 2018 тайлан (Дэлхийн банк, ҮСХ).

4. ӨРХИЙН УС ХАНГАМЖИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ БА ӨРХИЙН УСНЫ ХЭРЭГЛЭЭ

Энэ хэсэгт хэрэглэгчдийн усны хэрэглээний хэв маягийг өрхийн түвшинд сараар, нэг хүнд ногдох хэрэглээг өдрөөр авч үзсэн болно. Ялангуяа орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчид 200 л/хүн/өдөр (төлбөр тооцоонд ашигладаг стандарт) хэмжээний их ус хэрэглэдэг эсэхийг шалгаж, мөнгөн бус зардал нь гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээнд хэрхэн нөлөөлдөг болохыг судлах юм. Тус мэдээлэлд үндэслэн энэхүү судалгаа нь усны хэрэглээ хангалтгүй байгаа эмзэг бүлгийн хэрэглэгчдийн тоог гарган, нийгэм, эдийн засгийн бүтцийг тодорхойлж, үүний дагуу шаталсан тариф болон амьжиргаа тэтгэх тарифын тогтолцоог нэвтрүүлэх боломжийг хэлэлцэх юм.

4.1 Усны хүртээмж болон хэрэглээний тэгш бус байдал

Хэрэглэгчдийн тал орчим хувь нь төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдардаг бол үлдсэн тал нь гэр хороололд амьдардаг, УСУГ-аас ус нийлүүлдэг УТБ, цөөн тооны хувийн худаг болон булаг, шанд зэрэг байгалийн усны эх үүсвэрээс ус авдаг хэрэглэгчид юм. Энэхүү хоёр бүлгийн усны хүртээмж болон хэрэглээний эрс ялгаатай байдал нь нийгмийн тэгш бус байдлын асуудал³⁰ үүсгэж, ялангуяа тарифын өсөлтийн усны эрэлт хэрэгцээнд үзүүлэх нөлөөллийг анхаарч үзэхэд хүргэж байна.

ТТЭ-ийн судалгаагаар хотын ядуу хүмүүсийн 80% нь амьдардаг гэр хороололд амьдарч буй өрхүүдийн усны хэрэглээ (Бүлэг 2-ыг бүлгийг харна уу) орон сууцны хэрэглэгчдийн усны хэрэглээнээс дунджаар 7-10 дахин бага байна. Хүснэгт 4-т харуулснаар гэр хороололд амьдардаг нэг өрх сард 1.2 куб метр ус худалдаж авдаг. Гэтэл орон сууцанд амьдардаг дундаж тоолууртай өрх 8.3 куб метр ус хэрэглэдэг ба орон сууцанд амьдардаг өрхүүд сард дунджаар 11.4 куб метр усны төлбөр төлдөг гэжээ.

Хүснэгт 4: Өрхийн сарын усны хэрэглээ (м³)

Хэрэглэгчийн төрөл	Дундаж	Медиан	Доод хязгаар ¹	Дээд хязгаар ¹
Гэр хорооллын хэрэглэгч	1.2	0.9	0.4	2.2
Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгч ²	11.4	10	2	24
Усны тоолууртай орон сууцны хэрэглэгч	8.3	7	3	15
Хэрэглэгчдийн дундаж	4.5	1.7	0.5	12

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: 1. Доод болон дээд хязгаарыг усны хэрэглээний бодит хязгаарыг төлөөлөх чадвар багатай хамгийн доод болон дээд түвшний 10%-ийг хассаны дараа тооцоолов. 2. Усны хэрэглээ нь нэхэмжлэл дээр гардаггүй тул хэрэглэгчдийн мэдээлсэн усны хэрэглээ нь нэхэмжилсэн болон бодит хэрэглээний холимог дүн юм.

ТТЭ-ийн судалгаагаар нэг хүнд ногдох өрхийн хоногийн усны хэрэглээний хувьд гэр хорооллын хэрэглэгчдийн 80% нь 6-29 л/хүн/өдөр -ийн хооронд хэрэглэдэг гэжээ. Тэдний тал хувь нь 14 л/хүн/өдөр -ээс бага хэрэглээтэй байгаа нь нэг хүнд ногдох усны

³⁰ Ажлын удирдамж, Улаанбаатар хотын ус хангамжийн тогтвортой байдлыг хангах Зардал нөхөх техник туслалцаа (ЗНТТ)

хоногийн дундаж хэрэглээ 17 л/хүн/өдөр гэсэн үг. Энэ нь өмнөх судалгаанд³¹ дурдагдсан 5-10 л/хүн/өдөр гэсэн тоотой харьцуулахад илүү өндөр түвшинд байна. Гэр хорооллын усны хэрэглээ гэдэг нь судалгаанд хамрагдагсдын тооцоолсон өрхийн шууд хэрэглээг (УТБ-аас худалдаж авах эсвэл бусад эх үүсвэрээс авах - гол төлөв хувийн худгаас) хэлэх бөгөөд айл өрхүүд халуун усны газар, хувцас угаалгын газраар дамжуулан хэрэглэсэн усыг тооцдоггүй. Тиймээс энэ дүнг усанд орох, угаалга хийхэд ашигласан усны хэрэглээг багтаасан орон сууцны оршин суугчдын хэрэглээтэй шууд харьцуулах боломжгүй юм. 4.1.3 дугаар хэсэг нь гэр хорооллын хэрэглээний хэв маягийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг өгөх болно.

Хүснэгт 5: Нэг хүнд ногдох өдрийн дундаж усны хэрэглээ (литр)

Хэрэглэгчийн төрөл	Дундаж	Медиан	Доод хязгаар ¹	Дээд хязгаар ¹
Гэр хорооллын хэрэглэгч	17	14	6	29
Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгч ²	193	167	33	400
Усны тоолууртай орон сууцны хэрэглэгч	122	100	33	233
Хэрэглэгчдийн дундаж	67	9	7	167


Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: 1. Доод болон дээд хязгаарыг усны хэрэглээний бодит хязгаарыг төлөөлөх чадвар багатай хамгийн доод болон дээд түвшний 10%-ийг хассаны дараа тооцоолов. 2. Усны хэрэглээ нь нэхэмжлэл дээр гардаггүй тул хэрэглэгчдийн мэдээлсэн усны хэрэглээ нь нэхэмжилсэн болон бодит хэрэглээний холимог дүн юм.

4.1.1 Орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн усны хэрэглээ


Орон сууцны Тоолууртай орон сууцны өрхийн усны хэрэглээний шинжилгээнээс харахад усны хэрэглээний түвшнээр тодорхойлогдсон хэрэглэгчийн бүлэг хоорондын ялгаа харьцангуй их байна. **Цөөн тооны хэрэглэгчид (12%) усны эрэлтийн 31%-ийг бүрдүүлдэг.** Бусад хэрэглэгчдийг ойролцоогоор ижил хэмжээний гурван бүлэгт хувааж болно. **Эдгээр бүлгүүдийн нэг хүнд ногдох усны хэрэглээ нь 58-234 л/хүн/өдөр хооронд их хэмжээгээр хэлбэлзэнэ** (Зураг 10, 11-ийг харна уу).

³¹ Э.Гавел, К.Сигел, В. Бретшнайдер нар (2011). Монгол улсын ус хангамжийн худалдан авах чадвар: Худалдан авах чадварыг хэмжих эмпирик сургамжууд. (№. 9/2011). Хельмгольц Байгаль орчны судалгааны төв хэлэлцүүлгийн баримт бичиг; Түргэвчилсэн үнэлгээ. Их сургуулийн судалгаа компани ХХК (URC), Монголын Маркетингийн Зөвлөх Үйлчилгээний групп, 2016.



Зураг 10: Усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн бүлгийн (өрхийн сарын усны эрэлтээр) усны эрэлтийн эзлэх хувь


Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа



Зураг 11: Усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн нэг хүнд ногдох өдрийн усны хэрэглээ (өрхийн түвшний сарын усны эрэлтээр)


Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Өрхийн нийгэм, эдийн засгийн шинж байдлын хувьд усны хэрэгцээ хамгийн өндөр байгаа хоёр бүлэг нь таамагласны дагуу олон ам бүлтэй, хүүхэдтэй өрхүүд болон зөвхөн өндөр настантай байх магадлал багатай өрхүүд байна. Сонирхолтой нь энэ үзүүлэлтэд орон сууцны тоолууртай ядуу өрхийн талаас илүү хувь нь (54.7%) багтаж байна.



Зураг 12: Өрхийн түвшний сарын усны хэрэглээгээр харуулсан усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн өрхийн хүн ам зүйн байдал

Эх сурвалж: ТТЭ судалгаа



Зураг 13: Өрхийн түвшний сарын усны хэрэглээгээр харуулсан усны тоолууртай орон сууцны зөвхөн өндөр настантай болон ядуу өрхүүд

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

4.1.2 Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн нөхцөл байдал

Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн усны хэрэглээг тооцоход ашигладаг төлбөрийн аргачлалаас үүдэж эдгээр хэрэглэгчдийн нөхцөл байдалд тусгайлсан анхаарал хандуулах шаардлагатай байна.

Оршил хэсэгт тайлбарласнаар хэдийгээр төвийн ус хангамжийн шугам сүлжээнд холбогдсон бүх хэрэглэгч ижил төстэй усны үйлчилгээ авдаг боловч төвийн шугамд холбогдсон усны тоолуургүй хэрэглэгчдийн цэвэр усны төлбөр 46%-иар, бохир усны төлбөр ойролцоогоор 31%-иар илүү их байна. Түүнчлэн эдгээр хэрэглэгчдийн хэрэглэсэн усны хэмжээг ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээ болох нэг хүн

хоногт 200 литр (200 л/хүн/хоног буюу өрхийн нэг гишүүн сар тутам 6 куб метр ус хэрэглэсэнтэй тэнцэнэ) хэрэглэнэ гэсэн стандарт хэрэглээг хангагч байгууллагын бүртгэлд байгаа тухайн өрхийн гишүүний тоогоор үржүүлэн тооцож гаргадаг.

Хэдийгээр төлбөрийн нэхэмжлэл дээр хэрэглэсэн усны хэмжээ тусгагддаггүй ч гэсэн ТТЭ-ийн судалгаагаар орон сууцны усны тоолуургүй оршин суугчдаас усны хэрэглээнийх нь дундаж хэмжээг асуусан. Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн усны тооцоолсон төлбөрт тухайн өрхийн гишүүдийн тоог л дурдсан байдаг тул ТТЭ-ийн судалгаагаар зөвхөн усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн усны бодит хэрэглээтэй холбоотой мэдээллийг цуглуулсан. Тиймээс орон сууцанд амьдардаг усны тоолуургүй өрхүүдээс сард хэрэглэдэг усны хэмжээг аль болох бодитоор хариулахыг хүссэн. Эдгээр хэрэглэгчийн зарим нь бодитоор хэрэглэдэг гэж үзсэн усны хэмжээгээ хэлсэн бол зарим нь байрны төлбөрийн баримтад нэхэмжилсэн усны хэмжээг мэдээлсэн байх магадлалтай юм. Тиймээс шинжилгээгээр өгөгдсөн усны тарифын түвшинд тухайн өрхийн усны төлбөрийн дүн хэрэглэгчийн тайлагнасан усны хэрэглээний түвшинтэй тохирч байгаа эсэхийг шалгасан. Тайлагнасан усны хэрэглээний нийцтэй байдлыг шалгасан талаар болон бусад холбоотой мэдээллийг Судалгааны Арга зүйн хэсэг болон Хавсралт 2-оос үзэж болно.

Эдгээр хэрэглэгчид сард дунджаар 11.4 куб метр хэрэглээтэй гэж тайлагнасан ба энэ нь нэг хүний хоногийн 193.3 литр гэсэн үг юм. Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын нэгтгэсэн төлбөр тооцоо болон нийлүүлэлтийн тоон мэдээллээс энэхүү нөхцөл байдал нь орон сууцны усны тоолуургүй оршин суугчид (өөрсдөө хэрэглээгүй усанд төлбөр төлөх), эсвэл дээрх үйлчилгээ үзүүлэгчдийг (оршин суугчдын бодит хэрэглээнээс бага төлбөр авах) хохироож буй эсэхийг тодорхойлж болно. Энэхүү судалгааны дүн шинжилгээ хийх үед уг тоон мэдээлэл нь бэлэн байгаагүй. Тиймээс ТТЭ-ийн судалгаагаар усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчид нь үнэхээр 200 л/хүн/өдөр хэмжээний их ус хэрэглэдэг эсэхийг шалгасан. Судалгаагаар орон сууцны тоолуургүй оршин суугчдын усны төлбөр нь хэт өндөр байж болох хэд хэдэн шалтгаан тодорхойлсон.

Шинжилгээгээр эхлээд нэг гишүүнтэй өрхийн тоолуураар хэмжсэн усны хэрэглээний түвшинг судалсан. Тэд орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн 38%, орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн 26.1%-ийг эзэлдэг. Орон сууцанд амьдардаг нэг гишүүнтэй өрхийн талаас илүү хувь нь (57.3%) 167 л/хүн/өдрөөс бага ус хэрэглэдэг байна.

Хүснэгт 6: Нэг гишүүнтэй орон сууцны усны тоолууртай өрхийн усны хэрэглээ (хоногт нэг хүнд ногдох литр)

	Дундаж	Медиан	Доод хязгаар ¹	Дээд хязгаар ¹
Усны тоолууртай орон сууцны хэрэглэгч	188	167	33	367

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: 1. Доод болон дээд хязгаарыг усны хэрэглээний бодит хязгаарыг төлөөлөх чадвар багатай хамгийн доод болон дээд түвшний 10%-ийг хассаны дараа тооцоолов.

Орон сууцанд амьдардаг усны тоолуургүй хэрэглэгчдийн 30.8%-ийг зөвхөн өндөр настантай өрхүүд бүрдүүлдэг (орон сууцны тоолууртай хэрэглэгчдийн хувьд уг тоо нь 16.5% байна; Хоёрдугаар бүлгээс харна уу) тул шинжилгээ нь хоёрдугаарт зөвхөн өндөр настантай өрхийн тоолуураар хэмжсэн дундаж усны хэрэглээг авч үзсэн. Эдгээр

өрхүүдийн дийлэнх нь нэг эсвэл хоёр гишүүнтэй ба орон сууцны тоолуургүй өрхүүдийн төлбөрийг 200 л/хүн/өдөр-тэй тэнцэх усны хэрэглээгээр тооцож нэхэмжилдэг. Энэ төрлийн орон сууцны усны тоолууртай өрхүүд дунджаар 133 л/хүн/өдөр хэрэглэж байгаа нь усны тоолуургүй орон сууцны ижил төрлийн хэрэглэгчдээс нэхэмжилдэг дүнгээс 33.5% доогуур дүн юм.

Түүнчлэн фокус бүлгийн хэлэлцүүлгээр цуглуулсан өрхийн тайлбаруудаас (Шигтгээ 1, 2-ыг харна уу) харахад төлбөрийг яг тухайн үед амьдарч буй хүмүүсийн бодит тоог ашиглан тооцож буй эсэхэд үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд ч анхаарал хандуулдаггүй ба оршин суугчид нь ч хянах боломжгүй байдаг байна. Тухайлбал гол оролцогч талуудын хэлж буйгаар аливаа өрх нь орон сууц худалдан аваад хороон³² дээрээ бүртгүүлэх хэрэгтэй байдаг. Үүний дараагаар хорооноосоо тодорхойлох захидал аван контортоо³³ авч очиж, шинэ гэрээ байгуулдаг. Гэтэл бодит байдал дээр шинэ оршин суугчид нь контортойгоо гэрээгээ шинэчилдэггүй ба контор ч мөн адил тухайн өрхийн хэмжээ эсвэл эзэд нь өөрчлөгдсөн эсэхийг шалгадаггүй. Энэ нь оршин суугчдад ашиггүй байдаг. ЗНТТ-ны ус, ариун цэврийн инженер зөвлөхийн ажигласнаар контор нь зөвхөн өрхөөс тооцон нэхэмжилж буй усны хэмжээний төлбөр нь үйлчилгээ үзүүлэгчийн хүний тоогоор тооцсон хэрэглээнээс бага тохиолдолд л тухайн өрхийн бүтцийг шалгадаг байна.

Шигтгээ 1: Ганцаарчилсан ярилцлагаас – Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь орон сууцанд амьдардаг усны тоолуургүй хэрэглэгчдийн ам бүлийн тооны өөрчлөлтийг авч үздэггүй

“Бидний өмнө нь амьдарч байсан орон сууц тоолуургүй байсан. Би амаржиж манай ам бүлийн тоо өөрчлөгдөхөд контор энэ талаар мэдээгүй.”

- Баянзүрх дүүргийн орон сууцны оршин суугч 27 настай, эмэгтэй

Түүнчлэн фокус бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс харахад хэрвээ тухайн өрхийн амьдарч буй барилга хэт хуучин, нэг орон сууцанд нэлээн хэдэн усны тоолуур тавих эсвэл нарийн сантехникийн ажил шаардлагатай тохиолдолд **тоолуур суурилуулах нь маш өндөр зардалтай, бараг боломжгүй** болдог байна. Энэ асуудлыг Азийн хөгжлийн банк (АХБ)-ны 2008 онд дууссан “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл”³⁴-ийн гол бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч хэлэлцсэн. Тус төсөл нь хэрэглэгчдийн нөөц ашиглалтыг сайжруулах зорилт тавьж ажилласан боловч хуучин орон сууцуудад тоолуур суурилуулахад тулгарсан инженерийн нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэж чадаагүй юм.

³² Хороо нь Улаанбаатар хотын засаг захиргааны хамгийн жижиг нэгж юм.

³³ Усны үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг хэлнэ (хувийн болон улсын (ОСНААУГ) үйлчилгээ үзүүлэгчдийг аль алиныг хамруулж ойлгоно).

³⁴ Монгол улс: Улаанбаатар хотын дулааны ашгийг нэмэгдүүлэх төсөл, 2008 оны 9 дүгээр сар.
<https://www.adb.org/projects/documents/ulaanbaatar-heat-efficiency-project>

Шигтгээ 2: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс - Тоолууржилт

“Манайх хоёрдугаар 40 мянгатын хуучин орон сууцанд амьдардаг. Бидний амьдардаг орчмын бүх өрхүүдийн тоолуургүй солих сураг дуулдсанаас хойш манай байранд усны тоолуур тавихыг хүлээсээр байна.”

- Чингэлтэй дүүргийн орон сууцны оршин суугч 59 настай, эрэгтэй


“Олон жилийн өмнө айлуудад усны тоолуур суурилуулж өгөхөд би ажил дээрээ завгүй байж байгаад тоолуураа тавиулж чадаагүй. Гэтэл одоо тоолуурын үнэ өсөөд нэг нь 40,000 төгрөг хүрсэн ба бид дөрвийг авах шаардлагатай [...] Гэхдээ би усны тоолуур суурилуулах хэрэгтэй гэсэн бодолтой хэвээр байгаа.”

- Баянзүрх дүүргийн орон сууцны оршин суугч 42 настай, эрэгтэй

“Манай байр хуучин тул анх тоолуур суурилуулахад их хэмжээний сантехникийн ажил шаардлагатай болсон. Бид засвар хийлгэсний дараа тоолуур тавиулахаар шийдэж, хойшлуулсан [...] Бид тоолуургүй учраас контор тэдний бүртгэлд байгаа манай өрхийн гишүүдийн тоог үнэн зөвөөр шинэчлэхээс татгалзсан. Би ганцаараа амьдардаг, ус ч бага хэрэглэдэг.”

- Баянгол дүүргийн орон сууцны оршин суугч 54 настай, эмэгтэй

Батлагдсан норм стандартаар усны хэрэглээний төлбөрийг тооцож байгаа нь усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн санхүүгийн дарамтыг ихээхэн нэмэгдүүлдэг. ТТЭ-ийн судалгаанаас харахад дунджаар орон сууцны усны тоолуургүй өрхүүдийн орлогод эзлэх усны төлбөрийн хувь нь орон сууцны усны тоолууртай өрхүүдээс хоёр дахин их байна (2.4% ба 1.2%). Мөн Хүснэгт 7-д үзүүлснээр санхүүгийн дарамт нь 5% болон түүнээс дээш байх өрхийн эзлэх хувь орон сууцанд амьдардаг усны тоолуургүй өрхүүдийн хувьд (10.5%) тоолууртай өрхүүдээс (3.5%) илүү өндөр байна. Зураг 14-т орон сууцанд амьдардаг тоолуургүй хэрэглэгчдийн өрхийн төсөвт үзүүлэх усны хэрэглээний усны хэрэглээний түвшингээс үл хамааран хэрэглэгчдийн бүх бүлэгт санхүүгийн дарамт нь илүү өндөр ажиглагдаж байгааг харуулав.



Зураг 14: Орон сууцны усны тоолууртай, тоолуургүй хэрэглэгчдийн төрлөөр усны зардлын дундаж эзлэх хувь (өрхийн орлогод эзлэх %)

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Хүснэгт 7: Усны тоолууртай, тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн усны төлбөрийн санхүүгийн дарамт

Хэрэглэгчийн төрөл	Усны зардлын өрхийн орлогод эзлэх дундаж %		Усны зардал нь өрхийн орлогын 5 хувиас илүүг эзэлж буй өрхийн эзлэх хувь		Цэвэр, бохир усны зардал нь өрхийн орлогын 5 хувиас илүүг эзэлж буй өрхийн эзлэх хувь	
	Тоолууртай	Тоолуургүй	Тоолууртай	Тоолуургүй	Тоолууртай	Тоолуургүй
Дундаж	1.2	2.4	2.5	10.4	4	23

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

4.1.3 Гэр хорооллын хэрэглэгчдийн нөхцөл байдал

Гэр хорооллын хэрэглэгчдийн 22.1% нь 143 төвийн шугам сүлжээнд холбогдсон ухаалаг УТБ-аар, 13.4 % нь 180 төвийн шугам сүлжээнд холбогдсон түгээгчтэй УТБ-аар үйлчлүүлдэг бол 57% нь 332 зөөврийн устай УТБ-аас ундны ус авч байна.³⁵ Үлдсэн өрхүүд болох 7.5 орчим хувь нь бусад эх үүсвэрээс, голчлон хувийн УТБ-аас усаа авдаг байна. Ялангуяа гэр хорооллын оршин суугчдын усны худалдан авалтын түвшин доогуур байгаа нь тэдний хэрэглээний түвшинд худалдан авах чадварын асуудал нөлөөлж байж болзошгүйг илэрхийлж байна. Үүний дагуу энэ хэсэгт гэр хорооллын усны хэрэглээнд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт 4-т (3.1 дэх хэсэг) харуулснаар гэр хорооллын хэрэглэгчдийн дийлэнх нь сард 0.4 – 2.2 куб метр ус хэрэглэдэг. Ихэнх өрхүүдийн хувьд энэ хэмжээ нь тэдний усны хэрэглээг бүрэн хангадаггүй. УТБ-аас ундны ус авахаас гадна, гэр хорооллын өрхүүдийн 54.9% халуун усны газар ордог (орон сууцны хэрэглэгчдийн 0.3 %), 14.5% нь савласан ус худалдан авдаг (орон сууцны хэрэглэгчдийн 19.2%) бол 7.4% хувцас угаалгын газраар үйлчлүүлдэг (орон сууцны хэрэглэгчдийн 10%) байна. Эдгээр тохиолдлуудад хэрэглэгддэг усны хэмжээний талаарх мэдээлэл байхгүй тул гэр хорооллын болон орон сууцны хэрэглэгчдийн бодит хэрэглээний зөрүүг тодорхойлох боломжгүй юм. Түүнчлэн фокус бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс харахад эдгээр үйлчилгээ нь нэлээд үнэтэй байдаг байна. Нэг оролцогч халуун усны газрын нэг удаагийн төлбөрийг 4000³⁶ төгрөг болохыг дурдсан (Шигтгээ 3-ыг харна уу). Гэр хорооллын өрхүүдийн 37.7% нь эдгээр бараа, үйлчилгээнд зарцуулсан дүн гэж огт тайлагнаагүй ба тэдний усны бүхий л хэрэгцээг хувийн худаг болон булаг, шанд гэх мэт бусад усны эх үүсвэр хангадаг мэт харагдаж байна.

Эцэст нь фокус бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэлээс зарим өрхүүд орон сууцанд амьдардаг хамаатан садныхаа гэрт усанд орж, хувцас угаадаг байдал ажиглагдаж байгаа боловч ТТЭ-ийн судалгаанаас харахад энэ төрлийн хэрэглээ нь өргөн хүрээтэй биш байна. Гэр хорооллын өрхүүдийн 10 хүрэхгүй хувь нь УСУГ-ын УТБ-аас өөр ундны усны гол эх үүсвэртэй гэж тайлагнасан. Тус өрхүүдийн дийлэнх нь байгалийн нээлттэй эх үүсвэр, эсвэл хувийн худаг ашигладаг бол 10 өрх тутмын зөвхөн нэг нь тогтмол очдог орон сууцны, үйлдвэрийн эсвэл байгууллагын цоргоноос ус авах боломжтой байдаг. Тиймээс **бусад төрлийн усны эх үүсвэрийг тооцож үзсэн ч гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээ онцолж үзэхээр доогуур түвшинд байна.**

³⁵ 2020 оны 1 дүгээр сарын байдлаар УСУГ-ын удирдлагад 655 УТБ байна.

³⁶ Харьцуулахад, 100 литр усны өртөг 100 төгрөг.

Шигтгээ 3: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс– Гэр хорооллын усны хэрэглээ

“Бид баллонтой цэвэр ус ундны зориулалтаар худалдаж авдаг. Харин бусад хэрэглээний усаа УТБ-аас авдаг. Нэг удаад 500 литр ус авахад хангалттай байдаг. Бид таваас зургаан ширхэг 5 литрийн савлагаатай *Дусал* нэртэй усыг худалдан авч хоол, ундандаа ашигладаг.”

- *Баянзүрх дүүргийн гэр хорооллын оршин суугч 22 настай, эрэгтэй*

“Бид долоо хоногт хоёроос гурван удаа халуун усны газар очдог. Дөрвөн том хүн, хоёр хүүхэд ороход 60,000 төгрөг болдог.”

- *Хан-Уул дүүргийн гэр хорооллын оршин суугч 22 настай, эмэгтэй*

“Бид халуун усны газар очдог байсан бол одоо больсон. Хүүхдүүд гэртээ усанд ордог харин томчууд нь орон сууцанд амьдардаг хамаатан садныхаа гэрт очиж усанд ордог.”

- *Баянгол дүүргийн гэр хорооллын оршин суугч 48 настай, эмэгтэй*

“Бид ус халааж гэртээ усанд ордог.”

- *Баянгол дүүргийн гэр хорооллын оршин суугч 64 настай, эмэгтэй*

“Бидэнд (гэр хорооллын оршин суугчид) халуун усны хангамж байхгүй. Халуун усны газар нэг удаа ороход 4,000 орчим төгрөг байдаг. Тэгж бодоход, орон сууцны өрхүүд бага төлдөг. Халуун ванн эсвэл шүршүүрт ороход хүүхэд 3,000 төгрөг, жаахан хүүхэд 2,500 төгрөг, харин нярай хүүхэд үнэгүй байдаг. Гэр бүлээрээ нэг удаа ванн эсвэл шүршүүрт ороход 17,500 төгрөг болдог. Нэг хүн дунджаар 30 минут ордог.”

- *Чингэлтэй дүүргийн гэр хорооллын оршин суугч 39 настай, эмэгтэй*

Хэдий ийм боловч гэр хорооллын хэрэглэгчдийн дийлэнх нь (94.5%) тэдний авдаг ундны усны хэмжээ өрхийн долоо хоногийн хэрэгцээнд хангалттай байдаг уу гэсэн асуултад тийм гэж хариулсан байна. Оршин суугчдын тал нь 14 л/хүн/өдөр-ээс бага ус хэрэглэж байгаа нь гайхмаар үр дүн юм (Хүснэгт 5-ыг харна уу). Энэхүү үзэл бодол нь ядуу (94.2%) эсвэл савласан ус худалдаж авдаггүй (94.9%) байх зэргээс үл хамаараад бүх төрлийн өрхүүдийн хувьд дийлэнхдээ ижил байна. 2016 онд явуулсан гэр хорооллын усны хэрэглээ, хүртээмж, эрэлт нийлүүлэлтийн Түргэн үнэлгээний тайлангаас³⁷ арвал өрхүүдийн³⁸ усны хэрэглээний сэтгэл ханамж ойролцоо түвшинд (93.3%) байна. Гэсэн ч тус тайланд гэр хорооллын оршин суугчдын усны хэрэглээний түвшин оновчтой хэмжээнд биш байгаа тухай дурдсан байдаг. Цаашлаад хүн ам зүйн бүх бүлгүүдийн усны хэрэглээ дэлхийн дундажтай харьцуулахад доогуур байгаа ба усны хэрэглээ өндөртэй үйл ажиллагаанууд явагдахгүй байгаагаас үүдэлтэй бизнес, эдийн засгийн боломж алдагдаж байж болох тухай дурджээ. Тайланд гэр хорооллын хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр байгааг “иргэд бага хэмжээний усны хэрэглээнд дасан зохицсон эсвэл усны хэрэглээний давуу талуудын талаарх мэдээлэл дутмаг байдаг”-тай холбон тайлбарласан байна. Мөн тайланд “сайжруулсан усны үйлчилгээний далд хэрэгцээ их байгаа нь орчин нөхцөл таатай болбол оршин суугчид илүү их ус хэрэглэхээр байгааг илтгэж байна.”

Усны тарифаас гадна гэр хорооллын оршин суугчид ус авахад тээвэрлэлт, хэрэгсэл гэх мэт нэмэлт мөнгөн болон ус авахад зарцуулдаг цаг хугацаа, тулгардаг хүндрэл бэрхшээл (хүнд ус зөөх, өвөл хүйтэнд удаан хугацаагаар хүлээх, шөнө орой УТБ руу алхахтай холбоотой аюулгүй байдлын асуудлууд) зэрэг мөнгөн бус зардалтай

³⁷ Их сургуулийн судалгааны компани (URC), Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп ХХК. 2016 Баримтын хуудас. https://www.urc-chs.com/sites/default/files/MCC_Mongolia_FactSheet-2018.pdf

³⁸ Улаанбаатар хотын 6-н дүүргийн 810 хэрэглэгчээс авсан ярилцлага.

тулгардаг. Учир нь өрхийн авдаг болон хэрэглэж буй усны хэмжээ нь үндсэндээ усны эх үүсвэрийн зай эсвэл нийт ус авахад зарцуулдаг хугацаанаас³⁹ хамаарч буй бөгөөд энэхүү шинжилгээгээр гэр хорооллын хэрэглэгчдийн ус авахад зарцуулсан хугацааны алдагдсан боломжийн өртгийг тооцоолох замаар эдгээр мөнгөн бус зардлыг барагцаалахыг зорилоо.

ТТЭ-ийн судалгааны үр дүн сүүлийн жилүүдэд гэр хороололд УТБ руу очих болон УТБ дээр хүлээх хугацаа буурсан болохыг илтгэж байна. Энэ хугацаа нь 2016 онд дунджаар 28 минут⁴⁰ байснаас ойролцоогоор 17 минут болж гуравны нэгээс илүү хувиар (39%) буурсан харагдаж байна (Хүснэгт 8-ыг харна уу). Хугацаа буурсан явдал нь **нэг удаагийн ус авалтаар авах усны хэмжээ нэмэгдсэнтэй** холбоотой байх магадлалтай. ТТЭ-ийн судалгаагаар одоогийн нөхцөлд гэр хорооллын өрхүүдийн дөрөвний гурав нь нэг удаагийн ус авалтаар 40 литр эсвэл түүнээс их хэмжээтэй ус авдаг болох нь харагдсан. Дунджаар гэр хорооллын хэрэглэгч нь долоо хоногт 2.5 удаа ус авдаг ба нэг удаагийн авалтаар 106 литр ус авдаг байна. Хэдий тийм ч **гэр хорооллын хэрэглэгчдийн тал хувь (49.9%) нь УТБ руу долоо хоногт гурав ба түүнээс дээш удаа явдаг ба эдгээр хэрэглэгчдийн 11.1% нь ус авахдаа хагас цаг эсвэл түүнээс их хугацаа зарцуулдаг байна.**

Хүснэгт 8: Гэр хорооллын өрхүүдийн ус авахад зарцуулдаг цаг, авдаг усны хэмжээ, ус авах давтамж болон УТБ хүртэлх зай (өрхөд эзлэх %)

УТБ хүртэлх зай	
200 метр дотор	52.8
200 - 1000 метр	39.2
1000 метрээс дээш	8
Нийт	100
Долоо хоногт ус авдаг давтамж	
Долоо хоногт 1 удаа	15.9
Долоо хоногт 2 удаа	34.1
Долоо хоногт 3 удаа	31.7
Долоо хоногт 4-өөс дээш	18.2
Нийт	100
Өрхийн долоо хоногийн дундаж ус авах давтамж	2.5
Нэг удаагийн явалтаар авдаг усны хэмжээ	
10 - 20 литр	15.9
20 - 40 литр	34.1
40 - 100 литр	31.7
100 литрээс дээш	18.2
Нийт	100


³⁹ ДЭМБ-ын 2014 оны гарын авлага.

⁴⁰ Их сургуулийн судалгааны компани (URC), Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп ХХК. 2016 Баримтын хуудас. https://www.urc-chs.com/sites/default/files/MCC_Mongolia_FactSheet-2018.pdf

Өрхийн нэг удаагийн явалтаар авдаг дундаж хэмжээ	106
Нэг удаагийн ус авалтаар УТБ руу ирж, очиход зарцуулдаг хугацаа	
15 минутаас бага	51.7
15 - 30 минут	37.2
30 - 45 минут	8.7
45 минутаас дээш	2.4
Нийт	100
Өрхийн дундаж зарцуулдаг хугацаа минутаар	17.5

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Нэг удаагийн явалтаар авдаг усны хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байж болох өөр нэг өөрчлөлт бол **одоо усыг ихэвчлэн эрэгтэй том хүн авдаг болсон явдал юм**. 2016 оны Түргэн үнэлгээний үр дүнгээс харахад зарим ялангуяа эмэгтэй хэрэглэгчид тэргээр ус авдаг бол хүмүүс усаа машинаар авах нь нэмэгдэж байгаа ба нийт ус авч байгаа том хүмүүсийн 77.1% нь эрэгтэй байна (Зураг 15-ыг харна уу). ТТЭ-ийн судалгаагаар харин **нийт өрхүүдийн 22.9%-д хүүхдүүд нь УТБ-аас усаа авдаг гэжээ**. Энэ харьцаа нь ядуу өрхүүдийн хувьд илүү өндөр байна (31.5%). Харин энэ харьцаа үзүүлэлт нь ядуу өрхүүдийн хамгийн бага орлоготой 5 хувьд багтах хүнсний талон авдаг өрхүүдийн дунд тийм ч өндөр биш (7.1%) байна (Бүлэг 6-г харна уу). Насанд хүрэгсэд болон хүүхдүүдийн дунд алинд нь ч охид, эмэгтэйчүүд ус авах нь илүү бага байдаг. Охид ус авах ажлыг хариуцдаг өрхүүдийн нийт өрхөд эзлэх хувь өрхийн орлогын аль ч түвшинд ойролцоо байна (дунджаар 21%, ядуу өрхүүдийн хувьд 22.5%).



Зураг 15: Ус авах ажлыг хариуцдаг хүний нас, хүйс

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Эдгээр үр дүнд тулгуурлан гэр хорооллын өрхүүд нь сард дунджаар 3 цаг 24 минутыг ус авахад зарцуулдаг болохыг ТТЭ-ийн судалгаагаар тогтоосон.


- Хүснэгт 9-ийн ундны усны эх үүсвэрийн талаарх дүнгүүд нь УТБ хүртэлх зай ус авахад зарцуулдаг хугацаанд нөлөөлдөг болохыг харуулж байна:
 - Усны эх үүсвэртэй ойр байдаг өрхүүд сард дунджаар 2 цаг зарцуулдаг

- Усны эх үүсвэр хүртэл 1 км болон түүнээс хол зайтай өрхүүд сард ойролцоогоор 7 цаг зарцуулдаг
- УТБ-ны төрлүүдийн хувьд:
 - Зөөврийн ус хангамжтай УТБ-наас ус авах хугацаа нь төвийн шугамд холбогдсон УТБ-аас ус авах хугацаанаас арай урт байна. (2 цаг 30 минуттай харьцуулахад төвийн шугамд холбогдсон УТБ-ны хувьд 2 цаг 18 минут байна).
 - УТБ ойрхон тохиолдолд ухаалаг эсвэл түгээгчтэй УТБ-аас ус авахад зарцуулах цагийн хооронд их зөрүү байхгүй байна.
 - Түгээгчтэй УТБ-тай харьцуулахад ухаалаг УТБ-ны тасралтгүй ажиллах цагийн хуваарь илүү таатай байдаг (ухаалаг УТБ-ны давуу болон сул талын талаар 6.2.1 дугаар хэсгээс харна уу) тул хэрэглэгчдийн хол зайг туулж ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг хувь нь өндөр (Зураг 16-г харна уу, нэг км-ээс хол зай туулж ирж байгаа хэрэглэгчдийн хувь ухаалаг УТБ-ны хэрэглэгчдийн дунд түгээгчтэй УТБ-аас илүү өндөр байна). Тиймээс ухаалаг УТБ-ны хэрэглэгчид ус авахдаа түгээгчтэй УТБ-ны хэрэглэгчдээс дунджаас илүү цаг зарцуулдаг (3 цаг 12 минуттай харьцуулахад 2 цаг 48 минут).

Хүснэгт 9: Сард ус авахад зарцуулдаг хугацааг усны гол эх үүсвэрээр болон эх үүсвэр хүртэлх зайгаар харуулав

Гол ундны усны эх үүсвэрээр ангилсан гэр хорооллын хэрэглэгчдийн бүлгүүд	УТБ хүртэлх зай			Нийт өрхүүд
	200 метр дотор	200 - 1000 метр	1000 - с дээш метр	
Ухаалаг УТБ	2.3	3.3	7.5	3.2
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ	2.3	3.5	7.1	2.8
Зөөврийн УТБ	2.5	4.2	6.4	3.5
Бусад эх үүсвэр	2.2	5.1	7.1	4.1
Хэрэглэгчдийн дундаж	2	4	6.9	3.4

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа



Зураг 16: Өрхийн гол ундны эх үүсвэр хүртэлх зай

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Энэ хугацааны үнэлгээ нь өрх бүрийн хувьд ямар боломжууд алдагдаж байгаагаас хамаарна. Гэр хорооллын орлого бага байсан ч өрхүүдийн ус авахад зарцуулсан цагийг орлого олох, гэрийн ажил хийх, хүүхэд асрах, амрах зэрэг бусад дуртай ажил хийхэд зарцуулах боломжтой байх байсан. Гэр хорооллынхны ус авахад зарцуулдаг бусад нөөц бололцооны хувьд мөн адил өөр зүйлд зарцуулах боломжтой. Тиймээс хэрэглэгчдийн ус авахад зарцуулдаг цагийн алдагдсан боломжийн өртгийг мөнгөн дүнгээр үнэлэх нь санхүүгийн хязгаарлагдмал байдлаас гадна эдгээр зардал нь гэр хорооллын иргэдийн усны хэрэглээнд хэрхэн нөлөөлж болохыг ойлгоход туслах юм.

Алдагдсан боломжийн өртөг нь гэр хорооллын оршин суугчдын усны хэрэглээнд сөргөөр нөлөөлдөг гэсэн таамаглалыг шалгахын тулд хэрэглэгчдийн ус авахад зарцуулсан цагийн алдагдсан боломжийн өртгийг тооцоолсон болно. Энэ шинжилгээнд өрхүүд сайн сайхан байдлаа хамгийн их байлгахын тулд тэд хөдөлмөрийн ахиу өгөөжийг, амралт чөлөөт цагийн ахиу зардалтай адилтгадаг гэсэн эдийн засгийн онолыг ашигласан. Улаанбаатар хотын⁴¹ нэгэн адил ажилгүйдэл багатай эдийн засагт **чөлөөт цагийн ахиу зардал нь тухайн цагт олж болох байсан орлоготой тэнцүү гэж үздэг**. Шинжилгээгээр уг дүнг Улаанбаатар хотын 2020 оны ядуурлын шугамын дундаж буюу ҮСХ-ноос сард 230,000 төгрөг (81 ам.доллар) байхаар тогтоосон тухайн жилийн амьжиргааны доод түвшинтэй тэнцүү байхаар тооцоолсон. Хүснэгт 10 нь өрхүүдийн ус авахад зарцуулсан цагийн алдагдсан боломжийн өртгийн хязгаарын утгуудыг харуулж байна. Дунджаар нэг куб метр ус авахад зарцуулах цагийн алдагдсан боломжийн өртөг нь 5,068 төгрөг (1.78 ам.доллар)⁴² байна. Энэ дүн нь УТБ-ны усны тарифаас (куб метр тутамд 1,000 төгрөг, энэ нь 0.35 ам. доллартой тэнцэнэ) хамаагүй өндөр байгаа нь гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээ бага байгаа нь усны тарифаас илүү усны хүртээмжтэй байдалтай холбоотой асуудал болохыг илтгэж байна.

Хүснэгт 10: Гэр хорооллын хэрэглэгчид нэг м³ ус авахад зарцуулах цагийн алдагдсан боломжийн өртөг (төгрөгөөр)

Дундаж	Медиан	Доод хязгаар ¹	Дээд хязгаар ¹
5,068	3,686	1,561	10,110

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: 1. Доод болон дээд хязгаарыг усны хэрэглээний бодит хязгаарыг төлөөлөх чадвар багатай хамгийн доод болон дээд түвшний 10%-ийг хассаны дараа тооцоолов.

⁴¹ 2020 оны 9 дүгээр сарын байдлаар ажилгүйдлийн түвшин 7.3% байсан (ҮСХ).

⁴² Гэр хорооллын хэрэглэгчдийн цагийг ядуурлын шугамд тулгуурлан тооцсон эдийн засгийн үнэлгээ нь "гэр хорооллын өрхүүд ажил эрхэлдэггүй, сургуульд явдаггүй, эсвэл ямар нэг мөнгөний ажил хийддэггүй өрхийн гишүүдтэй байх зэргээр сул нөөц бололцоо ихтэй харагддаг. Ус авах хэрэгцээнээс шалтгаалан алдаж буй мөнгөн зардал нь ихэнх тохиолдол өчүүхэн юм" гэж үзэх хүмүүст өндөр санагдах байх. Түүнчлэн тэд "алдагдсан боломжийн өртөг нь усны тарифаас хэт өндөр байгаа болон ус ханган нийлүүлэгчид нь усыг гэр, гэрт нь бус УТБ-нд хүргэх үүрэгтэй учраас энэ өртгийг нэмэх нь гэр хорооллын хэрэглэгчдийн төлж буй дүн болон төлөх эрмэлзэлтэй дүнг гажуудуулж магадгүй" хэмжээн санаа зовниж байна. Судлаач нь усны үнэд алдагдсан боломжийн өртгийг нэмэх нь зүйтэй бөгөөд энэ нь гэр хорооллын усны хэрэглээ бага байгааг тайлбарлахад зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Энэ нь тарифын түвшний талаарх өрхийн үзэл бодлын шинжилгээ эсвэл санал болгож буй тарифт үзүүлэх өрхийн хандлагад суурилсан ТТЭ-ийн шинжилгээг гажуудуулаагүй. Харин ч энэ нь яагаад, ямар нөхцөлд илүү бага орлоготой хүмүүс нь илүү боломжтой хүмүүстэй харьцуулахад тарифыг 5 дахин өсгөхийг хүлээн зөвшөөрч байгааг ойлгоход туслах юм.

4.2 Усны эрэлт хэрэгцээ ⁴³

Энэ хэсэг дэх усны эрэлт хэрэгцээний функцийн тооцоолол нь ус авах алдагдсан боломжийн өртгийн гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээний түвшинд үзүүлж буй нөлөөг харуулна. Ерөнхийдөө энэ нь орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдийн усны эрэлтийг тодорхойлох хүчин зүйлүүдийн шинжилгээг хийх юм. Шинжилгээг бусад бараа бүтээгдэхүүний нэгэн адил усны эрэлт нь хэрэглэгчдийн орлого, нийгэм эдийн засгийн шинж чанар, усны үнэ, олдоц, усыг орлох буюу хоршиж хэрэглэх бусад бүх бүтээгдэхүүний үнээс хамаардаг гэсэн онолыг баримталж хийсэн⁴⁴. Гэхдээ ихэнх ахуйн усны хэрэглээг (хувийн ариун цэвэр сахих, цэвэрлэгээ гэх мэт) орлуулах бүтээгдэхүүн байдаггүй ба устай хоршиж хэрэглэгддэг бүтээгдэхүүнүүд нь удаан эдэлгээтэй богино хугацаанд өөрчлөгдөх магадлал багатай тоног төхөөрөмжүүд (угаалгын машин, ариун цэврийн тоног төхөөрөмж гэх мэт) байдаг тул дийлэнх судалгаанууд нь орлох болох хорших бүтээгдэхүүний талаар авч үздэггүй⁴⁵. Энэхүү ойлголт нь гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд мөн хамаатай учир нь халуун усны газар болон угаалгын үйлчилгээг ашигладаг зуршил нь өндөр үнэтэй бөгөөд усны тарифаас хамааралгүй юм. Түүнчлэн гэр хорооллын өрхүүдийн зөвхөн 14.5% нь л савласан ус худалдан авдаг гэж тайлагнасан. Аргачлал маань бодит усны үнийг авч үзсэн ба энэ нь гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд усны тариф болон өрхийн ус авах алдагдсан боломжийн өртгийн нийлбэр юм. Түүнчлэн шинжилгээнд хэрэглэгчдийн дунд ус нь чанарын хувьд нийтлэг бүтээгдэхүүн гэж үзсэн.

Хүснэгт 11-д танилцуулж буй үр дүнгээс харахад гэр хорооллын хэрэглэгчдийн усны эрэлт хэрэгцээ нь усны бодит үнэд (усны тариф ба ус авахад зарцуулах цагийн алдагдсан боломжийн өртөг хоёрын нийлбэр) мэдрэмтгий байна. Нэг куб метр усны бодит зардалтай холбоотой регрессийн коэффициент нь үнийн өөрчлөлттэй буюу орон сууцны хэрэглэгчийн бүлгүүдийн тариф болон гэр хорооллын хэрэглэгчдийн бодит зардалтай холбоотой усны эрэлт хэрэгцээний уян хатан байдлын түвшнийг илэрхийлж байна. **Гэр хорооллын хэрэглэгчдийн усны эрэлт хэрэгцээний үнийн уян хатан байдал нь -0.5446 байна**, энэ нь усны хэрэглээний бодит зардал нэг хувь өсөхөд гэр хорооллын усны эрэлт хэрэгцээ 0.54%-иар буурна гэсэн үг юм. Санхүүгийн хязгаарлагдмал байдлаас гадна УТБ-аас эвсэл бусад эх үүсвэрээс ус авахад тулгардаг таагүй байдлыг илэрхийлж буй ус авахад зарцуулах цагийн алдагдсан боломжийн өртөг нь гэр хорооллын оршин суугчдын усны хэрэглээнд бодитой дарамт учруулж байна. **Эдгээр коэффициентуудад тулгуурлан дүгнэхэд хэрвээ ус хэрэглэхэд УТБ дээрх тарифаас өөр нэмэлт зардал гардаггүй бол гэр хорооллын өрхүүдийн дундаж усны хэрэглээ ойролцоогоор 45%-иар илүү байх байсан**⁴⁷. Шинжилгээний үр дүнгээс

⁴³ Тоон мэдээллийн хязгаарлагдмал байдал болон тайлагнасан усны хэрэглээний нийцтэй байдлыг хэрхэн шалгасан талаар Арга зүй хэсэгт тайлбарласан (2.3.2)

⁴⁴ А.Рейно, Г.Романо нар (2018). Орон сууцны усны хэрэглээний эдийн засгийн шинжилгээний ололт амжилт: Танилцуулга. Ус, 10(9), 1162.

⁴⁵ А.Рейно, Г.Романо нар (2018). Орон сууцны усны хэрэглээний эдийн засгийн шинжилгээний ололт амжилт: Танилцуулга. Ус, 10(9), 1162.

⁴⁶ 1 гэсэн мөрний доод индекстэй усны бодит зардлын коэффициенттой тэнцүү.

⁴⁷ Үнийн уян хатан байдлыг (-.54) усны бодит зардлыг 1000 + 5068 (усны тариф болон алдагдсан боломжийн өртгийн нийлбэр) төгрөгөөс 84 хувиас бууруулан 1000 төгрөг болгосноор үржүүлсэнтэй тэнцүү.

бусад хэрэглэгчийн төрлүүдийн усны эрэлт хэрэгцээг тодорхойлогч хүчин зүйлсийн талаар бас харж болно.

Орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн усны эрэлт хэрэгцээний үнийн уян хатан байдал нь -0.40⁴⁸ байна. Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчидтэй⁴⁹ холбоотой коэффициент мөн статистикийн хувьд ач холбогдолтой бөгөөд -0.34 байна. Энэ нь орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчид усны хэрэглээгээ тарифт тохируулан өөрчилж байгааг илэрхийлж чадахгүй, учир нь өмнө нь тайлбарлаж байсанчлан эдгээр өрхийн усны хэрэглээний төлбөр нь тэдний бодит хэрэглэж буй хэмжээтэй холбоогүй байдаг. Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн хувьд энэ үзүүлэлтийн түвшин өндөр байгаа нь бусад бүх зүйл ижил байхад орон сууцны усны тоолуургүй өрхийн усны хэрэглээ (төлбөр тооцож буй) нь орон сууцны усны тоолууртай ижил шинж чанар бүхий өрхөөс өндөр байх магадлал байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 11: Усны эрэлт хэрэгцээний тооцоолол

Тайлбар: Тод үсгээр бичсэн эерэг коэффициент нь бусад бүх зүйл ижил байхад ийм шинж чанартай өрхүүд нь өндөр усны эрэлт хэрэгцээтэй болохыг харуулж байна. Тод үсгээр бичсэн сөрөг коэффициент нь бусад бүх зүйл ижил байхад ийм шинж чанартай өрхүүд бага усны эрэлт хэрэгцээтэй болохыг харуулж байна. Бусад тохиолдолд шинжилгээ нь тодорхой үр дүнд хүрээгүй байна.

OLS регресс – Хамаарагч хувьсагч: м ³ -р илэрхийлсэн өрхийн сарын усны хэрэглээ (логарифм утга)			
Хувьсагч	Козф.	Ст. алдаа	P>t
Нэг хүнд ногдох орлого (логарифм утга)	0.08	0.0139	0.00
УБ хотын хамгийн чинээлэг 3 дүүргийн нэгэнд амьдардаг байх	-0.02	0.0193	0.34
Өрхийн тэргүүн дээд боловсролтой	-0.02	0.0209	0.35
Өрхийн усны бодит зардал (логарифм утга)	-0.54¹	0.0233	0.00
Орон сууцны хэрэглэгчтэй хамааруулсан хувьсагч	0.13²	0.0086	0.00
Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчтэй хамааруулсан хувьсагч	0.07³	0.0065	0.00
Усны үйлчилгээ, чанарт өгсөн өрхийн дундаж сэтгэл ханамжийн үнэлгээ	-0.11	0.0302	0.00
орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчтэй хамааруулсан хувьсагч	0.09	0.0370	0.02
Өрхийн орлогод эзлэх усны зардлын (бодит зардал) хувь	0.02	0.0017	0.00
Өрхийн ам бүлийн тоо	0.14	0.0073	0.00
Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.04	0.0228	0.05
Зөвхөн өндөр настантай өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.13	0.0400	0.00
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.04	0.0318	0.23
Тэтгэврийн орлоготой өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.08	0.0221	0.00


⁴⁸ 1 болон 2 гэсэн мөрний доод индекстэй усны бодит зардлын коэффициентуудын нийлбэртэй тэнцүү.

⁴⁹ Энэ хэрэглэгчийн төрлийн усны эрэлт хэрэгцээний үнийн уян хатан байдал нь 1, 2, 3 гэсэн мөрний доод индекстэй усны бодит зардлын коэффициентуудын нийлбэртэй тэнцүү.

Хүнсний талон авдаг өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.05	0.0482	0.26
Тогтмол утга	3.18	0.2871	0.00
Ажиглалтын тоо	4,194		
F(15, 4178)	854.26		
Prob > F	0.0000		
R-squared	0.7541		
Adj R-squared	0.7532		


Шинжилгээний үр дүнгээс усны эрэлт хэрэгцээ нь өрхийн ам бүлийн тоо, орлогын түвшин, болон тэтгэврийн орлоготой уялдаатайгаар нэмэгддэг болох нь харагдаж байна. Усны зардлын өрхийн орлогод үзүүлэх өндөр дарамт нь усны өндөр эрэлт хэрэгцээтэй холбоотой байна. Эсрэгээрээ эмэгтэй өрхийн тэргүүнтэй, зөвхөн өндөр настантай өрхүүдийн усны эрэлт хэрэгцээний түвшин доогуур байна. Судалгаагаар хүүхэдтэй нэг тэжээгчтэй, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй, хүнсний талон авдаг, КОВИД-19 хямралын улмаас орлого нь багассан өрхүүдийн усны эрэлт хэрэгцээний түвшин бага байх талаар нарийвчилсан баримт нотолгоо илрүүлээгүй байна. **Энэ нь өрхийн орлогын түвшин, усны хүртээмжтэй байдал, өрхийн ам бүлийн тооны зөрүүтэй байдлыг тооцохгүй тохиолдолд өрхүүдийн усны хэрэглээний хэв маяг тийм ч их ялгаатай биш байгааг харуулж байна.**

Хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт хамрагдах магадлалтай сонгогдсон өрхийн дэд бүлгүүдээр нэг хүнд ногдох хоногийн усны хэрэглээний түвшин болон сарын усны эрэлт хэрэгцээний түвшин Зураг 17, 18-д харуулав. Төлбөрийн чадвартай холбоотой асуудлуудыг танилцуулсан 7 дугаар бүлэгт хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийг тодорхойлох ба үүний талаар энэ тайланд авч үзэх болсон бодлогын үндэслэлийг тайлбарлана. Усны эрэлт хэрэгцээг тооцоолоход зөвхөн өндөр настантай гэр бүлүүдийн усны эрэлт хэрэгцээ илүү бага байна гэж ажиглагдсан. Ам бүл олонтой өрхүүд (3 хүүхэдтэй өрх) усны эрэлт хэрэгцээ илүү өндөртэй, эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхүүд (хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрх) усны эрэлт хэрэгцээ илүү багатай Хүнсний талон авдаг өрхүүд нь дунджаар илүү олон ам бүлтэй байдаг тул илүү өндөр усны эрэлт хэрэгцээтэй боловч хоногийн нэг хүнд ногдох усны хэрэглээ нь бага байдаг байна.



Зураг 17 : Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгүүдээр болон хэрэглэгчийн төрлөөр сарын усны эрэлт хэрэгцээ (м³-ээр)

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа



Зураг 18: Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгээр болон хэрэглэгчийн төрлөөр нэг хүнд ногдох өдрийн усны хэрэглээ (литр/хүн/өдөр)

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Таамаглаж байснаас эсрэгээр хэрэглэгчийн төрлөөс үл хамааран **усны эрэлт хэрэгцээ нь өрхийн усны үйлчилгээ, чанарын талаарх ойлголттой урвуу хамааралтай байна.** Энэ нь бусад бүх зүйл ижил байхад усны үйлчилгээ, чанарт илүү сэтгэл хангалуун байдаг өрхүүд, сэтгэл ханамж багатай өрхүүдээс илүү бага ус хэрэглэдэг гэсэн үг юм. Хамаарал нь гэр хорооллын хэрэглэгчдийн (-0.11) хувьд орон сууцны хэрэглэгчдээс (-0.02) илүү их харагдаж байгаа нь бас сонирхолтой үр дүн юм. Учир нь Бүлэг 4-т тайлбарласанчлан гэр хорооллын хэрэглэгчид нь усны үйлчилгээ, чанарт орон сууцны хэрэглэгчдээс илүү өндөр оноо өгсөн. Мөн Бүлэг 4-т тайлбарласнаар аль аль хэрэглэгчийн төрлүүдэд хамгийн их усны эрэлт хэрэгцээтэй өрхүүд нь усны үйлчилгээ, чанарт сэтгэл ханамж хамгийн багатай өрхүүд байсан.

4.3 Хэрэглэгчдийн үндсэн усны хэрэгцээг хангах нь

Энэ хэсэгт ямар өрхүүд хангалтгүй усны хэрэглээтэй байх магадлалтайг тодорхойлох юм.

4.3.1 Усны хэрэглээ хангалтгүй болох эмзэг байдал

Хамтарсан A/333 тушаалаар тогтоосон стандартыг үндэслэн (Зураг 19 -ийг харна үү) Монгол Улсын Засгийн газар орон сууцны оршин суугчдад 200 л/хүн/өдөр, гэр хорооллын оршин суугчдад 50 л/хүн/өдөр ус шаардлагатай гэж үзсэн.

Ус хангамжийн төрөл			Ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээ, (хүн/хоног/литр)
I.Төвлөрсөн ус хангамж			
Нийт хэмжээ (хүн/хоног/литр)			200
Үүнээс:	Хоол хүнс бэлтгэх, сав суулга угаах		30
	Хувийн ариун цэвэр сахих	Шүд, нүүр, гар угаах	8
		Усанд орох (шүршүүрт)	55
	Угаалга, цэвэрлэгээ		67
	Ариун цэврийн байгууламж-суултуур		40
II. Төвлөрсөн бус ус хангамж			
Нийт хэмжээ (хүн/хоног/литр)			50
Үүнээс:	Хоол хүнс бэлтгэх, сав суулга угаах		14
	Хувийн ариун цэвэр сахих	Шүд, нүүр, гар угаах	8
		Усанд орох (бие угаах)	17
	Угаалга, цэвэрлэгээ		11

Зураг 19: Улаанбаатар хотын усны хэрэглээний албан ёсны стандартууд

Эх сурвалж: ЗНТТ Ажлын даалгавар 2.1 Бодлогын баримт бичгийн судалгаа


- **Усны тоолууртай орон сууцны өрхүүдийн хэрэглээ:** Одоогийн байдлаар орон сууцны тоолууртай хэрэглэгчдийн 42.7% нь 200 л/хүн/өдөр-тэй тэнцүү буюу үүнээс их хэрэглээтэй гэсэн бол 57.3% нь үүнээс бага хэрэглээтэй гэжээ.
- **Гэр хорооллын өрхүүдийн хэрэглээ:** Гэр хорооллын хэрэглэгчдийн дөнгөж 4.7% нь 50 л/хүн/өдөр-тэй тэнцүү буюу үүнээс их хэрэглээтэй гэсэн бол 95.3% нь үүнээс бага хэрэглээтэй гэжээ.

Орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдээс 34,000 орчим нь (10.1 хувь) Эрүүл мэндийн яамнаас гэр хорооллын оршин суугчдын хувьд тогтоосон 50 л/хүн/өдөр гэсэн стандартаас бага усны хэрэглээтэй гэж тайлагнасан байна. Засгийн газраас тухайн хэрэглэгчийн төрөлд тогтоосон зохистой хэрэглээний түвшинд хүрэхгүй байгаа өрхийн тоо нь засгийн газраас хэрэгжүүлэх аливаа нэг дэмжих хөтөлбөрийг, тухайн хөтөлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөд санаа зовохгүйгээр авч үзэх боломжгүй байна. Тиймээс усны хэрэглээ хангалтгүй байгаагаас гэр бүлийн хэрэгцээгээ бүрэн хангаж чадахгүй буй өрхүүдийг тодорхойлохын тулд Судалгаа нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын Ундны усны чанарын удирдамжийг дагасан.⁵⁰ Удирдамжид

⁵⁰ ДЭМБ (2017). Ундны усны чанарын удирдамж: эхний өөрчлөлтийг агуулсан дөрөв дэх хэвлэл. <https://www.who.int/publications/i/item/9789241549950>

ихэнх нөхцөлд, ихэнх хүмүүсийн хувьд цангаа тайлж, хоолонд хамт хэрэглэгдэж байгаа нэг хүнд ногдох хоногийн усны хамгийн бага хэмжээ нь 7.5 литр гэж тооцсон байна. Хоол хийх, хувцас угаах, хувийн болон ахуйн ариун цэвэрт зарцуулах хамгийн бага усны хэмжээг тодорхойлоогүй байна. Удирдамжид үйлчилгээний дөрвөн түвшнийг тодорхойлсон бөгөөд хамгийн бага нь нэг өрх өдөрт дунджаар нэг хүний 20 литр ус авах боломжтой байх хэрэглээний үндсэн түвшин юм. Ус түгээх цэг нь 1 км-ийн дотор эсвэл ус авахдаа 30 минут болон түүнээс бага хугацаа зарцуулж байвал усны хүртээмжийн үндсэн шаардлагыг хангаж байна гэж үзнэ. Ийнхүү энэ судалгаа нь ДЭМБ-ын 20 л/хүн/өдөр гэсэн босго хэмжээг усны хэрэглээ хангалтгүй болох магадлалтай Улаанбаатар хотын эмзэг бүлгийн өрхийн хувийг хэмжихдээ ашигласан.

Улаанбаатар хотын хэрэглэгчдийн томоохон хувь нь (41.5%) ДЭМБ-ын нэг хүний хоногийн 20 литр гэсэн усны түвшинд хүрэхгүй байна. Эдгээр нь бараг бүгд (98.3%) гэр хорооллын хэрэглэгчид ба гэр хорооллын хэрэглэгчдийн 74%-ийг бүрдүүлж байна. Энэ нь өмнөх судалгаанууд⁵¹ дээр ажиглагддаг байсан ч гайхмаар үр дүн юм. Учир нь гэр хорооллын хэрэглэгчдийн маш бага хувь (14.7%) нь үндсэн түвшний үйлчилгээнд (ус авах цэг 1 км-ийн дотор эсвэл ус авахад 30 минутаас бага хугацаа зарцуулдаг байх) хамрагддаггүй ба ДЭМБ-ын удирдамжийн дагуу энэ нь өрхүүд дунджаар хоногт хүний 20 литр ус авахад хангалттай нөхцөл бүрдсэн гэсэн үг юм. **ДЭМБ-ын босго хэмжээнд хүрэхгүй байгаа хэрэглэгчдийн эзлэх хувь гэр хорооллын ядуу өрхүүдийн эзлэх хувиас хамаагүй өндөр байна** (27.4%-тай харьцуулахад 74% байна, Бүлэг 2-ыг харна уу).



Зураг 20: Хэрэглэгчийн төрлөөр ДЭМБ-ын босгоос дээгүүр болон доогуур хэрэглээтэй өрхүүд

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

⁵¹ Э.Гавел, К.Сигел, В. Бретшнайдер нар (2011). Монгол улсын ус хангамжийн худалдан авах чадвар: Худалдан авах чадварыг хэмжих эмпирик сургамжууд. (№. 9/2011). Хельмгольц Байгаль орчны судалгааны төв хэлэлцүүлгийн баримт бичиг; Түргэн үнэлгээний их сургуулийн судалгаа компани ХХК (URC), Монголын Маркетингийн Зөвлөх Үйлчилгээний групп, 2016.

4.3.2 Бага усны хэрэглээтэй өрхүүдийн нийгэм эдийн засгийн шинж байдал

ДЭМБ-ын босгоос доогуур усны хэрэглээтэй өрхүүдийн шинж байдлыг тодорхойлсон эконометрик шинжилгээний (пробит) үр дүнгээс үзэхэд эдгээр өрхүүд нь ядуу, ам бүл олон, ус авах алдагдсан боломжийн өртөг өндөртэй өрхүүд байна.

Эсрэгээрээ ДЭМБ-ын босгоос доогуур усны хэрэглээтэй байх магадлал багатай өрхүүд нь: зөвхөн өндөр настантай өрх, төвийн шугам сүлжээнд холбогдсон, болон усны зардал нь өрхийн орлогын харьцангуй өндөр хувийг эзэлдэг өрхүүд байна.

Хүснэгт 12: Нэг хүнд ногдох бага усны хэрэглээтэй өрхүүдийн нийгэм эдийн засгийн шинж байдал

Тайлбар: Тод үсгээр бичсэн эерэг коэффициент нь бусад бүх зүйл ижил байхад ийм шинж чанартай өрхүүд нь нэг хүнд ногдох өдрийн усны хэрэглээ нь 20 л/хүн/өдрөөс доогуур байх өндөр магадлалтай байна. Тод үсгээр бичсэн сөрөг коэффициент нь бусад бүх зүйл ижил байхад ийм шинж чанартай өрхүүд нь нэг хүнд ногдох өдрийн усны хэрэглээ нь 20 л/хүн/өдрөөс доогуур байх магадлал багатай байна. Бусад тохиолдолд шинжилгээ нь тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Пробит регресс – Хамаарагч хувьсагч : 20 л/хүн/өдрөөс бага хэрэглээтэй өрх (1-тэй тэнцүү, өөр бол=-0)				
Хувьсагч	Козф.	Ст. алдаа	z	P>z
Ядуу өрхүүд (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.21	0.0852	0.02	0.21
УБ хотын хамгийн чинээлэг гурван дүүргийн нэгэнд амьдардаг байх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.10	0.0678	0.15	-0.10
3 болон түүнээс олон хүүхэдтэй өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.14	0.1149	0.22	-0.14
Зөвхөн өндөр настан бүхий өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.61	0.1273	0.00	-0.61
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.17	0.1068	0.11	-0.17
Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.07	0.0798	0.40	-0.07
Өрхийн ам бүлийн тоо	0.34	0.0312	0.00	0.34
COVID 19 хямралын улмаас орлого буурсан (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.02	0.0861	0.81	0.02
COVID 19 хямралын улмаас орлого нэмэгдсэн (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.10	0.0792	0.21	0.10
Хүнсний талон авдаг (бусад өрхүүдтэй харьцуулахад)	0.05	0.1755	0.79	0.05
Усны тоолуургүй орон сууцны оршин суугч (гэр хороололтой харьцуулахад)	-2.85	0.2575	0.00	-2.85
Усны тоолууртай орон сууцны оршин суугч (гэр хороололтой харьцуулахад)	-2.84	0.1001	0.00	-2.84
Өрхийн тэргүүн дээд боловсрол эзэмшсэн (бусад өрхүүдтэй харьцуулахад)	-0.05	0.0731	0.50	-0.05
1 м³ ус авах алдагдсан боломжийн өртөг	0.00	0.0000	0.00	0.00
Өрхийн нийт орлогод эзлэх усны зардал	-0.10	0.0143	0.00	-0.10
Тогтмол утга	-0.43	0.1373	0.00	-0.43
Ажиглалтын тоо	4,199			

LR chi2(13)	3906.3
Prob > chi2	0.0000
Pseudo R2	0.6813
Логарифм магадлал =	-1671.0

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

4.4 Амьжиргаа тэтгэх тарифын түвшин

Энэ хэсэг нь Ажлын даалгавар 1-ийн Зорилт 2-д чиглэсэн болно: “Амьжиргаа тэтгэх тариф” (lifeline tariff)-д тохирсон усны хэрэглээний хэмжээний талаар санал боловсруулах юм.

Амьжиргаа тэтгэх тариф нь өрхийг үндсэн усны хэрэгцээгээ хангахад тулгарч буй төлбөрийн чадварын асуудлыг шийдвэрлэх зорилготой. Энэ нь усны хэрэглээний өөр түвшнүүдэд (блок) өөр өөр тариф тогтоон, шаталсан үнэтэй болно гэсэн үг юм. Хэрэв усны хамгийн бага хэрэглээнд (ихэнхдээ усны үндсэн стандарт хэрэглээ болон/буюу зөвхөн суурь хэрэгцээг хангах хэмжээ) төрөөс татаас өгвөл үүнийг амьжиргаа тэтгэх тариф гэдэг.

Дээр дурдсан үр дүнгээс харахад гэр хорооллын 147,800 өрхийн хагас сая орчим хүн (гэр хорооллын хэрэглэгчдийн 74%) болон орон сууцны усны тоолууртай 2,500 өрхийн 10,000 орчим хүн 20 л/хүн/өдрөөс доогуур хоногийн усны хэрэглээтэй байна. (Ийм нөхцөл байдалтай орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн тоо бага байгаа нь энэхүү үр дүнг статистикийн хувьд маш тодорхой бус болгож байна.)

Амьжиргаа тэтгэх тарифыг нэвтрүүлэх нь гэхдээ гэр хорооллын хэрэглэгчдийг өдрийн усны хэрэглээний стандартад хүргэхэд тохиромжтой бодлого биш юм.

Учир нь энэ төрлийн хэрэглэгчийн усны бодит зардлын томоохон хэсгийг усны хэрэглээнээс (өөрөөр хэлбэл усны зардал) хамааралгүй зардал бүрдүүлж байна. Үнэгүй ус нийлүүлсэн ч эдгээр өрхүүдийн усны хэрэглээг маш багаар нэмэгдүүлэх юм. Тухайлбал ТТЭ-ийн судалгаагаар тооцоолсон ус авах бодит зардлыг 16%-иар бууруулж усыг үнэгүй болгох нь гэр хорооллын дундаж хэрэглэгчийн усны эрэлтийг 10%-иас багаар (8.9%)⁵² нэмэгдүүлэх юм. 2021 оны 7 дугаар сарын 1 хүртэл УТБ дээр үнэгүй ус түгээх Монгол улсын Засгийн газрын шийдвэр нь энэ төрлийн бодлогын бодит туршилт юм.

Орон сууцны хэрэглэгчдийн хувьд шаталсан үнийн тарифын систем нь их хэмжээний усны хэрэглээнд ногдох илүү өндөр тарифаар санхүүждэг тул **их хэмжээний ус хэрэглэдэг ядуу олон ам бүлтэй өрхүүдэд сөргөөр нөлөөлөх магадлалтай юм.** Орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн ДЭМБ-ын санал болгосон түвшнээс (20 л/хүн/өдөр) дутаж буй усны хэрэглээний дундаж дүн нь нэг хүний хоногийн 6.5 литр юм. Эдгээр өрхүүдийн дундаж ам бүлийн тоо нь 4 гишүүнээс бага зэрэг их байдаг гэж үзвэл өрхийн түвшний дундаж зөрүү нь хоногийн 28.5 литртэй тэнцэнэ. Энэ зөрүүг хаахын тулд сард хамгийн багадаа 1 куб метр ус үнэгүй⁵³ өгөх эсвэл 1.6 куб метр усыг 40% хямдруулж

⁵² Үнийн уян хатан байдлыг (-.54) усны бодит зардлыг 1000 + 5068 төгрөгөөс 16%-иар бууруулан 5068 төгрөг (алдагдсан боломжийн өртөг) болгосноор үржүүлсэнтэй тэнцүү.

⁵³ 28.5 л/өдөр үржих нь 365 өдөр, хуваах нь 12-той тэнцүү

худалдах бодлоготой болох шаардлагатай.⁵⁴ Гэвч ядуу өрхүүдийн 54.7% нь сард 8 куб метрээс илүү буюу их хэмжээний ус хэрэглэдэг. Эдгээр өрхүүдийн зарим нь ам бүлийн тоо олонтой. Энэ бодлого нь эдгээр өрхүүдэд туслахгүй. Түүнчлэн амьжиргаа тэтгэх тарифаас үүсэх санхүүгийн алдагдлыг нөхөх дээгүүр шатлалын өндөр тариф тогтоох систем нь эдгээр том хэрэглэгчдэд сөргөөр нөлөөлөх юм. Нөгөөтээгүүр сард 5 куб метрээс бага усны эрэлттэй 5 хэрэглэгч тутмын 4 нь ядуу биш юм. Амьжиргаа тэтгэх тариф нь ДЭМБ-ын удирдамжид тусгасан суурь хэрэглээний босгоос доогуур хэрэглээтэй өрхийн усны хэрэглээг дэмжихээсээ илүү **ядуу биш өрхүүдийн усны хэрэглээнд татаас болох эрсдэл үүсээд байна.**

⁵⁴ 20 л/хүн/өдөр стандартад нийцэхийн тулд орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн усны эрэлт 48%-иар нэмэгдэх хэрэгтэй, үүний тулд усны тарифыг 121%-иар бууруулах шаардлагатай ба энэ нь одоогийн усны тарифаас 40%-иар бага дундаж усны тариф гэсэн үг юм.

5. ӨНӨӨГИЙН ЦЭВЭР, БОХИР УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХ ХЭРЭГЛЭГЧДИЙН ОЙЛГОЛТ

Энэ бүлэгт Ажлын даалгавар 1-ийн 3 дугаар зорилт: “Одоогийн ус хангамж, бохир усны үйлчилгээний талаарх хэрэглэгчдийн ойлголтыг үнэлэх”-ийн хүрээнд хийсэн дүн шинжилгээг тусгав..

ТТЭ-ийн судалгаагаар өнөөгийн ус хангамжийн үйлчилгээ, үйлчилгээний чанарын талаарх өрхийн хэрэглэгчдийн ойлголт, уг үйлчилгээг сайжруулахын тулд ямар асуудалд нэн тэргүүнд анхаарах ёстой талаар өрхийн санал бодлыг цуглуулсан. Уг бүлэгт судалгааны үр дүнг хэрэглэгчдийн төрлөөр, тэр дундаа хэрэглэгчдийн дэд бүлгүүдээр ангилж орон сууцны хэрэглэгчдийн усны хэрэглээний түвшнээр, харин гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд ундны усны гол эх үүсвэрийн төрлөөр тус тус ялган харуулав. Өрхийн сэтгэл ханамжийн түвшнийг хэрэглэгчдийн дэд ангиллаар мөн үнэлж дүгнэв.

5.1 Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин

УСУГ-ын 2020 онд хийсэн “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа⁵⁵ -ны тайланд дурдсанаар хэрэглэгчид усны үйлчилгээ, усны чанарын талаар өндөр үнэлгээ өгсөн байна. Орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдэд зориулсан 5 бүлгийн шалгуур үзүүлэлтэд 1-ээс 10 хүртэлх оноогоор сэтгэл ханамжийг үнэлэхэд бүх үнэлгээ 7-гоос дээш байна.

ТТЭ-ийн судалгаагаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг мөн авч үзсэн. Орон сууцны хэрэглэгчдээс усны үйлчилгээтэй холбоотой 14 үзүүлэлтээр усны үйлчилгээний түвшин, усны чанарын талаар санал бодлыг нь авсан бол гэр хорооллын хэрэглэгчдээс 15 орчим үзүүлэлтээр санал бодлыг нь асуусан. Судалгаанд оролцсон өрхүүд дараах дөрвөн үндсэн бүлэгт багцалсан үзүүлэлт тус бүрийг үнэлгээний таван түвшний (“огт сэтгэл ханамжгүй”, “сэтгэл ханамжгүй”, “дунд зэрэг сэтгэл ханамжтай”, “сэтгэл ханамжтай”, “маш их сэтгэл ханамжтай”) аль нэгийг нь сонгон үнэлсэн. Үүнд:

- Усны чанар (хэрэглэгчдийн бүх ангиллын хувьд зэв, үнэр, амт, гэр хорооллын өрхүүдийн хувьд өнгө),
- Усны даралт (шугам сүлжээнд холбогдсон өрхүүдийн хувьд усны даралт, гэр хорооллын өрхүүдийн хувьд хэмжээ/ ус хангамжийн хүртээмж),
- Үйлчилгээний тасралтгүй байдал (шугам сүлжээнд холбогдсон өрхүүдийн хувьд эвдрэл гэмтэл гарах давтамж, эвдрэл гэмтлийг засах хугацаа, гэр хорооллын өрхүүдийн хувьд эвдрэлийг богино хугацаанд засах),
- Үйлчилгээний хүртээмж (гэр хорооллын өрхүүдийн хувьд УТБ-ны ажиллах цагийн хуваарь, ус авахад УТБ дээр хүлээдэг хугацаа, гэрээс УТБ хүртэлх зай, УТБ-ны гаднах орчны тохижилт).

Дүн шинжилгээ хийхэд үзүүлэлт тус бүрд өгсөн өрхийн сэтгэл ханамжийн түвшинд оноо өгсөн. Сэтгэл ханамжийн дундаж түвшнээс доогуур буюу "сэтгэл ханамжгүй", "огт сэтгэл ханамжгүй" гэсэн үнэлгээ тус бүрд нэг болон хоёр *сөрөг/хасах* оноог ногдуулан авч

⁵⁵ Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа (2020). УСУГ-ын захиалгаар Монголын судалгаа, зөвлөх үйлчилгээний компани гүйцэтгэв.

үзсэн. Сэтгэл ханамжийн дундаж түвшнээс дээгүүр буюу “сэтгэл ханамжтай” болон “маш их сэтгэл ханамжтай” гэсэн үнэлгээ тус бүрд нэг болон хоёр эерэг/нэмэх оноог ногдуулсан бол “дунд зэрэг сэтгэл ханамжтай” гэсэн үнэлгээ тус бүрд нэг эсвэл хоёр эерэг/нэмэх оноог ногдуулсан бол “дунд зэрэг сэтгэл ханамжтай” гэсэнд ямар ч оноо өгөөгүй. Үйлчилгээний нэг асуудалд өрхүүдийн өгсөн оноог нэмж тооцоход, эсвэл үйлчилгээтэй холбоотой бүх асуудалд нэг өрхийн сэтгэл ханамжийн түвшнийг тооцоход сэтгэл ханамжийн өндөр болон бага түвшин эцсийн дүндээ бие биеэ харилцан тэнцвэржүүлдэг. Дараах хэсэгт өрхүүдийн үзүүлэлт тус бүрээр сэтгэл ханамжийн дундаж түвшинд дүн шинжилгээ хийсэн. Оноо өндөр (дээд тал нь 2 хүртэл) байх тусам өрхийн сэтгэл ханамжийн дундаж түвшин өндөр байна, оноо бага байх тусам (багадаа 2 хүртэл) өрхийн сэтгэл ханамж бага байдлын дундаж түвшин өндөр байгааг илэрхийлнэ. Өрхийн түвшин дэх бүх үзүүлэлтийн дундаж оноог энэхүү тайлангийн эконометрик шинжилгээнд ашигласан болно.


Доорх Зураг 21-т хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг үйлчилгээтэй холбоотой асуудал/үзүүлэлт болон хэрэглэгчдийн төрлөөр харуулав. **Усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн усны үйлчилгээ, чанарын талаарх сэтгэл ханамжийн түвшин гэр хорооллын хэрэглэгчдийнхээс хамаагүй доогуур байна.** Ихэнх үзүүлэлтээр гэр хорооллын хэрэглэгчид “сэтгэл ханамжтай” гэсэн үнэлгээтэй дүйцэх ойролцоогоор 1 оноог өгсөн. Орон сууцны хэрэглэгчдийн өгсөн дундаж оноо 1-ээс доогуур байгаа бөгөөд энэ нь судалгаанд хамрагдагсдын өгсөн сөрөг оноог үл харгалзахгүй байхыг илтгэж байна.

Орон сууцны хэрэглэгчдийн усны үйлчилгээнд өгсөн дундаж оноо 0.4⁵⁶ байна, энэ нь “сэтгэл ханамжтай” гэхээсээ илүү “дунд зэрэг сэтгэл ханамжтай” гэсэн үнэлгээд ойр байгаа бөгөөд усны чанар, даралт, хэрэглэгчийн санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэх байдал зэрэг үзүүлэлтэд өгсөн хэрэглэгчийн ерөнхий сэтгэл ханамжийн түвшин доогуур байгааг харуулж байна. Усны үйлчилгээтэй холбоотой нэг ч үзүүлэлтэд орон сууцны хэрэглэгчид дунджаар “сэтгэл ханамжтай” гэсэн үнэлгээ өгөөгүй байна. Гэр хорооллын хэрэглэгчид усны үйлчилгээнд дунджаар 0.9 оноо өгсөн, энэ нь орон сууцны хэрэглэгчдийн өгсөн үнэлгээнээс өндөр байгаа боловч сэтгэл ханамжийн ерөнхий түвшин “сэтгэл ханамжтай” гэсэн үнэлгээнээс доогуур байгааг илтгэж байна. **Гэхдээ үнэлгээний түвшин өөрөө удирдамж болж чадахгүй гэдгийг дурдах хэрэгтэй.** Судалгаанд мөн үйлчилгээний үнэлгээг бусад үйлчилгээний үнэлгээтэй харьцуулсан эсвэл хэрэглэгчдийн бүлэг үйлчилгээний ижил талыг хэрхэн үнэлж байгааг харсан. Орон сууцны болоод гэр хорооллын хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшнийг зөвхөн дэд үзүүлэлтүүдээр харьцуулах боломжтой юм. Дараагийн хэсгүүдэд хэрэглэгчдийн төрөл тус бүрийн сэтгэл ханамжийн түвшинд хийсэн дүн шинжилгээг танилцуулах болно.

Орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн хамгийн өндөр оноо өгсөн гурван үзүүлэлтэд төлбөр тооцоо хийх арга, тоолуурын нарийвчлал, тоолуурыг баталгаажуулах гэсэн үзүүлэлт багтаж байна. Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн хувьд төлбөр тооцоо хийх арга хэлбэр, усны үнэр, эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засвар хийх хугацаа зэрэг гурван үзүүлэлтэд хамгийн өндөр оноо өгсөн байна. Энэ нь УСУГ-ын 2020

⁵⁶ Үнэлгээний оноо:-2 “огт сэтгэл ханамжгүй”, -1 “сэтгэл ханамжгүй”, 0 “дунд зэрэг сэтгэл ханамжтай”, 1 “сэтгэл ханамжтай”, 2 “маш их сэтгэл ханамжтай”.

онд хийсэн “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа”⁵⁷-ны үр дүнтэй нийцэж байгаагийн зэрэгцээ орон сууцны хэрэглэгчид үйлчилгээ үзүүлэгч байгууллагын “асуудлыг хурдан шийдвэрлэх чадвар”-тай холбоотой үзүүлэлтүүдэд хамгийн өндөр (8) үнэлгээ өгч байгааг харуулж байна. Гэр хорооллын хэрэглэгчид усны үнэр, эвдрэл гэмтэл гарахад засвар хийх хугацаа, зэвтэй байх зэрэг гурван үзүүлэлтэд хамгийн өндөр оноо өгсөн байна. Эсрэгээрээ орон сууцны хэрэглэгчдийн хувьд зэвтэй байх нь хамгийн бага үнэлгээ өгсөн гурван үзүүлэлтийн (хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал, хэрэглэгчийн санал гомдлыг шийдвэрлэх гэсэн үзүүлэлтийн зэрэгцээ) нэг нь юм. Тайлангийн 5.1.1-т илүү дэлгэрэнгүй нэмэлт тайлбар/дүн шинжилгээг оруулав. Гэр хорооллын хэрэглэгчид эвдрэл гэмтэл гарах давтамж, усны амтнаас гадна хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал гэсэн гурван үзүүлэлтэд хамгийн бага оноо өгсөн байна. УСУГ-ын 2020 онд хийсэн Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайланд “(өрхийн бус болон өрхийн хэрэглэгчдийн) санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх механизмтай холбоотой дэд үзүүлэлтээр хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин өмнөх оноос буурсан байна” 58 хэмээн мөн дурджээ.



Зураг 21: Усны үйлчилгээ, чанарын талаарх хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин


Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

5.1.1 Усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны өрхийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин

Зураг 22-т үзүүлсэнчлэн, **орон сууцны усны тоолууртай болон тоолуургүй өрхүүдийн аль аль нь үйлчилгээтэй холбоотой нэг үзүүлэлтэд сөрөг оноо өгсөн: засвар хийсний дараа цэвэр ус иртэл гоожуулж ус үрэх үзэгдэл.** Бусад хоёр үзүүлэлт харьцангуй бага оноо авсан: **зэв арилтал, мөн ус халуун болтол гоожуулж үр ашиггүй ус зарцуулах байдал.**

⁵⁷ “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа (2020). УСУГ-ын захиалгаар Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп гүйцэтгэв.

⁵⁸ Дээрх судалгаанд



Зураг 22: Орон сууцны тоолууртай хэрэглэгчдийн усны үйлчилгээ, усны чанарын талаарх сэтгэл ханамжийн түвшин, өрхийн усны хэрэглээний түвшнээр

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Орон сууцны хэрэглэгчид зэвтэй усанд сэтгэл ханамж бага байгаа нь УСУГ-ын саяхан хийсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар мөн адил гарсан болно⁵⁹. УСУГ-ын судалгаагаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг хэмжсэн таван дэд үзүүлэлтээс бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний чанар, ялангуяа зэв, ус хангамжийн тасалдалгүй байдал гэсэн үзүүлэлт төлбөр төлөх арга, хэрэгсэл (7.1), санал гомдол шийдвэрлэх байдал (7.4), усны тоолуур болон тоолуурын заалт авах (7.5), нэг цэгийн үйлчилгээ (7.8) гэсэн үзүүлэлтүүдтэй харьцуулбал хэрэглэгчдээс бага (10 оноотой шатлалаар 6.2 оноо) үнэлгээ авсан байна. УСУГ-ын “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа-2020”-ны⁶⁰ үр дүнг ТТЭ-ийн судалгааны үр дүнтэй харьцуулахад, ТТЭ-ийн судалгаагаар орон сууцны хэрэглэгчдийн ердөө 7.7% нь УСУГ-ыг орон сууцны өрхүүдэд цэвэр, бохир усны үйлчилгээг үзүүлдэг гэдгийг мэдээлж байсныг тэмдэглэх нь зүйтэй⁶¹.

Хүснэгт 13: Орон сууцны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин, сарын усны хэрэглээний түвшингээр

	5 м³ доош	5-аас 8 м³	8-аас 15 м³	15 м³ доош
Усны тоолуурын нарийвчлал	0.63	0.69	0.65	0.47

⁵⁹ Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа (2020). УСУГ-ын захиалгаар Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп гүйцэтгэв.

⁶⁰ Дээрх судалгаанд

⁶¹ Дээрх судалгаанд

Усны тоолуурын баталгаажилт хийх үйл явц	0.62	0.62	0.63	0.45
Усны даралт	0.63	0.69	0.62	0.58
Зэвтэй холбоотой	0.06	0.11	0.04	0.05
Усны үнэр	0.52	0.62	0.59	0.57
Усны амт	0.56	0.56	0.61	0.52
Ус хангамжийн үйл ажиллагааны доголдол, тасалдал	0.55	0.65	0.59	0.54
Эвдрэл гэмтлийг засах хугацаа	0.57	0.63	0.54	0.47
Ус тасарсны дараа зэвтэй ус арилтал гоожуулах	-0.32	-0.27	-0.38	-0.39
Ус халуун болтол гоожуулж ус үргүй зарцуулах байдал	0.10	0.24	0.12	0.12
Нэхэмжлэлийн ойлгомжтой байдал	0.52	0.62	0.56	0.51
Төлбөр тооцоо хийх арга	0.83	0.83	0.77	0.74
Харилцагчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал	0.43	0.52	0.40	0.44
Санал гомдол шийдвэрлэх байдал	0.34	0.44	0.31	0.29

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: Тод үсгээр бичсэн тоо харгалзах үзүүлэлтэд өгсөн хамгийн бага оноог илэрхийлнэ.


Өрхийн усны хэрэглээний түвшний дүнгээс үзэхэд хамгийн их хэрэглээтэй хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин хамгийн доогуур байна. Эдгээр өрх нь усны үйлчилгээтэй холбоотой асуудал байнга гардаг орон сууцанд амьдардаг, эсвэл бусад оршин суугчидтай харьцуулбал илүү их ус хэрэглэдэг тул ийм асуудалтай илүү тулгардаг байж болох юм. Үр ашиггүй зарцуулдаг усны хэмжээ нь өрхийн төсөвт усны төлбөрийн эзлэх хувийг нэмэгдүүлж байдагтай холбоотой байж болох юм. Хүснэгт 14-т үзүүлсэн үр дүнгээс харахад, сард 8-аас 15 куб метр усны хэрэглээтэй хэрэглэгчдийн 4.7%-д усны зардал нь өрхийн орлогын 5-аас илүү хувийг эзэлж байгаа бол 15 куб метрээс илүү усны хэрэглээтэй өрхүүдийн 4.3% нь өрхийнхөө орлогын 5-аас илүү хувийг усанд зарцуулж байна.

Хүснэгт 14: Усны хэрэглээний түвшнээс хамааран цэвэр ус, бохир усны төлбөрийн өрхийн орлогод үзүүлэх дарамт

Усны тоолууртай орон сууцны хэрэглэгчид	Усны төлбөр	Цэвэр болон бохир ус	Усны төлбөр нь өрхийн орлогын 5-аас дээш хувь эзэлдэг өрхүүдийн эзлэх хувь
Маш бага хэрэглээтэй: 5 м ³ доош	1	1.5	2.6
Бага хэрэглээтэй: 5-аас 8 м ³	1.3	1.9	2.6
Их хэрэглээтэй: 8-аас 15 м ³	1.2	1.8	4.7
Маш их хэрэглээтэй: 15 м ³ дээш	1.8	3	4.3
Хэрэглэгчийн дундаж	1.2	1.9	3.5

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Зураг 23-т харуулсанчлан **орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчид тоолууртай хэрэглэгчидтэй нэгэн адил сэтгэл ханамж бага байна** (засвар хийсний дараа ус үргүй зарцуулах, ус халуун болтол гоожуулах, ус зэвтэй ирэх, хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмжгүй байдал). Усны тоолуургүй хэрэглэгчид нэмэлт хоёр асуудалд, тухайлбал усны тоолуурын баталгаажилт хийх үйл явц болон тоолуурын нарийвчлал гэсэн асуудалд сэтгэл ханамж бага байгаа бөгөөд уг хоёр үзүүлэлтэд өгсөн сөрөг оноо нь бүх хэрэглэгчдийн сэтгэл ханамж бага байдлын түвшин өндөр байгааг харуулж байна. **Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн хэрэглэсэн усны хэмжээг тооцдог** аргад\байдалд сэтгэл ханамж бага байгаа нь эдгээр хэрэглэгчид хэрэглэсэн усны төлбөрт хэт их төлбөр төлдөгтэй холбоотой юм. (Бүлэг 3-ыг үзнэ үү).



Зураг 23: Орон сууцны усны тоолууртай болон тоолуургүй хэрэглэгчдийн усны үйлчилгээ, усны чанарын талаарх сэтгэл ханамжийн түвшнийг харьцуулсан байдал

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

5.1.2 Гэр хорооллын өрхийн хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин


Дээр дурдсанчлан **гэр хорооллын хэрэглэгчид усны үйлчилгээ, чанарын талаар харьцангуй сэтгэл ханамж өндөртэй байна**. Усны эс үүсвэрээр дүн шинжилгээ хийхэд зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн (гэр хорооллын хэрэглэгчдийн 57%; Бүлэг 3-ыг үзнэ үү) ус авахад УТБ дээр хүлээдэг хугацаа, гэрээс УТБ хүртэлх зай, усны чанар (зэв, амт болон үнэр), төлбөр төлөх арга хэрэгсэл, хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал болон хэрэглэгчийн санал гомдлыг шийдвэрлэдэг байдал зэрэгт их **сэтгэл ханамж бага байна**.

Ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн (гэр хорооллын хэрэглэгчдийн ойролцоогоор 22.1%) **сэтгэл ханамжийн түвшин илүү ялгаатай, жигд бус байна**. Хэрэглэгчдийн бусад бүлэгтэй харьцуулбал УТБ-ны ажиллах цагийн хуваарь, төлбөр төлөх аргын хувьд сэтгэл ханамжийн түвшин өндөр байна. Эсрэгээр ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчид эвдрэл гэмтэл гарах давтамж, түгээж буй усны хэмжээний

талаар сэтгэл ханамж бага, фокус бүлгийн хэлэлцүүлгээс харахад энэ нь усны даралттай холбоотой асуудал байдаг ажээ.

Түгээгчтэй УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчид (гэр хорооллын хэрэглэгчдийн ойролцоогоор 13.4%) **УТБ хүртэлх зай, түгээж буй усны хэмжээ, эвдрэл гэмтлийг засах хугацааны талаар илүү сэтгэл ханамж өндөртэй байна.** Эдгээр үзүүлэлтээс хоёрт нь ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчид огт сэтгэл ханамж бага байсан. Энэ нь фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон хэрэглэгчид онцолсноор яагаад энэ хоёр төрлийн УТБ-ыг хослуулан ашиглахыг илүүд үзэж байсны шалтгаан байж болох юм.

Хувийн худгаар үйлчлүүлдэг хэрэглэгчид (гэр хорооллын хэрэглэгчдийн ойролцоогоор 7.5%) **дараах үзүүлэлтүүдийн хувьд сэтгэл ханамжтай байна.** Ус авахад УТБ дээр хүлээдэг хугацаа, УТБ-ны гаднах орчны тохижилт, усны чанар (усны тунгалаг байдлыг эс тооцвол зэв, усны амт, үнэр), түгээж буй усны хэмжээ, эвдрэл гэмтэл гарах давтамж, эдгээрийг засах хугацаа, мөн хэрэглэгчдийн санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэх байдал зэрэг болно. Түгээгчтэй УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчидтэй нэгэн адил УТБ хүртэлх зай, УТБ-ны ажиллах цагийн хуваарийн хувьд сэтгэл ханамж багатай байна.



Зураг 24: Гэр хорооллын хэрэглэгчдийн усны үйлчилгээ, усны чанарын талаарх сэтгэл ханамжийн түвшин, ундны усны гол эх үүсвэрээр

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Хүснэгт 15: Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн дундаж түвшин

Төвлөрсөн шугам сүлжээнд	Төвлөрсөн шугам сүлжээнд	Зөөврийн ус хангамжтай УТБ	Хувийн худаг болон
--------------------------	--------------------------	----------------------------	--------------------


	холбогдсон ухаалаг УТБ	холбогдсон түгээгчтэй УТБ		бусад эх үүсвэр
УТБ-ны ажиллах цагийн хуваарь	1.17	0.85	0.81	0.87
Ус авахад УТБ дээр хүлээдэг хугацаа	0.99	0.89	0.80	1.00
Гэрээс УТБ хүртэлх зай	0.74	0.83	0.66	0.67
УТБ-ны гаднах орчны тохижилт	0.85	0.87	0.86	0.91
Нийлүүлсэн усны хэмжээ/хүртээмж	0.73	0.95	0.91	1.06
Усны тунгалаг байдал	1.00	0.99	0.96	0.94
Зэв	1.06	1.05	1.01	1.12
Усны амт	0.97	0.94	0.90	1.05
Усны өнгө	1.05	1.07	1.05	1.11
Усны үнэр	1.07	1.09	1.01	1.21
УТБ-ны үйл ажиллагааны доголдол тасалдал	0.77	0.94	0.89	0.99
Эвдрэл гэмтлийг засах хугацаа	0.88	1.14	0.98	1.16
Төлбөр төлөх байдал	1.15	0.96	0.90	1.06
Харилцагчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал	1.03	0.91	0.89	1.02
Санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх	0.97	0.99	0.91	1.08

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: Тод үсгээр бичсэн тоонууд нь харгалзах үзүүлэлтэд өгсөн хамгийн бага оноог илэрхийлнэ.

5.1.3 Өрхийн хэрэглэгчдийн зарим дэд ангиллын сэтгэл ханамжийн түвшин

Зураг 25-д Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдах боломжтой хэрэглэгчдийн дэд ангиллын сэтгэл ханамжийн дундаж түвшнийг харуулав. Дээрх дүн шинжилгээнд тайлбарласны дагуу аль ч ангиллын гэр хорооллын хэрэглэгчид усны үйлчилгээ, чанарын талаар сэтгэл ханамж сайтай байна. Үүнтэй адил Зураг 25-т үзүүлсэнчлэн усны хэрэглээ ихтэй орон сууцны хэрэглэгчид (гурав ба түүнээс олон хүүхэдтэй өрхүүд) бага оноо өгсөн байна. Энэ ангилалд багтах усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчид онцгойлон сэтгэл ханамж бага (оноо нь сөрөг) байна. Хүнсний талон авдаг өрхүүд мөн адил сэтгэл хангалуун бус байна.



Зураг 25: Усны үйлчилгээ, чанарын талаарх өрхийн сэтгэл ханамжийн дундаж түвшин (-2 ба +2), хэрэглэгчдийн зарим дэд ангилал, хэрэглэгчийн төрлөөр


Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

5.2 Нэн түрүүнд сайжруулалт хийх шаардлагатай чиглэлүүдийн талаарх хэрэглэгчдийн санал бодол

5.2.1 Орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн ус хангамжийн үйлчилгээг сайжруулах эрэлт хэрэгцээ

Орон сууцны хэрэглэгчдийн ус хангамжийн үйлчилгээг сайжруулах шаардлага нь тэдний сэтгэл ханамж бага байгаа шалтгааныг тод илэрхийлж байна. **Орон сууцны усны тоолууртай болоод тоолуургүй хэрэглэгчдийн аль аль нь ус үргүй зарцуулах, зэвийг арилгах талаар ямар нэгэн арга хэмжээ авахыг хүсэж байна.** Орон сууцны усны тоолууртай хэрэглэгчдийн бараг тал хувь нь (45%), тоолуургүй хэрэглэгчдийн 35% нь засвар хийсний дараа зэв арилтал ус гоожуулж ус үргүй зарцуулах байдлыг багасгахыг хүсэж байна; орон сууцны тоолууртай хэрэглэгчдийн 34%, тоолуургүй хэрэглэгчдийн 19% нь ус халуун болтол гоожуулах хугацааг багасгах; орон сууцны тоолууртай хэрэглэгчдийн 38%, тоолуургүй хэрэглэгчдийн 30% нь усны зэвийг арилгахыг хүсэж байна.

Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн хувьд (22%) усны тоолуур суурилуулах нь үйлчилгээг сайжруулахыг хүсэж буй гуравдах чухал асуудал болж байна.



Зураг 26: Усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн ус хангамжийн үйлчилгээг сайжруулах эрэлт хэрэгцээ

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Засвар хийсний дараа зэвтэй ус ирэх, мөн төвлөрсөн дулаан хангамжийн системд түгээмэл тохиолддог ус халуун болтол удаан гоожуулж үргүй ус зарцуулах асуудал

Улаанбаатар хотын хэрэглэгчдийн хувьд хурцаар тавигддаг асуудал байна. Усны үйлчилгээ, усны чанарын талаарх хэрэглэгчдийн үнэлгээ, сайжруулах шаардлагууд нь эдгээр асуудалд голлон төвлөрч байна. Фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр гарсан санал хүсэлтээс харахад хэрэглэгчид засвар хийсний дараа ус халуун болтол удаан, зарим тохиолдолд нэг цаг ба түүнээс ч удаан хугацаагаар ус гоожуулах болдог байна. Эдгээр асуудлын шалтгааныг олж, тайлбарлах нь уг судалгааны хамрах хүрээнээс гадуур юм. Төвлөрсөн дулаан хангамжийн систем нь хэрэглэгчдийн янз бүрийн эрэлт хэрэгцээнд төдийлөн сайн тохироогүйн зэрэгцээ уг системийн засаглал нь түгээлтийн системийн сүүлчийн хэсгийг засварлахыг дэмжиж чаддаггүй нь харуулж байна. Үүний улмаас ус түгээх хоолойн систем нь урт, хоолой нь зэвэрсэн, эвдрэл гэмтэл тогтмол гардаг, засвар хийхийн тулд системийн нэлээдгүй хэсгийг хаах шаардлагатай болдог байна.⁶²

Фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр нэг хэрэглэгчийн хэлснээр (Шигтгээ 4-ийг үзнэ үү) усыг удаан хугацаанд гоожуулах хэрэгтэй гэсэн хэрэглэгчийн үйлчилгээний өгдөг зөвлөгөө, ерөнхийд нь авч үзвэл түгээгч байгууллага асуудлыг шийдвэрлэх тууштай арга хэмжээ авахгүй байгаа нь ОСНААУГ-ын зүгээс өгдөг ус хэмнэх уриалгатай зөрчилдөж байна (ФБХ-ийн үеэр Чингэлтэй дүүргийн оршин суугч ярьсан). Фокус бүлгийн хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмж нь **усыг үрэлгэн зарцуулах байдал нь** усны хэрэглээ ихтэй хэрэглэгчдэд илүү нөлөөлдөг болохыг харуулж байна (Шигтгээ 4-ийг үзнэ үү). Усны томоохон хэрэглэгчид бусад хэрэглэгчидтэй харьцуулбал ус хангамжийн бүх үйлчилгээг доогуур үнэлж байгаа нь эдгээр хэрэглэгчид огт сэтгэл ханамж бага байдгийг тодоор харуулж байна. Өрхийн усны алдагдлын бодит хэмжээ тодорхойгүй, уг алдагдал нь ОСНААУГ эсвэл УСУГ-ын орлогод шууд сөргөөр нөлөөлөхгүй хэдий ч усыг үр ашиггүй зарцуулдаг байдалд анхаарал хандуулахгүй байж болохгүй.

Шигтгээ 4: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Усны үргүй зарцуулалт

“[манайх] ам бүл 5, бага насны 3 хүүхэдтэй. Усны хэрэглээ ихтэй. Угаалгын машинаар угаалга их хийдэг. Гэхдээ усыг хэмнэх тал дээр анхаардаг, хэрэглээгээ хянадаг. Бүх крантандаа ус хянах төхөөрөмж суурилуулсан. Ус их гарах бас нэг шалтгаан бол халуун усыг нэлээд гоожуулж байж халдаг учир тэр ашиглахгүй гоожуулж байгаа ус хий асгардаг. Өдөр бүр халуун ус байдаггүй, халуун усыг гоожуулаад ойролцоогоор 10-15 минутын дараа халуун ус ирдэг. Энэ талаар байнга гомдол гаргадаг. Гомдол хүсэлтийг хүлээн авдаг хэдий ч үр дүн гарсан зүйл байхгүй”

- Баянгол дүүргийн орон сууцны оршин суугч 36 настай, эрэгтэй

“Манайд орой 20 цагаас хойш муу халуун ус ирдэг. Яасан ч халахгүй байна гэсэн шаардлага тавихад “Та 1 цаг орчим гоожуул” гэж хэлсэн. Усаа хэмнэ гэдэг хэр нь ОСНААУГ [контор] ингэж хэлсэн. ...халуун усыг бүтэн цаг гоожуулна гэхэд хэдэн тонн гоожуулах бол, тэр усны төлбөрийг бид бас төлөх болно. Ам бүл тавуулаа амьдардаг. Өндөр настай ээжтэй, хоёр хүүхэдтэй...”

- Сонгинохайрхан дүүргийн орон сууцны оршин суугч 32 настай, эмэгтэй

“Манайх ам бүл дөрөв. Ойролцоогоор 6-7 м³ ус хэрэглэдэг. Халуун ус гоожихоороо зэв гардаг болохоор нэлээд ус гоожуулдаг... хэрэгцээгүй ус ихээр нэлээд зарцуулдаг тул усны хэрэглээ их гардаг...”

- Хан-Уул дүүргийн орон сууцны оршин суугч 59 настай, эмэгтэй

⁶² Төв ба Зүүн Европ, хуучин ЗХУ-ын халаалтын системийн үр ашгийг нэмэгдүүлэх нь (2000). Эрчим хүчний салбарын удирдлагын тусламжийн хөтөлбөр (ESMAP). https://www.esmap.org/sites/default/files/esmap-files/Rpt_Increasing_heatingsystemsesm234.pdf


5.2.2 Гэр хорооллын өрхийн хэрэглэгчдийн ус хангамжийн үйлчилгээг сайжруулах эрэлт хэрэгцээ

Төвлөрсөн шугамд холбогдох, ухаалаг картаар төлбөр хийх боломжийг нэмэгдүүлэхийг гэр хорооллын бүх өрх **хамгийн ихээр дэмжиж** байна (төвлөрсөн шугамд холбогдохыг гэр хорооллын нийт хэрэглэгчдийн 41%, ухаалаг картаар төлбөр хийхийг 40% тус тус дэмжиж байна). Ухаалаг УТБ-наас ус авахад төлбөрөө ухаалаг картаар төлдөг хэрэглэгчид гэртээ ус хүргэдэг үйлчилгээтэй болохыг хүсдэг бөгөөд энэ нь төвлөрсөн шугамд холбогдох гэсэн эрэлт хэрэгцээний дараа хоёрдугаарт орж буй ус хангамжийн үйлчилгээг сайжруулах эрэлт хэрэгцээ болж байна.

Гэр хорооллын хэрэглэгчдийн төвлөрсөн шугамд холбогдох, гэртээ ус хүргэдэг үйлчилгээтэй болох, гэртээ ойрхон УТБ-тай болох, УТБ-ны ажиллах цагийг уртасгах, УТБ өдөр болгон ажилладаг болох (санал болгосон 16 өөрчлөлтөөс 1, 3, 4, ба 5-д хамгийн ихээр дурдсан) гэсэн эрэлт хэрэгцээ нь хэрэглэгчдийн ус цуглуулахад зарцуулдаг цаг буюу цаг хугацааны үнэ цэнийг бууруулахын ач холбогдлыг харуулж байна. Хэрэглэгчдийн эдгээр шаардлага нь гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээ, ус авах хэв маягийн талаар тайлангийн 3.1.3-т хийсэн дүн шинжилгээтэй холбоотой юм. Уг дүн шинжилгээгээр УТБ хүртэлх зай, ундны ус авахад зарцуулдаг хугацаа, долоо хоногт ус авдаг давтамж (Хүснэгт 8) болон ус авахтай холбоотой хүндрэлийг авч үзсэн бөгөөд эдгээр хүндрэлийг хэрэглэгчийн ус (ундны ус болон бусад зориулалтаар ашиглах ус) авах давтамж, зарцуулах хугацаатай холбоотой алдагдсан боломжийн өртгөөр тооцон харуулсан.

Сонирхолтой нь, зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн талаас илүү хувь нь (57%) ухаалаг картаар төлбөр төлдөг үйлчилгээг нэмэгдүүлэхийг дэмжиж байна. Эдгээр хэрэглэгчид одоогийн төлбөр тооцоо хийх аргад хамгийн их сэтгэл ханамж бага гэсэн үнэлгээг өгч байна. Эндээс харахад УТБ хүртэлх зайны болон УТБ-ны ажиллах цагийн хуваариас бусад хүчин зүйлс нь гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээнд нөлөөлдөг болохыг харуулж байна. Гэвч ухаалаг карт ашиглах нь УТБ-ны тасралтгүй ажиллах хугацаа, өдөр болгон ажилладаг цагийн хуваарьтай хэрэглэгчид хэрхэн холбож ойлгож байгаа нь тодорхойгүй байна. Фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр хэрэглэгчид энэ талаар илүү ойлголт өгөх мэдээлэл өгөөгүй юм.

Ус төлөх гар утасны аппликейшныг УТБ-д нэвтрүүлэх нь эдгээр хэрэглэгчдэд тустай байж болох юм, учир нь зөөврийн ус хангамжтай УТБ-ыг ухаалаг болгон шинэчлэхэд эхлээд эдгээр УТБ-ыг төв шугамд холбох хэрэгтэй бөгөөд үүнд цаг хугацаа, хөрөнгө шаардагдана. ТТЭ-ийн судалгааны хүрээнд хэрэглэгчдийн уг аппликейшныг ашиглах чадварын талаар тайлбар өгөх боломжгүй, харин төлбөрийн хялбар аргуудын эрэлт хэрэгцээ их байгаа, мөн ус авахад эдийн засгийн бусад их хэмжээний зардал байгаа тул уг аппликейшныг ашигласнаар ус авахад илүү хялбар болж, хэрэглэгчид дээрх хүндрэл бэрхшээлийг хурдан даван туулж чадахгүй бол сэтгэл гонсойж магад юм.



Зураг 27: Гэр хорооллын бүх хэрэглэгчдийн үйлчилгээг сайжруулах шаардлага, ундны усны гол эх үүсвэрээр

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Хүснэгт 16: Гэр хорооллын хэрэглэгчдийн шаардаж буй дөрвөн төрлийн үйлчилгээ, ундны усны эх үүсвэрээр

	Гэр хорооллын бүх хэрэглэгч	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон ухаалаг УТБ	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон түгээгчтэй УТБ	Зөөврийн ус хангамжтай УТБ	Хувийн худаг болон бусад эх үүсвэр
Шугам сүлжээнд холбогдох	41%	55%	21%	44%	41%
Ухаалаг картаар төлбөр хийх	40%	5%	38%	57%	40%
Алдагдсан боломжийн өртгийг бууруулах (гэрт ойрхон УТБ, ажиллах цагийг уртасгах, өдөр болгон ажилладаг болох, гэрт ус хүргэх)	43%	35%	36%	49%	43%
Усны тунгалаг байдал	41%	55%	21%	44%	41%

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа



Зураг 28: Гэр хорооллын хэрэглэгчдийн хамгийн их шаардаж байгаа үйлчилгээг сайжруулах дөрвөн чиглэл, ундны усны гол эх үүсвэрээр

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Хүснэгт 17: Гэр хорооллын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, ундны усны эх үүсвэрээр

	Нийт	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон ухаалаг УТБ	Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон түгээгчтэй УТБ	Зөөврийн ус хангамжтай УТБ	Хувийн худаг болон бусад эх үүсвэр
Төвлөрсөн шугамд холбогдох	41%	55%	21%	44%	27%
Ухаалаг картаар төлбөр хийдэг болох	40%	5%	38%	57%	30%
Гэртээ ойрхон УТБ-тай болох	20%	17%	9%	22%	27%
Гэртээ ус хүргэх үйлчилгээтэй болох	14%	21%	15%	11%	12%
УТБ-ны ажиллах цагийг уртасгах	13%	2%	13%	17%	15%
УТБ-ыг өдөр бүр ажилладаг болох	11%	3%	9%	15%	12%
УТБ орчмын тохижилт цэвэрлэгээг сайжруулах	10%	12%	14%	9%	8%
Цэвэр тунгалаг байдлыг сайжруулах	9%	7%	10%	8%	14%
Харилцагчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал	5%	10%	3%	5%	3%
Нэмэлт амтгүй байх	5%	5%	5%	4%	7%
УТБ-ны үйл ажиллагааны доголдол тасалдлыг бууруулах	3%	7%	1%	3%	1%
Эвдрэл гэмтлийг хурдан засварлах	3%	5%	4%	2%	1%
Зэвтэй ус гардаггүй байх	3%	3%	3%	3%	1%
Үнэргүй байх	2%	2%	2%	3%	3%
Санал гомдол хурдан шийдвэрлэх	2%	3%	1%	2%	0%
Өнгөгүй байх	1%	1%	1%	1%	2%

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: Тод үсгээр дурдсан шаардлага хэрэглэгчдийн тавьж буй гол шаардлага, тод үсгээр бичсэн тоо нь энэ шаардлагыг хамгийн ихээр тавьсан хэрэглэгчийн бүлэгт хамаарна.

УСУГ-ын 2020 хийсэн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны⁶³ үр дүнгээс үзэхэд гэр хорооллын хэрэглэгчдийн шаардаж байгаа үйлчилгээний сайжруулалт нь гол төлөв

⁶³ “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа (2020). УСУГ-ын захиалгаар Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп гүйцэтгэв.

УТБ-ны гаднах орчныг сайжруулах эрэлт хэрэгцээ байгааг харуулж байна. Тухайлбал, “Гэр хорооллын хэрэглэгчдийн дундаж сэтгэл ханамжийг өсгөхөд хэрэглэгчдийн хамгийн их ач холбогдол өгч байгаа үзүүлэлт болох УТБ-ны гаднах орчныг сайжруулах нь зүйтэй. Ус түгээх байрны гадна орчинд анхаарал хандуулж өвөлдөө хөлдөж мөстдөг, зундаа шавар шавхай үүсдэг байдлыг бууруулж ус түгээх байрны орчныг тохижуулах хэрэгтэй байна. Ус авч байх үед ус хий асгардаг тул ус авдаг хэсэгт ус зайлуулагч хийх хэрэгтэй байна. Ихэвчлэн хүүхдүүд УТБ-аас ус авдаг тул машин замтай ойр байдаг худгийг хашаатай болгож хүүхдийн аюулгүй байдлыг хангах хэрэгтэй байна”⁶⁴.

5.3 Хэрэглэгчийн мэдээллийн эх сурвалж

ТТЭ-ийн Судалгаагаар фокус бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнг ашиглан усны талаарх мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх илүү тохиромжтой хэвлэл мэдээллийн хэрэгслийг судалж үзсэн.

ФБХ-ийн урьдчилсан үр дүнгээс (Шигтгээ 5-ыг үзнэ үү) үзэхэд олон нийтэд мэдээ мэдээлэл түгээх зорилгоор зар тавих, (жишээ нь УТБ дээр мэдээлэл байршуулах), ТВ-ээр зарлах, УТБ дээр товхимол тараах, зарлал байрлуулах зэрэг хэвлэл мэдээллийн уламжлалт хэлбэрүүдийг бүх хэрэглэгчдэд зориулсан чухал мэдээлэл түгээхэд олон нийтийн сүлжээнээс илүү тохиромжтой гэж үзсэн байна.

Шигтгээ 5: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Мэдээллийн эх сурвалж

“Усны талаар бодож үзэж байгаагүй, харин одоо бол би мэдээлэл авахыг шаардана. Усны талаар асуудал гарвал л авахыг хүсэх байсан байх. УТБ дээр тодорхой самбар дээр мэдээлэл тавьдаг байх хэрэгтэй. УСУГ-ын мэргэжлийн нэгжээс мэдээлэл өгдөг байх. Телевизээр мэдээлэл өгдөг байвал зүгээр байна. УСУГ-аас гаргасан усны талаар богино хэмжээний шторк явуулбал их хэрэгтэй.”

- Гэр хороололд амьдардаг 33 настай эрэгтэй

“Өөрсдийн хэрэгцээт мэдээллийг цахимаар авдаг. Ер нь ТВ-үүдээр устай холбоотой мэдээ гардаггүй. Цахимаар усны хэрэглээний талаар авдгаас биш төлбөрийн талаар мэдээллээ авдаггүй.”

- Орон сууцанд амьдардаг 54 настай эмэгтэй

“Залуучуудын хувьд нийгмийн сүлжээ. Харин настай хүмүүсийн хувьд бүх төрлийн мэдээллийн сувгаар гээд бүх хүнд боломжит, тохирсон сувгаар өгөх. Энэ зөвхөн тухайн байр, орон сууцны асуудал биш, улсын хэмжээний асуудал ярьж байгаа учир. Жишээ нь “Цагийн хүрд”-ээр хэдэн минутын богино контентыг телевизээр гаргадаг.”

- Орон сууцанд амьдардаг 22 настай эмэгтэй


“Зурагтаар мэдээлэл авахыг илүүд үздэг. Өндөр настай хүмүүс тэр бүр фейсбүүк ашиглаж мэдэхгүй.”

- Гэр хороололд амьдардаг 43 настай эмэгтэй

Хэрэглэгчид мэдээлэл хаанаас авдаг тухай ТТЭ-ийн судалгааны асуултад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ нь усны сэдвээр мэдээлэл авдаг гол эх сурвалж болдог гэж судалгаанд оролцсон өрхүүд хариулсан байна. Усны үйлчилгээ, чанартай холбоотой олон асуудал байгааг орон сууцны хэрэглэгчид судалгаанд мэдээлж байсан нь нийлүүлэгч байгууллагад мэдээлэл авахаар хандах тохиолдол (орон

⁶⁴ Дээрх судалгаанд

сууцны хэрэглэгчдийн зөвхөн 7%, гэр хорооллын хэрэглэгчдийн 4%) бага байгаатай нь нийцэхгүй байсан.



Зураг 29: Хэрэглэгчдийн усны сэдвээр мэдээлэл авдаг эх сурвалж, хэрэглэгчдийн ангиллаар

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Орон сууцны хэрэглэгчдийн дийлэнх нь олон нийтийн сүлжээнээс мэдээлэл авахаар ханддаг бөгөөд 18-39 насны хэрэглэгчдийн хувьд олон нийтийн сүлжээ мэдээллийн гол эх сурвалж нь болдог байна. Гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд олон нийтийн сүлжээ нь 18-29 насныхны хувьд мэдээллийн гол эх сурвалж нь болдог байна.

Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогч залуус өөрсдийн СӨХ эсвэл УСУГ-ын албан ёсны веб хуудас фейсбүүк хуудас байдгийг мэдэж байсан. Залуучууд онлайнаар мэдээлэл авахыг илүүд үздэг ч олон нийтийн сүлжээг тэр бүр мэдээллийн найдвартай эх үүсвэр байдаггүй хэмээн тэмдэглэж байв. Залуучуудын ашигладаг бусад мэдээллийн эх сурвалжийн хувьд телевиз нь мэдээллийн хоёр дахь чухал эх сурвалж нь болдог байна. Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон зарим иргэд богино хэмжээний нэвтрүүлэг, ярилцлага үздэг тухай дурдаж байсан бол зарим нь үнэн зөв мэдээлэл авах үүднээс Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз (МҮОНТ) болон бусад үндэсний сувгуудыг үздэг хэмээн онцолж байв.

Телевизээр мэдээлэл түгээх аргуудын хувьд МҮОНТ-ийн мэдээний нэвтрүүлгийн үеэр устай холбоотой хэдэн минутын контент, ярилцлага, мэдээлэл өгвөл хүн амын бүх бүлгүүдэд хүртээмжтэй эх сурвалж болно хэмээн фокус бүлгийн хэлэлцүүлгээр дурдаж байсан. Орон сууцны цөөн хэдэн хэрэглэгч контор, хороо, конторын байцаагчаас мэдээлэл авахыг илүүд үздэг байна. Гэр хорооллын хэрэглэгчид УТБ-д мэдээлэл байршуулах эсвэл ус түгээгчээс дэлгэрэнгүй мэдээлэл авахыг илүүд үздэг байна.

6. ӨРХИЙН УС ХАНГАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЦЭЭ, ТӨЛБӨР ТӨЛӨХ ЭРМЭЛЗЭЛ

Энэ бүлэгт 1 болон 5 дугаар зорилт: “Сайжруулсан ус хангамжийн үйлчилгээнд Улаанбаатар хотын орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийг тооцож, усны үйлчилгээний эрэлт хэрэгцээг үнэлэх, төлбөр төлөх эрмэлзэлд нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн болон сэтгэл ханамжийн гол үзүүлэлтүүдийг тодорхойлох”-ын хүрээнд хийсэн дүн шинжилгээг тусгав.

Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан үйлчилгээний зорилтот түвшин, түүнд холбогдох хөрөнгө оруулалт, төлөвлөлт хийх шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр усны салбарын эрх бүхий байгууллагуудыг хангах (судалгааны хоёр дахь зорилго)-ын тулд ТТЭ-ийн судалгаа нь үйлчилгээг сайжруулах болон ирээдүйд усны хомстол, хязгаарлалтаас сэргийлэхийн тулд хөрөнгө оруулалт хийхтэй холбоотойгоор тарифыг нэмэгдүүлэхэд хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийн талаар мэдээлэл цуглуулсан. ТТЭ-ийн судалгааны удирдамжийг ХСУХАТАУЗЗ, УСУГ, ОСНААУГ, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, БХБЯ, хувийн конторууд, Монголын МСС, МСК зэрэг усны салбарын эрх бүхийн байгууллагууд болон гол оролцогч талуудтай хэлэлцүүлэг хийсний үндсэн дээр боловсруулсан. Энэ бүлэгт судалгааны үзэл баримтлал, аргачлалын тайлбарын дараа гэр хорооллын хэрэглэгчдийн сайжруулсан үйлчилгээнд (ялангуяа шинэ болон сайжруулсан УТБ-нд) болон усны хомстол, хязгаарлалтаас сэргийлэхэд үзүүлэх төлбөр төлөх эрмэлзэл, орон сууцны хэрэглэгчдийн хомстол, хязгаарлалтаас сэргийлэхэд үзүүлэх төлбөр төлөх эрмэлзлийн талаар авч үзсэн болно. Бүлгийн төгсгөлд хэрэглэгчдийн дундаж төлбөр төлөх эрмэлзлийг тодорхойлогч хүчин зүйлүүдийн нарийвчилсан шинжилгээг харуулсан.

6.1 Үзэл баримтлал, судалгааны аргачлал

6.1.1 Төлбөр төлөх эрмэлзлийн тухай ойлголт, судалгааны аргачлал болон анхаарах зүйлс

Төлбөр төлөх эрмэлзэл нь хэрэглэгч үйлчилгээний үр өгөөжийг хүртэхийн тулд төлөхөд бэлэн байгаа хамгийн дээд үнийг хэмждэг эдийн засгийн ойлголт юм. Энэ нь хэрэглэгч тухайн үйлчилгээний бусад бараа, үйлчилгээнээс илүү үр өгөөжтэй байдал болон өөрийн төсвийн хэмжээг харгалзан үзсэний үндсэн дээр үйлчилгээг авах хүслээс хамаарна. Оролцогч талуудтай хэлэлцүүлгүүд хийсний үндсэн дээр гэр хорооллын хэрэглэгчдээс үйлчилгээний чанарыг сайжруулах (ялангуяа шинэ болон сайжруулсан ухаалаг УТБ) болон усны хомстолоос сэргийлэхийн тулд тэдний төлбөр төлөх эрмэлзэл ямар байгаа талаар асуусан. Орон сууцны хэрэглэгчдийн хувьд одоогоор үйлчилгээг сайжруулах тодорхой төлөвлөгөө байхгүй байгаа тул зөвхөн усны хомстол, хязгаарлалтаас сэргийлэхийн тулд төлбөр төлөхөд бэлэн байгаа талаар асуусан. Ерөнхий түвшинд, эдгээр өрхийн төлбөр төлөх эрмэлзлийн цэвэр өсөлтийн нийлбэр нь бодлого боловсруулагчдад үйлчилгээ үзүүлэх аливаа төлөвлөсөн арга хэмжээнээс хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжийн нийлбэрийн талаар мэдээлэл өгөх болно.

ТТЭ-ийг хэмжихэд хэд хэдэн арга зүйг ашигласан. Үүнд:

Зах зээлийн үнийн аргыг ашиглан үнэлэх (*Revealed preference*) арга нь тодорхой үйлчилгээний талаар өрхүүдийн илүүд үзэж буй сонголтыг тодорхойлохын тулд бусад зах зээлийн эдийн засгийн зан төлөвт тулгуурладаг. Жишээ нь, гэр хороололд УТБ хаалттай үед савласан цэвэр ус худалдан авах зардал нь өрхийн 24 цагийн турш ус авах

боломжтой болж, хүнсний дэлгүүр явж цэвэр ус худалдан авахаас зайлсхийхийн тулд төлөхөд бэлэн байгаа хамгийн дээд үнийг илтгэдэг. Гэхдээ аюулгүй байдал, хувь хүний амтны сонголт гэх мэт савласан цэвэр усны хэрэглээнд нөлөөлөх бусад хүчин зүйлс бас бий. Энэ нь зөвхөн савласан цэвэр усанд зарцуулсан зардлаар нь 24 цагийн ажилладаг УТБ-нд үзүүлэх ТТЭ-ийг тооцоолох боломжгүй гэдгийг харуулж байна. Үүний нэгэн адил, Улаанбаатар хотын оршин суугчид өмнө нь усны хомстолд орж байгаагүй тул усны хомстол нь хэрэглэгчдийн усны хэрэгцээнд, усны хэрэглээний үр өгөөжид хэрхэн нөлөөлөхийг тайлбарлахын тулд дүн шинжилгээ хийх өгөгдөл, дата байхгүй байна.

ТТЭ -ийн судалгаанд ашиглагдсан санал асуулгад тулгуурлан үнэлэх (*The stated preference*) арга нь асуулга судалгаа болон ФБХ-ийн үеэр хэрэглэгчдээс таамаглал бүхий үнийн хувилбаруудад үзүүлж буй ТТЭ-ийг хувилбарт үнийн асуултуудаар шууд асуудаг. Хэрэглэгчдээс санал болгож буй үйлчилгээний үнийг тодорхойлох болон тухайн үйлчилгээнд санал болгож буй үнийг төлөхөд бэлэн байгаа эсэхийг асуусан. Энэ аргын хувьд нэг анхаарууштай зүйл нь зөвхөн таамаглалын мэдээлэл цуглуулдаг явдал юм. Өрхийн хариулт нь тухайн судалгаа эсвэл хэлэлцүүлгийн үеийн өрхийн ТТЭ-ийг тодорхойлдог. Энэхүү судалгаагаар гарсан ТТЭ нь ирээдүйд шинэ тариф мөрдөгдөж эхлэх үед тухайн тарифыг судалгаанд оролцогч төлөхөд бэлэн эсвэл хүлээн зөвшөөрч буй гэдгийг илэрхийлэхгүй. Судалгаанд оролцогч шинэ тарифыг хүлээн зөвшөөрөхөд нөлөөлж буй нөхцөл байдал болон хувьсагчид тухайн үед өөрчлөгдсөн байх боломжтой.

Энэхүү судалгаа нь ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг урьдчилан таамагласан хувилбаруудаар хэрэглэгчдийн ТТЭ-ийг хэмждэг тул бодлогын чухал ач холбогдолтой юм. Хэрэв хөрөнгө оруулалт нь хурдан хийгдээгүй эсвэл оролцогчийн урьдчилан тооцоолоогүй байдлаар хэрэгжсэн бол оролцогчийн нэмэгдсэн тарифын бэлэн байдал нь судалгаагаар хэмжсэн ТТЭ-ийн тооцоолсон хэмжээтэй тохирохгүй байх магадлалтай.

Бусад анхаарууштай асуудал⁶⁵ нь оролцогчдын шийдвэрт нөлөөлөхийн тулд стратегитай хариулах боломжтой эсвэл "тохиромжтой хариултын тухайд эргэлзэж байгаа, ярилцлага авагчид таалагдахыг хүссэн хариулагч анхны үнийг "зөв" санал" гэж ойлгох магадлалтай."⁶⁶

Усыг хэмнэх хэрэглэгчдийн хандлагын талаарх нэмэлт асуултууд болон эдгээр таамаглалаар Улаанбаатар хотын хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзэлд дүн шинжилгээ хийх нь хэрэглэгчдийн тарифын өсөлтөд хандах хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх үндсэн мэдээллийг өгдөг.

6.1.2 Төлбөр төлөх эрмэлзлийн судалгааны асуултууд

Судалгаанд ашигласан хувилбарт үнийн аргачлалыг Шигтгээ 6-д үзүүлэв. Гэр хорооллын хэрэглэгчдээс 1 литр усанд төлөхийг зөвшөөрч буй үнийн тодорхой түвшнүүдийн хувьд хувилбарт (таамаглалт) асуултууд асуусан. Шугамд холбогдсон орон сууцны хэрэглэгчдээс сарын усны төлбөрийг нь 25%, 50%, 100% нэмэгдүүлэхэд төлөх эсэхийг асуусан.⁶⁷ Хувилбар тус бүрийн хувьд, судалгаагаар хэрэглэгчийн ТТЭ-

⁶⁵ Ж.Н.Дуберштейн, Ж.Э.Де Стайгер нарын дурдсанаар (2003 оны Аравдугаар сар). Хувилбарт үнэ ба усны сав газрын менежмент: Өмнө ба ирээдүйн хэрэглээний тойм. Усны сав газрын судалгааны агентлаг хоорондын анхдугаар бага хуралд. *АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны Хөдөө аж ахуйн судалгааны алба*.

⁶⁶ Уитингтон нар. (1990). Хөгжиж буй орнуудын усны үйлчилгээний төлбөр төлөх эрмэлзлийг тооцох нь: Гайтигийн өмнөд хэсэгт хувилбарт үнийн судалгааг ашигласан жишээ.

⁶⁷ ҮСХ-ны мэдээлэл цуглуулагчид автоматаар үнийг бодох таблетаар судалгааг авсан.

ийг доор тайлбарласны дагуу дундаж ТТЭ ба хамгийн дээд ТТЭ гэсэн хоёр янзаар тооцоолсон.

Дундаж ТТЭ нь анхны санал болгосон үнэ болон түүний дараагийн асуултууд бүхий 4 интервалын дагуу өрхийн шинж чанар болон тархаалтын эконометрик шинжилгээнээс тооцно. Дундаж ТТЭ-ийг хэрэглэгчийн төрлөөр болон хэрэглэгчийн бүлэг тус бүр дэх хэрэглэгчийн төрлүүдийн хүрээнд тооцоолсон. Үүний тулд, тийм/үгүй гэсэн асуултыг төлбөр төлөх эрмэлзлийн гурван интервалтай харгалзуулан дөрөв ангилсан. Дөрөвдүгээр интервал нь бүх асуултад тийм гэж хариулсан, ТТЭ-ийн дээд хязгааргүй хэрэглэгчийн бүлэгт хамаарна. Эконометрик шинжилгээнд Лопез-Фелдман (2012)-ы боловсруулсан давхар хязгаарлагдмал загвараас үүссэн ТТЭ-ийг тооцдог асуултуудтай аргыг ашигласан.⁶⁸

Хамгийн дээд ТТЭ-ийг тухайн өрхийн үйлчилгээний төлбөрт төлөх тарифын эсвэл цэвэр, бохир усны төлбөрийн боломжит дээд хэмжээг нээлттэйгээр асуусан асуултад өгсөн хариултаар энгийнээр тооцдог.

Шигтгээ 6: Нэмэгдсэн тарифаар төлбөр төлөх эрмэлзлийг тодорхойлох судалгааны асуултууд

Ирээдүйд үүсч болзошгүй усны хомстол болон үйлчилгээг сайжруулах хувилбаруудыг тайлбарласны дараа дараах хоёр төрлийн асуултууд тавигдсан:

- Үнийн хязгаар заагаагүй нээлттэй асуулт
- Анхны санал усны тарифын (гэр хороололд), эсвэл цэвэр, бохир усны төлбөрийн (орон сууцанд) тодорхой түвшингийн дэх ТТЭ-ийн эхний асуулт, оролцогчийн хариултад үндэслэн цаашид өссөн эсвэл буурсан үнийн саналыг дараах хүснэгтэд үзүүлсэний дагуу асуусан. Судалгаанд оролцогчдын ТТЭ-ийн дөрвөн интервалын тархалтаас дундаж ТТЭ-ийн эконометриксийг тооцоолсон.
- Усны хомстол, хязгаарлалтгүй үйлчилгээний ТТЭ-тэй холбоотой хоёр нэмэлт асуулт асуусан. Ирээдүйд усны хомстолд орох магадлалын талаарх судалгаанд оролцогчдын мэдлэг ойлголт, энэ хомстолыг шийдвэрлэхийн тулд их хэмжээний хөрөнгө оруулалт хийхэд үнэ тарифыг нэмэгдүүлэх талаар тэдний санал бодлыг асуусан.

Усны хомстол, хязгаарлалтгүй үйлчилгээнд

Гэр хорооллын оршин суугчид	Орон сууцны оршин суугчид
Зарим хүмүүс 10-15 жилийн дараа Улаанбаатар хот усны нөөцийн хомстолд орж усны хязгаарлалт хийх болзошгүй нөхцөл байдал үүснэ гэж бодож байхад нөгөө хэсэг нь үүнийг хэтрүүлэн хэмээн үзэж байна. Цаашид усны нөөц багассаар байвал усны хомстолоос үүдэн айл өрх, УТБ-ны усны үйлчилгээнд хэмжилт, тасалдал үүсэж болох юм. Танай өрх одоогоор 1 литр усанд 1 төгрөг төлдөг.	Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй хүн ам нь усны нөөцийн хэрэглээг улам бүр нэмэгдүүлж байна. Ирэх 10 жилд усны нөөц хомстохоос сэргийлэн одоо ашиглаж байгаа нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр гүний худгууд гаргах, ус дахин ашиглах үйлдвэр барих, хүн амыг усны баталгаат эх үүсвэрээр хангахад чиглэсэн их хэмжээний хөрөнгө оруулалт хийх юм. Эдгээр хөрөнгө оруулалтыг нөхөхийн тулд хэрэглэгчдийн усны төлбөрийг нэмэгдүүлэх магадлалтай юм.

⁶⁸ А. Лопез-Фелдман. (2012). Stata ашиглан хувилбарт үнэлгээ хийх танилцуулга. Мюнхений хувийн архив. Баримт бичгийн дугаар 41018

Та усны нөөцийн хомстол үүсэж хязгаарлалт хийх магадлалтай эсэхэд хэр санаа зовж байна вэ?			Та усны нөөцийн хомстол үүсэж хязгаарлалт хийх магадлалтай эсэхэд хэр санаа зовж байна вэ?		
Усны хомстолоос сэргийлэхийн тулд усны үнийг өсгөх хэрэгтэй гэдэгтэй та санал нэг байна уу?			Усны хомстолоос сэргийлэхийн тулд усны үнийг өсгөх хэрэгтэй гэдэгтэй та санал нэг байна уу?		
Нээлттэй асуулт: Дээр дурдсан нөхцөлд усны хязгаарлалтад орохгүйгээр 1 литр усанд төлөх төлбөрийн боломжит хэмжээ танай өрхийн хувьд хэд байх вэ?			Нээлттэй асуулт: Дээр дурдсан нөхцөлд усны хязгаарлалтад орохгүйгээр цэвэр, бохир усны үйлчилгээ авах бол үйлчилгээний төлбөрт танай өрхийн сард төлөх боломжит дээд хэмжээ хэд байх вэ?		
Хаалттай асуулт: 3 төгрөг төлөх үү?	тийм	5 төгрөг төлөх үү?	Хаалттай асуулт: Та энэ хэмжээний (одоогийн сарын төлбөрийг 50%-иар нэмэгдүүлсэнтэй тэнцэх) төлбөрийг төлөх үү?	тийм	Та энэ хэмжээний (одоогийн сарын төлбөрийг 75%-иар нэмэгдүүлсэнтэй тэнцэх) төлбөрийг төлөх үү?
	үгүй	2 төгрөг төлөх үү?		үгүй	Та энэ хэмжээний (одоогийн сарын төлбөрийг 25%-иар нэмэгдүүлсэнтэй тэнцэх) төлбөрийг төлөх үү?
24 цаг ажилладаг ухаалаг УТБ эсвэл үйлчилгээ сайжирсан ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг болоход					
Ирээдүйд танай өрх ухаалаг УТБ-аас 24 цагийн турш ус авах эсвэл сайжруулсан ухаалаг УТБ-аар үйлчлүүлнэ гэж үзье. Танай өрх одоогоор 1 литр усанд 1 төгрөг төлдөг.					
Нээлттэй асуулт: Дээр дурдсан нөхцөлд УТБ-ны үйлчилгээг сайжруулсны дараа 1 литр усанд танай өрх хамгийн ихдээ хэдэн төгрөг төлөх боломжтой вэ?					
Хаалттай асуулт: 5 төгрөг төлөх үү?	тийм	7 төгрөг төлөх үү?			
	үгүй	3 төгрөг төлөх үү?			

6.2 Ухаалаг УТБ эсвэл үйлчилгээ сайжирсан ухаалаг УТБ-нд төлбөр төлөх эрмэлзэл

Энэ хэсэгт гэр хорооллын хэрэглэгчдийн "24 цагийн турш ажилладаг ухаалаг УТБ-наас ус авдаг болох эсвэл үйлчилгээ сайжирсан ухаалаг УТБ-аар үйлчлүүлэх" төлбөр төлөх эрмэлзэлд дүн шинжилгээ хийсэн болно. Энэ нь Дөрөвдүгээр бүлэгт онцолсон ухаалаг УТБ-ны давуу тал, үйл ажиллагааны асуудлуудын талаарх хэрэглэгчдийн ойлголтыг

эхлээд судална. Түүний дараа хэрэглэгчийн төлбөр төлөх эрмэлзлийг тодорхойлох хүчин зүйлс, гэр хорооллын хэрэглэгчдийн ТТЭ-ийн ялгааг усаа авдаг УТБ-ны төрлөөр нь шинжилгээ хийж, эцэст нь түгээгчтэй УТБ-ыг ухаалаг болгоход тулгарч болзошгүй ус авахтай холбоотой хүндрэл бэрхшээл болон тэдгээрийг бууруулах арга хэмжээний талаар авч үзсэн.

6.2.1 Ухаалаг УТБ-ны давуу болон сул тал

7 хоногийн долоон өдөр, 24 цагийн турш ажилладаг ухаалаг УТБ нь түгээгчтэй УТБ-тай харьцуулахад илүү сайжирсан үйлчилгээ авчирсан. ТТЭ-ийн судалгааны хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үр дүнгээс (4.1.3-ыг үзнэ үү) гэр хорооллын оршин суугчид ус авах цаг уртассан болон төлбөр төлөх хэлбэрт таатай хандаж байгаа боловч, эвдрэл гэмтлийн давтамж, усны даралт багатай холбоотой асуудалд сэтгэл дундуур байгааг харуулж байна. Доор үзүүлсэн фокусын бүлгийн хэлэлцүүлгийн ишлэл нь эдгээр дүгнэлтийг баталж, нарийвчлан харуулсан болно.

Ухаалаг УТБ нь ажил тарсны дараа ус авах боломжийг бүрдүүлснээрээ онцгой ач холбогдолтой. Ердийн түгээгчтэй шугамд холбогдсон УТБ нь ихэвчлэн 10:00-19:00 цагийн хооронд дундаа завсарлагатай ажилладаг. Зарим нь хагас өдөр л ажилладаг бол зарим нь ажлын бүх өдрүүдэд ажилладаггүй. УТБ-ны ажиллах цагийг уртасгах нь өрхүүд ундны усгүй болох магадлалыг бууруулахад тусалдаг. Ойролцоох УТБ хаагдахад гэр хорооллын өрхийн 28% нь л өөр УТБ руу явдаг. Зарим хэрэглэгчид хүнсний дэлгүүрээс савласан ус худалдаж авдаг боловч ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс харахад УТБ-ны хэрэглэгчдийн дөнгөж 14.5% нь савласан ус худалдаж авдаг байна.

Шигтгээ 7: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Ухаалаг УТБ ба усны хэрэглээ

“Ухаалаг УТБ-тай учраас манайх усаа хүссэн үедээ авдаг.”

- Хан-уул дүүргийн гэр хорооллын оршин суугч 33 настай, эрэгтэй

“Ухаалаг УТБ-тай болоод 1 жил болж байна. Энэ нь шөнө ч байсан авдаг болохоор амар болсон гэхдээ дуртай цагтаа авч байгаа болохоор хэрэглээ ихсэж байна. Ухаалаг УТБ-гүй байхад усгүй болсон тохиолдол байдаг байсан. Усгүй байгаа үедээ айлаас авах хүнээс гуйх тохиолдол байдаг. Хөрш айлаасаа ихэвчлэн авна, авсан усаа дараа буцаагаад өгдөг.”

- Чингэлтэй дүүргийн гэр хорооллын оршин суугч 39 настай, эмэгтэй

Ухаалаг УТБ-ны урьдчилж төлбөр хийдэг, УТБ дээр бэлэн мөнгө ашиглахаас зайлсхийсэн горим нь хэрэглэгчдийн талархлыг их хүлээдэг байна (Бүлэг 4-өөс үзнэ үү). Ухаалаг картаар төлбөрөө төлөх нь гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд эрэлтээрээ хоёрт орж буй, зөөврийн ус хангамж бүхий УТБ-ны хэрэглэгчдийн хувьд хамгийн их эрэлттэй байгаа сайжруулсан үйлчилгээ юм.

Байнгын ажиллагаатай ухаалаг УТБ нь усны хүртээмжийг нэмэгдүүлснээр гэр хорооллын иргэдийн усны хэрэглээг дэмжинэ.

УСУГ-ын 2020 оны Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс үзэхэд ухаалаг УТБ-нд хэрэглэгчдийн сэтгэл ханамж нэмэгджээ: “УТБ-нд сэтгэл ханамж өссөн нь УТБ-ны зохион байгуулалт, үйлчилгээний ажилтнуудын харилцааны соёлоос гадна ажиллах цаг (сэтгэл ханамж нэмэгдсэн) ихээхэн нөлөөлсөн байна”⁶⁹. Гэсэн хэдий ч өмнө

⁶⁹ Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа -2020 УСУГ-ын захиалгаар Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп гүйцэтгэв.

дурдсанчлан ухаалаг УТБ-ны үйл ажиллагаанд зарим ноцтой асуудал тулгардаг. **Үйлчилгээ нь ихэвчлэн эвдрэл гэмтэл, усны даралтын асуудлаас болж тасалддаг.** Фокус бүлэгт оролцсон сэтгэл ханамжтай хэрэглэгч хүртэл эвдрэл гэмтэл болон карт ашиглахтай холбоотой бэрхшээлийн талаар дурдсан байна (Шигтгээ 12-ыг үзнэ үү). Эдгээр асуудал нь тийм ч жижиг зүйл биш бөгөөд ухаалаг УТБ-ны эдгээр талуудад сэтгэл ханамж багатай байсан хэрэглэгчдэд бодит хүндрэл учруулж байна.

Энэ нь 2020 оны УСУГ-ын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр ч бас “Гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд дэд үзүүлэлттэй холбоотой эсвэл тоног төхөөрөмжийн хүндрэлтэй холбоотой асуудалд сэтгэл хангалуун бус байдаг нь ухаалаг төхөөрөмж гацах/ажиллахгүй байх, улмаар хэрэглэгчид ус авч чадахгүй болдгоос харагдаж байна” гэж ажиглагдсан⁷⁰.

Шигтгээ 8: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс–Ухаалаг УТБ ба үйлчилгээний чанар

“Манайх 24 цагийн ухаалаг картаар үйлчилдэг УТБ-руу машинаар явдаг хэдий ч очих болгонд оочир ихтэй байдаг. Хэрэгцээ их, харин УТБ-ны хүрэлцээ байхгүй болохоор оочир ачаалал их байгаа байх. Усны даралт бас бага гардаг.”

- Баянзүрх дүүргийн гэр хорооллын оршин суугч 31 настай, эмэгтэй

“Картад мөнгө хийснээс хойш 20 мин хүлээж байж цэнэглэгддэг. УТБ дотроо усыг хурдан, удаан гоожих даралтын зохицуулдаг юм байна лээ. Манай УТБ их удаан гоождог учир оочир дараалал үүсгэх гээд байдаг тохиолдол байдаг.”

- Баянзүрх дүүргийн гэр хорооллын оршин суугч 26 настай, эмэгтэй

“Хүүхдийн тоглоомын талбайд хамгийн ойрхон УТБ-ны карт унших хэсэг нь маш их эвдэрдэг. УТБ хүрэлцээ муутай байдаг. Ухаалаг карттай УТБ-тай болсноос хойш засвар үйлчилгээ хариуцсан ажилтан нь 3 УТБ-ны голд нэг хүнийг хуваарилдаг болсон байсан. Манай тэнд байдаг УТБ тогтмол гацах тохиолдол байдаг. Энэ тохиолдолд 70-тай утас руу нь залгахаар УТБ-ны ажилтны дугаар луу залга гэнэ нөгөө хүн рүү нь залгахаар би өөр УТБ дээр байна гэж дамжуулж хэлдэг. УТБ орчмын гэрэлтүүлэг муу байдаг.”

- Чингэлтэй дүүргийн гэр хорооллын оршин суугч 39 настай, эмэгтэй

“Ухаалаг карттай УТБ эвдрээд УСУГ руу залгасан чинь сэлбэг нь өндөр үнэтэй байдаг учраас Хятадаас захиалдаг гэсэн. 5,6 сард ажиллаагүй. Тэгэхээр түгээгчтэй болсон, 24 цаг байхаа больсон учраас.”

- Хан-уул дүүргийн гэр хорооллын оршин суугч 38 настай, эмэгтэй

УТБ-ыг ухаалаг болгоход тодорхой бүлгийн хэрэглэгчдэд бэрхшээлтэй байж болох нэг тал нь **буяны ажлын хүрээнд усны мөнгийг төлж хэрэглэгчдэд үнэгүй ус түгээдэг уламжлалд ухаалаг УТБ-ны автомат горим саад болж магадгүй явдал юм.** ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс үзэхэд энэ уламжлалын талаар ухаалаг УТБ-ны хэрэглэгчдээс бусад УТБ-ны хэрэглэгчид 3.5 дахин илүү мэдээлсэн байна.

⁷⁰ Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа (2020). УСУГ-ын захиалгаар Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп гүйцэтгэв.

6.2.2 Гэр хорооллын хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзэл өндөр байна


Гэр хороололд 1 куб метр усны үнэ 1,000 төгрөг байгаа бол ТТЭ-ийн судалгааны үр дүнгээр 24 цаг ажилладаг ухаалаг УТБ болон үйлчилгээ сайжруулсан ухаалаг УТБ-наас ус авахад төлбөр төлөх эрмэлзлийн дундаж хэмжээ 1 куб метр нь 5,404 төгрөг, дээд хэмжээ нь 6,692 төгрөг байна. ТТЭ ийм өндөр байгаа нь ухаалаг УТБ-ны урт хугацаагаар ажиллах цаг, илүү үр ашигтай төлбөр төлөх аргын эрэлт хэрэгцээ их байгааг харуулж буй бөгөөд гэр хорооллын хэрэглэгчид ус авахад зарцуулдаг алдагдсан боломжийн өртөг өндөр байдагтай харьцуулбал гайхмаар зүйл биш юм.

2016 онд хийгдсэн түргэвчлэн үнэлгээний судалгаагаар⁷¹ ажиллах цаг, өдрийг уртасгах, УТБ-ны зайг өрхүүдэд ойртуулах, очирлох хугацааг хамгийн бага байлгах зэрэг үйлчилгээний тодорхой сайжруулалтад төлбөр төлөх эрмэлзэл одоогийн тарифыг бараг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний байгааг гаргасан. Бямбадорж, Ли нар⁷² гэр хорооллын бохир ус, ариутгах татуургын дутагдлын асуудлыг хөндөж, ус хангамж бохир ус цэвэрлэх байгууламж суурилуулахад куб метр тутамд 1000 төгрөг, энэ ус хангамж, бохир ус цэвэрлэх байгууламжийг удирдахад шаардагдах ашиглалтын болон менежментийн зардалд куб метр тутамд хамгийн ихдээ дунджаар 3000 төгрөг төлөх эрмэлзэлтэй байгааг тооцоолсон байна.

6.2.3 Гэр хорооллын хэрэглэгчийн бүлгүүд дэх ялгаа

Судалгаанд оролцогчдын зарим нь одоо ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг тул УТБ-ны үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх тухай асуултууд бусад УТБ-ны хэрэглэгчдийнхтэй адил утгатай биш байна. УТБ-наас ус авахад тулгарч болзошгүй бэрхшээл болон алдагдсан боломжийн өртөг нь хэрэглэгчдэд харилцан адилгүй байдаг.

Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын саналууд үйлчлүүлдэг УТБ-ны төрлөөс хамаарч өөр өөр байгааг харгалзан ундны ус авдаг УТБ-ны төрлөөр хэрэглэгчдийг ангилж авч үзлээ. Зарим ялгаа харагдаж байгаа боловч ялгаа нь зөвхөн хамгийн дээд ТТЭ-ийн түвшинд ажиглагдаж байгаа тул үр дүн нь тийм ч ач холбогдолтой биш байна



⁷¹ МСК (2018) Ус, ариун цэвэр, эрүүл ахуй (WASH) төсөл —Монгол улс, Баримтын хуудас.

⁷² А.Бямбадорж, Х.С, Ли нар (2019). Улаанбаатар хотын гэр хорооллын өрхүүдийн бохир ус цэвэрлэх, ус хангамжийн системийг сайжруулахад төлбөр төлөх эрмэлзэл, Монгол улс. Ус, 11(9), 1856 2019 он.

(Зураг 30-ийг үзнэ үү). Усны үйлчилгээг сайжруулахад (24/7 ухаалаг УТБ-тай болох) төлбөр төлөх эрмэлзэл хамгийн өндөр байгаа бүлэг нь ундны усаа УТБ-наас бусад эх үүсвэрээс авдаг өрхүүд, хоёрдугаарт, зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг өрхүүд байна. Дээд ТТЭ-ийн харгалзах дундаж түвшин нь ухаалаг болон түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-уудаас статистикийн хувьд өндөр байна. Сонирхолтой нь, шугамд холбогдсон болон зөөврийн ус хангамжтай УТБ-ны үйлчлүүлэгчдийн хоорондын ийм ялгаатай байдал нь хэрэглэгчдийн усны үйлчилгээ, чанарын талаарх ойлголтод ч ажиглагдаж байв.

Зураг 30: Гэр хорооллын хэрэглэгчдийн сайжруулсан үйлчилгээнд үзүүлэх хамгийн их болон дундаж ТТЭ (төгрөг/м³)

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: Багана бүр нь ТТЭ-ийн итгэх түвшний интервалыг илэрхийлнэ; Хэрэглэгчийн бүлэгт ногдох хамгийн их ТТЭ-ийн дундаж утгыг харьцуулахын тулд дунджийн зөрүүг тодорхойлох таамаглалын тестийг ашигласан бөгөөд, тэдгээр нь зөөврийн ус хангамжтай болон бусад эх үүсвэрээс ус хэрэглэгчдийн хамгийн их ТТЭ-ийн дундаж нь ухаалаг УТБ болон шугамд холбогдсон түгээгчтэй УТБ-ны дунджаас, эдгээр нь хоорондоо ч мөн ялгаатай болохыг харуулж байна.

Хүснэгт 18: Гэр хорооллын хэрэглэгчдийн сайжруулсан ухаалаг УТБ-нд үзүүлэх ТТЭ

Ундны усны эх үүсвэр	Дундаж ТТЭ	Дээд ТТЭ
Ухаалаг УТБ	5379	6519
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ	5489	5966
Зөөврийн ус хангамжтай УТБ	5396	6791
Бусад эх үүсвэр	5440	7685
Нийт	5404	6692

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ны хэрэглэгчдийг зөөврийн ус хангамжтай УТБ болон бусад эх үүсвэрийн хэрэглэгчидтэй харьцуулахад төлбөр төлөх эрмэлзэл бага байгаа нь одоогийн үйлчилгээнд сэтгэл ханамж өндөр байдаг хэрэглэгчдийн бүлэгтэй холбоотой юм. Түгээгчтэй УТБ-ны хувьд эвдрэл гэмтэл, усны даралт бага байхтай холбоотой хүндрэлийг бууруулах, засах цагийг хэмнэхэд тусалдаг байна. Эдгээр гурван асуудлын тухайд, ухаалаг УТБ нь түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-наас сэтгэл ханамжийн үнэлгээгээр бага оноо авсан байна.

Нөгөө талаас, зөөврийн ус хангамжтай УТБ-ны хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзэл өндөр байгаа нь одоогийн үйлчилгээнд сэтгэл ханамж бага байгаатай холбоотой юм. Ухаалаг УТБ болон зөөврийн ус хангамжтай УТБ-ны үйлчилгээний ялгаатай байдал нь ухаалаг УТБ болон түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ныхаас хамаагүй их юм.

Зөөврийн ус хангамжтай УТБ-ны хэрэглэгчид гэрээс УТБ хүртэлх зай, хүлээх хугацаа, усны чанар (зэв, амт, үнэр), төлбөр төлөх арга, харилцагчийн үйлчилгээний хүртээмж, хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх талаар сэтгэл ханамж бага байв. (Бүлэг 4-өөс үзнэ үү). Хүртээмжийн хувьд зөөврийн ус хангамж бүхийн УТБ-ны усны нийлүүлэлт хязгаарлагдмал тул "хамгийн сайн цагт" ирэх нь ус авах боломжийг нэмэгдүүлдэг. Энэ нь эргээд ус авахад гарах алдагдсан боломжийн өртгийг мэдэгдэхүйц өсгөж магадгүй юм. Фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр эдгээр хэрэглэгчид УТБ-ны ус дуусахаас өмнө эрт ирэх хэрэгтэй байдаг талаар дурдаж байв.

Зөөврийн ус хангамж бүхий УТБ-ны хэрэглэгчдийн нэгэн адил хувийн УТБ-ны хэрэглэгчид УТБ-ны сайжруулсан үйлчилгээнд төлбөр төлөх эрмэлзэл өндөр байна.

Хоёр бүлэг хоёулаа туулдаг зай, ажилладаг цагийн тухайд түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ны хэрэглэгчидтэй харьцуулахад сэтгэл ханамж бага, үйлчилгээг сайжруулах эрэлт хэрэгцээтэй байна.

Шигтгээ 9: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс –Зөөврийн ус хангамжтай УТБ болон ухаалаг УТБ-аар үйлчлүүлэхэд тулгардаг асуудлууд

“Манайх зөөврийн УТБ. Ажлын 2 өдөр амардаг учраас ажил тараад ирэхээр усны хомстолд ордог. Хааяа дэлгүүрээс цэвэр ус авдаг. Хүн ам ихтэй учраас ус дуусах тохиолдол их байдаг. Байнга ажилладаг түгээгчтэй өөр УТБ руу явдаг. УСУГ-ынх гэж ойлгодог, үнэ нь ижил байдаг. Гэхдээ 2-3 км хол байдаг учраас хүндрэлтэй. Манай 22-р хороонд ухаалаг УТБ ховор байдаг. Баянгол дүүрэгт ухаалаг УТБ ер нь байдаггүй”

- Баянгол дүүргийн гэр хорооллын оршин суугч 31 настай, эмэгтэй

“Манай амьдардаг тэр хавьд 8 УТБ-тай. Ухаалаг УТБ байхгүй. Ажилдаа яваад ирэхэд усгүй болох нөхцөл үүсдэг. Карттай газарт зорьж очих үед байдаг. УТБ усгүй болчихоод байхад ус ирэхгүй үе байдаг. Өвлийн үед УТБ-ны ус дууссан үед дэлгүүрээс авах эсвэл 11-р хороололд байдаг хол гүний худаг руу явдаг. Манай худгууд Даваа болон Пүрэв гарагт тогтмол амардаг.”

- Баянгол дүүргийн гэр хорооллын оршин суугч 52 настай эрэгтэй

“Манайх СХД-ын 23-р хороо, ухаалаг карттай УТБ-ны хүртээмж бага байдаг. Манай гэртэй ойролцоо зөөврийн усан хангамжтай улсын ганц УТБ байдаг. Тэр хавьдаа улсын ганц УТБ болохоор хүмүүс их үйлчлүүлдэг. Заримдаа усны хүрэлцээ бага байдаг. Ойролцоо хувийн худаг байдаг хэдий ч усны чанар муу, хатуулаг ихтэй. Улсын УТБ-ны усны хүрэлцээ заримдаа муу байдаг хэдий ч усны чанарын хувьд хувийн худгаас илүү байдаг.”

- Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын оршин суугч 22 настай эрэгтэй

Шигтгээ 10: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Ухаалаг УТБ-ны усны даралт бага байх асуудал

“Манай амьдарч байгаа орчинд усны хүртээмж гайгүй. УТБ Мягмар, Пүрэв гарагт амардаг бусад өдөр өглөө 10:00-19:00 цаг хүртэл ажилладаг. Зарим тохиолдолд усаа авч амжихгүй ажилдаа явна. Орой ирэхэд УТБ хаасан байдаг зэрэг дээр жаахан асуудалтай. Усны хувьд саванд удаан хадгалах нөхцөл байхгүй зөв амтагддаг. Карттай УТБ-ны хувьд даралт бага гардгаас үүдэн очер үүсдэг”

- Баянзүрх дүүргийн гэр хорооллын оршин суугч 29 настай, эрэгтэй

6.2.4 Түгээгчтэй УТБ-ыг ухаалаг УТБ болгоход тулгарч болзошгүй хүндрэлүүд

Энэ хэсэгт Ажлын даалгавар 1-ын Зорилт 6: “Түгээгчтэй УТБ-ыг ухаалаг картаар ажилладаг болгоход хэрэглэгчийн зарим бүлгүүдэд тулгарч болох саад бэрхшээлийг олж тогтоох, улмаар саад бэрхшээлийг бууруулах арга хэмжээг тодорхойлох”-ийн хүрээнд хийсэн шинжилгээг тусгав.

Ухаалаг УТБ-ны бүтэн цагаар ажиллах цаг, төлбөр төлөх хялбар арга зэрэг нь одоогийн ухаалаг УТБ-ны хэрэглэгчдийн талархлыг хүлээж, бусад хэрэглэгчдийн хувь эрэлт хэрэгцээ болж байна. Гэсэн хэдий ч ТТЭ-ийн судалгаа болон фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчдын саналаас харахад ажилтны оролцоо багассанаар эвдрэл

гэмтэл засахад удаашрах, усны даралт бага гэсэн асуудлуудтай тулгарч байна. Хэрэглэгчийн дундаж ТТЭ-ийг тодорхойлогч хүчин зүйлсийн дүн шинжилгээ (6.6 дугаар хэсэг) нь **хөгжлийн бэрхшээлтэй гишүүн(д)-тэй болон тэтгэврийн орлоготой өрхүүдийн ТТЭ бага байгааг харуулж** байна

Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогч эмэгтэй “Ухаалаг УТБ-ны ухаалаг картыг мөнгө шилжүүлэх замаар цэнэглэдэг, энэ нь өндөр настай хүмүүст хүндрэлтэй байж болзошгүй талаар дурдаж байв. Эдгээр хэрэглэгчдийн ТТЭ бага байгаа нь УТБ-ны ажилтнууд голцуу эмэгтэйчүүд⁷³ байдаг ба хөдөлгөөний болон бусад хөгжлийн бэрхшээлтэй, настай хүмүүст онцгой анхаарал хандуулдаг учраас түгээгчтэй худгийг илүүд үзэх хандлагатай холбоотой байж болох юм.

Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын зарим нь ухаалаг УТБ болон түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ыг хослуулахыг илүүд үзэж байлаа.

ТТЭ-ийн судалгааны үр дүнгээс харахад түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ны одоогийн хэрэглэгчид ухаалаг УТБ-ны хэрэглэгчдийг бодвол эвдрэл гэмтэл, засвар, усны даралт зэрэгт илүү сэтгэл ханамжтай ТТЭ-тэй байна. Буяны ажлын хүрээнд үнэгүй ус түгээх нь бусад төрлийн УТБ-уудтай харьцуулахад ухаалаг УТБ-уудад бага байна. Энэ нь зарим хэрэглэгчдийн хувьд соёлын асуудал үүсгэж болзошгүй юм.

Эвдрэл гарсан үед үзүүлэх үйлчилгээг сайжруулах, ер нь ухаалаг УТБ-ны үйлчилгээний найдвартай байдлыг сайжруулах нь ухаалаг УТБ-ны үйлчилгээг түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ны хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинд хүргэхэд тусална.

Хэдийгээр ТТЭ-ийн судалгаанд үүний шалтгааныг шууд нотлох баримт байхгүй ч хөгжлийн бэрхшээлтэй гишүүн болон өндөр настантай өрхүүдийн ТТЭ бага байгаагаас ухаалаг УТБ-ны хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулснаар түгээгчтэй УТБ-ыг ухаалаг картын горимд шилжүүлэхэд учирч болох таагүй байдлыг бууруулж болохыг харуулж байна.

УСУГ-ын 2020 оны хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд оролцогчдын дийлэнх нь ухаалаг УТБ руу шилжихийг дэмжсэн ба нэг оролцогч “Өвлийн улиралд систем гацах, ухаалаг карт унших төхөөрөмж заримдаа карт уншихгүй болж тоног төхөөрөмжтэй холбоотой асуудлаас болж хүмүүс ус авч чаддаггүй”⁷⁴ хэмээн саналаа илэрхийлсэн байна.

Дараах хэсэгт хэрэглэгчдийн үйлчилгээний төлбөр төлөх эрмэлзэлд дүн шинжилгээ хийж, тайлбарласан. Хэрэглэгчдийн ус хэмнэх, усны хомстолд хандах хандлага, усны хомстолоос сэргийлэхийн тулд үйлчилгээ сайжруулах зорилгоор усны үнэ тарифыг нэмэгдүүлэх эсэх талаар санал бодолд дүн шинжилгээ хийсэн. Дараа нь орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдийн эдгээр үйлчилгээнд төлбөр төлөх эрмэлзлийн дундаж болон дээд хэмжээг тайлбарлалаа.


6.3 Хэрэглэгчдийн ус хэмнэх хандлага

Судалгаанд оролцогч гэр хороолол болон орон сууцанд амьдардаг хэрэглэгчдийн дийлэнх нь (80.7%) Улаанбаатар хот хэдийнээ усны хомстолд орсон гэж үзэж

⁷³ Түргэвилсэн үнэлгээ (2016). Их сургуулийн судалгаа ХХК (URC), Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп ХХК

⁷⁴ “Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа-2020”. УСУГ-ын захиалгаар Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп гүйцэтгэв.

байна (Зураг 31-ээс үзнэ үү). Хэрэглэгчдийн усны хомстолын талаарх мэдлэг ийнхүү өндөр байгаа нь фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр ч харагдаж байв. Гэр хороолол болон орон сууцны хэрэглэгчид аль аль нь ойрын хэдэн арван жилд их хэмжээний усны хомстолд орох, ус хангамжийг сайжруулахгүй бол усны хязгаарлалтад орж болзошгүй талаар санал нэг байна.




Зураг 31: Улаанбаатарын өнөөгийн усны хомстолын талаарх хэрэглэгчдийн бодол

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Харин ирээдүйд болзошгүй хомстолд **санаа зовох байдал**, усаа хэмнэхийг хэр чухалчилж байгаа нь гэр хороолол болон орон сууцны хэрэглэгчдийн дунд ялгаатай байна. Орон сууцны хэрэглэгчдийн дийлэнх нь (97%) ирээдүйн усны хомстолд санаа зовж байгаа бол гэр хорооллын хэрэглэгчдийн ердөө 48.6% нь л санаа зовж байна. Эсрэгээрээ, гэр хорооллын хэрэглэгчдийн 97% нь ус хэмнэх нь чухал, маш чухал гэдэгтэй санал нийлж байгаа бол орон сууцанд амьдардаг хэрэглэгчдийн арай бага хувь (68.7%) нь үүнтэй санал нийлж байна. Фокус бүлгийн хэлэлцүүлгээр хоёр бүлгийн хэрэглэгчдийн ялгаатай санал бодлыг ойлгоход дөхөм байв.

Доорх фокус бүлгийн хэлэлцүүлгийн эшлэлээс харахад гэр хорооллын хэрэглэгчид **усны хомстолтой аль хэдийн нүүр тулж, хэрхэн шийдвэрлэхээ мэддэг гэж боддог** тул тэд үүнд арай бага санаа зовдог ч, ус хэмнэхийг дэмжих хандлага орон сууцанд амьдардаг хэрэглэгчдээс илүү байна.

Гэхдээ ирээдүйд усны хомстолоос зайлсхийхийн тулд тарифыг нэмэгдүүлэх нь зүйтэй гэсэн үзэл баримтлалтай санал нийлж байгаа эсэхийг хэрэглэгчдээс асуухад тийм ч их ялгаа биш байв. Зураг 32-т үзүүлсний дагуу, гэр хорооллын хэрэглэгчдийн гуравны хоёр нь (66.3%), орон сууцны хэрэглэгчдийн талаас илүү хувь нь (орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчийн 57.8%, тоолууртай хэрэглэгчийн 58.7%) ирээдүйд усны хомстолоос сэргийлэхийн тулд тарифыг нэмэгдүүлэхтэй санал нэгдэж байна.



Зураг 32: Ирээдүйд усны хомстол үүсэх, үүнтэй холбоотойгоор тарифыг нэмэгдүүлэх шаардлагатай эсэх талаар гэр хорооллын болон орон сууцны хэрэглэгчийн санал бодол

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

6.3.1 Орон сууцны хэрэглэгчийн ус хэмнэх хандлага

Шигтгээ 11-т үзүүлсэн эшлэлийн дагуу, орон сууцны хэрэглэгчид усны хомстолын нөхцөл байдлын талаар болон ус хэмнэх асуудлын талаар сайн мэдэж байна. Тэд Улаанбаатар хотод Туул голын эрэг дагуу барьсан барилга, арьс ширний үйлдвэрүүдийн хог хаягдал, томоохон үйлдвэр болон уул уурхайн компаниуд хамгийн их нөлөөтэй гэж үзэж байна.

Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдоос өдөр тутамдаа усаа хэмнэдэг эсэх талаар асуухад хувцсаа гараар угаах, шүдээ угаахдаа аяга хэрэглэх, усаа хаах мөн “нэг тоосго”⁷⁵ уриалгын хүрээнд жорлонгийн ус татахад зарцуулах усыг хэмнэх зорилгоор ус хураагуурт тоосго байрлуулах зэрэг олон янзын аргуудыг дурдаж байв. Мөн тэд усанд орсон усаа жорлонд хийх, аяга угаасан усаар цэцэг услах, угаалга хийхэд ашигласан усаар шал цэвэрлэх зэрэг ус дахин хэрэглэх янз бүрийн аргуудыг дурдсан.

⁷⁵ Зохиогчид ийм нэртэй албан ёсны кампанит ажил байсан эсэхийг тодорхойлох боломжгүй байв.

Шигтгээ 11: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Орон сууцны хэрэглэгчдийн ус хэмнэх хандлага

“Санал нийлж байна. Усны хомстол болох байх гэж бодож байна. Туул голоос ундны ус татдаг ш дээ. Усны хомстолд ер нь санаа зовдог.”

- Орон сууцны оршин суугч 25 настай, эрэгтэй

“Ус хомстож байгаа талаар бол мэдэж байгаа. Усыг үнэд оруулмаар байна. Үнэтэй болгомоор байна. Усны үнийг архины дайтай үнэтэй болгох хэрэгтэй байх.”

- Орон сууцны оршин суугч 57 настай, эмэгтэй

“Хомстож байгаа гэж бодож байна. Үр хүүхэд маань л ийм байдалд илүү их орох байх гэж бодож байна. Улаанбаатар хотын даац хэтэрсэн болохоор хомстож байгаа гэж санаа зовдог. Уул уурхайн компаниуд гүний усыг замбараагүй хэрэглэдэг учраас цэвэр усны нөөц багасаад эхэлж байна. Энэ асуудал төр засгаас нь зохицуулалт хийх хэрэгтэй гэж үзэж байна. Хувь хүмүүс бол ойлгож байгаа.”

- Орон сууцны оршин суугч 56 настай, эмэгтэй

“Санал нийлдэг. Гүний ус хэрэглэдэг. Монгол улсын усны нөөцийн 2% гүний ус. Нуур гол мөрөн 80% гэдэг гэтэл нуур гол горхи нь ширгэж байна.”

- Орон сууцны оршин суугч 36 настай, эрэгтэй

“Бид мянга хэмнээд яах вэ дээ. Тэр байгалиа сүйтгэж байгаа хүмүүс бодох хэрэгтэй байх. Бид хүүхдийнхээ шүдийг угаахдаа миний хүү усаа хэмнээрэй гэж хэлээд угаалгаж байхад тэр арьс ширний үйлдвэр, томоохон үйлдвэр, байгаль сүйтгэгч нар тэр тухай бодохгүй байхад энд бид хэмнээд хэмнэгдэхгүй байх.”

- Орон сууцны оршин суугч 37 настай, эмэгтэй

Хүмүүс, байгууллага, аж ахуйн нэгжүүдийг усаа хэмнэх, байгалийн усны нөөцийг хамгаалдаг болгохын тулд ямар бодлого баримтлах талаар хэлэлцэх үед (i) боловсрол олгох, ус хамгаалах соёлыг төлөвшүүлэх, ялангуяа залуучуудын дунд, (ii) төрийн зохицуулалт, хяналтыг сайжруулах, (iii) аж ахуйн нэгж, байгууллагуудын бохирдлын хяналтыг нэмэгдүүлэх гэсэн үндсэн гурван асуудлыг дэвшүүлсэн.

Шигтгээ 12: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Усны хэмнэлтийг сайжруулах шийдэл

“Бохирдуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагууд дээр илүү хяналттай ажиллах хэрэгтэй байх. Түүнчлэн хүүхэд багачуудад ЕБС-аас хичээлээр ойлгуулж таниулах хэрэгтэй байх.”

- Орон сууцны оршин суугч 25 настай, эмэгтэй

“Усны хуулийг сайжруулах, хяналтыг сайжруулах. Аж ахуйн нэгж байгууллагын усны төлбөрийг нэмэгдүүлэх ус мөнгө олохоос илүү үнэтэй зүйл гэдэг дээр хуулийг сайжруулах”

- Орон сууцны оршин суугч 42 настай, эмэгтэй

“Улаанбатар хотын усны нөөцийг хамгаалахын тулд усаа хэмнэж хэрэглэхтэй санал нийлж байна. Тоолуур хүн усыг хязгаартай, боломжтой байдлаар хэрэглэх аргад сургаж байгаа.”

- Орон сууцны оршин суугч 59 настай, эмэгтэй

6.3.2 Гэр хорооллын хэрэглэгчдийн ус хэмнэх хандлага

Шигтгээ 13: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Гэр хорооллын хэрэглэгчдийн ус хэмнэх хандлага

“Усны хомстолтой санал нийлнэ. Ялангуяа гэр хорооллынхон нэг хэрэглэсэн усаа олон ашигладаг. Гамнадаг.”

- *Гэр хорооллын оршин суугч 48 настай, эмэгтэй*

“Гэр хорооллын бид усыг маш их хэмнэдэг. Харин байрныхан хэмнэхгүй маш их хэрэглэж байна. Өөрсдөө усыг зөөдөг учраас бид сайн хэмнэж байна. Ус хомстож байна гэж бодож байна.”

- *Гэр хорооллын оршин суугч 61 настай, эмэгтэй*

“Хүн элбэг байгаагаараа л хэрэглэж байна. Одоо орон сууцны 00 ус гэхэд бид уудаг усаа 00-д татаад хамаагүй хэрэглэж байна. Мөн гэр хорооллын өрхүүд 3 литр усаар аягаа угааж байхад орон сууцны айлууд 20, 30 литр усаар бараг аягаа угааж байх жишээтэй. Тэгэхээр замбараагүй хэрэглээ их байна.”

- *Гэр хорооллын оршин суугч 35 настай, эмэгтэй*

“Усны хомстол үүснэ. Хот төлөвлөлт буруу, үйлдвэрүүдийн ашиггүй хэрэглээ, хүмүүсийн буруу хэрэглээнээс болж байгаа байх.”

- *Гэр хорооллын оршин суугч 32 настай, эрэгтэй*

“Хомстол үүсэж байгаа. Хүүхдүүддээ ч усаа хэмнэх талаар зөвлөдөг. Улаанбаатар хотод чинь цэвэр ундны усны ганцхан Туул гол байна. Хотын хүмүүсийнх нь даац нь хэтэрчихсэн байна. Бидний багад ямар байлаадаа Сэлбэ гол. Гэтэл одоо бүр ширгээд шалбааг болсон байна. Бас Дунд гол гэж байсан бас л ширгэсэн байна.”

- *Гэр хорооллын оршин суугч 31 настай, эмэгтэй*

“Хомстож байгаа гэж бодож байна. Хэрэгцээтэй зүйлдээ усаа зөв хэрэглэх хэрэгтэй гэж боддог. Орон сууцных нь тэгдэггүй юм шиг санагддаг.”

- *Гэр хорооллын оршин суугч 22 настай, эмэгтэй*

“Хомстол үүсэж байгаа. Адаглаад 00 руугаа цэвэр ус хийж байна. Хятадад гэхэд тэгдэггүй өөр ус хэрэглэдэг юм байна лээ.”

- *Гэр хорооллын оршин суугч 33 настай, эрэгтэй*

Гэр хорооллын хэрэглэгчид зөвхөн өөрсдийгөө ус хэмнэдэг гэж боддог нь фокус бүлгийн саналуудаас харагдаж байна. Тэд крантнаас гоождог ус хэрэглэгчид дураараа их хэрэглэдэг гэж үздэг байна. Төвлөрсөн шугамд холбогдсон орон сууцны хэрэглэгчдийн ус хэмнэх аргуудтай харьцуулахад тэдний ус хэмнэх арга аяга таваг эсвэл үс угаасан усаа шал угаахад ашиглах, нохойндоо аяга таваг угаасан ус өгөх; хувцас угаасан усаар машин угаах, зун борооны ус тосож ахуйн цэвэрлэгээ, угаалгад ашиглах зэрэг ус нэмэх илүү олон янзын аргыг дурдаж байлаа.

Нийгмийн бусад хэсэгт ийм хүчин чармайлтууд гаргадаггүй, орон сууцанд цэвэр усыг жорлонд хэрэглэдэг, машин угаалгын газар, үйлдвэрүүд, орон сууцны хэрэглэгчдийн усны хэрэглээг хянадаггүй гэж тэд боддог байна. Мөн тэдний үзэж байгаагаар усаа хамгаалах соёлгүйгээс хот төлөвлөлтийг буруу зохион байгуулж, хэт олон цооног бий болсон байна. Нөхцөл байдлыг сайжруулахын тулд мод тарих, төлөвлөлтийг сайжруулах, үйлдвэрүүдийг нүүлгэх, үйлдвэрүүд усаа дахин ашиглах, аж ахуйн нэгжүүд байгууллагуудад төрөөс тавих хяналтыг сайжруулах хэрэгтэй гэжээ.

Шигтгээ 14: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Гэр хорооллын хэрэглэгчдийн ус хэмнэх шийдэл

“Чухал. Гэр хорооллын 5 ам бүлтэй айл өдөрт 40 литр усаар хэрэглээгээ хангаж байхад орон сууцны айл бол тэгж чадахгүй. Тийм болохоор усны замбараагүй хэрэглээг багасгах хэрхэн хэмнэх талаар бараг КОВИД-ын үе шиг хичээл ороход болох байх.”

- Гэр хорооллын оршин суугч 35 настай, эмэгтэй

“Дахин боловсруулдаг саарал ус гээд байгаа тэрийг арьс ширний болон томоохон үйлдвэрүүд хэрэглэх гэх мэт зохицуулалт хийж болох юм.”

- Гэр хорооллын оршин суугч 32 настай, эмэгтэй

“Цайны газар, ресторан зоогийн газар бас усны хязгааргүй, замбараагүй хэрэглээтэй байна. Учир нь аягаа угаагүй атал тэр крантны усыг гоожуулаад байж байх жишээтэй.”

- Гэр хорооллын оршин суугч 22 настай, эрэгтэй

“Аж ахуйн нэгж байгууллагууд дахин хэмнэлтийг хийх шаардлагатай. Арьс ширний үйлдвэрийг хотоос гаргах шаардлагатай. Цахилгаан станцуудаа нэмж барих хэрэгтэй. Гэр хороололд саарал усаа дахин ашиглах.”

- Гэр хорооллын оршин суугч 61 настай, эмэгтэй

“Голын ойр орчимд барилга барьсан байна. Усыг хэрэглэж болно. Гэхдээ цаашдаа бүрэн бүтнээр нь байлгах сүйтгэхгүй талаас нь анхаарах байх хэрэгтэй.”

- Гэр хорооллын оршин суугч 29 настай, эрэгтэй

УСУГ-ын 202 оны хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар “УСУГ-ын хэрэглэгчдийн 99% нь усаа хэмнэх хэрэгтэй ба хүүхдүүдээ ус хэмнэх талаар сургадаг” гэсэн байна. Гэхдээ тус судалгаанд “63% нь усны үнийн өсөлт тэдний усны хэрэглээгээ бууруулах шалтгаан болохгүй” гэж хариулсан байна”.⁷⁶


6.4 Орон сууцны хэрэглэгчдийн усны хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл

6.4.1 Орон сууцны хэрэглэгчдийн дундаж болон дээд төлбөр төлөх эрмэлзэл

Ирээдүйд усны хомстолд орохоос сэргийлэхийн тулд тарифыг нэмэгдүүлэх талаар орон сууцны хэрэглэгчдийн санал хуваагдсан (41.4% нь дэмжиж, 58.6% нь дэмжээгүй), ялангуяа тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн дунд илүү ажиглагдаж байна.

Усны хомстолоос зайлсхийхийн тулд төлөх цэвэр, бохир усны төлбөрийн түвшний талаар асуухад, Зураг 33-т харуулсны дагуу орон сууцны хэрэглэгчдийн 80.2%, усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн 62.8% нь санал болгосон хувилбаруудын наанадаж нэгийг нь хүлээн зөвшөөрсөн байна. Цэвэр, бохир усны төлбөрийн эерэг өсөлтийг (дээд ТТЭ) илэрхийлсэн хэрэглэгчдийн эзлэх хувь бага байгаа нь усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн бараг тал (49.8%), тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн гуравны нэгээс (35.4%) арай илүү байна.

⁷⁶ Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа (2020). УСУГ-ын захиалгаар Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп гүйцэтгэв.




Зураг 33: Орон сууцны усны тоолууртай болон тоолуургүй өрхийн хувилбарт асуултуудад хариулсан тархалт, цэвэр, бохир усны төлбөрийн нэмэгдлийг хүлээн зөвшөөрсөн хувиар

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Дундаж ТТЭ-ийн үр дүнгээс харахад усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн цэвэр, бохир усны төлбөр төлөх эрмэлзэл төлбөрийг 59.3% ба 55.3% байна. Үнэ нэмэгдэхгүй байх хэмжээтэй тэнцэхүйц ТТЭ-тэй хэрэглэгчдийн эзлэх хувь их байгаагаас, хамгийн дээд ТТЭ-ийн үр дүн усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны хэрэглэгчид ойрын хорин жилд усны хомстол, хязгаарлалтаас зайлсхийхийн тулд цэвэр, бохир усны төлбөрийг 32.3%, 10.8%-иар өсгөн тус тус төлөхөд бэлэн байгааг харуулж байна. Өрхийн дундаж болон дээд ТТЭ-ийн хоорондох том ялгаа нь ТТЭ-ийн аргачлалын танилцуулахад тайлбарласан анхааруулгатай холбоотой байж магадгүй юм, учир нь зарим судалгаанд оролцогчид анхны саналыг (25% -иар өссөн) "зөв" санал гэж ойлгосон байж магадлалтай.


Ямар ч арга хэмжээ авсан бай, **илүү их хэмжээний ус хэрэглэдэг хэрэглэгчдийн ТТЭ бага** байгааг Зураг 34-т үзүүлсэн үр дүн харуулж байна. Усны хэрэглээ нь дундаж ТТЭ-д гол нөлөө үзүүлдэг (6.6 хэсгийг үзнэ үү); мөн их хэрэглэгчдийн (их ба маш их хэрэглэгчид) дээд ТТЭ-ийн дундаж түвшин нь усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн хувьд бусад хоёр бүлгийн (бага, маш бага хэрэглэгчид) дундаж үзүүлэлтээс статистикийн хувьд ялгаатай байна.



Зураг 34: Орон сууцны усны тоолууртай өрхийн дундаж болон хамгийн их ТТЭ, усны хэрэглээний түвшнээр

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: Багана бүр нь ТТЭ-ийн итгэх түвшний интервалыг илэрхийлнэ; Хэрэглэгчийн бүлэгт ногдох хамгийн их ТТЭ-ийн дундаж утгыг харьцуулахын тулд дунджийн зөрүүг тодорхойлох таамаглалын тестийг ашигласан бөгөөд тэдгээр нь их хэрэглээтэй хоёр хэрэглэгчийн (их ба маш их хэрэглэгчид) бусад бүлгийнхээс ялгаатай эдгээр хоёр нь хоорондоо ч мөн ялгаатай болохыг харуулж байна.



Зураг 35: Орон сууны усны тоолууртай болон тоолуургүй өрхийн ирээдүйд ус хомстохоос сэргийлэхэд үзүүлэх дундаж болон хамгийн их ТТЭ, хэрэглээний түвшнээр

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: Багана бүр нь ТТЭ-ийн итгэх түвшний интервалыг илэрхийлнэ. Хэрэглэгчийн бүлэгт ногдох хамгийн их ТТЭ-ийн дундаж утгыг харьцуулахын тулд дунджийн зөрүүг тодорхойлох таамаглалын тестийг ашигласан бөгөөд тэдгээр нь их хэрэглэгчдийн дундаж нь бусад бүлгийнхээс ялгаатай болохыг харуулж байна.

Сонирхолтой нь, усны **их хэрэглээтэй хэрэглэгчид усны үйлчилгээ, чанарын талаар хамгийн сэтгэл ханамж багатай** байсан (Бүлэг 5-аас үзнэ үү). Бусад хэрэглэгчдийн нэгэн адил тэд ус зэвтэй эсэх, засварын дараа усны арилтал гоожуулж усыг үргүй зарцуулсан хэмжээ, ус халуун болтол гоожуулж үрсэн усны хэмжээ зэрэгт сэтгэл хангалуун бус байв. Үүнээс гадна тоолуурын нарийвчлал, тоолуур баталгаажилт хийлгэх үйл үйл явц, усны даралт, үнэр, амт, эвдрэл гэмтлийг засварлах хугацаа, төлбөр төлөх арга, харилцагчийн үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн түвшин доогуур байгааг харуулж байна.

Хүснэгт 19: Усны тоолууртай болон тоолуургүй орон сууцны өрхийн дундаж ба хамгийн их ТТЭ, хэрэглээний түвшнээр

	Хамгийн их ТТЭ		Дундаж ТТЭ	
	Усны тоолууртай	Усны тоолуургүй	Усны тоолууртай	Усны тоолуургүй
Маш бага хэрэглээ: 5м³-ээс бага	59	58.1	41	12.5
Бага хэрэглээ: 5- 8 м³	59.7	62.4	39.8	12.2
Их хэрэглээ: 8- 15 м³	60.5	49.1	24.3	7.3
Маш их хэрэглээ: 15 м³ -ээс дээш	55.6	52.8	21.4	9.8
Дундаж	59.3	55.3	32.4	10.8

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Хэдийгээр өрхүүдийн усны алдагдлын хэмжээ тодорхойгүй, эдгээр алдагдал нь ОСНААУГ, УСУГ-ын орлогод шууд нөлөөлөхгүй байсан ч усны үргүй зарцуулалтын асуудлыг орхигдуулж болохгүй юм.

Орон сууцны хэрэглэгчид ойрын 10 жилд усны хомстолд орж болзошгүй талаар өргөн ойлголттой байгаа хэдий ч ус хангамжийн системийг сайжруулах, усны хомстолоос сэргийлэх хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор үнэ тарифыг нэмэгдүүлэх саналыг яагаад тийм ч сайн дэмжихгүй байгаа нь усны үргүй зарцуулалтад сэтгэл дундуур байгаагаас харагдаж байгааг онцлох нь зүйтэй юм. Хэрэглэгчдийн **сайтар мэдэж байгаа усны үргүй зарцуулалтын асуудлыг шийдэлгүй орхиод, усны хомстолоос сэргийлэхийн тулд санхүүгийн золиос гаргахыг шаардсан стратегийг дагаж мөрдөхөд хэцүү** байх магадлалтай юм.


Энэ зөрчлийг шийдвэрлэхээс нааш хэрэглэгчдийн ирээдүйн тогтвортой тарифын өсөлтийг хүлээн зөвшөөрч төлбөр төлөх эрмэлзэл, бэлэн байдал бага хэвээр байх магадлалтай байна. Энэ тохиолдолд, усны салбарын удирдлагууд, нийлүүлэгчид уг асуудлыг мэдэж байгаа, шийдвэрлэх арга замыг эрэлхийлж буй гэдгийг харуулсан мэдээллийн кампанит ажил өрнүүлэх, мөн түүнчлэн, шинэ тарифын хуваарийг ус хангамжийн найдвартай байдлыг хангах, ус хэмнэлтийг дэмжих, усны үргүй зарцуулалтын системийн шалтгааныг бууруулах цогц төлөвлөгөөний нэг хэсэг байдлаар танилцуулбал их хэрэглээтэй хэрэглэгчдийн ТТЭ-ийг нэмэгдүүлэхэд дөхөм болох боломжтой. Хавсралт 4-т дурдсанчлан эдгээр нь цаашид судлах шаардлагатай хэсгүүд юм.

6.4.2 Орон сууцны сонгогдсон дэд бүлгийн хэрэглэгчдийн дээд төлбөр төлөх эрмэлзэл

Зураг 36-д хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн зорилтот хэрэглэгчид байж болох орон сууцны хэрэглэгчдийн дэд бүлгийн дээд ТТЭ-ийг харуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүн(д)-тэй болон хүнсний талон авдаг өрхүүдийн ТТЭ нь усны тоолууртай орон сууцны бусад хэрэглэгчдийнхээс өндөр байна. Гэхдээ, өрхийн дундаж ТТЭ-ийг тодорхойлогч хүчин зүйлсийн дүн шинжилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүн(д) багтсан өрхүүдийн дундаж ТТЭ нь орон сууцны бусад бүх хэрэглэгчдийн дунджаас ялгаатай биш байгааг харуулж байна. Үүний нэгэн адил, хүнсний талон авдаг өрхүүдийн ТТЭ дунджаас өндөр байгааг нотлох үндэслэл шинжилгээгээр гарсангүй.

Гурав ба түүнээс дээш хүүхэдтэй өрхүүд болон өрхийн орлого нь КОВИД-19-ын хямрал нөлөөсөн өрхүүд дунджаас арай дээгүүр ТТЭ-тэй байна. Мөн адил эдгээр үр дүн нь өрхийн дундаж ТТЭ-ийн тодорхойлогч хүчин зүйлсийн шинжилгээгээр батлагдаагүй байгаа нь эсрэгээрээ их хэрэглээтэй өрхүүдийн дундаж ТТЭ бага байгааг харуулж байна.



Зураг 36: Өрхийн хамгийн их ТТЭ (тарифын өсөлтийн %), орон сууцны хэрэглэгчдийн сонгогдсон дэд ангиллаар

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

6.5 Гэр хорооллын хэрэглэгчдийн усны хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл

6.5.1 Гэр хорооллын хэрэглэгчдийн усны хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл

Гэр хорооллын хэрэглэгчдийн ирээдүйн хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл нь адилхан өндөр байгаа боловч ухаалаг УТБ эсвэл сайжруулсан ухаалаг УТБ-ны үйлчилгээтэй харьцуулахад арай бага байна. **Ирээдүйд хомстолоос сэргийлэхэд ТТЭ-ийн дундаж болон дээд хэмжээ нь 4,877 ба 6,281 төгрөг байсан бол үйлчилгээг сайжруулахад 5,504 ба 6,692 төгрөг байна.** Энэ үр дүн нь одоогийн УТБ-уудыг ухаалаг УТБ болгон хувиргах ажил аль хэдийн хийгдэж байгаа бөгөөд үнэ тарифыг нэмэгдүүлэх шаардлагагүй гэсэн үндэслэлээр усны хомстолоос сэргийлэхэд ТТЭ өндөр байгааг харуулсан фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын санал бодолтой зөрчилдөж байна.


Энэ ялгааг ухаалаг УТБ-ны хэрэглэгчид хомстолоос сэргийлэхэд бусад төрлийн хэрэглэгчдээс илүү өндөр ТТЭ-тэй байгаатай холбон тайлбарлаж болно (Хүснэгт 20-г үзнэ үү). Энэхүү хэрэглэгчийн бүлэг нь фокус бүлгийн оролцогчдын тал хувийг эзэлж байсан⁷⁷ боловч ТТЭ-ийн судалгаанд хамрагдсан гэр хорооллын хэрэглэгчдийн дөнгөж 22% нь байв. Тэдний ирээдүйн усны хомстолоос сэргийлэхэд ТТЭ нь фокус бүлгүүдэд илүү давамгайлсан байх магадлалтай.

Хүснэгт 20: Гэр хорооллын хэрэглэгчдийн усны хомстолоос сэргийлэхэд үзүүлэх дундаж болон хамгийн их ТТЭ

⁷⁷ Гэр хорооллын 29 оролцогчдын 15 нь ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг.

	Дундаж ТТЭ (төгрөг)	Хамгийн их ТТЭ (төгрөг)
Ухаалаг УТБ	4,971	7,238
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ	4,945	4,355
Зөөврийн ус хангамжтай УТБ	4,878	6,436
Ундны бусад эх үүсвэр	4,982	5,258
Нийт гэр хорооллын хэрэглэгчид	4,877	6,281

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа




Зураг 37: Гэр хорооллын хэрэглэгчдийн хомстолоос сэргийлэхэд үзүүлэх дундаж болон хамгийн их ТТЭ, ундны усны эх үүсвэрийн төрлөөр

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: Багана бүр дундаж ТТЭ-ийн итгэх түвшний интервалыг илэрхийлнэ.

Зураг 36-д үзүүлсэнчлэн үйлчилгээний сайжруулалт болон хомстолоос сэргийлэхэд ТТЭ-ийн хамгийн дээд түвшнийг нарийвчилсан дүн шинжилгээ хийж, харьцуулж үзэхэд үйлчилгээний сайжруулалтад куб метр тутамд 3,000 төгрөгөөс дээш ТТЭ-тэй байгаа ч ялгаа нь бага байна. Хүснэгт 21-т үнийн саналуудад хариулсан байдлыг харьцуулж үзэхэд хэрэглэгчдийн 47.9% орчим нь усны хомстолоос сэргийлэхэд куб метр тутамд 5,000 төгрөгөөс дээш тарифыг сонгосон бол сайжруулсан үйлчилгээнд 51.2%-тай харагдаж байна. Мөн л энэ нь бага ялгаа юм. Эхний үнийн саналын хувьд хомстолоос зайлсхийхээс илүү сайжруулсан үйлчилгээнд өндөр тоо байсан нь үр дүнд нөлөөлсөн байж магадгүй юм.



Зураг 38: Хамгийн их ТТЭ-ийн тархалт, гэр хорооллын хэрэглэгчдийн үйлчилгээг сайжруулах, хомстолоос сэргийлэх хувилбаруудаар

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа


Хүснэгт 21: Гэр хорооллын хэрэглэгчдийн дундаж ТТЭ

Хомстолоос сэргийлэхийн тулд		Үйлчилгээг сайжруулахын тулд	
Тарифын түвшин (төгрөг)	Хэрэглэгчдийн хувь	Тарифын түвшин (төгрөг)	Хэрэглэгчдийн хувь
2,000 -аас бага	7	3,000-аас бага	21.2
2,000 -3,000	17.3		
3,000 -5,000	27.8	3,000 -5,000	27.6
5,000-аас дээш	47.9	3,000 -7,000	23.6
		7,000-аас дээш	27.6

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

6.5.2 Гэр хорооллын хэрэглэгчдийн сонгогдсон дэд бүлгийн төлбөр төлөх эрмэлзэл

Зураг 39-д хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн зорилтот бүлэг байх магадлалтай гэр хорооллын хэрэглэгчийн дэд бүлгийн дээд ТТЭ-ийг харуулав. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхөөс бусад бүх дэд бүлгийн сайжруулсан үйлчилгээний дээд ТТЭ нь усны хомстолоос сэргийлэхээс арай их буюу ойролцоогоор бараг ижил байна. Зөвхөн өндөр настан бүхий өрхүүд болон өрхийн орлогод нь КОВИД-19-ийн хямрал нөлөөлсөн өрхүүд сайжруулсан үйлчилгээнд (дээд ТТЭ нь 8,716 ба 7,796 төгрөг) болон хомстолоос сэргийлэхэд (дээд ТТЭ нь 7,504 ба 7,745 төгрөг байна) аль алинд нь ТТЭ хамгийн их байгааг харуулж байна. Нөгөөтээгүүр, дундаж ТТЭ-ийг тодорхойлогч хүчин зүйлсийн дүн шинжилгээ (Хэсэг 6.6-г үзнэ үү) нь тэтгэврийн орлоготой өрхүүд болон КОВИД-19-ийн сөрөг нөлөөнд орлого нь өртсөн өрхүүдийн ТТЭ бусад өрхүүдээс бага, бүгд адил байгааг тогтоосон байна. Харамсалтай нь, хоорондоо зөрчилдөж буй эдгээр хоёр үр дүнд ямар нэгэн тайлбар болохуйц мэдээлэл фокус бүлгийн хэлэлцүүлгийн үед гараагүй.



Зураг 39: Гэр хорооллын сонгогдсон дэд бүлгийн хэрэглэгч өрхийн дээд ТТЭ, 1 м³ тутамд

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

6.6 Төлбөр төлөх эрмэлзлийг тодорхойлох хүчин зүйлс

Тайлангийн 6.1.2-т тайлбарласны дагуу, Дундаж ТТЭ-ийг анхны үнийн санал болон дараагийн асуултын үр дүнд бий болсон 4 интервалаар өрхүүдийн шинж чанар, тархаалтын эконометрик дүн шинжилгээнээс тооцоолсон. Энэ хэсэгт дээр дурдсан шинжилгээнүүдэд үзүүлсэн түвшнийг тооцоолоход ашигласан техникийн үзүүлэлтүүд болон илүү өргөн хүрээнд тодорхойлох боломжит хүчин зүйлсийн нарийвчилсан шинжилгээний үр дүнг харуулав. Баримт бичгийн судалгааны зөвлөмжийн⁷⁸ дагуу дүн шинжилгээнд өрхийн дөрвөн төрлийн шинж чанарын нөлөөллийг авч үзсэн.

Эхний төрөл нь өрхийн эдийн засаг, нийгэм-эдийн засгийн шинж байдлыг илтгэсэн өрхийн орлого, эдийн засгийн зардлыг багасгахын зэрэгцээ нөөцийг оновчтой ашиглах чадвар үр ашигтай холбоотой. Үүнд нэг хүнд ногдох орлого, өрхийн тэргүүний боловсрол (дээд, дунд, бүрэн бус дунд боловсрол гэх мэт), ядууралтай холбоотой нөхцөл байдал, орон сууцны өмчлөлийн хэлбэр (хувийн өмч, түрээслэгч болон бусад хэлбэр), болон өрхийн орлогод КОВИД-19 цар тахлын сөргөөр нөлөөлсөн эсэхтэй холбоотой хувьсагчдыг багтаана. Энэ бүлэг хувьсагчид усны хүртээмж, үнэ тарифт хандах хандлагад нөлөөлж болзошгүй өрхийн авьяас чадвар, харилцаа холбоо болон бусад ажиглагдахгүй шинж чанаруудыг тусгахын тулд амьдарч буй байршлыг (Улаанбаатар хотын хамгийн чинээлэг гурван дүүрэг ба бусад дүүрэг) багтаасан болно.

Хоёр дахь бүлэг нь өрхийн хүн ам зүй, бүтэцтэй хамааралтай. Үүнд өрхийн гишүүдийн тоо, өрхийн тэргүүлэгчийн нас, хүйс, хүүхдийн тоотой холбоотой хувьсагч (гурав ба түүнээс дээш, бусад гэх мэт), хүүхэдтэй өрх ганц тэжээгчтэй эсэх, хөгжлийн бэрхшээлтэй гишүүн (50-аас доош насны) байгаа эсэх эсвэл зөвхөн өндөр настан бүхий (65 ба түүнээс дээш насны) өрх гэсэн үзүүлэлтүүд багтана. Өрхийн орлоготой холбоотой үзүүлэлт хэдий ч, энэ бүлэгт тухайн өрх тэтгэврийн орлоготой эсэх, хүнсний талон авдаг эсэх

⁷⁸ Холбоотой материалууд: АХБ (2013) Хөгжлийн зардал-үр ашгийн шинжилгээ: Гарын авлага. Филиппин, Мандалуйонг хот: Азийн хөгжлийн банк; and, С. Гуляни нар (2005) Хотын ядуу хүмүүст зориулсан ус: Кени дэх усны зах зээл, өрхийн эрэлт, үйлчилгээний сонголт, Ус хангамж, ариун цэврийн салбарын зөвлөлийн хэлэлцүүлгийн баримт бичгийн цуврал №. 5, Дэлхийн банк.

гэсэн хоёр хувьсагчийг багтаасан. Эдгээр хувьсагч нь өндөр настан, асаргаа шаарддаг хүн эсвэл нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагддаг тусгай ангилалд багтсан гишүүн байгаа эсэхээр өрхийн бүрэлдэхүүнийг авч үздэг.

Гурав дахь бүлэг нь айл өрхийн усны хэрэглээ, зарцуулалт болон усны хүртээмжид нөлөөлж болзошгүй худалдан авах чадвар эсвэл 1 куб метр ус авахад гарах алдагдсан боломжийн өртөг гэх мэт хүчин зүйлүүдтэй холбоотой. Үүнд өрхийн сарын усны хэрэглээ, нэг хүнд ногдох хоногийн усны хэрэглээ, өрхийн орлогод усны зарцуулалтын эзлэх хувь; орон сууцанд байгаа хэрэглэгчдийн хувьд орон сууц нь усны тоолууртай эсэх, нийлүүлэгчийн төрөл (зарим өрх нийлүүлэгчээ мэддэггүйг анхаарна уу); гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд ус авахад туулсан зай, зарцуулсан цаг хугацаа, ундны усны гол эх үүсвэр (УТБ болон бусад эх үүсвэр), үндсэн эх үүсвэр хаалттай үед ашигласан өөр эх үүсвэрийн тоо зэрэгтэй холбоотой, 1 куб метр ус тутамд гарах алдагдсан боломжийн өртөг, үүний ундны усны эх үүсвэрийн хамаарал зэргийг багтаасан.

Эцэст нь, Дөрөвдүгээр бүлэгт усны үйлчилгээ, чанарын талаарх өрхийн санал бодол (өрхийн дундаж үнэлгээ, үүний гэр хорооллын ундны усны эх үүсвэртэй хамаарал), үнэ тариф (боломжийн, үнэтэй ба хямд), усны ирээдүйн хомстол, ирээдүйд усны хомстол үүсэхээс сэргийлэн их хэмжээний хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой тарифын өсөлт (зөвшөөрч байна, эсвэл мэдэхгүй, зөвшөөрөхгүй байна)-тэй холбоотой хувьсагчуудыг авч үзсэн.

Хүснэгт 28-д эдгээр өрхийн шинж чанарын мэдээллийн дүн шинжилгээгээр ажиглагдсан дундаж ТТЭ-д үзүүлэх нөлөөг нэгтгэн харуулав. Бүх үр дүнг 22-28 дугаар хүснэгтэд үзүүлсэн. Хувьсагч хоорондын олон шугаман хамаарлын эх үүсвэрийг арилгахын тулд өөр өөр үзүүлэлтүүдийг туршсан Жишээлбэл, нэг аялалд туулах зай, цагийг авсан усны 1 куб метр тутамд зарцуулах алдагдсан боломжийн өртгийг тусгаж эсвэл тусгахгүйгээр.

Хүснэгт 22-т эдгээр өрхийн шинж чанарын өгөгдөлд дүн шинжилгээ хийх замаар ажиглагдсан дундаж ТТЭ-д үзүүлэх нөлөөг нэгтгэн харуулсан. Хувилбаруудаар гарсан үр дүнг Хүснэгт 23-28-д харууллаа. Үзүүлсэн загварууд нь туршиж үзсэн бүх хувьсагчдыг жагсаасан загварууд бөгөөд 6.2, 6.3, 6.4-т тайлбарласан хэрэглэгчдийн дундаж ТТЭ-ийг тооцоолоход ашигласан загварууд юм. Жишээлбэл, ус авахад зарцуулсан цаг хугацаа эсвэл УТБ хүртэлх зайд хамаарах хувьсагчийн ач холбогдол нь 1 куб метр ус авах цаг хугацааны боломжийн зардлын хувьсах хэмжигдэхүүнтэй холбоотой байж болно (энэ нь мөн өрхүүдийн авсан усны хэмжээг харгалзан үзнэ). Гэхдээ алдагдсан боломжийн өртгийг загварт оруулаагүй байсан ч эдгээр хоёр хувьсагч болон өрхийн ТТЭ хооронд шууд хамааралтай болохыг нотлох баримт байхгүй байна. ФБХ-ийн үеэр гарсан санал шүүмжлэл болон хэрэглэгчдийн усны чанар, үйлчилгээний үнэлгээний талаарх дүн шинжилгээ нь гэр хорооллын хэрэглэгчдийг УТБ-ны төрлөөр нь ялгах нь үр дүнтэй болохыг харуулж байгаа тул харилцан үйлчлэлээр дамжуулан эдгээр загварууд нь хэрэглэгчдийн үйлчилгээний үнэлэмж болон цуглуулсан 1 куб метр ус тутамд зарцуулах алдагдсан боломжийн өртгийн хамаарал нь эдгээр хэрэглэгчдийн бүлгүүдэд харилцан адилгүй байгаа эсэхийг туршсан.

6.6.1 Өрхийн эдийн засаг, нийгэм эдийн засгийн шинж байдлын нөлөө

Өндөр орлого, эдийн засгийн үр ашигтай байдал нь сайжруулсан үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлж, ирээдүйд хомстолоос сэргийлэх хүслийг нэмэгдүүлж байна. Аль ч хувилбар байсан, дундаж ТТЭ нь нэг хүнд ногдох өрхийн орлоготой эерэг хамааралтай байна.

Орлогын түвшний энэ хамаарал нь гэр хорооллын ядуу өрх, орон сууцны ядуу өрхүүдэд үйлчилгээний сайжруулалт эсвэл хомстолоос сэргийлэхэд ТТЭ-ийн дундаж хэмжээ бага байгаа нь ажиглагдаж байна. Хамгийн чинээлэг гурван дүүргийн аль нэгэнд амьдардаг, илүү их усны нөөцтэй, сайн холбогдсон тул усны хэрэглээнээс хамгийн их ашиг хүртэх чадвартай гэр хорооллын хэрэглэгчийн дундаж ТТЭ өндөр, түүнийг дагаад усны үйлчилгээг сайжруулах эсвэл усны хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл илүү байна. Өрхийн орлогод нь КОВИД-19 сөргөөр нөлөөлсөн гэр хороолол болон орон сууцны өрхүүд усны хомстолоос сэргийлэх үйлчилгээнд ТТЭ багатай байна. Эдгээр өрхүүдийн шинж байдлыг харахад бусад өрхүүдээс өндөр ТТЭ-тэй байх ёстой учир энэ үр дүн өөр байлаа. Тэд ядуу байх магадлал бага, цалинтай ажилтай байх магадлал өндөр (3.7-г үзнэ үү), тиймээс усны хэрэглээгээ хамгийн сайн байлгахын тулд бусад хэрэглэгчдээс илүү сайн тоноглогдсон байх хандлагатай, улмаар ТТЭ өндөр байх магадлалтай юм. Энэхүү шинжилгээнээс тэдний ТТЭ бага гарсан нь түр зуурынх байж болох бөгөөд цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хүндрэлтэй холбоотой байж болно.

Гэр хорооллын дээд боловсролтой өрхүүд үйлчилгээний чанар сайжруулахад ТТЭ бага, хомстолоос сэргийлэх ТТЭ өндөр байхад, орон сууцны дээд боловсролтой өрхүүд эсрэгээрээ хомстолоос сэргийлэхэд ТТЭ багатай байна. Гэр хороололд хандлагын эдгээр ялгаа нь хэрэглэгчдийн 1 куб метр усны хэрэглээний үр ашиг (хомстолд орсон тохиолдолд багасна) нь УТБ-ны үйлчилгээг сайжруулснаар хэрэглэгчид ирэх үр ашгаас өндөр байгааг харуулж байна. Гэр хорооллын болон орон сууцны өрхүүдийн хомстолоос сэргийлэх дундаж ТТЭ-ийн зөрүү гэр хорооллын айл өрхүүдийн дунд "Гэр хорооллын иргэд усаа [өөрсдөө] явж авчирдаг учраас байж болох боломжит хэмжээгээр хэмнэдэг" гэсэн саналын талаархи фокус бүлгийн хэлэлцүүлгийн үеэр дурдсан үр дүнг харуулж байна (Шигтгээ 9-ийг үзнэ үү). Шинжилгээгээр сууцны өмчлөл ТТЭ -д нөлөөлөхийг тодорхойлох баримт гараагүй. А.Бямбадорж, Х.С.Лий нар Улаанбаатар хотын Дамбадаржаа дахь гэр хорооллын ус цэвэрлэх байгууламжийн талаар хийсэн судалгаагаар тусдаа байшинд амьдардаг хэрэглэгчид ус цэвэрлэх байгууламжийн суурилуулалт, ашиглалт, засвар үйлчилгээний зардалд ТТЭ илүү өндөртэй болохыг тогтоожээ. А.Бямбадорж, Х.С. Лий нар.⁷⁹ Энэ нь ТТЭ-ийн шинжилгээнд хомстолоос сэргийлэхэд гэр хороолол дахь ТТЭ өндөр байгаа шалтгаан юм гэжээ. Мөн дундаас дээш боловсролтой хүмүүс ус цэвэршүүлэх байгууламж суурилуулахад ТТЭ илүү байгааг судалгаагаар тогтоосон байна.

6.6.2 Өрхийн хүн ам зүй, бүтцийн нөлөө

Өрхийн хүн ам зүй, бүтэц бүрэлдэхүүний хувьд ахмад настны өрх аль ч хувилбарт ТТЭ-ийн дундаж хэмжээ бага байна. Үүний нэгэн адил, тэтгэврийн орлоготой өрхүүд (ахмад настан эсвэл асран хамгаалуулдаг гишүүн байгаа бол илүү магадлалтай) мөн дундаж ТТЭ бага байна. Эдгээр үр дүн нь залуу хүмүүс ирээдүйд илүү их санаа зовдог, ахмад настууд өнөө цагтаа илүү үнэ цэнэ өгч байгаатай холбоотой эсэхийг судлахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Гэр хороололд, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхийн дундаж ТТЭ үйлчилгээг сайжруулахад бага байна. 6.2-т болон энэ хэсэгт

⁷⁹ А. Бямбадорж Х. С. Ли нар (2019 он). Улаанбаатар хотын гэр хорооллын өрхүүдийн бохир ус цэвэрлэх, ус хангамжийн системийг сайжруулахад төлбөр төлөх эрмэлзэл. Ус сэтгүүл, 11(9), 1856.

дурдсан тэтгэврийн насны өрхүүдийн ТТЭ-ийн доод хэмжээ нь ухаалаг УТБ-наас илүү түгээгчтэй УТБ нь хэрэглэгчид илүү ээлтэй байдаг гэсэн үнэлгээтэй холбоотой гэсэн таамаглалыг судлахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай болно.

Орон сууцны ам бүл олонтой өрхийн дундаж ТТЭ бага байна. Энэ үр дүн нь ядуу өрхүүдийн ТТЭ бага байна гэсэн өмнө дурдсан дүгнэлттэй нийцэж байна. Мөн энэ үр дүн нь өрхийн усны хэрэглээ нэмэгдэхэд дундаж ТТЭ буурдаг гэсэн доорх дүгнэлттэй нийцэж байна.

6.6.3 Өрхийн усны хэрэглээний хэмжээ, зарцуулалт, ашиглалттай холбоотой хүчин зүйлсийн нөлөө

Дундаж ТТЭ болон усны хэрэглээний хэмжээ хоорондын хамаарал нь зөвхөн орон сууцанд байгаа хэрэглэгчдийн хувьд ажиглагдлаа. Шинжилгээгээр сөрөг хамааралтай гарсан бөгөөд энэ нь өрхийн усны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр дундаж хэрэглэгчийн ТТЭ буурдаг гэсэн үг юм. Усны хэрэглээг сард куб метрээр эсвэл нэг хүнд ногдох литрээр эсвэл тайланд тодорхойлсон хэрэглэгчдийн дөрвөн ангиллаар хэмжсэн тохиолдолд энэ хамаарлыг ажиглах боломжтой болно. Их ус хэрэглэгчид (сард 15 куб метр ба түүнээс дээш) хамгийн бага ТТЭ-тэй байна.

Усны тоолуургүй орон сууцанд амьдардаг өрхүүд тоолууртай орон сууцанд амьдардаг өрхөөс бага ТТЭ-тэй байв. Дээр дурдсанчлан, зөвхөн өндөр настан бүхий өрхүүдээс гадна тоолуургүй орон сууц болон тоолууртай орон сууцны өрхийн гол ялгаа нь усны хэрэглээний тооцоонд оршдог. Өөрөөр хэлбэл тоолуургүй орон сууцны хувьд хэрэглэсэн усны хэмжээгээр бус нэг өрхийн нэг гишүүнд 200 литр байх стандартыг үндэслэдэг. Усны тоолуургүй орон сууцны өрхүүдийн ТТЭ бага байгаа нь төлбөрийн нөхцөлтэй холбоотой байх магадлалтай. Өрхийн орлогод усны зарцуулалтын эзлэх хувь болон дундаж ТТЭ-ийн хоорондох сөрөг хамаарал нь энэхүү тайлбарын нэг нотолгоо болж байна. Учир нь тоолуургүй орон сууцны усны хэрэглээний төлбөрт орлогынхоо 5-аас дээш хувийг усанд зарцуулдаг тул тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн ТТЭ-ийн эзлэх хувь өндөр байгаагаар тайлбарлаж байна (4.1.2-ыг үзнэ үү). Ангилалд тоолуургүй орон сууц, тоолууртай орон сууц гэсэн хувьсагчийг оруулахгүй тохиолдолд усны зарцуулалтын санхүүгийн дарамт ба өрхийн ТТЭ-ийн хооронд хамаарал ажиглагдлаа. Энэ нь эдгээр хоёр хувьсагч ижил нөлөөтэй болохыг харуулж байна (Хүснэгт 27 ба 28-ыг үзнэ үү).

Ус нийлүүлэгч байгууллагаа мэддэг хэрэглэгчдийн хувьд ОСНААУГ болон хувийн конторын хэрэглэгчдийн ТТЭ нь УСУГ-ын хэрэглэгчид болон ус нийлүүлэгч байгууллагаа мэдэхгүй хэрэглэгчдийнхээс бага байна. ТТЭ-ийн судалгааны үр дүнгээр ч, фокус бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнгээр ч үүний шалтгааныг тайлбарлах боломжгүй байна.

Гэр хорооллын хэрэглэгчийн дундаж ТТЭ болон УТБ хүртэлх зай эсвэл ус авахад зарцуулсан цаг хугацаа хоёрын хооронд шууд хамаарал байхгүй байна. А.Бямбадорж, Х.С. Лий нарын дээр дурдсан судалгаанд Дамбадаржаа дахь хэрэглэгчдээс 30 минутын дотор ус авч чадахгүй байгаа хэрэглэгчдийн ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний зардалд санал болгож буй ТТЭ бага байгаа нь ажиглагдсан.

Хэрэглэгчдийн усны хүртээмж дундаж ТТЭ-д хэрхэн нөлөөлж байгааг нотлох баримт нь ундны усны гол эх үүсвэр хаагдсан үед хэрэглэгчид ус авах эх үүсвэрийн тоо, ундны ус авах гол эх үүсвэр болгон үйлчлүүлдэг УТБ-ны төрөл, мөн, усны үр ашигтай зардал, 1 куб метр ус авах тутамд гардаг алдагдсан боломжийн өртөг ба усны тарифын нийлбэрээр тодорхойлогдоно.

Ундны усны гол эх үүсвэр хаагдсан үед өөр эх үүсвэрийн олон сонголттой хэрэглэгчдийн дундаж ТТЭ өндөр байна.

Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ны хэрэглэгчид бусад хэрэглэгчтэй харьцуулахад хомстолоос сэргийлэх дундаж ТТЭ бага байв.

Алдагдсан боломжийн өртөг өндөртэй хэрэглэгчдийн хувьд үйлчилгээг сайжруулах эсвэл хомстолоос сэргийлэхэд дундаж ТТЭ нь бага байна. Эндээс алдагдсан боломжийн өртөг өндөртэй хэрэглэгчид хамгийн бага ТТЭ-тэй болох нь харагдаж байна. Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ны хэрэглэгчдийн дунд энэ сөрөг хамаарал байхгүй байна. Алдагдсан боломжийн өртөг өндөр байх үед усны усны хомстолоос сэргийлэхэд дундаж ТТЭ өндөр байх нь ажиглагдаж байна. Түүнчлэн алдагдсан боломжийн өртгийн хувьд усны хомстолоос сэргийлэхэд зөөврийн ус хангамжтай УТБ-ны хэрэглэгчид ухаалаг УТБ-ны хэрэглэгчдээс дундаж ТТЭ илүү байна (Хүснэгт 25-ын тэмдэглэлийг үзнэ үү). Эдгээр үр дүнгээс худалдан авах чадвар, хүртээмж нь хэрэглэгчдийн ТТЭ-д хэрхэн нөлөөлж байгааг харуулж байна.

6.6.4 Өрхийн санаа бодлын нөлөө

Аль ч хувилбар байсан усны үйлчилгээ, чанарт сэтгэл ханамжтай хэрэглэгчдийн ТТЭ-ийн дундаж түвшин өндөр байна. Үүнд хамаарахгүй зүйл нь УТБ-наас бусад эх үүсвэртэй хэрэглэгчид үйлчилгээний чанарт сэтгэл хангалуун байгаа үед УТБ-ны сайжруулсан үйлчилгээний ТТЭ нь доогуур хэрэглэгчид юм (Хүснэгт 23, 25-ын тэмдэглэлийг үзнэ үү). Зөөврийн ус хангамжтай УТБ-ны хэрэглэгчдийн хувьд энэ хамаарал бага боловч эерэг коэффициенттой байгаа нь усны үйлчилгээний үнэлэмжийн харьцуулсан түвшинд зөөврийн ус хангамжтай УТБ-ны хэрэглэгчид сайжруулсан үйлчилгээнд эсвэл хомстолоос сэргийлэхэд дундаж ТТЭ нь бага байна гэсэн үг юм (дундаж ТТЭ нь бага хурдаар нэмэгдэж байна, Хүснэгт 23, 25-ын тэмдэглэлийг үзнэ үү).

Үүнээс гадна, аль ч хувилбараас үл хамааран усны тарифыг үнэтэй гэж үздэг хэрэглэгчдийн дундаж ТТЭ нь усны тарифыг хямд гэж үздэг хэрэглэгчдийнхээс доогуур байв. Усны тарифыг зохистой гэж үздэг хэрэглэгчдийн дундаж ТТЭ нь усны тарифыг хямд гэж үздэг хэрэглэгчийнхээс бага байгаа ч ТТЭ-д үзүүлэх нөлөөллийн хэмжээ бага байна.

Эцэст нь хэлэхэд, ирээдүйд усны хомстолд орох нь санаа зовоосон асуудал гэж үзэж буй, мөн тарифыг зохих хэмжээгээр нэмэх ёстой гэдэгтэй санал нийлж буй орон сууц, гэр хорооллын хэрэглэгчид усны хомстолоос урьдчилан сэргийлэх дундаж ТТЭ нь үйлчилгээнийхээс өндөр байна.

Хүснэгт 22: Дундаж ТТЭ-ийн тодорхойлогч хүчин зүйлс

Шалгуур	Гэр хороололд сайжруулсан үйлчилгээнд	Гэр хороололд хомстолоос сэргийлэхэд	Орон сууцанд хомстолоос сэргийлэхэд
Нэг хүнд ногдох орлого (логарифм утга)	Эерэг	Эерэг	Эерэг
Ядуу өрх (бусад өрхтэй харьцуулахад)	Сөрөг		Сөрөг
УБ хотын хамгийн чинээлэг 3 дүүргийн нэгэнд амьдардаг (бусад өрхтэй харьцуулахад)	Эерэг	Эерэг	Эерэг
КОВИД-19 орлогод нь сөргөөр нөлөөлсөн (бусад өрхтэй харьцуулахад)	Сөрөг	Сөрөг	Сөрөг
Өрхийн тэргүүн дээд боловсролтой (бусад өрхтэй харьцуулахад)	Сөрөг	Сөрөг	Сөрөг

Түрээсэлдэг (ба хувийн өмчийн)			Эерэг
Түрээс, хувийн өмчөөс бусад төрлийн өмчлөл (хувийн өмчийнхтэй харьцуулахад)			
Ам бүлийн тоо			Сөрөг
Өрхийн тэргүүний нас	Сөрөг	Сөрөг	Сөрөг
Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)			
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	Сөрөг		
3-аас дээш хүүхэдтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)			
Ганц бие тэжээгчтэй, хүүхэдтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)			
Зөвхөн ахмад настайн бүхий өрх (бусад өрхтэй харьцуулахад)			
Тэтгэврийн орлоготой (бусад өрхтэй харьцуулахад)	Сөрөг	Сөрөг	Сөрөг
Хүнсний талонд хамрагддаг (бусад өрхтэй харьцуулахад)			
Өрхийн сарын усны хэрэглээний хэмжээ			Сөрөг
Нэг хүнд өдөрт ногдох усны хэмжээ, литр			Сөрөг
Усны хэрэглээ 5-8 м ³ (бага хэрэглээтэй)			Сөрөг
Усны хэрэглээ 8-15 м ³ (их хэрэглээтэй)			Сөрөг
Усны хэрэглээ 15 м ³ -ээс дээш (маш их хэрэглээтэй)			Сөрөг
Усны зарцуулалтын өрхийн орлогод эзлэх хувь (алдагдсан боломжийн өртгийг оруулаад)			Сөрөг
Усны тоолуургүй орон сууц (тоолууртай орон сууцтай харьцуулахад)			Сөрөг
ОСНААУГ (мэдэхгүй хариулттай харьцуулахад)			Сөрөг
Хувийн контор (мэдэхгүй хариулттай харьцуулахад)			Сөрөг
УСУГ (мэдэхгүй хариулттай харьцуулахад)			
Ус авахад зарцуулсан хугацаа 30-45 мин (15-30 мин.тай харьцуулахад)			
Ус авахад зарцуулсан хугацаа 15 мин-аас бага (15-30 мин.тай харьцуулахад)			
Ус авахад зарцуулсан хугацаа 45 мин-аас их (15-30 мин.тай харьцуулахад)			
УТБ хүртэлх зай 200м-1км (200м-ээс багатай харьцуулахад)			
УТБ хүртэлх зай 1 км-ээс их (200м-ээс багатай харьцуулахад)			
Үндсэн эх үүсвэр хаахад очих сонголтын тоо		Эерэг	
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ (ухаалаг УТБ-тай харьцуулахад)		Эерэг	
Зөөврийн ус хангамжтай УТБ (ухаалаг УТБ-тай харьцуулахад)			

Гол эх үүсвэр нь ихэвчлэн хувийн худгууд (шугамд холбогдсон УТБ-тай харьцуулахад)			
Усны үр ашигтай зардал (усны тариф болон 1 м³ ус авах алдагдсан боломжийн өртгийн нийлбэр)	Сөрөг	Сөрөг	
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)		Эерэг	
Зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)		Сөрөг	
Хувийн худгаас ихэвчлэн ус авдаг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)			
Усны үйлчилгээ, чанарын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ	Эерэг	Эерэг	Эерэг
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)			
Зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	Эерэг	Эерэг	
Хувийн худгаас ихэвчлэн ус авдаг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	Сөрөг	Сөрөг	
Усны үнэ боломжийн (хямдтай харьцуулахад)	Сөрөг	Сөрөг	Сөрөг
Усны үнэ үнэтэй (хямдтай харьцуулахад)	Сөрөг	Сөрөг	Сөрөг
Ирээдүйд усны хомстолд орж болзошгүй гэдэгт итгэдэг			Эерэг
Цаашид усны хомстолд орохгүйн тулд үнэ тарифыг нэмэгдүүлэхийг хүлээн зөвшөөрч байна		Эерэг	Эерэг

Хүснэгт 23: Гэр хорооллын сайжруулсан үйлчилгээнд дундаж ТТЭ-ийг тодорхойлогч хүчин зүйлс

Тайлбар: Тод үсгээр бичсэн эерэг коэффициент нь бусад бүх нөхцөл ижил байгаа тохиолдолд ийм шинж чанартай өрхүүд илүү өндөр ТТЭ-тэй байх магадлалтайг харуулна. Тод үсгээр бичсэн сөрөг коэффициент нь бусад бүх зүйл ижил байсан ч ийм шинж байдалтай өрхүүдийн ТТЭ бага байх магадлал өндөр байгааг харуулж байна. Бусад тохиолдолд дүн шинжилгээ нь тодорхойгүй байна.

Хамаарах хувьсагч: гэр хорооллын сайжруулсан үйлчилгээнд санал болгож буй тарифын түвшинд өгсөн хариулт			
Хувьсагч	Коэф.	Ст. хазайлт	P>t
Нэг хүнд ногдох орлого (байгаа эсэх)	0.38	0.1076	0.00
Улаанбаатар хотын хамгийн чинээлэг гурван дүүргийн нэгэнд амьдардаг (бусад өрхтэй харьцуулахад)	0.34	0.1384	0.02
КОВИД-19 орлогод нь сөргөөр нөлөөлсөн (бусад өрхтэй харьцуулахад)	-0.35	0.1604	0.03
Өрхийн тэргүүн дээд боловсролтой (бусад өрхтэй харьцуулахад)	-0.34	0.1582	0.03
Түрээсэлдэг (ба хувийн өмчийн)	0.33	0.8362	0.69
Түрээс, хувийн өмчөөс бусад төрлийн өмчлөл (хувийн өмчийнхтэй харьцуулахад)	-0.23	0.4230	0.59
Ам бүлийн тоо	0.01	0.0604	0.81
Өрхийн тэргүүний нас	-0.02	0.0071	0.03
Эмэгтэй тэргүүнтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.14	0.1660	0.41

Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй (бусад өрхтэй харьцуулахад)	-0.34	0.2064	0.096
3-аас дээш хүүхэдтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.05	0.2212	0.84
Ганц бие тэжээгчтэй, хүүхэдтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.11	0.1712	0.51
Зөвхөн ахмад настан бүхий өрх (бусад өрхтэй харьцуулахад)	0.28	0.3015	0.35
Тэтгэврийн орлоготой (бусад өрхтэй харьцуулахад)	-0.31	0.1935	0.11
Хүнсний талонд хамрагддаг (бусад өрхтэй харьцуулахад)	0.19	0.2601	0.46
Өрхийн сарын усны хэрэглээний хэмжээ	-0.18	0.1602	0.27
Усны зарцуулалтын өрхийн орлогод эзлэх хувь (алдагдсан боломжийн өртгийг оруулаад)	-0.01	0.0092	0.42
Усны хэрэглээ 5-8 м³ (бага хэрэглээтэй)	-0.12	0.3079	0.71
Усны хэрэглээ 8-15 м³ (их хэрэглээтэй)	-0.13	0.1956	0.50
Усны хэрэглээ 15 м³ -ээс дээш (маш их хэрэглээтэй)	0.02	0.5075	0.97
УТБ хүртэлх зай 200м-1км (200м-ээс багатай харьцуулахад)	0.08	0.1635	0.61
УТБ хүртэлх зай 1 км-ээс их (200м-ээс багатай харьцуулахад)	0.33	0.3240	0.31
Үндсэн эх үүсвэр хаахад очих сонголтын тоо	0.12	0.0872	0.19
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-3.53	3.7013	0.34
Зөөврийн ус хангамжтай УТБ (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-1.78	2.5574	0.49
Гол эх үүсвэр нь ихэвчлэн хувийн худгууд (шугамд холбогдсон УТБ-тай харьцуулахад)	4.53	4.2083	0.28
Усны үр ашигтай зардал (усны тариф болон 1 м³ ус авах алдагдсан боломжийн өртгийн нийлбэр)	-0.55	0.3070	0.08
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	0.53	0.4334	0.22
Зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	0.31	0.2944	0.29
Хувийн худгаас ихэвчлэн ус авдаг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-0.17	0.4884	0.73
Усны үйлчилгээ, чанарын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ	0.93^a	0.3553	0.01
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-0.82	0.5096	0.11
Зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-0.82^b	0.4150	0.05
Хувийн худгаас ихэвчлэн ус авдаг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-2.24^c	0.5675	0.00
Усны үнэ боломжийн (хямдтай харьцуулахад)	-1.21	0.1691	0.00
Усны үнэ үнэтэй (хямдтай харьцуулахад)	-1.53	0.3139	0.00
Тогтмол утга	6.19	3.1316	0.05
Sigma тогтмол	2.77	0.0700	0.00
Ажиглалтын тоо	2,084		
Wald Chi2(12)	146.76		
Log Likelihood	-2788.5		

Prob>chi2	0.0000
-----------	--------

Тайлбар 1/а ба в коэффициентуудын нийлбэр эерэг хэвээр байгаа бөгөөд энэ нь усны чанар, үйлчилгээний зэрэглэлийг харьцуулж үзэхэд зөөврийн ус хангамжтай УТБ-ны хэрэглэгчид ухаалаг УТБ-ны хэрэглэгчдээс дундаж ТТЭ бага гэсэн үг юм (дундаж ТТЭ бага хурдаар нэмэгддэг). 2/ а ба с коэффициентуудын нийлбэр эерэг байгаа нь УТБ-наас бусад эх үүсвэрийг ашиглан ус авдаг хоёр ижил хэрэглэгчийн усны үйлчилгээ, чанарыг сайн гэж үнэлдэг хэрэглэгч нь бага ТТЭ-тэй болохыг харуулж байна.

Хүснэгт 24: Гэр хорооллын сайжруулсан үйлчилгээний дундаж ТТЭ-ийн түвшнийг тооцоолоход ашигласан хамаарлыг тайлбарлав

Тайлбар: Тод үсгээр бичсэн эерэг коэффициент нь бусад бүх нөхцөл ижил байгаа тохиолдолд ийм шинж чанартай өрхүүд илүү өндөр ТТЭ-тэй байх магадлалтайг харуулж байна. Тод үсгээр бичсэн сөрөг коэффициент нь бусад бүх нөхцөл ижил байсан ч ийм шинж чанартай өрхүүдийн ТТЭ бага байх магадлал өндөр байгааг харуулж байна. Бусад тохиолдолд дүн шинжилгээ нь тодорхойгүй байна

Гэр хорооллын сайжруулсан үйлчилгээний дундаж ТТЭ-ийн түвшинг тооцоолоход ашигласан хамаарал- Хамаарах хувьсагч: гэр хорооллын сайжруулсан үйлчилгээнд санал болгож буй тарифын түвшинд өгсөн хариулт

Хувьсагч	Коэф.	Ст.хазайлт	P>t
Ядуу өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.33	0.1537	0.03
Улаанбаатар хотын хамгийн чинээлэг гурван дүүргийн нэгэнд амьдардаг (бусад өрхтэй харьцуулахад)	0.47	0.1395	0.00
Өрхийн тэргүүн дээд боловсролтой (бусад өрхтэй харьцуулахад)	-0.22	0.1595	0.16
Ам бүлийн тоо	-0.04	0.0463	0.43
Эмэгтэй тэргүүнтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.26	0.1657	0.11
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй (бусад өрхтэй харьцуулахад)	-0.35	0.2025	0.08
Тэтгэврийн орлоготой (бусад өрхтэй харьцуулахад)	-0.48	0.1540	0.00
Усны зарцуулалтын өрхийн орлогод эзлэх хувь (алдагдсан боломжийн өртгийг оруулаад)	-0.01	0.0087	0.45
Усны үйлчилгээ, чанарын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ	0.28	0.1566	0.07
Тогтмол утга	5.64	0.2630	0.00
Sigma тогтмол	2.85	0.0722	0.00
Ажиглалтын тоо	2,084		
Wald Chi2(12)	42.4		
Log Likelihood	-2842.65		
Prob>chi2	0.0000		

Хүснэгт 25: Хомстолоос сэргийлэхэд дундаж ТТЭ-ийг тодорхойлогч хүчин зүйлс

Тайлбар: Тод үсгээр бичсэн эерэг коэффициент нь бусад бүх нөхцөл ижил байсан ч ийм шинж чанартай өрхүүд ТТЭ өндөр байх магадлалтайг харуулж байна. Тод үсгээр бичсэн сөрөг коэффициент нь бусад бүх зүйл ижил байсан ч ийм шинж чанартай айл өрхүүдийн ТТЭ бага байх магадлал өндөр байгааг харуулж байна. Бусад тохиолдолд дүн шинжилгээ тодорхойгүй байна.

Хамаарах хувьсагч: гэр хороололд хомстолоос сэргийлэхэд санал болгосон тарифын түвшинд өгсөн хариулт

Хувьсагч	Коэф	Ст.Хазайлт	P>t
----------	------	------------	-----

Нэг хүнд ногдох орлого (байгаа эсэх)	0.20	0.078	0.01
Улаанбаатар хотын хамгийн чинээлэг гурван дүүргийн нэгэнд амьдардаг (бусад өрхтэй харьцуулахад)	0.13	0.101	0.20
КОВИД-19 орлогод нь сөргөөр нөлөөлсөн (бусад өрхтэй харьцуулахад)	-0.28	0.116	0.02
Өрхийн тэргүүн дээд боловсролтой (бусад өрхтэй харьцуулахад)	-0.14	0.115	0.23
Түрээсэлдэг (хувийн өмчийнхтэй харьцуулахад)	-0.19	0.588	0.75
Түрээс, хувийн өмчөөс бусад төрлийн өмчлөл (хувийн өмчийнхтэй харьцуулахад)	-0.40	0.301	0.18
Ам бүлийн тоо	-0.01	0.043	0.89
Өрхийн тэргүүний нас	-0.02	0.005	0.00
Эмэгтэй тэргүүнтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	0.00	0.119	0.97
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй (бусад өрхтэй харьцуулахад)	-0.19	0.148	0.21
3-аас дээш хүүхэдтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	0.12	0.161	0.46
Ганц бие тэжээгчтэй, хүүхэдтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.04	0.125	0.77
Зөвхөн ахмад настайн бүхий өрх (бусад өрхтэй харьцуулахад)	0.27	0.220	0.22
Тэтгэврийн орлоготой (бусад өрхтэй харьцуулахад)	-0.27	0.139	0.06
Хүнсний талонд хамрагддаг (бусад өрхтэй харьцуулахад)	0.10	0.188	0.60
Өрхийн сарын усны хэрэглээний хэмжээ	-0.06	0.116	0.63
Усны зарцуулалтын өрхийн орлогод эзлэх хувь (алдагдсан боломжийн өртгийг оруулаад)	-0.00	0.006	0.70
Ус авахад зарцуулсан хугацаа 30-45 мин (15-30 мин.тай харьцуулахад)	0.18	0.226	0.43
Ус авахад зарцуулсан хугацаа 15 мин-аас бага (15-30 мин.тай харьцуулахад)	0.01	0.142	0.97
Ус авахад зарцуулсан хугацаа 45 мин-аас их (15-30 мин.тай харьцуулахад)	0.04	0.366	0.92
УТБ хүртэлх зай 200м-1км (200м-ээс багатай харьцуулахад)	0.14	0.119	0.24
УТБ хүртэлх зай 1 км-ээс их (200м-ээс багатай харьцуулахад)	0.28	0.239	0.24
Үндсэн эх үүсвэр хаахад очих сонголтын тоо	0.14	0.065	0.04
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-8.24	2.655	0.00
Зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-2.75	1.829	0.13
Хувийн худгаас ихэвчлэн ус авдаг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-0.19	3.185	0.95
Усны үр ашигтай зардал (усны тариф болон 1 м³ ус авах алдагдсан боломжийн өртгийн нийлбэр)	-0.53^a	0.220	0.02
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	1.02^b	0.312	0.00

Зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	0.38^c	0.210	0.07
Хувийн худгаас ихэвчлэн ус авдаг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	0.22	0.370	0.56
Усны үйлчилгээ, чанарын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ	0.61^d	0.263	0.02
Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-0.28	0.368	0.45
Зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-0.56^e	0.305	0.07
Хувийн худгаас ихэвчлэн ус авдаг (ухаалаг УТБ-тай харьцуулахад)	-0.96^f	0.426	0.03
Усны үнэ боломжийн (хямдтай харьцуулахад)	-0.75	0.127	0.00
Усны үнэ үнэтэй (хямдтай харьцуулахад)	-1.01	0.227	0.00
Ирээдүйд усны хомстолд орж болзошгүй гэдэгт итгэдэг	-0.03	0.097	0.72
Цаашид усны хомстолд орохгүйн тулд үнэ тарифыг нэмэгдүүлэхийг хүлээн зөвшөөрч байна	1.54	0.102	0.00
Тогтмол утга	6.69	2.243	0.00
Sigma тогтмол	1.89	0.052	0.00
Ажиглалтын тоо	2,084		
Wald Chi2(12)	369.5		
Log Likelihood	-2273.17		
Prob>chi2	0.0000		

Тайлбар 1/ а ба b коэффициентуудын нийлбэр эерэг байгаа нь түгээгчтэй шугамд холбогдсон УБТ ашигладаг хоёр ижил хэрэглэгчийн хооронд алдагдсан боломжийн өртөг өндөртэй нь ТТЭ илүү байгааг харуулж байна. 2/ а ба c коэффициентуудын нийлбэр сөрөг хэвээр бөгөөд энэ нь алдагдсан боломжийн өртгийн харьцуулж болохуйц түвшинд зөөврийн ус хангамжтай УТБ-ны хэрэглэгчид ухаалаг УТБ-ны хэрэглэгчдээс дундаж ТТЭ илүү байна гэсэн үг юм (дундаж ТТЭ бага хурдаар буурдаг). 3/ d ба e коэффициентуудын нийлбэр эерэг хэвээр бөгөөд энэ нь усны чанар, үйлчилгээний зэрэглэлийг харьцуулж үзэхэд зөөврийн ус хангамжтай УТБ-ны хэрэглэгчид ухаалаг УТБ-ны хэрэглэгчидтэй харьцуулахад хомстолоос сэргийлэхэд дундаж ТТЭ бага байна гэсэн үг юм. (дундаж ТТЭ нь бага хурдаар нэмэгддэг). 4/ d ба f коэффициентуудын нийлбэр эерэг байгаа нь УТБ-наас бусад эх үүсвэрээс ус авдаг хоёр ижил хэрэглэгчдийн хооронд усны үйлчилгээ, чанарыг илүү үнэлсэн нь ТТЭ багатай болохыг харуулж байна.

Хүснэгт 26: Тайланд дурдагдсан гэр хороололд хомстолоос сэргийлэхийн тулд ТТУ-ийн дундаж түвшнийг тооцоолоход ашигласан хамаарал

Хүснэгтийн тайлбар: Тод үсгээр бичсэн эерэг коэффициент нь бусад бүх нөхцөл ижил байвал ийм шинж чанартай өрхүүд илүү өндөр ТТЭ-тэй байх магадлалтайг харуулж байна. Тод үсгээр бичсэн сөрөг коэффициент нь бусад бүх нөхцөл ижил байсан ч ийм шинж чанартай өрхүүдийн ТТЭ бага байх магадлал өндөр байгааг харуулж байна. Бусад тохиолдолд дүн шинжилгээ нь тодорхойгүй байна.

Тайланд тайлбарласан гэр хороололд хомстолоос сэргийлэхэд ТТУ-ийн дундаж түвшинг тооцоолоход ашигласан хамаарал – Хамаарах хувьсагч: гэр хороололд хомстолоос сэргийлэхийн тулд санал болгосон тарифын түвшинд өгсөн өрхийн хариулт

Хувьсагч	Коэф.	Ст. Хазайлт	P>t
Нэг хүнд ногдох орлого (байгаа эсэх)	0.3028	0.1023	0.00

Улаанбаатар хотын хамгийн чинээлэг гурван дүүргийн нэгэнд амьдардаг (бусад өрхтэй харьцуулахад)	0.2050	0.1015	0.04
КОВИД-19 орлогод нь сөргөөр нөлөөлсөн (бусад өрхтэй харьцуулахад)	-0.2703	0.1165	0.02
Өрхийн тэргүүн дээд боловсролтой (бусад өрхтэй харьцуулахад)	0.2439	0.1143	0.03
Ам бүлийн тоо	0.0205	0.0345	0.55
Эмэгтэй тэргүүнтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.0901	0.1195	0.45
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй (бусад өрхтэй харьцуулахад)	-0.2349	0.1443	0.10
Тэтгэврийн орлоготой (бусад өрхтэй харьцуулахад)	-0.4974	0.1126	0.00
Усны зарцуулалтын өрхийн орлогод эзлэх хувь (алдагдсан боломжийн өртгийг оруулаад)	0.0028	0.0063	0.65
Усны үйлчилгээ, чанарын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ	0.2083	0.1520	0.17
Ирээдүйд усны хомстолд орж болзошгүй гэдэгт итгэдэг	-0.0876	0.0985	0.37
Цаашид усны хомстолд орохгүйн тулд үнэ тарифыг нэмэгдүүлэхийг хүлээн зөвшөөрч байна	1.6228	0.1037	0.00
Тогтмол	-0.0024	1.3636	1.00
Sigma тогтмол	1.9396	0.0535	0.00
Ажиглалтын тоо	2,084		
Wald Chi2(12)	292.98		
Log Likelihood	-2319.09		
Prob>chi2	0.0000		

Хүснэгт 27: Орон сууцанд хомстолоос сэргийлэхэд дундаж ТТЭ-ийг тодорхойлогч хүчин зүйлс

Тайлбар: Тод үсгээр бичсэн эерэг коэффициент нь бусад бүх нөхцөл ижил байгаа тохиолдолд ийм шинж чанартай өрхүүд илүү өндөр ТТЭ-тэй байх магадлалтайг харуулна. Тод үсгээр бичсэн сөрөг коэффициент нь бусад бүх зүйл ижил байсан ч ийм шинж чанартай өрхүүдийн ТТЭ бага байх магадлал өндөр байгааг харуулж байна. Бусад тохиолдолд дүн шинжилгээ нь тодорхойгүй байна.

Хамаарах хувьсагч: төвлөрсөн шугамд холбогдсон орон сууцанд усны хомстолоос сэргийлэхийн тулд санал болгосон цэвэр, бохир усны төлбөрийн түвшинд өгсөн хариулт			
Хувьсагч	Көзф.	Ст. хазайлт	P>t
Нэг хүнд ногдох орлого (байгаа эсэх)	0.04	0.0151	0.00
Улаанбаатар хотын хамгийн чинээлэг гурван дүүргийн нэгэнд амьдардаг (бусад өрхтэй харьцуулахад)	-0.04	0.0194	0.05
КОВИД-19 орлогод нь сөргөөр нөлөөлсөн (бусад өрхтэй харьцуулахад)	-0.04	0.0199	0.08
Өрхийн тэргүүн дээд боловсролтой (бусад өрхтэй харьцуулахад)	-0.05	0.0196	0.02
Түрээсэлдэг (хувийн өмчийнхтэй харьцуулахад)	0.31	0.1556	0.05
Түрээс, хувийн өмчөөс бусад төрлийн өмчлөл (хувийн өмчийнхтэй харьцуулахад)	-0.02	0.0304	0.50
Ам бүлийн тоо	-0.00	0.0090	0.97

Өрхийн тэргүүний нас	-0.00	0.0009	0.00
Эмэгтэй тэргүүнтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.02	0.0226	0.44
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй (бусад өрхтэй харьцуулахад)	-0.03	0.0361	0.38
3-аас дээш хүүхэдтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	0.03	0.0316	0.36
Ганц бие тэжээгчтэй, хүүхэдтэй өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.01	0.0220	0.61
Зөвхөн өндөр настан бүхий өрх (бусад өрхтэй харьцуулахад)	-0.04	0.0411	0.30
Тэтгэврийн орлоготой (бусад өрхтэй харьцуулахад)	-0.00	0.0266	0.90
Хүнсний талонд хамрагддаг (бусад өрхтэй харьцуулахад)	0.16	0.1419	0.25
Усны хэрэглээ 5-8 м³ (бага хэрэглээтэй)	-0.06	0.0266	0.04
Усны хэрэглээ 8-15 м³ (их хэрэглээтэй)	-0.09	0.0254	0.00
Усны хэрэглээ 15 м³ -ээс дээш (маш их хэрэглээтэй)	-0.17	0.0307	0.00
Усны зарцуулалтын өрхийн орлогод эзлэх хувь (алдагдсан боломжийн өртгийг оруулаад)	-0.01	0.0031	0.01
Усны тоолуургүй орон сууц (тоолууртай орон сууцтай харьцуулахад)	-0.11	0.0310	0.00
ОСНААУГ (мэдэхгүй хариулттай харьцуулахад)	-0.05	0.0268	0.04
Хувийн контор (мэдэхгүй хариулттай харьцуулахад)	-0.09	0.0291	0.00
УСУГ (мэдэхгүй хариулттай харьцуулахад)	0.02	0.0425	0.63
Усны үйлчилгээ, чанарын сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ	0.08	0.0151	0.00
Усны үнэ боломжийн (хямдтай харьцуулахад)	-0.17	0.0248	0.00
Усны үнэ үнэтэй (хямдтай харьцуулахад)	-0.27	0.0300	0.00
Ирээдүйд усны хомстолд орж болзошгүй гэдэгт итгэдэг	0.08	0.0371	0.02
Цаашид усны хомстолд орохгүйн тулд үнэ тарифыг нэмэгдүүлэхийг хүлээн зөвшөөрч байна	0.24	0.0186	0.00
Тогтмол	1.27	0.2200	0.00
<i>Sigma тогтмол</i>	0.35	0.0097	0.00
Ажиглалтын тоо	2,110		
Wald Chi2(12)	491.21		
Log Likelihood	-2587.76		
Prob>chi2	0.0000		

Хүснэгт 28: Тайланд тайлбарласнаар хомстолоос сэргийлэхийн тулд ТТЭ-ийн дундаж түвшнийг тооцоолоход ашигласан хамаарал

Доорх хүснэгтийг уншихад анхаарах нь: Тод үсгээр бичсэн эерэг коэффициент нь бусад бүх зүйл ижил байвал ийм шинж чанартай өрхүүд илүү өндөр ТТЭ-тэй байх магадлалтайг харуулж байна. Тод үсгээр бичсэн сөрөг коэффициент нь бусад бүх зүйл ижил байсан ч ийм шинж чанартай өрхүүдийн ТТЭ бага байх магадлал өндөр байгааг харуулж байна. Бусад тохиолдолд дүн шинжилгээ нь тодорхой бус байна.

Тайланд тайлбарласанаар хомстолоос сэргийлэхийн тулд ТТЭ-ийн дундаж түвшнийг тооцоолоход ашигласан хамаарал – Хамаарах хувьсагч: Төвлөрсөн ус хангамжийн

сүлжээнд холбогдсон орон сууцанд усны хомстолоос сэргийлэхийн тулд санал болгож буй цэвэр, бохир усны төлбөрт үзүүлж буй хариу

Хувьсагч	Коеф.	Стандар т хазайлт	P>t
Ядуу өрх (ба бусад өрх)	-0.0570	0.0308	0.06
Ам бүлийн тоо	-0.0136	0.0068	0.05
Эмэгтэй тэргүүнтэй өрх (ба бусад өрх)	-0.0321	0.0230	0.16
Хөгжлийн бэрхшээлтэй гишүүн бүхий өрх (ба бусад өрх)	-0.0445	0.0367	0.23
Тэтгэврийн орлоготой (ба бусад өрх)	-0.0789	0.0205	0.00
Өрхийн орлогод усны зарцуулалтын эзлэх хувь	-0.0125	0.0029	0.00
Усны үйлчилгээ, чанарт үзүүлэх сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ	0.0942	0.0155	0.00
Ирээдүйд усны хомстолд орж болзошгүй гэж үзэх байдал	0.0898	0.0388	0.02
Цаашид усны хомстолд орохгүйн тулд тарифыг нэмэгдүүлэх зарчмыг хүлээн зөвшөөрөх байдал	0.2888	0.0191	0.00
Тогтмол утга	1.3968	0.0463	0.00
<i>Сигма тогтмол</i>	0.3754	0.0103	0.00
<i>Нийт утгын тоо</i>	2,110		
Вальд Хи-квадрат (12)	342.24		
Log Likelihood	-2682.10		
Prob>chi2	0.0000		

7. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛУУД

Төлбөрийн чадварыг авч үзэх бодлогын үндэслэл нь усны төлбөрийн чадварын асуудалтай хэрэглэгчдэд хандсан хөтөлбөрийн эрэлт, хэрэгцээ бий эсэхийг тодорхойлох төлбөрийн чадварын нэг болон олон хэмжигдэхүүнээр тодорхойлогдох явдал юм. ТТЭ-ийн судалгааны долоон зорилтын нэг нь (2.2 дугаар хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан) Ажлын даалгавар 2-ын хүрээнд хийгдэх Төлбөрийн чадвар болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн судалгаанд ашиглах хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, механизмуудын талаарх хэрэглэгчдийн үзэл бодлыг тодорхойлох явдал юм. Энэхүү судалгаа нь төлбөрийн чадварын асуудалтай тулгарсан, эсвэл тулгарах магадлалтай хэрэглэгчдийн дэд бүлгүүдийг дэмжих хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрөөр дамжин зорилтот хэрэглэгчдэд хүрэх татаасны хувилбаруудыг санал болгох юм.

Хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр нь хэрэглэгчдэд холбогдох зардлыг төлөхөд дэмжлэг үзүүлэх замаар үйлчилгээний хүртээмж, боломжийг хангахад тусалдаг нийгмийн халамжийн хөтөлбөр юм. Эдгээр нь ихэвчлэн тусламж хэрэгтэй байгаа хувь хүн болон өрхүүдэд чиглэдэг эсвэл тийм хүмүүс, өрхүүдэд үйлчилдэг байгууллагыг дэмждэг. Усан хангамжийн хувьд хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр нь хүртээмжийг дэмжих механизм (жишээ нь холболтын зардлыг хямдруулах эсвэл огт авахгүй байх), тарифт суурилсан татаас (жишээ нь тарифыг хямдруулах, өөр өөр хэрэглэгчийн бүлгүүдийн хооронд татаас шилжүүлэх), тарифаас гадуур шууд татаас (жишээ нь усны талон) эсвэл бусад тарифын бус татаасан хувилбаруудаар дамжуулан олгох байж болно. Сайн боловсруулсан хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр нь үйлчилгээ үзүүлэгчид бүх хэрэглэгчдийнхээ тарифыг тохируулахад сөргөөр нөлөөлөх ёсгүй бөгөөд үүний зэрэгцээ ядуу иргэдийг хамгаалах юм.

Тайлангийн энэ хэсэгт ТТЭ-ийн судалгаа хийх үеийн усны үйлчилгээний төлбөрийн чадварын талаарх мэдээлэл өгөх юм. Ажлын даалгавар 2-ын хүрээнд хийгдэх Төлбөрийн чадвар болон Хэрэглэгчид дэмжлэг үзүүлэх судалгаа нь тарифын аль түвшинд төлбөрийн чадварын асуудалтай тулгарах өрхүүдийг авч үзэх замаар ТТЭ-ийн тоон мэдээллийн шинжилгээ дээр тулгуурлан хийгдэх юм.

7.1 Санхүүгийн дарамт, төлбөр төлөхөд тулгарах бэрхшээлүүд болон тарифын талаарх үзэл бодол

Гэр хорооллын усны хэрэглээ болон зардал нь судалгаанд хамрагдсан өрхийн шууд хэрэглээний хэмжээг илэрхийлэх бөгөөд өрхүүдийн халуун усны газар болон угаалгын газраар дамжуулан хэрэглэж болох усыг тооцоогүй. Тиймээс доорх хүснэгт, дүн шинжилгээг харахдаа усанд орох, угаалга хийх усны хэрэглээг багтаасан орон сууцны оршин суугчдын мэдээлсэн хэрэглээ, зарцуулалттай шууд харьцуулж болохгүй.

7.1.1 Усны хэрэглээний санхүүгийн дарамт

Усны хэрэглээний "санхүүгийн дарамт"-ыг хэмжих нь өрхийн төсөвт усны хэрэглээний зардлын харьцангуй ачааллыг хэмжихийг хэлнэ. Энэхүү судалгаа нь усны хэрэглээний санхүүгийн дарамтын дараах хоёр хэмжигдэхүүнийг тооцоолсон:

- УТБ дээрх усны зарцуулалт болон нийт өрхийн орлогын харьцаа,
- УТБ дээрх усны зарцуулалт болон ус авахад зарцуулж буй цагийн алдагдсан боломжийн өртөг хоёрын нийлбэр ба өрхийн нийт орлогын харьцаа.

Хүснэгт 25-д усны зардлын хүрээг хэрэглэгчийн төрлөөр харуулав. Өрхийн орлогын хүрээг тайлангийн эхэнд Хүснэгт 2-т танилцуулсан (2.1 хэсгийг үзнэ үү). 26 дугаар хүснэгтэд усны хэрэглээний санхүүгийн дарамтыг, Хүснэгтэд 27-д гэр хорооллын хэрэглэгчдийн алдагдсан боломжийн өртгийг, Хүснэгтэд 28-д ус авах алдагдсан боломжийн өртгийг оруулж тооцсон санхүүгийн дарамтын түвшнийг харуулав.

Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн хувьд тэдний усны хэрэглээний санхүүгийн дарамт нь орон сууцны тоолууртай хэрэглэгчдийн усны хэрэглээний санхүүгийн дарамтын түвшнээс дунджаар хоёр дахин илүү байна. Энэ нь тэдний хувьд ашиглагддаг тооцооллын аргын шууд үр дагавар юм. 3 дугаар хэсэгт тайлбарласанчлан тоолуургүй орон сууцны усны хэрэглээг Засгийн газрын хоногт 200л ус хэрэглэх стандартыг үндэслэн тодорхойлдог.

Гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд тэд бага хэмжээний ус авдаг учраас усны зардал орлоготой нь харьцуулахад өчүүхэн хэсэг нь байна (дунджаар 0.4%). Гэхдээ Бүлэг 3-т тайлбарласанчлан гэр хорооллын усны хэрэглээ нь алдагдсан боломжийн өртөг дагуулж байдаг. Ус авахад зарцуулдаг цагийн алдагдсан боломжийн өртгийг тооцоонд оруулахад гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээний санхүүгийн дарамт нь бусад төрлийн хэрэглэгчдийн санхүүгийн дарамттай ойролцоо байна. **Дунджаар алдагдсан боломжийн өртгийг оруулсан усны хэрэглээний санхүүгийн дарамт нь Хүснэгт 28⁸⁰-д харуулсанчлан гэр хорооллын оршин суугчдын өрхийн орлогын 1.22%-ийг эзэлж байна.**

Хүснэгт 29: Хэрэглэгчийн төрлөөр сар бүрийн усны зардал (төгрөгөөр)

Хэрэглэгчийн төрөл	Дундаж	Медиан	Доод хязгаар ¹	Дээд хязгаар ¹
Гэр хороолол (зөвхөн УТБ-наас авах)	2,365	1000	300	3,000
Усны тоолуургүй орон сууц	19,331	18,000	9,000	34,200
Усны тоолууртай орон сууц	11,368	9,390	5,130	18,620

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: 1/ Доод болон дээд хязгаарыг орлогын бодит хязгаарыг төлөөлөх чадвар багатай орлогын хамгийн доод болон дээд түвшний 10%-ийг хассаны дараа тооцоолов.

Хүснэгт 30: Өрхийн орлогод эзлэх сарын усны зардлын хувиар илэрхийлсэн санхүүгийн дарамт

Хэрэглэгчийн төрөл	Дундаж	Медиан	Доод хязгаар ¹	Дээд хязгаар ¹
Гэр хороолол (зөвхөн УТБ-наас авах)	0.41	0.12	0.03	0.54

⁸⁰ Мөнгөн бус зардлаас гадна “УТБ дээр найзууд, хөршүүдтэйгээ харилцах харилцаанаас авах нийгмийн болон сэтгэлзүйн ашиг тус”, “УТБ руу ирж, очих алхалтаас авах эрүүл мэндийн ашиг тус” зэрэг мөнгөн бус ашиг тусыг мөн авч үзэж болно. Гэсэн хэдий ч судлаач гэр хорооллын хүмүүс хүнсний дэлгүүр рүү явах гэх мэт маш хүйтэн цаг агаарт оочирлох шаардлагагүй өөр төрлийн нийгмийн харилцааны хэлбэрүүд байгааг дурдсан. Явган алхахаас үүсэх эрүүл мэндийн ашиг тусын хувьд энэ нь хувь хүнээс шалтгаалах бөгөөд гэр хорооллын иргэд машинаар очиход хэцүү газар амьдардаг тул тэдэнд алхах боломж их байдаг. Нийгмийн ашиг тусыг тооцохгүй байх нь шинжилгээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

Усны тоолуургүй орон сууц	2.44	1.77	0.59	5.12
Усны тоолууртай орон сууц	1.26	0.78	0.31	2.33

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: 1/ Доод болон дээд хязгаарыг орлогын бодит хязгаарыг төлөөлөх чадвар багатай орлогын хамгийн доод болон дээд түвшний 10%-ийг хассаны дараа тооцоолов.

Хүснэгт 31: Гэр хорооллын хэрэглэгчдийн ус авахад зарцуулсан цагийн алдагдсан боломжийн өртөг (төгрөг/м3)

Дундаж	Медиан	Доод хязгаар ¹	Дээд хязгаар ¹
5,068	3,686	1,561	10,110

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: 1/ Доод болон дээд хязгаарыг орлогын бодит хязгаарыг төлөөлөх чадвар багатай орлогын хамгийн доод болон дээд түвшний 10%-ийг хассаны дараа тооцоолов.


Хүснэгт 32: Өрхийн орлогод эзлэх сарын усны зардал болон алдагдсан боломжийн өртгийн хувиар (%) илэрхийлсэн гэр хорооллын хэрэглэгчдийн санхүүгийн дарамт

Дундаж	Медиан	Доод хязгаар ¹	Дээд хязгаар ¹
1.22	0.64	0.20	2.14

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Тайлбар: 1/ Доод болон дээд хязгаарыг орлогын бодит хязгаарыг төлөөлөх чадвар багатай орлогын хамгийн доод болон дээд түвшний 10%-ийг хассаны дараа тооцоолов.

Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдах магадлалтай хэрэглэгчдийн дэд бүлгээрх өрхийн орлогод эзлэх усны хэрэглээний санхүүгийн дарамтыг Зураг 40-д үзүүлэв. Дээрх дүн шинжилгээнд дурдсанчлан аль ч дэд бүлэгт усны хэрэглээ нь усны тоолуургүй орон сууцны өрхүүдэд тоолууртай орон сууцны болон гэр хорооллын оршин суугчдаас илүү санхүүгийн дарамт болж байна. Орон сууцанд амьдардаг ядуу өрхүүдийн дарамт нь усны тоолуургүй (дунджаар 2.4%), тоолууртай (1.3%) аль ч орон сууцны хэрэглэгчдийн дундаж дарамтаас хамаагүй өндөр байна. Гэр хорооллын ядуу өрхүүдийн хувьд мөн адил энэ дарамт нь гэр хорооллын нийт хэрэглэгчдийн дунд ажиглагдсан санхүүгийн дарамт дунджаас (1.2% эсвэл ус авах алдагдсан боломжийн өртгийн оруулж тооцсон тохиолдолд 2.9%) өндөр байна.



Зураг 40: Сонгогдсон хэрэглэгчдийн бүлгүүд болон хэрэглэгчийн төрлөөрх өрхийн орлогод эзлэх хувиар (%) илэрхийлсэн өрхийн усны хэрэглээний санхүүгийн дарамт

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

7.1.2 Уламжлалт төлбөрийн чадварын харьцаа – 5 хувь болон түүнээс илүү санхүүгийн дарамттай өрхийн эзлэх хувь

Уламжлалт төлбөрийн чадварын харьцаа (УТЧХ) нь усны хэрэглээний санхүүгийн дарамтыг засгийн газар эсвэл зохицуулагчийн тодорхойлсон жишиг үзүүлэлттэй харьцуулдаг. Энэ хүрээнд Монголд аливаа удирдамж байдаггүй. Доор үзүүлсэн үр дүнг АХБ болон Дэлхийн банкны судалгаанд ашигласан өрхийн орлогын 5% гэсэн жишиг үзүүлэлт дээр үндэслэсэн болно.⁸¹ Цаашид Ажлын даалгавар 2 ЗНТТ-ны Төлбөрийн чадвар болон Хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх судалгааны хүрээнд усны хэрэглээний жишиг үзүүлэлт, УТЧХ шинжилгээний талаар илүү судлах болно.

УТЧХ нь 5% болон түүнээс дээш өрхийн эзлэх хувь орон сууцны усны тоолууртай (2.4%) болон гэр хорооллын (0.8%) хэрэглэгчдийн хувьд нэлээн бага байна. Усны тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн цэвэр болон бохир усны зардлыг авч үзэхэд энэ хувь 4% буюу бага хэвээрээ байна. Алдагдсан боломжийн өртгийг оруулж тооцоход УТЧХ нь 5%-иас өндөр гэр хорооллын хэрэглэгчдийн хувь (2.6%) нь орон сууцны тоолууртай хэрэглэгчдийн зөвхөн цэвэр усны зардлыг тооцсон хувьтай ижилхэн байна.

Өмнөх хэсэгт дурдсанчлан орон сууцны усны тоолуургүй оршин суугчдын төлбөр тооцооны арга нь 5%-иас дээш УТЧХ -тай эдгээр өрхүүдийн эзлэх хувь өндөр байх нөхцөлийг бүрдүүлж байна. Цэвэр, бохир усны төлбөрийг авч үзэхэд ойролцоогоор орон сууцны усны тоолуургүй (23%) 5 хэрэглэгч тутмын нэг нь 5%-иас дээс УТЧХ -тай байна.


Хүснэгт 33: Хэрэглэгчийн төрлөөр 5 хувиас дээш санхүүгийн дарамттай өрхүүдийн эзлэх хувь

⁸¹ С.Фанхаузер, С.Тепик нар (2007) Ядуу хэрэглэгчид эрчим хүч, усны төлбөрийг төлж чадах уу? Шилжилтийн үеийн орнуудын боломжийн дүн шинжилгээ. Эрчим хүчний бодлого, 35(2), 1038-1049.

Хэрэглэгчийн төрөл	Усны зардал	Усны зардал болон алдагдсан боломжийн өртөг	Бохир усны зардал
Гэр хороолол	0.8	2.6	Тохирохгүй
Усны тоолуургүй орон сууц	10.4	Тохирохгүй	23
Усны тоолууртай орон сууц	2.5	Тохирохгүй	4


Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Зураг 42 болон 43-т өрхийн цэвэр усны хэрэглээний санхүүгийн дарамт болон цэвэр, бохир усны хэрэглээний санхүүгийн дарамтын хувь нь 5 хувиас өндөр хэрэглэгчдийг Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдах магадлалтай хэрэглэгчийн дэд бүлгээр харуулав. 5 хувиас өндөр УТЧХ -тай орон сууцны тоолууртай ядуу өрхүүдийн хувь харьцангуй өндөр байна (28.%, ба бохир усны төлбөрийг оруулбал 41.2%). Орон сууцны тоолуургүй ядуу өрхүүдийн хувьд ижил хандлага ажиглагдаж буй бөгөөд эзлэх хувь нь бүр ч өндөр (36.7% ба 64.5%) байна. Гэр хорооллын хэрэглэгчдийн хувьд 5%-иас өндөр УТЧХ -тай ядуу өрхийн эзлэх хувь бага буюу 2% байна. Ус авахад зарцуулах цагийн алдагдсан боломжийн өртгийг нэмж тооцоход ойролцоогоор арван ядуу өрх тутмын нэг (9.1%) нь 5%-иас илүү УТЧХ -тай байна.



Зураг 41: Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгүүд болон хэрэглэгчийн төрлөөр усны зардлын санхүүгийн дарамт нь 5 хувиас илүү өрхүүдийн хувь

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа



Зураг 42: Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгүүд болон орон сууцны хэрэглэгчийн төрлөөр цэвэр, бохир усны зардлын санхүүгийн дарамт нь 5%-иас илүү өрхүүдийн хувь

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

7.1.3 Боломжит төлбөрийн чадварын арга – Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас санал болгосон босгод үндэслэсэн өрхийн усны боломжит зардал

Боломжит төлбөрийн чадварын арга (БТЧА) нь “засгийн газрын бодлого, олон улсын/эрүүл мэндийн байгууллагуудын тодорхойлсноор нэг хүнд ногдох усны хамгийн бага хэмжээг төлөхийн тулд өрхүүдийн шаардлагатай орлогын хэмжээг ойлгоход хэрэглэгддэг.”⁸² Үзүүлэлтийн зорилго нь усны хүртээмж, бэлэн байдал сайжирсан тохиолдолд хэн (ямар төрлийн өрхүүд) төлбөрийн чадварын асуудалтай тулгарч болохыг тодорхойлох явдал юм. Тухайн хүний зохистой гэж үзсэн усны хэрэглээний түвшнээс үл хамааран өрхүүд хамгийн наад захын шаардлагатай усыг хэрэглэх хувилбар юм.

“УТЧХ шиг өрхийн нийт зарлагад эзлэх өрхийн усны бодит дундаж зардлыг тооцохын оронд БТЧА нь усны хэрэглээний хамгийн бага жишиг хэмжээнд үндэслэн өрхийн усны боломжит зардлын өрхийн нийт зардалд эзлэх дүнг хувиар илэрхийлэн хэмждэг.”⁸³ Энэхүү судалгаанд бид дээр дурдсан УТЧХ-гаар илэрхийлсэн санхүүгийн ачааллын ижил жишиг хэмжээг (5%) болон ДЭМБ-ын санал болгосон нэг хүний нэг өдрийн 20 литр гэсэн жишиг хэмжээг ашигласан. Үүнийг 4.3.1 дугаар бүлэгт тайлбарласан. Ажлын даалгавар 2. ЗНТТ-ны Төлбөрийн чадвар болон Хэрэглэгчид дэмжлэг үзүүлэх судалгааны хүрээнд усны хэрэглээний жишиг болон БТЧА шинжилгээний талаар илүү судлах болно.

Хүснэгт 34-т нэг өрхийн нэг гишүүн өдөрт 20 литр ус хэрэглэхэд тухайн өрхийн орлогын 5 хувиас дээш зардалтай тэнцэх өрхийн дундаж хувийг үзүүлэв.

⁸² Ажлын удирдамж, Улаанбаатар хотын ус хангамжийн тогтвортой байдлыг хангах Зардал нөхөх техник туслалцаа.

⁸³ Ажлын удирдамж, Улаанбаатар хотын ус хангамжийн тогтвортой байдлыг хангах Зардал нөхөх техник туслалцаа.

Гэр хороолол, орон сууц аль алинд 20 л/хүн/өдөр ус хэрэглэхэд өрхийн сарын орлогын 5%-иас дээш хувийг зарцуулж болох хэрэглэгчдийн тоо маш бага буюу 1%-иас доогуур байна. Алдагдсан боломжийн өртгийг тооцвол гэр хорооллын хэрэглэгчдийнх 4.1% болж өснө. Усны тоолуургүй орон сууцанд хэрэглэгчдийн сарын усны зарцуулалтыг 200 л/хүн/өдрийн нормоор тооцож байгаа бөгөөд бодит хэрэглэсэн усны хэмжээтэй хамааралгүй тул энэ үзүүлэлт нь энэ ангилалд хамаарахгүй.

Хүснэгт 34: Хэрэглэгчийн төрлөөр 5 хувиас дээш санхүүгийн дарамттай өрхүүдийн эзлэх хувь

Хэрэглэгчийн төрөл	Усны зардал	Усны зардал болон алдагдсан боломжийн өртөг	Бохир усны зардал
Гэр хороолол	0.3	4.1	Тохирохгүй
Усны тоолуургүй орон сууц	Тохирохгүй	Тохирохгүй	Тохирохгүй
Усны тоолууртай орон сууц	0.4	Тохирохгүй	0.6

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Зураг 43-т өдрийн усны хэрэглээ нь ДЭМБ-аас зөвлөсөн 20 л/хүн/өдөр ус хэрэглэхэд зардлын санхүүгийн дарамт нь өрхийн орлогын 5 хувиас илүүг эзлэх өрхүүдийн хувийг хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт хамрагдах магадлалтай хэрэглэгчийн дэд бүлгүүдээр салгаж харуулав. Орон сууц болон гэр хорооллын алинд нь ч **ДЭМБ-ын босгыг давах хэмжээнд хэрэглэхэд санхүүгийн дарамт нь хэт өндөр байх ядуу өрхийн эзлэх хувь нь бусад бүх дэд бүлгүүдийн хэрэглэгчдийн хувьд гарсан хэмжээнээс нэлээдгүй өндөр байна.** Гэсэн хэдий ч орон сууц, гэр хорооллын ядуу хэрэглэгчдийн ихэнхийн хувьд өрхийн орлогод хэт их санхүүгийн дарамт учрахгүйгээр 20 л/хүн/өдөр ус хэрэглэх боломжтой. Зөвхөн гэр хорооллын ядуу хэрэглэгчдийн 1.8%, орон сууцны усны тоолууртай ядуу хэрэглэгчдийн 8.7% нь 5 хувиас илүү санхүүгийн дарамттай учирна.



Зураг 43: Сонгогдсон хэрэглэгчийн дэд бүлгүүд болон хэрэглэгчийн төрлөөр 20 л/хүн/өдөр усны хэрэглээ нь 5 хувиас илүү санхүүгийн дарамт учруулах өрхийн хувь

Тайлбар: Орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн төлбөр 200 л/хүн/өдөр дээр үндэслэж тооцогддог тул тэдний хувь энэ үзүүлэлтийг тооцох боломжгүй юм.

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

7.1.4 Төлбөрийн чадварыг хэмжих өөр нэгэн үзүүлэлт- Үлдэгдэл орлогын арга


Үлдэгдэл орлогын арга (ҮОА) нь усны төлбөрөө төлсний дараа тухайн өрх бусад бараа, үйлчилгээний хэрэглээний доод түвшнийг хангахад шаардлагатай мөнгөний эх үүсвэргүй болж магадгүй гэсэн ойлголтод үндэслэсэн болно. Тиймээс ҮОА нь усны үнээс үүдэлтэй орлого эсвэл өрхийн төсвийн хязгаарлалтыг тооцдог. Өрхийн үлдэгдэл орлогыг тухайн үеийн өрхийн нийт орлогоос усны бодит зардлыг хасаж тооцдог. Үлдэгдэл орлогын дүнг бодлого, норматив стандартын дагуу уснаас бусад худалдан авах шаардлагатай өрхийн бараа, үйлчилгээний дүнтэй харьцуулан үнэлнэ (тухайлбал, ядуурлын шугамыг амьжиргааны доод түвшин гэж үзнэ). Хэдийгээр УТЧХ, БТЧА ашиглахад төлбөрийн чадварын асуудал илрээгүй ч усны зардлаас үүдэлтэй өрхийн ядуурлыг тодруулах боломжтой байдаг учраас ҮОА нь хэрэгтэй хэмжигдэхүүн юм. Судалгаа нь ҮОА ашиглан хэрвээ усны зардал нь тэдний бодит зардлын биш нийт орлогын 5 хувийг эзэлсэн нөхцөлд өрхийн орлого нь амьжиргааны доод түвшнээс бага болох орон сууцны болон гэр хорооллын ойролцоогоор 5000 өрх эсвэл нийт ядуу биш өрхийн 1.7% байна гэж тооцоолсон. Ажлын даалгавар 2-ын хүрээнд УТЧХ, БТЧА, ҮОА-г ашиглан төлбөрийн чадварыг үнэлэх нэмэлт шинжилгээнүүдийг хийх болно.

7.1.5 Төлбөр төлөхөд тулгарах асуудлууд

Төлбөрийн чадварын асуудалд хандах өөр нэг арга бол олон өрх төлбөрийн бэрхшээлтэй байгаа эсэхийг ажиглах явдал юм. Орон сууцны хэрэглэгчдийн төлбөрөө төлөхгүй мөн хоцроож байгаад үндэслэн ОСНААУГ хэрэглэгчдийнхээ 10-15 хувийг нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдах боломжтой орлого, хүн ам зүйн бүлэгт багтана гэж тооцоолжээ.⁸⁴ Гэсэн хэдий ч аж ахуйн нэгжийн харснаар эдгээр үйлчлүүлэгчдийн нэлээд хэсэг нь төлбөрөө төлдөг байна. Ганцаарчилсан ярилцлагын үеэр хэд хэдэн оролцогч талууд дундаж давхаргын болон илүү боломжтой өрхүүд харин ч төлбөрөө хоцроох эсвэл төлбөрөө дахин дахин хэсэгчлэн төлдөг болохыг дурдсан. Төлбөрөө хоцроодог эсвэл төлбөрийн зөрчил гаргадаг бусад хэрэглэгчид нь түр зуурын түрээслэгчид байдаг (тухайлбал оюутнууд, өвөлдөө орон сууцанд амьдарч байгаа гэр хорооллын өрхүүд).

⁸⁴ Ажлын удирдамж. Улаанбаатар хотын ус хангамжийн тогтвортой байдлыг хангах Зардал нөхөх техник туслалцаа

ТТЭ-ийн судалгаа нь энэ асуудлаар орон сууцны хэрэглэгчдээс мэдээлэл цуглуулсан. Ойролцоогоор таван орон сууцны хэрэглэгч тутмын нэг (18.2%) нь судалгаа авахаас өмнөх 12 сард цэвэр, бохир усны төлбөрөө хоцроож байсан байна. Энэ хувь нь ядуу өрхүүдийн хувьд илүү өндөр байна (22.3%). Дурдагдсан хоёр үндсэн шалтгаан нь мөнгөгүй байх (ядуу хэрэглэгчдийн хувьд 55.3%; ядуу биш хэрэглэгчдийн хувьд 33.1%) болон төлбөрөө төлөхөө мартах (ядуу хэрэглэгчдийн хувьд 10.7%; ядуу биш хэрэглэгчдийн хувьд 28.9%) явдал байв.



Зураг 44: Орон сууцны ядуу болон ядуу биш хэрэглэгчдийн төлбөрөө хоцроох шалтгаан болон төлбөрийн бэрхшээл

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

7.1.6 Төлбөр төлөх арга, хэлбэрүүд


Энэ хэсэг нь Ажлын даалгавар 1-ийн Зорилт 7-д хэсэгчлэн хандсан болно: Төлбөр төлөх өнөөгийн арга, сайжруулах боломжит хувилбарууд болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн талаарх хэрэглэгчдийн санал бодлыг тодорхойлж, дараагийн шатны судалгаанууд болох Ажлын даалгавар 2-“Худалдан авах чадвар болон Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн судалгаа”, Ажлын даалгавар 3-“Тарифын хувилбарын судалгаа”-г шаардлагатай мэдээллээр хангах.

Гэр хорооллын оршин суугчид нь шууд УТБ дээр төлбөр хийх эсвэл ус авахаасаа өмнө урьдчилан ухаалаг картаа цэнэглэсэн байх шаардлагатай байдаг тул төлбөр төлөхгүй

байх эсвэл хоцроох гэсэн асуудал байдаггүй. Харин орон сууцны хэрэглэгчдийн хувьд төлбөрөө хоцроох давтамж өндөр байдаг болон холбогдох торгууль нь өрхийн санхүүгийн дарамтыг нэмэгдүүлэх магадлалтай байдаг. Тиймээс энэхүү судалгаа нь фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчдоос төлбөр төлөх арга хэлбэр, энэ нь хэрэглэгчдийн төлбөрөө цагтаа төлөх байдалд хэрхэн нөлөөлөх магадлалтай талаар мэдээлэл цуглуулсан. Төлбөрөө хоцроосон тохиолдолд хэрэглэгчид нэг өдөрт нийт дүнгийн 0.5%-тай⁸⁵ тэнцэх хэмжээний торгуулийг ногдуулдаг. Энэ нь нэг сар төлбөрөө хоцрооход хоцроосон дүнгийн 16%-тай тэнцүү торгууль гэсэн үг юм.

Хамгийн түгээмэл төлбөрийн арга бол банканд төлбөр төлөх юм (орон сууцны оршин суугчдын 56%). Гэхдээ фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчид банкин дээрх оочир хүндрэл үүсгэдэг талаар дурдсан. Цахим төлбөрийн арга нь олон оролцогчдын дурдсан сонголт байсан. Энэхүү шийдлийг орон сууцны хэрэглэгчдийн 28% нь ашигладаг.

Татвараас зайлсхийхтэй тэмцэхэд дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил Монголын татварын алба хэрэглэгчдийг сар бүрийн сугалаанд баримт бүрээ бүртгүүлэн, НӨАТ төлөхийг уриалахыг эрмэлздэг. Хэдийгээр цахимаар төлбөрөө хийсэн ч сугалаанд оролцох боломжтой байдаг боловч фокус бүлгийн хэлэлцүүлгээс харахад тэр бүр бүх оршин суугчид энэ талаар мэддэггүй бололтой. Энэ нь цахим төлбөр төлөх хувилбарыг тийм ч таатай санагдуулдаггүй. Магадгүй усны төлбөрөө цахимаар төлбөр төлсөн нөхцөлд хэрхэн сугалаанд хамрагдах боломжтой талаар илүү мэдээлэл өгөх нь банк орох хэрэгцээг багасгаж, төлбөрийн хоцрогдлыг бууруулахад нэмэртэй.



Зураг 45: Орон сууцны хэрэглэгчдийн одоогийн төлбөр төлдөг арга хэлбэр

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

⁸⁵ Торгууль нь Иргэний хуулиар тодорхойлогдсон байдаг ба бүх орон сууцны хэрэглэгчдэд үйлчилнэ. Төрийн Банк сар бүрийн 25-наас хойш төлөөгүй үлдэгдэл дээр өдрийн 0.5%-ийн хүү тооцдог. Энэ дүн нь тэдний банкны программ дээр автоматаар бодогддог. Усны үйлчилгээ үзүүлэгч, банк хоорондоо 0.3%, 0.4% дээр тохиролцож болдог гэдэг. Төрийн банк хэрэглэгчид ногдуулсан торгуулийн 50%-ийг авч, үлдсэнийг нь усны үйлчилгээ үзүүлэгч байгууллага руу шилжүүлдэг. Төлбөрийн өрийн үлдэгдэл их байгаа тохиолдолд хэрэглэгчид хуримтлагдсан өрийг торгууль төлөхгүйгээр шууд банкин дахь усны үйлчилгээ үзүүлэгчийн данс руу төлж, ус нийлүүлэгч нь торгуулийг хүчингүй болгох тухай албан бичиг Банк руу илгээдэг.

Шигтгээ 15: Фокус бүлгийн хэлэлцүүлгээс – Төлбөр төлөх арга, хэлбэрийн талаарх үзэл бодол

“Төрийн банкаар биш бусад банкн дээр төлдөг бол илүү сайн байна. Төрийн Банкн дээр нэг хүнд 30 минут үйлчилдэг ба энэ нь урт оочир үүсгэдэг.”

- 22 настай эрэгтэй

“Хамгийн төвөгтэй нь тэд биднийг банкн дээр очиж төлбөрөө төл гэдэг. Цахимаар төлсөн тохиолдолд ямар ч баримт өгдөггүй. Бид бүгд Төрийн банкн дээр төлөх шаардлагатай учраас маш их оочир дараалал үүссэн байдаг. Цахимаар төлбөрөө хийхэд и-баримт [НӨАТ-ын системээс гардаг сугалаанд хожих магадлалтай цахим/цаасан баримт] авдаг бол их зүгээр байна. Бусад банкн дээр төлбөр төлсөн тохиолдолд мөн баримт өгдөггүй.”

- 22 настай эмэгтэй

“Банкн дээрх оочир асуудалтай байдаг. Мэдээж цахимаар төлбөрөө хийх нь илүү дээр боловч и-баримтын кодтой төлбөрийн баримт хэрхэн авах мэдээллийг сайн өгөх хэрэгтэй. Нөгөөтэйгүүр банкны систем нь цахимаар гүйлгээ хийж чадахгүй ахимаг насны хүмүүст хэрэгтэй байж болох юм. QR кодын систем нь амар байх гэж бодож байна. Хэдийгээр АТМ нь олон газарт байдаг ч дансны дугаарыг цээжлэх эсвэл дансны дугаар оруулах нь хэцүү байх.”

- 28 настай эмэгтэй

“Эхний жилүүдэд би Төрийн банк руу очиж төлөөд, и-баримтын дугаараа авдаг байсан. Гэхдээ сүүлийн жилүүдэд би бүх гүйлгээгээ цахимаар хийдэг болсон тул нэг ч баримт аваагүй. Тэд баримт цахим хаягаар ирдэг гэж хэлдэг боловч би цахим хаягаа банктайгаа холбож амжаагүй л явна.”

- 28 настай эмэгтэй


“Хэрэв цахимаар төлбөрөө хийвэл баримтаа цахим хаягаараа авчихна. Үүнд ямар ч асуудал байхгүй. Өвөө, эмээ маань ихэвчлэн орон сууцны хэрэглээний төлбөрөө төлдөг. Гэхдээ тэд цахимаар юм уу, мобайл банк ашиглан төлбөр төлдөггүй. Төлбөрийн талаар мэйлээр мэдэгдэл хүлээн авдаггүй [тиймээс] тэд нотлох баримтаа алддаг. Хэрэв технологийг бүрэн ашиглаж чадвал үүдний танхим бүрийн булан болон самбар дээр QR кодыг тавихад төлбөр төлөх нь хамгийн хялбар болно. Төлбөр төлөхөд 5 минут л зарцуулна.”

- 22 настай эрэгтэй

7.1.7 Тарифын талаарх үзэл бодол


Улаанбаатар хотын хэрэглэгчдийн багахан хэсэг (12.4%) нь усыг үнэтэй гэж үздэг бөгөөд гуравны хоёр нь "Боломжийн" гэж үнэлдэг бол таван хүн тутмын нэг нь хямд үнэтэй гэж үздэг байна. Ядуу өрхүүд болон нэг хүнд ноогдох усны маш бага өдрийн хэрэглээтэй өрхүүд нь ядуу биш өрхүүдтэй үзэл бодлын адил харьцаатай байна (Зураг 46). **Гайхалтай нь усны тарифыг үнэтэй гэж үздэг орон сууцны усны тоолуургүй хэрэглэгчдийн хувь өндөр (30.2%) байна.** Энэ нь усны тоолуургүй орон сууцны төлбөр тооцдог аргачлал нь оршин суугчдад сөргөөр нөлөөлдгийн бас нэг илрэл юм.

Өнгөрсөн удаагийн тарифын өсөлтийг орон сууцны оршин суугчдын 62.1% нь анзаарсан байна (Зураг 47 харна уу). Энэ харьцаа нь хэрэглэгчдийн төрөл эсвэл өрх нь ДЭМБ-ын зөвлөсөн түвшнээс доогуур нэг хүнд ноогдох өдрийн усны бага хэрэглээтэй байхаас үл хамааран ижил байна. Ядуу өрхүүд энэ өсөлтийг анзаарсан илүү хувь (70.8%) өндөр байв.




Зураг 46: Одоогийн усны тарифын талаарх хэрэглэгчдийн үзэл бодол

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа



Зураг 47: Урьд нь тариф нэмэгдэхэд анзаарсан хэрэглэгчдийн хувь

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа



Зураг 48: Одоогийн усны тарифын талаарх хэрэглэгчдийн үзэл бодол, хэрэглэгчийн төрлөөр

Эх сурвалж: ТТЭ-ийн судалгаа

Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн дийлэнх ихээхэн хувь (30%) нь, одоогийн тарифыг өндөр үнэтэй гэж үзэж байгаа нь эдгээр хэрэглэгчдийн орлогод усны зардлын үзүүлэх санхүүгийн дарамт ихтэй холбоотой байж болох юм. (Зураг 48-ыг харна уу).

7.2 Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн танилцуулга

Энэ хэсэгт Ажлын даалгавар 1-ийн Зорилт 7-г хэсэгчлэн авч үзэв: Төлбөр төлөх өнөөгийн арга, сайжруулах боломжит хувилбарууд болон Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн талаарх хэрэглэгчдийн санал бодлыг тодорхойлж, дараагийн шатны судалгаанууд болох Ажлын даалгавар 2-“Худалдан авах чадвар болон Хэрэглэгчийг дэмжих хөтөлбөрийн судалгаа”, Ажлын даалгавар 3-“Тарифын хувилбарын судалгаа”-г шаардлагатай мэдээллээр хангах.

Шигтгээ 16: Боломжит Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрүүдийн (ХДХ) сонголт ба Ажлын даалгавар 2-ын зах зээлийн нөхцөл байдлыг боловсруулахад ашиглах хувилбарууд болон ХДХ-ийн хувилбарууд

Зарим айлууд усны төлбөр төлөх, усан хангамжийн хүртээмжийг жилийн турш биш юмаа гэхэд ядаж жилийн хэдэн сарын турш хүссэнээрээ байлгахад бэрхшээлтэй байдаг гэж бид сонссон. Энэ талаар та юу гэж бодож байна вэ? Та үүнийг зарим өрхийн асуудал гэж үзэж байвал, тэдний усан хангамжийн асуудлыг юу үүсгэж байна гэж бодож байна вэ?

Хэрэв та зарим өрхөд усны төлбөр төлөх нь хүндрэлтэй байдаг гэж үзэж байвал үүнийг шийдэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж бодож байна вэ? Ямар төрлийн дэмжлэг үзүүлж болох вэ?

- Хэрэв та зарим өрхөд ус хэрэглэхэд асуудалтай байдаг гэж үзэж байвал үүнийг шийдэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж бодож байна вэ?
- Дэмжлэгийг хэрхэн үзүүлэх хэрэгтэй вэ? Таны бодлоор дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг ямар байгууллага, эсвэл засгийн газрын агентлаг удирдан хэрэгжүүлж чадах вэ?
- Хэрэв зөвхөн хамгийн их тусламж шаардлагатай өрхүүдэд дэмжлэг үзүүлэх боломжтой бол тухайн өрхүүдийг хэрхэн сонгох вэ? Дэмжлэг үзүүлэх хөтөлбөр маань хамрагдах боломжтой хүмүүсээ хэрхэн баталгаажуулах вэ? Хөтөлбөрт хамрагдахын тулд хүмүүст ямар төрлийн нотлох баримт хангалттай эсвэл шаардлагатай байх вэ?

Удирдамж: Төлбөрийн дэмжлэг үзүүлэх хувилбарууд: хөнгөлөлттэй тариф, усны төлбөрийн зарим хэсгийг төлөх усны талон. Хүртээмж нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх хувилбарууд: усны тэргээр хангах, 24-цагийн ажиллагаатай УТБ, усны саваар хангах, бага төлбөртэй усны хүргэлт хийх. Хэлэлцүүлгийн явцад хариулт өгөөгүй бол ядуу өрхүүдийг хэрхэн тодорхойлж, зорилтот бүлэгт оруулах талаар асуух.

Тайлангийн 3.4 дүгээр хэсэгт тайлбарласан шаталсан үнэ болон амьжиргаа тэтгэх тариф нэвтрүүлэхээс гадна тарифын өсөлтийн ядуу өрхүүдэд үзүүлж болох сөрөг нөлөөг бууруулах өөр нэг арга нь Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх явдал юм. Ажлын даалгавар 2 ЗНТТ-ны Төлбөрийн чадвар болон Хэрэглэгчдийг дэмжих судалгаа нь хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн үндэслэл болон хамгийн сайн загварыг нарийвчлан судлах болно.

Энэ хэсэг нь хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр ямар байх хэрэгтэй талаарх фокус бүлгийн оролцогчдын үзэл бодлыг танилцуулж, тайлбар өгөх болно. Шигтгээ 16 нь оролцогчдод энэ сэдвийг танилцуулсан арга хэлбэр, мөн оролцогчид ямар төрлийн дэмжлэг байх боломжтой талаар өөрсдийн санаагаа гаргаж чадахгүй нөхцөлд хэлэлцүүлгийн чиглүүлэгчдэд өгсөн удирдамжийг харуулж байна.

7.2.1 Фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчдын үзэл бодол ба санаа зовниж буй асуудлууд

Фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчдын дийлэнх нь тариф өссөн тохиолдолд хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөр шаардлагатай гэдэг дээр санал нийлж байв. Гэр хорооллоос оролцсон 29 хүний 8 нь ийм хөтөлбөр хэрэгтэй гэж үзсэн бол орон сууцны 26 хэрэглэгчдийн 15 нь дэмжсэн буюу орон сууцны хэрэглэгчид илүү хүчтэй дэмжиж байсан. Иймэрхүү хөтөлбөрт дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай биш өрхүүд хамрагдахвий гэсэн болгоомжлолоос үүдэн оролцогчдын ихэнх нь хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл өндөр настай гэх мэт ажиллах боломж хязгаарлагдмал бүлгүүдэд чиглэсэн шийдлүүдийг дэмжиж байв. Нийгмийн халамжийн тэтгэмж нь нийгмийн тусламж хэрэгтэй байгаа өрхүүдэд аль хэдийнээ дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд зөвхөн усны хэрэглээг дэмжих зорилгоор тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагагүй гэж цөөн хэдэн оролцогчид үзэж байв. Гурав дахь бүлэг харин ангилалд суурилсан нийгмийн халамжийн хөтөлбөрүүд хамрагдах ёстой бүх өрхийг хамруулж чадахгүй байгаа гэж үзэв. Дэлхийн банкны⁸⁶ хийсэн судалгаагаар Монгол улсад хэрэгжүүлж буй нийгмийн халамжийн хөтөлбөрүүд ядуу болон ядуу биш өрхүүдийг хамардаг бөгөөд бүх ядуу өрхүүд, тэр дундаа хөдөлмөр эрхлэх насны хүмүүстэй ядуу өрхүүдэд хүрч чаддаггүй болохыг харуулж байна. Зөвхөн хүнсний талон олгох хөтөлбөр нь ядуу өрхөд, 5 хувьд хамрагдах нэн ядуу өрхөд зориулагдсан байна.

Гэр хорооллоос оролцсон фокус бүлгийн оролцогчид дэмжлэгийг ухаалаг карт хэлбэрээр эсвэл сар бүрийн давтамжтай өгөх нь зүйтэй гэж үзлээ. Орон сууцны хэрэглэгчид усны талон болон бусад усны төлбөрийг бууруулах аргууд эсвэл төлбөр хоцроосны торгуулийг болиулах аргуудыг дурджээ. Хоёр бүлэг хоёулаа хүнсний талон хүлээн авагчдад үзүүлэх тусламжийг нэмэгдүүлэхийг дэмжиж байна (зөвхөн усны төлбөр төлөх асуудалтай хүмүүст биш). Оролцогчдын дийлэнх нь хөтөлбөрийг удирдан зохион байгуулахад засгийн газар эсвэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд байх ёстой гэж үзэж байна. Шигтгээ 16-д харуулсанчлан хэлэлцүүлгийн удирдагч нь аливаа нэг байгууллага эсвэл засгийн газрын агентлагийг хөтөлбөрийн удирдан зохион байгуулагчаар санал болгоогүй. Оролцогчид хороо, УСУГ эсвэл бие даасан байгууллага байж болох талаар дурдсан. Зорилтот бүлгийг тодорхойлох аргыг зөв сонгох, сайн мэдээллийн сан, хөтөлбөрийн хяналт, удирдлага зэрэг нь хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэхэд шаардлагатай гэж үзсэн.

7.2.2 Орон сууцанд амьдардаг ядуу өрхүүдийг дэмжсэн бодлого

Орон сууцанд амьдардаг ядуу өрхүүдийн хувьд ТТЭ-ийн судалгаагаар ойролцоогоор орон сууцны усны тоолууртай 7,000 өрхийн 28,000 хүн, тоолуургүй 1,000 өрхийн 4,000 хүн ядуу байна. Орон сууцны усны тоолуургүй ядуу өрхүүдийн хувьд 3 дугаар хэсэгт дурдсан төлбөр тооцох аргыг шинэчлэх нь явдал нь тэдэнд туслах хамгийн хялбар зам юм.

⁸⁶ Дэлхийн банк & Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам (2015). Монгол улс дахь нийгмийн халамжийн хөтөлбөрүүд.

8. ЗӨВЛӨМЖ

8.1 ОСНААУГ болон хувийн конторуудад зориулсан зөвлөмж

Зөвлөмж 1: Орон сууцны хэрэглэгчдэд тулгарч буй усны үр ашиггүй зарцуулалттай холбоотой ноцтой асуудлыг анхааралдаа авч, хариу арга хэмжээ авах.

Нотлох баримт:

- Орон сууцны хэрэглэгчдийн 58.6% нь ус хангамжийг сайжруулах, усны хомстолоос сэргийлэхийн тулд тарифын өсөлтийг дэмжихгүй байна (6.4 дэх хэсэг)
- Усны үр ашиггүй зарцуулалт болон зэвтэй усны талаар хэрэглэгчид маш их сэтгэл ханамж бага байгаагийн зэрэгцээ үүнийг сайжруулах эрэлт хэрэгцээ өндөр байна (5.1.1, 5.2.1 дэх хэсэг)
- Дундаж ТТЭ нь усны үйлчилгээтэй холбоотой өрхийн хэрэглэгчийн сэтгэл ханамж өндөр байх тусам өсөж, өрхийн усны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр буурч байна (6.6.3. , 6.6.4 дэх хэсэг)
- Орон сууцны хэрэглэгчдийн усны хэрэгцээний гуравны нэгийг бүрдүүлдэг усны хэрэглээ ихтэй хэрэглэгчдийн сэтгэл ханамж бага байдал нь илүү өндөр, дундаж болон дээд ТТЭ нь илүү бага байна (Бүлэг 5, 6)

Орон сууцны хэрэглэгчдийн усны алдагдлын бодит хэмжээ тодорхойгүй, уг алдагдал нь ОСНААУГ-ын орлогод шууд сөргөөр нөлөөлөхгүй хэдий ч холбогдох эрх бүхий байгууллагууд болоод оролцогч талууд уг асуудалд анхаарлаа хандуулахгүй байж болохгүй. Ойрын арван жилд усны хомстолд орох магадлал өндөр байгаа гэдэгтэй хэрэглэгчид санал нийлж байгаа хэдий ч ихэнх орон сууцны хэрэглэгчид ус хангамжийн үйлчилгээг сайжруулах, ус хязгаарлахаас зайлсхийхийн тулд тариф нэмэхийг дэмжихгүй байгаагийн гол шалтгааны нэг нь ус үргүй зарцуулдаг байдалд сэтгэл ханамж бага байдгийг үгүйсгэх аргагүй юм. Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин бага, үйлчилгээг сайжруулах тэдний эрэлт хэрэгцээ, фокус бүлгийн хэлэлцүүлгээр хэрэглэгчдийн хэлж ярьсан зүйл зэрэг нь асуудал хэр ноцтой байгааг харуулж байна. Усны их хэрэглээтэй өрхүүд ус хангамжийн үйлчилгээнд хамгийн их сэтгэл ханамж бага байгаагийн зэрэгцээ ирээдүйд усны хязгаарлалтаас зайлсхийхэд төлбөр төлөх хамгийн бага эрмэлзэлтэй байна. Холбогдох эрх бүхий байгууллагууд ус үргүй зарцуулдаг асуудлыг шийдэхэд дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй хэр нь ирээдүйд ус хязгаарлахаас зайлсхийхийн тулд хэрэглэгчдээс санхүүгийн хувь нэмэр гаргуулах гэсэн стратегийг орон сууцны хэрэглэгчид дэмжихгүй гэдгийг бодлого боловсруулагчид анхаарах хэрэгтэй.

Хэрэв энэ таамаглал нотлогдвол усан хангамжийн тогтвортой байдлыг хангах илүү нарийвчилсан төлөвлөгөөнд тусгах, эсвэл наад зах нь түгээгч байгууллагын зүгээс яагаад хэрэглэгчдээс санхүүгийн хувь нэмэр гаргуулах шаардлагатай байгааг сайтар тайлбарлах замаар энэхүү зөрчилдөөнийг шийдвэрлэх хүртэл хэрэглэгчид ирээдүйн усны тарифын тогтвортой өсөлтийг хүлээж авах хүсэл багатай, бэлэн бус байх болно.

Зөвлөмж 2: Усны үйлчилгээний төлбөрийг цахимаар хэрхэн төлөх, цахимаар төлөхдөө НӨАТ-ийн сугалаанд хэрхэн оролцох талаар хэрэглэгчдийг илүү их, тодорхой мэдээллээр хангах

Нотлох баримт:

- Орон сууцны таван хэрэглэгч тутмын нэг нь өрхийн судалгаа авахаас өмнөх сүүлийн арван хоёр сарын хугацаанд цэвэр, бохир усны төлбөрөө хоцроосон байна.
- Төлбөрөө хоцроох үндсэн хоёр шалтгаан нь мөнгөгүй байх, төлбөр төлөхөө мартсан явдал байв
- Төлбөр төлөх хамгийн түгээмэл хэлбэр бол банканд биеэр очиж төлөх байдаг боловч ФБХ-ээр хэрэглэгчид банкин дээр үүсдэг урт дарааллын талаар сэтгэл дундуур байдаг талаар ярьж байв
- Хэдийгээр цахимаар төлбөр хийхэд НӨАТ-ын сугалаанд оролцох эрхийг хязгаарладаггүй ч ФБХ-д оролцогчдын үзэж байгаагаар цахимаар төлбөр хийхэд НӨАТ-ын сугалаанд оролцох боломжтой гэдгийг бүх хэрэглэгчид тэр бүр мэддэггүйг харуулж байгаагаас гадна цахимаар төлбөр хийхийг сонгохгүй байхад хүргэдэг байна.

Онлайнаар төлбөр төлөхөд НӨАТ-ын сугалаанд хэрхэн оролцох зэрэг онлайнаар төлбөр хийх хүртээмжтэй аргуудын талаар мэдээлэл өгөх нь хэрэглэгчдийн банканд дугаарлах хугацааг багасгах, орлого багатай өрхүүд зэрэг бүх хэрэглэгчдийг төлбөрөө цаг тухайд нь төлөхөд түлхэц болох юм.

8.2 УСУГ-д зориулсан зөвлөмж

Зөвлөмж 3: Гэр хорооллын усны үнэ нэмэгдэхийн хэрээр зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн усны хүртээмж, үйлчилгээг сайжруулах шаардлагатай.

Нотлох баримт:

- УТБ-аар түгээдэг усны үнэ (нэг куб метр нь 1000 төгрөг) ус авахад зарцуулдаг цаг хугацаа, төвөгтэй байдлаас үүсэх мөнгөн бус зардал, ус авахад тулгардаг хүндрэл/төвөгтэй харьцуулбал харьцангуй бага юм. Энэхүү судалгаанд нэг куб метр ус авахад зарцуулах цаг хугацааны алдагдсан боломжийн өртгөөр усны үнийг ойролцоогоор тооцоолсон болно (4.1.3 дахь хэсэг)
- Ус хангамжийн үйлчилгээг сайжруулах эрэлт хэрэгцээ, төлбөр төлөх эрмэлзэл гэр хорооллын хэрэглэгчдийн дунд маш өндөр байна. Зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдийн ТТЭ бусад төрлийн УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчдээс илүү байна (6.2.3 дахь хэсэг)
- Зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг хэрэглэгчид төлбөр төлөх аргыг илүү сайжруулах хүсэлтэй байна (5.2.2 дахь хэсэг).
- Хэрэглэгчид ухаалаг УТБ-ны ажлын цаг урт болон төлбөр төлөх хялбар байдалд ам сайтай байна. Гэсэн хэдий ч гэр хорооллын хэрэглэгчдийн 57% нь зөөврийн ус хангамжтай УТБ-аас ус авдаг бөгөөд эдгээр хэрэглэгчдийн цөөн хэсэг нь л төвлөрсөн шугамд холбогдсон түгээгчтэй УТБ-ыг ухаалаг горимд шилжүүлэн сайжруулснаар гарах өгөөжийг хүртэхээр байна. (6.2.1 дэх хэсэг)

Судалгаанаас харахад УТБ-аар түгээдэг усны үнэ (нэг куб метр нь 1000 төгрөг) ус авахад зарцуулдаг цаг хугацааны алдагдсан боломжийн өртөгтэй (нэг куб метр нь 5,068 төгрөг) харьцуулбал харьцангуй бага байна. Түүнчлэн гэр хорооллын хэрэглэгчид үйлчилгээг

сайжруулахад төлбөр төлөх өндөр эрмэлзэлтэйн зэрэгцээ ус хангамжийн үйлчилгээг сайжруулах эрэлт хэрэгцээ ихтэй байгааг судалгааны үр дүн харуулж байна. Хэрэглэгчид ухаалаг УТБ-ны ажиллах цаг болон төлбөр төлөх арга хэлбэрийн хялбар байдалд сайшаалтай байна. Гэсэн ч гэр хорооллын хэрэглэгчдийн 57% нь зөөврийн ус хангамжтай УТБ-аар үйлчлүүлдэг ба түгээгчтэй УТБ-ыг ухаалаг горимд шилжүүлэн сайжруулснаар гарах өгөөжийг хүртэх цөөн тооны хэрэглэгч байна. Цөөн тооны иргэд өгөөжийг нь хүртэх хөрөнгө оруулалт хийхийн тулд усны тарифыг мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдүүлэхийг хэрэглэгчид таатай хүлээж авахгүй байх магадлалтайг бодлого боловсруулагчид хийгээд нийлүүлэгч байгууллагууд бодолцох хэрэгтэй. Энэхүү таамаглал үнэн байх тохиолдолд төлбөрийн шинэ тохиромжтой аргыг нэвтрүүлж, төвлөрсөн шугамд холбогдсон түгээгчтэй УТБ-ыг ухаалаг горимд шилжүүлснээр гарах хэмнэлтийн тодорхой хэсгийг зөөврийн ус хангамжтай УТБ-ны ажиллах цагийг уртасгахад зарцуулах нь зардал нөхөх төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тус дэмтэй байх болно. Ухаалаг картаар төлбөрөө хийдэг болох хүсэлтэй хэрэглэгчид төлбөр тооцооны шинэ, илүү хялбар аргыг (жишээ нь мессежээр эсвэл гар утасны аппликейшнээр) нэвтрүүлэхийг дэмжиж болох юм.

8.3 ХСУХАТАУ33-д зориулсан зөвлөмж

Зөвлөмж 4: Хэрэглэгчдийн төлбөрийн чадвартай холбоотой асуудлыг шийдэхийн тулд орон сууцанд амьдардаг усны тоолуургүй хэрэглэгчдийн усны хэрэглээг тооцох аргачлалыг эргэн харах шаардлагатай.

Нотлох баримт:

- Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн 23% нь өрхийн нийт орлогынхоо 5-аас дээш хувийг цэвэр, бохир усны төлбөрт зарцуулж байна. Харин тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн ердөө 4% өрхийн нийт орлогынхоо 5-аас дээш хувийг цэвэр, бохир усны төлбөрт зарцуулж байна (4.1.2 дахь хэсэг)
- Орон сууцанд амьдардаг усны тоолуургүй өрхүүд дунджаар цөөн ам бүлтэй байхаас гадна ихэнхдээ зөвхөн өндөр настан бүхий өрх байна (3.5 дахь хэсэг)
- Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн сард ус ашигласны төлбөрт нэхэмжилсэн нэг хүн хоногт 200 л ус хэрэглэснийг нотлох баримт алга байна (4.1.2 дахь хэсэг)
- Усны тоолууртай орон сууцны хэрэглэгчидтэй харьцуулахад тоолуургүй орон сууцны хэрэглэгчид усны хомстолоос сэргийлэх үүднээс ус хангамжийн үйлчилгээг сайжруулахад төлбөр төлөх эрмэлзэл багатай байна (6.4 ба 6.6.3 дахь хэсэг)

Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн 23% нь өрхийн нийт орлогынхоо 5-аас дээш хувийг цэвэр, бохир усны төлбөрт зарцуулдаг бол тоолууртай орон сууцны хэрэглэгчдийн ердөө 4% өрхийн нийт орлогынхоо 5-аас дээш хувийг цэвэр, бохир усны төлбөрт зарцуулж байна. Тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн сард ус ашигласны төлбөрт нэхэмжилсэн нэг хүн хоногт 200 л ус хэрэглэснийг нотлох баримт алга байна. Орон сууцанд амьдардаг тоолуургүй өрхүүд дунджаар цөөн ам бүлтэй байхаас гадна ихэнхдээ зөвхөн өндөр настан бүхий өрх байна. Усны тоолууртай орон сууцанд амьдардаг харьцуулж болохуйц өрх дунджаар 133 л/хүн/өдөр ус хэрэглэж байгаа нь тоолуургүй орон сууцны ижил төстэй хэрэглэгчийн нэхэмжилсэн хэрэглээнээс гуравны нэгээр бага байна. Усны тоолуургүй орон сууцны хэрэглэгчдийн ус хангамжийн

үйлчилгээнд хэр сэтгэл ханамж муутай байгааг усны тоолуур, төлбөр төлөх арга хэрэгсэл, хэрэглэгчийн үйлчилгээнд муу үнэлгээ өгч, мөн ТТЭ-ийн бага байгаагаас харж болно.

438	<i>/Карт харуулж сонголт хийлгэнэ/</i> Танай өрхийн ус хангамжтай холбоотой ямар сайжруулалт шаардлагатай байна вэ? (Ач холбогдлоор нь 3 хүртэлх хариулт сонгоно уу)	Усны даралтыг нэмэгдүүлж, тогтворжуулах A Эвдрэл, гэмтлийн давтамж, хугацааг багасгах B Ус тасарсны дараа зэв арилтал гоожуулдаг явдлыг багасгах C Ус халуун болохыг хүлээж гоожуулах явдлыг багасгах D Зэвтэй ус гардаггүй байх E Үнэргүй байх F Нэмэлт амтгүй байх G Цэвэр, бохир усны нэхэмжлэхийг уншиж, ойлгоход хялбар болгох H Тоолуургүй хэрэглэгч тоолууртай болох I Орцондоо тоолууртай болох J Тоолуур баталгаажилт хийлгэх явцыг сайжруулах K Усны төлбөрөө цахим банкаар төлдөг болох L Төлбөр төлөх сайжруулсан хөтөлбөрүүдтэй болох (үлирлаар эсвэл хагас жилээр төлөх хуваарь) M Мэдээлэл, санал гомдол шийдвэрлүүлэх хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах N Ухаалаг тоолуур суурилуулах O Бусад /бичиж/ P	
439	Таны хэрэглэж буй ус эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаж чадаж байна гэж та бодож байна уу?	Тийм 1 Үгүй 2 Мэдэхгүй (Энэ хариултыг уншиж өгөхгүй) 8	
УСНЫ ТАРИФТАЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД			
440	1 м ³ цэвэр усны одоогийн тариф хэд вэ? (Хэрэв мэдэхгүй бол "баримжаагаар хэд гэж бодож байна?" гэж асуух)		
441	Та цэвэр, бохир усныхаа одоогийн үнэ, тарифын талаар ямар бодолтой байдаг вэ?	Маш үнэтэй 1 Үнэтэй 2 Бодит 3 Хямд 4 Хэт хямд 5	
442	Хэрэв усны тариф өсвөл танай өрх усны хэрэглээгээ бууруулах уу?	Тийм 1 Үгүй 2 Мэдэхгүй (Энэ хариултыг уншиж өгөхгүй) 8	
443	Цэвэр, бохир усны тариф сүүлийн 3 жилд нэмэгдсэн гэж танд санагдаж байна уу?	Тийм 1 Үгүй 2	
ҮНЭ ӨСГӨХ ХУВИЛБАРУУД			
444	Зарим хүмүүс 10-15 жилийн дараа Улаанбаатар хот усны нөөцийн хомсдолд орж усны хязгаарлалт хийх болзошгүй нөхцөл байдал үүснэ гэж байхад нөгөө хэсэг нь үүнийг хэтрүүлэг хэмээн үзэж байна. Харин та усны нөөцийн хомсдол үүсэж хязгаарлалт хийх эсэхэд хэр санаа зовж байна вэ?	Маш их санаа зовж байна 1 Санаа зовж байна 2 Нэг их санаа зовохгүй байна 3 Огт санаа зовохгүй байна 4 Мэдэхгүй (Энэ хариултыг уншиж өгөхгүй) 8	
Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй хүн ам нь усны нөөцийн хэрэглээг улам бүр нэмэгдүүлж байна. Ирэх 10 жилд усны нөөц хомсдохоос сэргийлэн одоо ашиглаж байгаа нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр гүний худгууд гаргах, ус дахин ашиглах үйлдвэр барих, хүн амыг усны баталгаат эх үүсвэрээр хангахад чиглэсэн их хэмжээний хөрөнгө оруулалт хийх юм. Эдгээр хөрөнгө оруулалтыг нөхөхийн тулд хэрэглэгчдийн усны төлбөрийг нэмэгдүүлэх магадлалтай юм. Энэ талаар та бидэнтэй санал, бодлоо хуваалцана уу.			
445	Усны хомсдолоос сэргийлэхийн тулд цэвэр, бохир усны үнийг өсгөх хэрэгтэй гэдэгтэй та санал нэг байна уу?	Би санал нэг байна. 1 Би санал нийлэхгүй байна. 2 Мэдэхгүй (Энэ хариултыг уншиж өгөхгүй) 8	

Хувилбар 1: Усны хязгаарлалтад орохоос сэргийлэх		
Би танай өрхийн цэвэр, бохир усны үйлчилгээнд төлбөр төлөх эрмэлзэл болон чадамжтай холбоотой асуултууд асуух гэсэн юм. Хэрвээ ирээдүйд усны нөөц үргэлжлэн буурсаар байвал хомсдол үүсэж, өрхийн усны үйлчилгээ тасалдан хязгаарлалт хийх болзошгүй нөхцөл үүсэж болох юм. Танай өрх одоогоор цэвэр, бохир усандаа сард төгрөг нэхэмжлэлийн дагуу төлдөг гэж үзье.		
446	Дээр дурдсан нөхцөлд усны хязгаарлалтад орохгүйгээр цэвэр, бохир усны үйлчилгээ авах бол үйлчилгээний төлбөрт танай өрхийн сард төлөх боломжит дээд хэмжээ хэд байх вэ?	Төгрөг /Хариулаагүй тохиолдолд хоосон үлдээнэ/
447	Танай өрх усны хязгаарлалтад орохгүйгээр цэвэр, бохир усны үйлчилгээ авах бол сардаа төгрөг төлөх үү?	Тийм 1 Үгүй 2 → 449
448	Танай өрх усны хязгаарлалтад орохгүйгээр цэвэр, бохир усны үйлчилгээ авах бол сардаа төгрөг төлөх үү?	Тийм 1 → 451 Үгүй 2 → 451
449	Танай өрх усны хязгаарлалтад орохгүйгээр цэвэр, бохир усны үйлчилгээ авах бол сардаа төгрөг төлөх үү?	Тийм 1 → 451 Үгүй 2
450	Хэрэв танай өрх усны хязгаарлалтад орохгүйгээр цэвэр, бохир усны үйлчилгээнд сард төгрөг төлөхгүй бол шалтгаанаа тайлбарлана уу:	Улаанбаатар хот усны хомсдолд орохгүй гэж бодож байна 1 Би хязгаарлалтад санаа зовохгүй байна, манай өрх хэрэглээгээ бууруулж чадна 2 Ус хангамжийн байгууллагууд дээрх сайжруулалтыг хийнэ гэдэгт итгэхгүй байна 3 Би дээрх сайжруулалтад төлбөр төлөх ёстой гэж бодожгүй байна 4 Би цэвэр, бохир усандаа энэ төлбөрийг төлж чадахгүй 5
УСНЫ НӨӨЦ, ХЭМНЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД		
451	Хэрэв танай өрх сард хэрэглэж буй усны хэмжээгээ мэдэж байвал дараа сарынхаа усны хэрэглээг төлөвлөж чадах уу?	Тийм 1 Үгүй 2 Мэдэхгүй 8
452	Танай өрх усны хэрэглээний төлбөрөө бууруулах шаардлага гарвал усны хэрэглээгээ багасгаж чадах уу?	Тийм 1 Үгүй 2
453	Та гэр хорооллын оршин суугчдын төлдөг усны төлбөрийг үнэтэй, хямд, эсвэл бодит гэж боддог уу?	Хэт үнэтэй 1 Үнэтэй 2 Бодит 3 Хямд 4 Хэт хямд 5 Мэдэхгүй 8
454	Та усаа хэрхэн гамтай хэрэглэх талаар зөвлөмж, мэдээллийг хаанаас авдаг вэ?	Контор 1 УСУГ 2 ОСНААУГ-ХҮТ 3 Гэр бүлийн гишүүд 4 Найз нөхөд 5 Олон нийтийн сүлжээ (Social media) 6 Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл 7 Мэдээлэл авдаггүй 8 Бусад /бичих/ 9
УЛААНБААТАР ХОТЫН УНДНЫ УС, ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ-2020		Хуудас 13
455	Та Улаанбаатар хот усны хомсдолд орж байгаа гэж боддог уу?	Тийм 1 Үгүй 2 Мэдэхгүй 8
456	Танай өрхийн усны хэрэглээ Улаанбаатар хотын усны нөөцөд нөлөөтэй гэж бодож байна уу?	Тийм 1 Үгүй 2 Мэдэхгүй 8
457	Улаанбаатар хотын усны нөөцийг хамгаалахын тулд усыг хэмнэх нь таны хувьд хэр чухал вэ?	Маш чухал 1 Зарим талаар чухал 2 Чухал биш 3 Огт чухал биш 4
ДУУСГАХ		
СУДАЛГААНД ХАМРАГДСАНД БАЯРЛАЛАА		
Судалгаа дууссан : Цаг : Минут		

БҮЛЭГ 5. ГЭР ХОРООЛЛЫН ӨРХИЙН АСУУЛГА			
№	АСУУЛТ	ХАРИУЛТ	АЛХАМ
УС ХЭРЭГЛЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД			
500	Танай өрхөд хэн нь ихэвчлэн усанд явдаг вэ?	Насанд хүрсэн эрэгтэй өрхийн тэргүүн 1 Насанд хүрсэн эмэгтэй өрхийн тэргүүн 2 Нөхөр 3 Эхнэр 4 Эрэгтэй хүүхэд 5 Эмэгтэй хүүхэд 6 Бусад насанд хүрсэн эрэгтэй 7 Бусад насанд хүрсэн эмэгтэй 8 Усанд явдаггүй 9 Бусад 10	
501	Хэрэв та бусдад ус авч өгдөг бол хэнд авч өгдөг вэ?	Бусдад ус авч өгдөггүй 1 Хашаанд байдаг бусад өрхүүдэд 2 Хөршүүддээ 3 Бусад /бичих/ 4	
502	Танай өрхийн хоол, ундны усны гол эх үүсвэр нь юу вэ?	Шугамд холбогдсон худаг (УТБ) 1 Зөөврийн усан хангамжтай худаг (УТБ) 2 Ухаалаг худаг (УТБ) 3 Хөрш айлын хувийн худаг 4 Өөрийн хашаан дахь хувийн худаг 5 Задгай эх үүсвэр (Гол, горхи, булаг) 6 Зөөврөөр гэрт хүргэгдсэн ус 7 Савласан ус 8 Бусад /бичих/ 9	
503	Танай өрх хоол, ундандаа усны ямар эх үүсвэрийг илүүд үздэг вэ?	Шугамд холбогдсон худаг (УТБ) 1 Зөөврийн усан хангамжтай худаг (УТБ) 2 Ухаалаг худаг (УТБ) 3 Хөрш айлын хувийн худаг 4 Өөрийн хувийн худаг 5 Задгай эх үүсвэр (Гол, горхи, булаг) 6 Зөөврөөр гэрт хүргэгдсэн ус 7 Савласан ус 8 Бусад /бичих/ 9	
504	Танай өрх хоол, ундны усаа хэр холоос авдаг вэ?	200 метр хүртэл 1 201-1000 метр 2 1001-ээс дээш метр 3	
505	Танай өрх хоол, ундны ус авахдаа ямар хугацаа зарцуулдаг вэ? /Гэрээсээ гараад ус аваад буцаад гэртээ ирэх нийт хугацаа/	15 минутаас бага 1 15-30 минутын хооронд 2 30-45 минутын хооронд 3 45 минутаас их 4	
506	Танай өрх хоол, ундны усаа долоо хоногт хэдэн удаа авдаг вэ?	Долоо хоногт нэг удаа 1 Долоо хоногт хоёр удаа 2 Долоо хоногт гурван удаа 3 Долоо хоногт 4-өөс олон 4	
507	Хоол унднаас бусад зориулалтаар өөр эх үүсвэрээс цэвэрлэгээ, угаалга хийх, усанд ороход зориулж ус авдаг уу?	Тийм 1 Үгүй 2	512
508	Хоол унднаас бусад зориулалтаар өөр эх үүсвэрээс цэвэрлэгээ, угаалга хийх, усанд ороход зориулсан усаа хаанаас авдаг вэ?	Хашаанд байдаг өөрийн худаг 1 Бусдын хашаанд байдаг худаг 2 Задгай эх үүсвэр 3 Борооны ус 4 Зөөврөөр гэрт хүргэгдсэн ус 5 Бусад /бичих/ 6	
509	Хоол унднаас бусад зориулалтаар өөр эх үүсвэрээс цэвэрлэгээ, угаалга хийх, усанд ороход зориулсан усаа хэр холоос авдаг вэ?	200 метр хүртэл 1 201-1000 метр 2 1001-ээс дээш метр 3	
510	Хоол унднаас бусад зориулалтаар өөр эх үүсвэрээс цэвэрлэгээ, угаалга хийх, усанд ороход зориулсан усаа авахад ямар хугацаа зарцуулдаг вэ?	15 минутаас бага 1 15-30 минутын хооронд 2 30-45 минутын хооронд 3 45 минутаас их 4	

511	Хоол унднаас бусад зориулалтаар өөр эх үүсвэрээс цэвэрлэгээ, угаалга хийх, усанд ороход зориулсан усаа долоо хоногт хэдэн удаа авдаг вэ?	Долоо хоногт нэг удаа 1 Долоо хоногт хоёр удаа 2 Долоо хоногт гурван удаа 3 Долоо хоногт 4-өөс олон 4																																																																																																																	
512	Худаг хаалттай үед та өөр газраас ундны усаа авдаг уу?	Тийм 1 Үгүй 2	514																																																																																																																
513	Хэрэв тийм бол ус авдаг бүх газраа дурдана уу? (Олон сонголттой)	Шугамд холбогдсон худаг (УТБ) A Зөөврийн усан хангамжтай худаг (УТБ) B Хөрш айлаасаа ус авдаг C Хөрш айлын хувийн худаг D Өөрийн хашаан дахь хувийн худаг E Задгай эх үүсвэр (Гол, горхи, булаг) F Зөөврөөр гэрт хүргэгдсэн ус G Савласан ус H Бусад /бичих/ I																																																																																																																	
514	Та өрхийнхөө долоо хоногт хэрэглэдэг усны хэмжээг мэдэх үү?	Тийм 1 Үгүй 2	516																																																																																																																
515	Танай өрх долоо хоногт хэдэн литр ус хэрэглэдэг вэ?	А. Өвлийн улиралд (12 дугаар сараас 2 сар) 1. Ажлын өдрүүдэд /Даваа-Баасан гарагт/ 2. Амралтын өдрүүдэд /Хагас, бүтэн сайнд/ В. Бусад улиралд 1.Ажлын өдрүүдэд /Даваа-Баасан гарагт/ 2.Амралтын өдрүүдэд /Хагас, бүтэн сайнд/																																																																																																																	
516	Танай өрх нэг удаагийн авалтаар дунджаар хэдэн литр ус авдаг вэ?	10 литр хүртэл 1 10-20 литр 2 20-40 литр 3 40-100 литр 4 100-аас дээш 5																																																																																																																	
УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД																																																																																																																			
517	Та өрхийнхөө үйлчлүүлдэг ус түгээх байрны /худаг/ үйлчилгээний чанарын талаар сэтгэл ханамжаа 1-5 оноогоор үнэлнэ үү. (1 - маш муу, 5 - маш сайн сэтгэл ханамжийн түвшинг илэрхийлнэ)	<table border="1"> <thead> <tr> <th>Сэтгэл ханамжийн түвшин</th> <th>Маш муу</th> <th>Муу</th> <th>Дунд зэрэг</th> <th>Сайн</th> <th>Маш сайн</th> <th>МД</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1 Худгийн ажиллах цаг</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>2 Ус авахад хүлээдэг хугацаа</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>3 Гэрээс худаг хүртэлх зай</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>4 Худаг орчмын цэвэрлэгээ</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>5 Усны гоожих хэмжээ</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>6 Цэвэр тунгалаг байдал</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>7 Зэвтэй холбоотой</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>8 Амттай холбоотой</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>9 Өнгөтэй холбоотой</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>10 Үнэртэй холбоотой</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>11 Худгийн үйл ажиллагааны доголдол, тасалдал</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>12 Эвдрэл гэмтлийг засах хугацаа</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>13 Төлбөр төлөх байдал</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>14 Хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> <tr><td>15 Санал гомдол шийдвэрлэх байдал</td><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>8</td></tr> </tbody> </table>	Сэтгэл ханамжийн түвшин	Маш муу	Муу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	МД	1 Худгийн ажиллах цаг	1	2	3	4	5	8	2 Ус авахад хүлээдэг хугацаа	1	2	3	4	5	8	3 Гэрээс худаг хүртэлх зай	1	2	3	4	5	8	4 Худаг орчмын цэвэрлэгээ	1	2	3	4	5	8	5 Усны гоожих хэмжээ	1	2	3	4	5	8	6 Цэвэр тунгалаг байдал	1	2	3	4	5	8	7 Зэвтэй холбоотой	1	2	3	4	5	8	8 Амттай холбоотой	1	2	3	4	5	8	9 Өнгөтэй холбоотой	1	2	3	4	5	8	10 Үнэртэй холбоотой	1	2	3	4	5	8	11 Худгийн үйл ажиллагааны доголдол, тасалдал	1	2	3	4	5	8	12 Эвдрэл гэмтлийг засах хугацаа	1	2	3	4	5	8	13 Төлбөр төлөх байдал	1	2	3	4	5	8	14 Хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал	1	2	3	4	5	8	15 Санал гомдол шийдвэрлэх байдал	1	2	3	4	5	8	
Сэтгэл ханамжийн түвшин	Маш муу	Муу	Дунд зэрэг	Сайн	Маш сайн	МД																																																																																																													
1 Худгийн ажиллах цаг	1	2	3	4	5	8																																																																																																													
2 Ус авахад хүлээдэг хугацаа	1	2	3	4	5	8																																																																																																													
3 Гэрээс худаг хүртэлх зай	1	2	3	4	5	8																																																																																																													
4 Худаг орчмын цэвэрлэгээ	1	2	3	4	5	8																																																																																																													
5 Усны гоожих хэмжээ	1	2	3	4	5	8																																																																																																													
6 Цэвэр тунгалаг байдал	1	2	3	4	5	8																																																																																																													
7 Зэвтэй холбоотой	1	2	3	4	5	8																																																																																																													
8 Амттай холбоотой	1	2	3	4	5	8																																																																																																													
9 Өнгөтэй холбоотой	1	2	3	4	5	8																																																																																																													
10 Үнэртэй холбоотой	1	2	3	4	5	8																																																																																																													
11 Худгийн үйл ажиллагааны доголдол, тасалдал	1	2	3	4	5	8																																																																																																													
12 Эвдрэл гэмтлийг засах хугацаа	1	2	3	4	5	8																																																																																																													
13 Төлбөр төлөх байдал	1	2	3	4	5	8																																																																																																													
14 Хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал	1	2	3	4	5	8																																																																																																													
15 Санал гомдол шийдвэрлэх байдал	1	2	3	4	5	8																																																																																																													
518	хоосон																																																																																																																		

519	<i>/Карт харуулж сонголт хийлгэнэ/</i> Танай өрхийн ус хангамжтай холбоотой ямар сайжруулалт шаардлагатай байна вэ? (Ач холбогдлоор нь 3 хүртэлх хариулт сонгоно уу)	Гэртээ ойрхон худагтай болох A Худгийн ажиллах цагийг уртасгах B Цэвэр тунгалаг байдлыг сайжруулах C Зэвтэй ус гардаггүй байх D Нэмэлт амтгүй байх E Өнгөгүй байх F Үнэргүй байх G Худаг орчмын тохижилт цэвэрлэгээ H Худаг өдөр болгон ажилладаг болгох I Гэртээ ус хүргэдэг үйлчилгээтэй болох J Ухаалаг картаар төлбөр хийдэг болох K Төвлөрсөн шугамд холбогдох L Худгийн үйл ажиллагааны доголдол, тасалдлыг бууруулах M Эвдрэл, гэмтлийг хурдан засварлах N Хэрэглэгчийн үйлчилгээний хүртээмж сайжруулах O Санал гомдол хурдан шийдвэрлэх P Бусад /бичих/ Q	
520	Та болон танай гэр бүлийн гишүүд сүүлийн 6 сарын хугацаанд худгаас авсан уснаас болж өвдсөн үү?	Тийм 1 Үгүй 2	522
521	Хэрэв ТИЙМ гэж хариулсан бол та болон танай гэр бүлийн гишүүд ямар өвчнөөр өвдсөн бэ?	Суулгалт 1 Гэдэсний өвчин 2 Халдварт шар 3 Бусад /бичих/ 4	
522	Танай өрхийн үйлчлүүлдэг худгийн ус эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангаж чадаж байна гэж та бодож байна уу?	Тийм 1 Үгүй 2 Мэдэхгүй (Энэ хариултыг уншиж өгөхгүй) 8	
УСНЫ ТАРИФТАЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД			
523	Танай өрх худгаас ус авахад долоо хоногт дунджаар хэдэн төгрөг зарцуулдаг вэ?	А. Өвлийн улиралд (12 дугаар сараас 2 сар) 1. Ажлын өдрүүдэд /Даваа-Баасан гарагт/ □ □ □ □ 2. Амралтын өдрүүдэд /Хагас бүтэн сайнд/ □ □ □ □ В. Бусад улиралд 1. Ажлын өдрүүдэд /Даваа-Баасан гарагт/ □ □ □ □ 2. Амралтын өдрүүдэд /Хагас бүтэн сайнд/ □ □ □ □	
524	Танай өрх худгаас ус авахдаа төлбөрөө яаж төлдөг вэ?	Ус авах бүрдээ бэлнээр 1 Ус авах бүрдээ ухаалаг картаар 2 Бусад /бичих/ 3	
525	Танай өрхийн худгаас ус авахдаа төлдөг төлбөрийн талаар юу та гэж бодож байна вэ?	Хэт үнэтэй 1 Үнэтэй 2 Бодит 3 Хямд 4 Хэт хямд 5	
526	Танай өрх бусад эх үүсвэрээс (савласан, машинаар зөөдөг, гүний худгаас ...) ус авахад долоо хоногт дунджаар хэдэн төгрөг зарцуулдаг вэ?	Бусад эх үүсвэрээс ус авдаггүй 1 → А. Өвлийн улиралд (12 дугаар сараас 2 сар) 1. Ажлын өдрүүдэд /Даваа-Баасан гарагт/ □ □ □ □ 2. Амралтын өдрүүдэд /Хагас бүтэн сайнд/ □ □ □ □ В. Бусад улиралд 1. Ажлын өдрүүдэд /Даваа-Баасан гарагт/ □ □ □ □ 2. Амралтын өдрүүдэд /Хагас бүтэн сайнд/ □ □ □ □	528
527	Танай өрх бусад эх үүсвэрээс (савласан, машинаар зөөдөг, гүний худгаас ...) ус авахдаа төлдөг төлбөрийн талаар юу гэж бодож байна вэ?	Хэт үнэтэй 1 Үнэтэй 2 Бодит 3 Хямд 4 Хэт хямд 5	
528	Танай өрх ус авахдаа бусдад төлбөр төлж усаа зөөлгөдөг бол хэнд төлдөг вэ?	Машин түрээслэх 1 Бусад хүмүүст 2 Өөрөө авдаг 3 →	530

529	Танай өрх ус авахдаа бусдад төлбөр төлдөг бол нэг удаад хэдэн төгрөг төлдөг вэ?	1000 хүртэл 1 1000-3000 2 3000-5000 3 5000-аас дээш 4	
530	Өнгөрсөн сард худгаас буяны ажлын хүрээнд ус үнэгүй авсан уу?	Тийм 1 Үгүй 2 →	532
531	Хэрвээ буяны ажлын хүрээнд ус үнэгүй авч байсан бол сард дунджаар хэдэн удаа авсан бэ?	1-2 1 3-5 2 5-аас олон 3	
532	1 литр усны одоогийн тариф хэд вэ?		
533	Та одоогийн усны тарифын талаар ямар бодолтой байдаг вэ?	Хэт үнэтэй 1 Үнэтэй 2 Бодит 3 Хямд 4 Хэт хямд 5	
ҮНЭ ӨСГӨХ ХУВИЛБАРУУД			
534	Зарим хүмүүс 10-15 жилийн дараа Улаанбаатар хот усны нөөцийн хомсдолд орж усны хязгаарлалт хийх болзошгүй нөхцөл байдал үүснэ гэж бодож байхад нөгөө хэсэг нь үүнийг хэтрүүлэг хэмээн үзэж байна. Харин та усны нөөцийн хомсдол үүсэх магадлалтай эсэхэд хэр санаа зовж байна вэ?	Маш их санаа зовж байна 1 Санаа зовж байна 2 Нэг их санаа зовохгүй байна 3 Огт санаа зовохгүй байна 4 Мэдэхгүй (Энэ хариултыг уншиж өгөхгүй) 8	
Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй хүн ам нь усны нөөцийн хэрэглээг улам бүр нэмэгдүүлж байна. Ирэх 10 жилд усны нөөц хомсдохоос сэргийлэн одоо ашиглаж байгаа нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр гүний худгууд гаргах, ус дахин ашиглах үйлдвэр барих, хүн амыг усны баталгаат эх үүсвэрээр хангахад чиглэсэн их хэмжээний хөрөнгө оруулалт хийх юм. Эдгээр хөрөнгө оруулалтыг нөхөхийн тулд хэрэглэгчдийн усны төлбөрийг нэмэгдүүлэх магадлалтай юм. Энэ талаар та бидэнтэй санал, бодлоо хуваалцана уу.			
535	Усны хомсдолоос сэргийлэхийн тулд усны үнийг өсгөх хэрэгтэй гэдэгтэй та санал нэг байна уу?	Би санал нэг байна. 1 Би санал нийлэхгүй байна. 2 Мэдэхгүй (Энэ хариултыг уншиж өгөхгүй) 8	
Хувилбар 1: Худаг дээрх усны хязгаарлалтад орохоос сэргийлэх			
Би танай өрхийн усны үйлчилгээнд төлбөр төлөх боломж болон чадамжтай холбоотой асуултууд асуух гэсэн юм. Ирээдүйд усны нөөц үргэлжлэн буурсаар байвал усны үйлчилгээ тасалдаж, хязгаарлалт хийж болзошгүй нөхцөл үүсэж болох юм. Танай өрх одоогоор 1 литр усанд 1 төгрөг төлдөг гэдгийг санаад асуулгадаа хариулаарай.			
536	Дээр дурдсан нөхцөлд усны хязгаарлалтад орохгүйгээр 1 литр усанд төлөх төлбөрийн боломжит дээд хэмжээ танай өрхийн хувьд хэд байх вэ?	Төгрөг /Хариулаагүй тохиолдолд хоосон явуулна/	Заавал хариулт авах гэж шахах хэрэггүй. Гэхдээ заавал асууна.
537	Танай өрх усны хязгаарлалтад орохгүйгээр цэвэр усны үйлчилгээ авах бол 1 литр усанд 3 төгрөг төлөх үү?	Тийм 1 Үгүй 2 →	539
538	Хязгаарлалтад орохгүйгээр цэвэр усны үйлчилгээ авах бол 1 литр усанд 5 төгрөг төлөх үү?	Тийм 1 Үгүй 2	541-р асуулт руу шилжинэ үү
539	Хязгаарлалтад орохгүйгээр цэвэр усны үйлчилгээ авах бол 1 литр усанд 2 төгрөг төлөх үү?	Тийм 1 → Үгүй 2	541

540	Хэрэв хязгаарлалтад орохгүйгээр цэвэр усны үйлчилгээнд 1 литр усанд 2 төгрөг төлөхгүй бол шалтгаанаа тайлбарлана уу:	Улаанбаатар хот усны хомсдолд орохгүй гэж бодож байна 1 Би хязгаарлалтад санаа зовохгүй байна, манай өрх хэрэглээгээ бууруулж чадна 2 Ус хангамжийн байгууллагууд дээрх сайжруулалтыг хийнэ гэдэгт итгэхгүй байна 3 Би дээрх усны хязгаарлалтгүй үйлчилгээнд төлбөр төлөх ёстой гэж бодохгүй байна 4 Би усандаа энэ төлбөрийг төлж чадахгүй 5	
Хувилбар 2: Худгийн үйлчилгээний чанар сайжруулах			
Би танай өрхийн усны үйлчилгээнд төлбөр төлөх эрмэлзэл болон чадамжтай холбоотой асуултууд асуух гэсэн юм. Ирээдүйд танай өрх ухаалаг худгаас 24 цагийн турш ус авах эсвэл сайжруулсан ухаалаг УТБ-аар үйлчлүүлнэ гэж үзье. Танай өрх одоогоор 1 литр усанд 1 төгрөг төлдөг гэдгийг санаад асуултад хариулаарай.			
541	Дээр дурдсан нөхцөлд худгийн үйлчилгээг сайжруулсны дараа 1 литр усанд танай өрх хамгийн ихдээ хэдэн төгрөг төлөх боломжтой вэ?	_____ Төгрөг /Хариулаагүй тохиолдолд хоосон үлдээнэ/	Заавал хариулт авах гэж шахах хэрэггүй. Гэхдээ заавал асууна.
542	Худгийн үйлчилгээг сайжруулсны дараа 1 литр усанд 5 төгрөг төлөх үү?	Тийм 1 Үгүй 2 →	544
543	Худгийн үйлчилгээг сайжруулсны дараа 1 литр усанд 7 төгрөг төлөх үү?	Тийм 1 Үгүй 2	546-р асуулт руу шилжинэ үү
544	Худгийн үйлчилгээг сайжруулсны дараа 1 литр усанд 3 төгрөг төлөх үү?	Тийм 1 → Үгүй 2	546
545	Хэрэв худгийн үйлчилгээг сайжруулсны дараа 1 литр усанд 3 төгрөг төлөхгүй бол шалтгаанаа тайлбарлана уу:	Би одоогийн үйлчилгээнд сэтгэл хангалуун байна. 1 Би төлөх боломжгүй 2 Би төлөх хүсэлгүй 3 Бусад /бичих/ 4	
546	Танай өрх хэрэглэгчийн үйлчилгээний төвтэйгээ хэрхэн холбогдохыг мэдэх үү?	Тийм 1 Үгүй 2 →	548
547	Та хэрэглэгчийн үйлчилгээний төвтэйгээ ямар аргаар холбогдохыг илүүд үзэх вэ?	Байгууллагын цахим хуудсаар 1 И-мэйл хаягаар 2 Фэйсбүүкээр 3 Утасны аппликейшн 4 Утсаар ярих 5 Биечлэн уулзах 6 Бусад /бичих/ 7	
УСНЫ НӨӨЦ, ХЭМНЭЛТЭЙ ХОЛБООТОЙ АСУУЛТУУД			
548	Танай өрхийн авдаг ундны ус долоо хоногийн хэрэгцээндээ хүрэлцдэг үү?	Хангалттай хүрэлцдэг 1 → Ихэвчлэн хүрэлцдэг 2 → Заримдаа хүрэлцдэг 3 Огт хүрэлцдэггүй 4	550 550
549	Хэрэв долоо хоногийн хэрэгцээнд тань хүрэлцдэггүй бол та ямар арга хэмжээ авдаг вэ? (Олон сонголттой)	Хэрэглээгээ багасгадаг A Усаа дахин ашигладаг B Дахиад ус авдаг C Үнэгүй/хямд эх үүсвэрээс ус авдаг D Худгаас зээлдэг E Хөршөөсөө авдаг F Бусад /бичих/ G	
550	Гэр хорооллын оршин суугчид орон сууцны оршин суугчдаас их/бага ус хэрэглэдэг гэж та боддог уу?	Их хэрэглэдэг 1 Ижил хэрэглэдэг 2 Бага хэрэглэдэг 3 Мэдэхгүй 8	

551	Та орон сууцны оршин суугчдын төлдөг усны төлбөрийг үнэтэй, хямд, эсвэл бодит гэж боддог уу?	Хэт үнэтэй 1 Үнэтэй 2 Бодит 3 Хямд 4 Хэт хямд 5	
552	Та усаа хэрхэн гамтай хэрэглэх талаар зөвлөмж, мэдээллийг хаанаас авдаг вэ?	УСУГ 1 Гэр бүлийн гишүүд 2 Найз нөхөд 3 Олон нийтийн сүлжээ (Social media) 4 Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл 5 Мэдээлэл авдаггүй 6 Бусад /бичих/ 7	
553	Та Улаанбаатар хот усны хомсдолд орж байгаа гэж боддог уу?	Тийм 1 Үгүй 2 Мэдэхгүй 8	
554	Улаанбаатар хотын усны нөөцийг хамгаалахын тулд усыг хэмнэх нь таны хувьд хэр чухал вэ?	Маш чухал 1 Чухал 2 Зарим талаар чухал 3 Чухал биш 4	
555	Бохир ус нь хөрс болон гүний усыг бохирдуулдаг талаар та сонсож байсан уу?	Тийм 1 Үгүй 2 Мэдэхгүй (Энэ хариултыг уншиж өгөхгүй) 8	
ДУУСГАХ			
СУДАЛГААНД ХАМРАГДСАНД БАЯРЛАЛАА			
Судалгаа дууссан		: Цаг : Минут	

ХАВСРАЛТ 4. ЦААШИД СУДЛАХ АСУУДАЛ

Тус судалгааны тайланд нэмэлт судалгаа хийж шалгах шаардлагатай таамаглалуудыг дэвшүүлсэн. Энэ хэсэгт эдгээр таамаглалыг нэг дор харуулсан тул компактын хүрээнд нийгмийн болон зан үйлийн өөрчлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахын тулд хэрэглэгчдийн чадавх, боломж, сэдлийн талаар үргэлжлүүлэн судлахад хялбар байх болно.

Төлбөр төлөх эрмэлзэл – орон сууцны хэрэглэгчид

- Фокус бүлгийн хэлэлцүүлэг болон тоон судалгааны дүн шинжилгээнээс усны үргүй зарцуулалтын асуудал хэрэглэгчдийн сэтгэл ханамж бага байдалд нөлөөлж буй чухал хүчин зүйл бөгөөд энэ нь ус хэмнэхтэй холбоотой мессежний ач холбогдлыг сулруулж байгаа нь харагдаж байна. Энэ нь мөн ойрын арван жилд усны хомстолд орж болзошгүй талаар орон сууцны оршин суугчид зөвшөөрч байгаа хэдий ч усны тарифыг нэмэгдүүлэхийг дэмжихгүй байгааг зарим талаар тайлбарлаж байна. Хүмүүсийн сайн мэдэж байгаа усны үргүй зарцуулалтын асуудлыг багасгахын тулд дэд бүтэц, үйлчилгээг сайжруулахгүйгээр усны хомстолоос сэргийлэхийн тулд үнийг нэмэгдүүлэхийг хэрэглэгчид дэмжихгүй байх магадлалтай. Энэ асуудлыг шийдвэрлэх хүртэл хэрэглэгчдийн ирээдүйн тарифын тогтвортой өсөлтийг хүлээн зөвшөөрөх хүсэл бага хэвээр байх хандлагатай байна. Цаашдын судалгаагаар тодруулбал зохих асуудал:
 - Усны салбарын зохицуулагч болон нийлүүлэгч байгууллагууд энэ асуудлыг мэдэж байгаа бөгөөд шийдэл хайж байгааг харуулсан мэдээллийн кампанит ажил ;
- Тарифын шинэ хуваарийг ус хангамжийн аюулгүй байдлыг хангах, ус хэмнэлтийг нэмэгдүүлэх, усны алдагдалд хүргэж буй системийн шалтгааныг бууруулах цогц төлөвлөгөөний нэг хэсэг болгон танилцуулах. Өрхийн хүн ам зүй, бүтцийн хувьд өндөр насай өрхийн тэргүүнтэй өрхүүд ямар ч хувилбараас үл хамааран дундаж ТТЭ бага байна. Үүний нэгэн адил, тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой өрхүүд (ахмад настан эсвэл асаргаанд байдаг гишүүнтэй тохиолдолд илүү магадлалтай) мөн дундаж ТТЭ бага байна. Эдгээр үр дүн нь ахмад настануудын өнөө үедээ илүү үнэ цэнэ өгдөг, харин залуу хүмүүс ирээдүйдээ илүү санаа тавьж буйтай холбоотой эсэхийг судлахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай.

Төлбөр төлөх эрмэлзэл – гэр хорооллын хэрэглэгчид

- Үнэгүй усаар хангасан ч гэр хорооллын өрхүүд ДЭМБ-аас зөвлөсөн нэг хүний хоногийн хэрэглээ 20 литрт хүрэх нь эргэлзээтэй. Монгол Улсын засгийн газраас 2021 оны долоодугаар сарын 1-ний өдрийг хүртэл УТБ-уудаар усыг үнэгүй түгээх шийдвэр (КОВИД-19 цар тахлын хариу арга хэмжээний хүрээнд) гаргасан нь ийм бодлогын бодит туршилт юм. УСУГ ухаалаг УТБ-аар үйлчлүүлдэг ухаалаг карт эзэмшигчдийн хэрэглээний мэдээллийг ашиглан энэхүү туршилтын үр дүнд дүн шинжилгээ хийх боломжтой болно.
- Өрхийн хүн ам зүй, бүтцийн хувьд өндөр настай өрхийн тэргүүнтэй өрхүүд ямар ч хувилбараас үл хамааран дундаж ТТЭ бага байна. Үүний нэгэн адил, тэтгэвэр, тэтгэмжийн орлоготой өрхүүд (ахмад настан эсвэл асаргаанд байдаг гишүүнтэй

тохиолдолд илүү магадлалтай) мөн дундаж ТТЭ бага байна. Эдгээр үр дүн нь ахмад настуудын өнөө үедээ илүү үнэ цэнэ өгдөг, харин залуу хүмүүс ирээдүйдээ илүү санаа тавьж буйтай холбоотой эсэхийг судлахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай.

Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ыг ухаалаг УТБ-ны горимд шилжүүлэх

- Ухаалаг УТБ-ны бүтэн цагаар ажилладаг, төлбөр төлөх хялбар арга зэрэг нь одоогийн ухаалаг УТБ-ны хэрэглэгчдийн талархлыг хүлээж, бусад хэрэглэгчдийн хувьд эрэлт хэрэгцээ болж байна. Гэсэн хэдий ч ТТЭ-ийн судалгаа болон фокус бүлгийн хэлэлцүүлгийн оролцогчдын саналаас харахад ажилтны оролцоо багассанаар эвдрэл гэмтэл засахад удаашрах, усны даралт бага гэсэн асуудлуудтай тулгардаг байна. Түгээгчтэй шугамд холбогдсон УТБ-ны одоогийн хэрэглэгчид ухаалаг УТБ-ны хэрэглэгчдээс эвдрэл гэмтэл, засвар, усны даралт бага зэрэгт илүү сэтгэл ханамжтай байна. Үүгээр фокус бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчид яагаад энэхүү хоёр төрлийг хослуулахыг илүүд үзэж байсныг тайлбарлаж болох юм.
- Хэрэглэгчид түгээгчтэй шугамд холбогдсон УТБ болон ухаалаг УТБ-ыг хослуулахыг илүүд үзэж байх магадлалтай бусад шалтгаанууд:
 - Ухаалаг УТБ нь өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хэрэглэхэд ээлтэй биш байх магадлалтай. Түгээгчтэй УТБ-ны операторууд ихэвчлэн эмэгтэй хүмүүс⁸⁹, байдаг бөгөөд тэд хөдөлгөөний болон бусад төрлийн хөгжлийн бэрхшээл болон насжилттай холбоотой асуудалтай хүмүүст илүү онцгой анхаарал хандуулдаг байх боломжтой юм.
 - Буяны ажлын хүрээнд ус үнэгүй түгээдэг заншилд ухаалаг УТБ-ны автомат горим саад болж болзошгүй юм.

Төлбөр төлөх аргын сонголт

- Татварын ерөнхий газраас төлбөрийн баримтаа бүртгүүлэн сугалаанд оролцох замаар хэрэглэгчдийн НӨАТ төлөлтийг идэвхжүүлдэг. Цахимаар төлбөрөө төлөхөд уг сугалаанд оролцох боломжтой хэдий ч фокус бүлгийн хэлэлцүүлгээр НӨАТ-ын сугалаанд оролцох боломжгүй гэсэн ойлголтоор зарим хүмүүс цахимаар төлбөр төлөхөөс татгалзахад хүргэдэг нь харагдсан тул үүнийг төдийлөн сайн мэдэхгүй, ойлгохгүй байна. Усны төлбөрөө онлайнаар төлөхдөө сугалаанд хэрхэн оролцох талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь банк явах хэрэгцээг багасгаж, төлбөрийн хоцролтыг бууруулахад хувь нэмэр оруулах боломжтой.
- Ухаалаг карт ашиглах эрэлт өндөр байгаа үйлчлүүлэгчид төлбөрийн шинэ, илүү тохиромжтой аргуудыг (мессеж эсвэл гар утасны аппликейшн гэх мэт) ч нээлттэй хүлээж авах хандлагатай байна.

⁸⁹ Түргэвчилсэн үнэлгээ (2016). Их Сургуулийн судалгаа ХХК, Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп

ХАВСРАЛТ 5. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

А.Бямбадорж, Х.С, Ли нар (2019). Улаанбаатар хотын гэр хорооллын өрхүүдийн бохир ус цэвэрлэх, ус хангамжийн системийг сайжруулахад төлбөр төлөх эрмэлзэл, Монгол улс. Ус сэтгүүл, 11(9), 1856; 2016 он

АХБ (2013) Хөгжлийн зардал-үр ашгийн шинжилгээ: Гарын авлага. Филиппин, Мандалуйонг хот: Азийн хөгжлийн банк

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (2017). Ундны усны чанарын удирдамж: эхний өөрчлөлт орсон агуулсан дөрөв дэх хэвлэл. <https://www.who.int/publications/i/item/9789241549950>.

Э.Гавел, К.Сигел, В. Бретшнайдер нар (2011). Монгол улсын ус хангамжийн худалдан авах чадвар: Худалдан авах чадварыг хэмжих эмпирик сургамжууд. (№. 9/2011). Хельмгольц Байгаль орчны судалгааны төв хэлэлцүүлгийн баримт бичиг

С. Гуляни нар (2005) Хотын ядуу хүмүүст зориулсан ус: Кени дэх усны зах зээл, өрхийн эрэлт, үйлчилгээний сонголт, Ус хангамж, ариун цэврийн салбарын зөвлөлийн хэлэлцүүлгийн баримт бичгийн цуврал №. 5, Дэлхийн банк

Их сургуулийн судалгаа ХХК (URC), Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп ХХК. 2016 оны мэдээллийн хуудас. https://www.urchs.com/sites/default/files/MCC_Mongolia_FactSheet-2018.pdf

Коронавирусийн нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгааны үр дүн (3 дахь шат). Дэлхийн банк –ҮСХ.

А.Рейно, Г.Романо нар (2018). Орон сууцны усны хэрэглээний эдийн засгийн шинжилгээний ололт амжилт: Танилцуулга. Ус, 10(9), 1162

Төв ба Зүүн Европ, хуучин ЗХУ-ын халаалтын системийн үр ашгийг нэмэгдүүлэх нь (2000). Эрчим хүчний салбарын удирдлагын тусламжийн хөтөлбөр (ESMAP). https://www.esmap.org/sites/default/files/esmap-files/Rpt_Increasing_heatingsystemsesm234.pdf

Уочи, Икүко нар. (2020) Монголын ядуурлын тойм 2018: “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2018 оны тайлан <https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/532121589213323583/mongolia-poverty-update-2018>.

С.Фанхаузер, С.Тепик нар (2007) Ядуу хэрэглэгчид эрчим хүч, усны төлбөрийг төлж чадах уу? Шилжилтийн үеийн орнуудын боломжийн дүн шинжилгээ. Эрчим хүчний бодлого, 35(2), 1038-1049

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа (2020). УСУГ-ын захиалгаар Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний групп ХХК гүйцэтгэв.

ХАВСРАЛТ 6. ЯРИЛЦЛАГАД ХАМРАГДСАН ГОЛ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ

Оролцогч тал	Салбар дахь институтийн үүрэг	Ярилцлага зохион байгуулсан өдөр	Ярилцлагын сэдэв
ХСУХАТАУЗЗ	Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний үнэ тарифыг тогтоох, операторуудад (УСУГ, ОСНААУГ болон хувийн контор, хэрэглэгчид үйлчлэх төвүүд) тусгай зөвшөөрөл олгох.	2019 оны Арванхоёрдугаар сарын 19	ТТЭ-ийн өмнөх судалгаа, тарифын аргачлал, зардал нөхөх, бага орлоготой хэрэглэгчдэд үзүүлэх дэмжлэг, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд
		2020 оны Зургаадугаар сарын 26	Цэвэр бохир усны тарифын арга зүй, зардал нөхөх
Улаанбаатар хотын захиргаа	Цэвэр, бохир усны дэд бүтцийн бүтээн байгуулалт, ус, ариун цэврийн байгууламжийн төслүүдийг хариуцах, УСУГ-ын төсвийг батлах.	2019 оны Арванхоёрдугаар сарын 26	Хотын захиргааны үүрэг, гомдол санал ба гомдол шийдвэрлэх
УСУГ	Нийслэлийн хэрэглэгчдийг ундны усны стандартад нийцсэн усаар тасралтгүй хангах, бохир ус зайлуулах	2019 оны Арванхоёрдугаар сарын 30	Үйлчилгээний сайжруулалт, усны тариф, бохир усны систем
ОСНААУГ	Нийслэлийн иргэдийг дулаанаар, халуун хүйтэн усаар хангах, ус зайлуулах үйлчилгээг хариулна. ОСНААУГ-ын Салбар Түгээх төв, Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдийн өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хариуцна.	2019 оны Арванхоёрдугаар сарын 20	Хэрэглэгчид, төлбөр хураах, тариф нэмэгдүүлэх, хэрэглэгчийн сэтгэл ханамж, гомдол шийдвэрлэлт
		8 th July 2020	
Хувийн контор	Тарифын асуудал, харилцагчийн үйлчилгээ, төлбөр хураах.	Хаусинг Холд ХХК – 2020 оны Арванхоёрдугаар сарын 25	Усны төлбөр, тариф, техникийн асуудлууд
		Тэргүүн Чансаа ХХК - 2020 оны	Төлбөр тооцох болон төлөх систем; одоо байгаа МХХТ;

Оролцогч тал	Салбар дахь институтын үүрэг	Ярилцлага зохион байгуулсан өдөр	Ярилцлагын сэдэв
		Долоодугаар сарын 10	цуглуулах үр ашиг; өр, авлагын насжилт; хязгаарлах бодлого; татаас
		Хаусинг Холд ХХК - 2020 оны Долоодугаар сарын 10	Төлбөр тооцох болон төлөх систем; одоо байгаа МХХТ; цуглуулах үр ашиг; өр, авлагын насжилт; хязгаарлах бодлого; татаас
Хэрэглэгчид үйлчлэх төвийн ажилтнууд	Хэрэглэгчийн үйлчилгээ болон төлбөр хураах асуудлыг шууд хариуцдаг	Тэргүүн Чансаа - 2020 оны Есдүгээр сарын 11	Хэрэглэгчдийн сарын дундаж хэрэглээ, тоолуурын заалт, төлбөрийн өр, төлбөрийн арга, ус хэмнэлтийн талаарх хэрэглэгчдийн хандлага, хэрэглэгчдийн гаргасан гомдлын төрөл
		“Богд-Асар Инженеринг ХХК”, 2020 оны Есдүгээр сарын 14	
		ОСНААУГ-ХҮТ 8 – 2020 оны Есдүгээр сарын 15	

ХАВСРАЛТ 7. ТҮҮВРИЙН СТРАТЕГИ БА СУДАЛГААНЫ ХЭРЭГСЛҮҮДИЙН САЙЖРУУЛСАН ХУВИЛБАР



ТҮҮВРИЙН СТРАТЕГИ БА СУДАЛГААНЫ
ХЭРЭГСЛҮҮДИЙН САЙЖРУУЛСАН ХУВИЛБАР

УЛААНБААТАР ХОТЫН УСАН ХАНГАМЖИЙН СИСТЕМИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХҮРЭЭНД ЗАРДАЛ
НӨХӨХӨД ЧИГЛЭСЭН ТЕХНИК ТУСЛАЛЦАА

ГЭРЭЭНИЙ ДУГААР MCA-M/PROC/009

sachsenWasser
consulting + operations + management

SIGA

Cowater
International

Агуулга

1	Судалгааны тайлангийн хураангуй	11
1.1	Зорилго, зорилтууд	11
1.2	Судалгааны арга зүй	11
1.3	Ус хэрэглэгчдийн төрөл, ангилал	11
1.4	Судалгааны үр дүн	12
1.5	Зөвлөмж	20
2	Оршил.....	22
2.1	Танилцуулга	22
2.2	Судалгааны зорилго, зорилтууд	23
2.3	Судалгааны арга зүй	24
2.4	Нөхцөл байдал	26
2.5	Тайлангийн бүтэц	29
3	Хэрэглэгчдийн төрөл ба нийгэм эдийн засгийн шинж чанар	31
3.1	Өрхийн нийт орлого болон нэг хүнд ногдох өрхийн орлого	31
3.2	Өрхийн ам бүлийн тоо	32
3.3	Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй, хараат байдлын харьцаа өндөр өрхүүд	Error! Bookmark not defined.
3.4	Эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрх ба хүүхэдтэй, нэг тэжээгчтэй өрх	33
3.5	Зөвхөн өндөр настнаас бүрдсэн эсвэл хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүд	34
3.6	Өрхүүдийг өрхийн тэргүүний боловсролоор нь ангилсан байдал	35
3.7	Ядуу өрхүүд	35
3.8	Сонгогдсон нийгэм эдийн засгийн бүлгүүд	38
4	Өрхийн усан хангамжийн хүртээмжтэй байдал ба өрхийн усны хэрэглээ	39
4.1	Усны хүртээмж болон хэрэглээний тэгш бус байдал	39
4.2	Усны эрэлт хэрэгцээ	Error! Bookmark not defined.
4.3	Хэрэглэгчдийн үндсэн усны хэрэгцээг хангах нь	56
4.4	Амьжиргаа тэтгэх тарифын түвшин	59
5	Өнөөгийн цэвэр, бохир усны үйлчилгээний талаарх хэрэглэгчдийн ойлголт	61
5.1	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин	61
5.2	Сайжруулалт хийх шаардлагатай тэргүүлэх чиглэлүүдийн талаарх хэрэглэгчдийн санал бодол	69
5.3	Хэрэглэгчийн мэдээллийн эх сурвалж	76
6	Өрхийн ус хангамжийн үйлчилгээний хэрэгцээ, төлбөр төлөх эрмэлзэл	78

6.1	Үзэл баримтлал, судалгааны аргачлал	78
6.2	Ухаалаг УТБ эсвэл үйлчилгээ сайжирсан ухаалаг УТБ-нд төлбөр төлөх эрмэлзэл	81
6.3	Хэрэглэгчдийн ус хэмнэх хандлага	87
6.4	Орон сууцны хэрэглэгчдийн усны хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл	92
6.5	Гэр хорооллын хэрэглэгчдийн усны хомстолоос сэргийлэхэд төлбөр төлөх эрмэлзэл	96
6.6	Төлбөр төлөх эрмэлзлийг тодорхойлох хүчин зүйлс	99
7	Төлбөрийн чадвартай холбоотой асуудлууд	113
7.1	Санхүүгийн дарамт, төлбөр төлөхөд тулгарах бэрхшээлүүд болон тарифын талаарх үзэл бодол	113
7.2	Хэрэглэгчдийг дэмжих хөтөлбөрийн танилцуулга	125
8	Зөвлөмж.....	127
8.1	ОСНААУГ болон орон сууцны хувийн хэвшлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд зориулсан зөвлөмж	127
8.2	УСУГ-д зориулсан зөвлөмж	128
8.3	ХСУХАТАУ33-д зориулсан зөвлөмж	129
ХАВСРАЛТ 1	Мэдээлэл	цуглуулалтын арга
	132	
ХАВСРАЛТ 2	Судалгааны	хэрэгжилт
	134	
ХАВСРАЛТ 3	Төлбөр төлөх эрмэлзлийн судалгааны асуулга-Эцсийн	хувилбар
	140	
ХАВСРАЛТ 4	Цаашид	судлах асуудал
	158	
ХАВСРАЛТ 5	Ашигласан	материалын жагсаалт
	160	
ХАВСРАЛТ 6	Ярилцлагад хамрагдсан гол оролцогч талуудын төлөөлөл	
	161	
ХАВСРАЛТ 7	Түүврийн стратеги ба судалгааны хэрэгслүүдийн сайжруулсан хувилбар	
	163	

Товчилсон үгсийн жагсаалт

СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
ХДҮХ	Хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр
CAPI	Computer-Assisted Personal Interviewing
ССА	СӨХ-ны дээд зөвлөл
ЗНТТ	Зөрдөл нөхөх техник туслалцаа
ХҮС	Хувилбарт үнийн судалгаа
БДА	Багийн дэд ахлагч
ФБХ	Фокус бүлгийн хэлэлцүүлэг
НН	Household Өрх
НQ	Headquarter
IBT	Шатлан өсгөх блок тариф
KII	Key Informant Interview
МСА-М	Монголын Мянганы Сорилтын Сан
МСК	Мянганы Сорилтын Корпорац
МОМ	Minutes of Meeting Хурлын тэмдэглэл
НЗА	Municipality of Ulaanbaatar Нийслэлийн захирагчийн алба
ОБУ	None-Revenue Water Орлого болоогүй ус
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
НТР	Notice to Proceed
О&М	Operation and Maintenance Засвар үйлчилгээ
TL	Team leader
ToRs	Ажлын даалгавар
УБ	Улаанбаатар
НҮБ-ын ХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
ОСНААУГ	Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
WASH	Ус, Ариун цэвэр, Эрүүл ахуйн төсөл
ХСУХАТАҮЗ З	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл

WTP

Willingness to Pay

1. ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

Cowater International Inc. компани Sachsen Wasser GmbH-тай хамтран Монголын Мянганы Сорилтын Сан (Монголын МСС)-тай байгуулсан Улаанбаатар (УБ) хотын усан хангамжийн системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх хүрээнд Зардал нөхөхөд чиглэсэн техник туслалцаа (ЗНТТ)-ны зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу энэхүү хоёр дахь тайланг бэлтгэн, хүргүүлж байна.

Товч тайланд түүврийн стратеги, судалгааны хэрэгслүүд, ярилцлага болон фокус бүлгийн хэлэлцүүлгийн удирдамжийг боловсруулах явцын ажлуудыг нэгтгэн тусгасан болно. Гол оролцогч талуудтай хийх ярилцлагууд (ГОТХЯ) болон Фокус бүлгийн хэлэлцүүлэг (ФБХ)-ийн ерөнхий зорилго нь хувилбарт үнийн судалгаа (ХҮС)-нд шаардлагатай чанарын мэдээллээр оршино. ГОТХЯ болон ФБХ-ээр усны хэрэглээний хэв маяг (хүртээмж, хэрэглээ), ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчдийн хандлага, санаа бодлыг судлахад түлхүү анхаарах бөгөөд үр дүнг нь Ажлын даалгавар 2-ын хүрээнд тариф нэмэгдүүлэх хувилбарууд, Хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд (ХДҮХ)-ийн хувилбаруудыг боловсруулахад ашиглах болно. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл (ХСУХАТАҮЗЗ), Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар (ОСНААУГ), Ус сувгийн удирдах газар (УСУГ), Хаусинг Холд ХХК, хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгч, Улаанбаатар хотын захиргаатай таван ФБХ хийхээр төлөвлөж байна.

ФБХ-ийг гэр хорооллын хэрэглэгчид, гэр хороололд амьдардаг эмзэг бүлгийн хэрэглэгчид, орон сууцанд амьдардаг хэрэглэгчид, орон сууцанд амьдардаг эмзэг бүлгийн хэрэглэгчид, мөн ус хангамжийн компаниудын хэрэглэгчидтэй хамгийн ойр, анхан шатанд ажилладаг ажилтнуудын бүлэг гэсэн таван бүлгийн дагуу зохион байгуулахаар төлөвлөв. ФБХ-т оролцогчийг сонгохдоо хэрэглэгчдийн хүйс, нас, тэдний нийгэм, эдийн засгийн байдал, одоо авч байгаа үйлчилгээний төрөл зэргийг харгалзан үзнэ. Эхний ФБХ-үүдийг 2019 оны 12-р сарын 26-наас 2020 оны 1-р сарын 6-ны хооронд явуулахаар төлөвлөсөн. ХҮС-ны үр дүнд цуглуулсан мэдээлэлд аливаа орхигдол гарсан тохиолдолд зөвлөх баг нэмэлт ФБХ-үүдийг зохион байгуулж гүнзгийрүүлэн судлах шаардлагатай мэдээллийг цуглуулна.

2019 оны 12-р сарын 19-нөөс 2020 оны 1-р сарын 11-ний хооронд зөвлөх баг, ҮСХ, Мянганы Сорилтын Корпорац (МСК), Монголын МСС-тай түүврийн стратеги, өрхийн судалгааны асуумжийн талаар ажлын уулзалтуудыг хийсэн. Зөвлөх баг түүврийн стратегийг хянаж үзээд ҮСХ-той хийсэн уулзалт, зөвшилцлийн явцад ХҮС-ны түүвэрлэлтийн эцсийн стратеги нь хэрэглэгчийн Төлбөр төлөх эрмэлзэл (ТТЭ)-ийн талаарх судалгааны ерөнхий зорилгыг дэмжсэн зөвшилцлийн баримт бичиг байхад анхааран дэмжлэг үзүүлж ажилласан. Зөвлөх баг нь ХҮС-ны судалгааны хэрэгслүүдийг боловсруулахад ҮСХ, МСК, Монголын МСС-тай нягт хамтран ажиллав. Судалгааны асуулгыг сайжруулж, санал авах хэлэлцүүлгийг 2020 оны 1-р сарын 22-нд зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн үеэр оролцогчдоос гаргасан саналууд болоод санал болгосон өөрчлөлтийг багтаасан тэмдэглэлийг Монголын МСС, ҮСХ-нд тус тус хүргүүлж судалгааны асуумжийн төсөлд тусгасан.

Тайланд Монголын МСС-д ХҮС-ны хэрэгжилтэд хяналт тавих, туршилтын судалгаа хийхээс эхлэн судалгааны ажлын үр дүнг танилцуулах семинар зохион байгуулах хүртэл судалгааны бүхий л үе шатанд чанарыг хянах, судалгааны үр ашгийг хангахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Мэдээллийн чанарт хяналт тавих нарийвчилсан төлөвлөгөө”-г тусгасан

болно. Талбар дээрх хяналтыг 150 өрх буюу нийт түүврийн 3%-д хийнэ. Судалгааны мэдээллийн хяналтыг хийхдээ серверт нэвтрэх замаар эсвэл судалгаа авсан тухайн өдрийн маргааш нь Монголын МСС болон ҮСХ-ноос CsPro программаар тухай бүр мэдээллийг хүлээн авч байх болно. Хүлээн авсан судалгааны өгөгдөл, мэдээллийн логик алдааг Run batch программаар шалгахын зэрэгцээ долоо хоногт 20 өрхийн мэдээллийг (нийт түүврийн 2% буюу 100 өрх) CsPro программ ашиглан асуулт бүрээр нарийвчлан шалгахаар төлөвлөсөн.

Энэхүү тайланд дараахь хавсралтуудыг оруулсан болно. Үүнд: (1) гол оролцогч талуудтай хийх ярилцлагын загвар, (2) ФБХ хийх заавар, (3) Түүврийн стратеги; ба (4) Өрхийн судалгааны асуулга,

2. ОРШИЛ

2.1. Танилцуулга

Ус сувгийн удирдах газар (УСУГ) болон Улаанбаатар хотын Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар (ОСНААУГ) нь алдагдалтай ажиллаж байгаа бөгөөд одоо мөрдөж байгаа тарифын түвшинд ашиглалт, засвар үйлчилгээний (АЗҮ) зардал, элэгдэл болон өрийн үйлчилгээний зардлаа нөхөж чадахгүй байна.⁹⁰ УСУГ-аас нийлүүлсэн усыг жижиглэнгээр Улаанбаатар хотын хүн амын бараг тал хувьд нь түгээж хүргэдэг хувийн конторуудын хувьд байдал мөн ижил байна. Энэ нь одоогийн ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний тогтвортой байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар тэгш бус байдлыг арилгах зорилтыг дэвшүүлсэн Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ын биелэлтийг хангахад Монгол Улсын Ус, Ариун цэвэр, Эрүүл ахуй (WASH) төслийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудад хүрэх, шаардлагатай ус хангамжийн шугам сүлжээнд өргөтгөл хийхэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна.⁹¹ УСУГ-ын одоогийн их хэмжээний алдагдлын үндсэн шалтгааныг дурдвал: (i) усны үйлчилгээний тариф нь зардлаа нөхөх хэмжээнд тогтоогдоогүй, (ii) усны биет алдагдал болон биет бус алдагдлыг бүрэн тооцдоггүй, ба (iii) ОСНААУГ болон Хувийн конторуудын хугацаандаа төлөөгүй төлбөрийн үлдэгдлээс шалтгаалж байна. ОСНААУГ нь мөн хэрэглэгчдийн усны төлбөр цуглуулалтын түвшин бага, орлого болоогүй ус (ОБУ)-ны хэмжээ их болон боловсон хүчний илүүдэл зэрэг шалтгааны улмаас санхүүгийн хувьд ижил бэрхшээлтэй тулгараад байна.⁹²

Салбарын санхүүгийн тогтвортой байдал алдагдсан нь дэд бүтцийн засвар үйлчилгээг цаг хугацаанд нь хийхгүй хойшлуулахад хүргэж байгаа бөгөөд 1950-иад оноос хойш цэвэр усны шугам хоолойн дөнгөж 20%-ийг шинэчилсэн байна.⁹³ Энэ нь цэвэрлэгдээгүй бохир усыг хаясны улмаас ус бохирдох, дэд бүтцэд эвдрэл, гэмтэл гарах эрсдэлийг бий болгодог. Түүнчлэн ус хангамжийн шугам сүлжээнд өргөтгөл хийхэд шаардлагатай томоохон хөрөнгө оруулалт хугацаандаа хийгдэхгүй байна.⁹⁴ Түгээлтийн сүлжээнд даралт хангалтгүй байдагтай холбоотойгоор орон сууцны дээд давхрын оршин суугчид чанар муу, найдваргүй үйлчилгээ авч байгаа бол гэр хороололд амьдардаг 300 гаруй өрхөд дунджаар 1 худаг ногдож байгаа нь огт хангалтгүй юм.^{95,96} Хэрэглэгчдийг найдвартай, аюулгүй усаар

⁹⁰ Дэлхийн Банк (2018 оны 11-р сар) Монгол Улс: Цогц дүн шинжилгээ <http://documents.worldbank.org/curated/en/576101543874150141/pdf/mongolia-scd-final-version-november-2018-11282018-636792121231072289.pdf>

⁹¹ Монголын тухай товч мэдээлэл. SWA 2019 оны салбар хариуцсан сайд нарын хурал. <http://sanitationandwaterforall.org/wp-content/uploads/download-manager-files/Mongolia%20Country%20Brief.pdf>

⁹² Bock, Franziska. (2014 он). Монгол Улсын ус хангамж, ариун цэврийн байгууламж болон эрүүл ахуй: Байгууллагын шинжилгээ 10.13140/2.1.1641.7288.

⁹³ Мөн тэнд

⁹⁴ Мөн тэнд

⁹⁵ *Монгол дахь Ус, Ариун цэвэр, Эрүүл ахуй (WASH)-н төсвийн санхүүжилтийн тэгш байдал*. Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан/НҮБ-ын Хүүхдийн сангийн Зүүн Ази, Номхон далайн бүсийн газар, 2016 он.

⁹⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрх, ундны усны аюулгүй байдал, ариун цэврийн байгууламжийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн Монгол Улсад хийсэн айлчлалын дүгнэлт. 2018 оны 7-р сар https://www.google.ca/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=4&cad=rja&uact=8&ved=2ahUKEwjPu8_Bn9DjAhUEAp0JHYFsCC8QFjADegQIBRAC&url=https%3A%2F%2Fwww.ohchr.org%2FDocuments%2FIssues%2FWater%2FA_HRC_39_55_Add_2_EN.docx&usq=AOvVaw0v08lAU9jdJzBrMKY-HDA

тогтвортой хангах өнөөгийн тулгамдсан асуудал нь хот суурин газрын өсөлт, цаг уурын өөрчлөлтийн улмаас улам хурцаар тавигдахаар байна.

2.2. Төслийн зорилтууд

Монгол Улсын Засгийн газар УСУГ-ын нийт хэрэглэгчид, тэр дундаа гэр хорооллын хэрэглэгчдээс бүрдүүлэх цэвэр, бохир усны тарифын орлого, хураамжаас (болон шаардлагатай бол тусгай татаасаас) ус хангамж, ариутгах татуурга, бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалтын болон засвар үйлчилгээ зардал, мөн элэгдлийн зардлыг 2023 он гэхэд бүрэн нөхөх зорилготой нарийвчилсан төлөвлөгөө (Зардал нөхөх төлөвлөгөө) боловсруулж батлах зорилт тавьсан⁹⁷. Зардал нөхөх төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж, ундны усны нэмэлт эх үүсвэрээс хэрэглэгчдийг усаар тогтвортой хангахын тулд тариф болон түүний бүтцэд хийх аливаа өөрчлөлтийг Улаанбаатар хотын оршин суугчид хүлээн зөвшөөрөх, эдгээр өөрчлөлт нь хэрэглэгчдийн худалдан авах чадварт нийцсэн байх шаардлагатай.

Энэ утгаараа **Зардал нөхөхөд чиглэсэн техник туслалцааны** төслийн зорилго нь хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзэл, худалдан авах чадварт үнэлгээ хийсний үндсэн дээр ус хангамжийн системийн тогтвортой байдлыг хангах тарифын бүтцийг тогтооход Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (ХСУХАТАҮЗЗ)-д дэмжлэг үзүүлэхэд оршиж байна. Тодруулбал, төсөл нь хэрэглэгчдэд үзүүлэх дэмжлэг, хэрэглэгчийн татаасны оновчтой бүтцийг бий болгох, эдгээрийг олгох тохиромжтой хувилбаруудыг санал болгох зорилготой юм. Төслийн уг зорилгын хүрээнд дараах дөрвөн ажлын даалгаврыг тодорхойлсон ба, үүнд:

1. **Ажлын даалгавар 1 – Төлбөр төлөх эрмэлзлийн судалгаагаар** орон сууцны хэрэглэгчдийн болон гэр хорооллын хэрэглэгчдийн ус хангамжийн үйлчилгээнд Төлбөр төлөх эрмэлзэл (ТТЭ), үйлчилгээний боломжит сайжруулалтын талаарх хандлагыг фокус бүлгийн хэлэлцүүлэг, гол мэдээлэгчтэй хийх ярилцлага, туршилтын судалгааны үр дүнд тулгуурлан Хувилбарт үнийн (ХҮ) судалгааны аргачлалыг ашиглан үнэлнэ. Энэхүү судалгаагаар орон сууцны болон гэр хороололд худгаас ус авдаг хэрэглэгчдийн нийгэм, эдийн засгийн байдал, усны төлбөр төлөх эрмэлзэл болон худалдан авах чадвартай холбоотой мэдээлэл цуглуулах юм.
2. **Ажлын даалгавар 2 – Худалдан авах чадвар ба хэрэглэгчдэд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох судалгаагаар** ТТЭ-ийн судалгааны хүрээнд цуглуулсан төлөөлөл болох өрхийн орлогын мэдээллийг ашиглан одоо мөрдөж буй усны тариф мөн орон сууцанд амьдардаг хэрэглэгчдийн болоод гэр хороололд амьдарч худгаас ус авдаг хэрэглэгчдэд мөрдөх тарифын янз бүрийн таамагласан түвшнийг хэрэглэгчид төлж чадах эсэхэд дүн шинжилгээ хийх юм. Уг судалгаа нь Монгол болон бусад орны тэргүүн туршлага дээр тулгуурлан худалдан авах чадвартай холбоотой тулгарч буй эсвэл тулгарч болзошгүй хүндрэлүүдийг тооцон, зорилтот хэрэглэгчдэд чиглэсэн татаасны хэлбэрийг тодорхой дэд бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдээр дамжуулан санал болгох юм.
3. **Ажлын даалгавар 3 – Тарифын хувилбаруудын судалгааны** хүрээнд тарифын симуляцийн загвар боловсруулж УСУГ, Улаанбаатар хотын захиргаа, ОСНААУГ, ХСУХАТАҮЗЗ болон Монголын МСС-аас тодорхойлсон бусад оролцогч талуудтай

⁹⁷ Ажлын даалгавар: Улаанбаатар хотын ус хангамжийн системийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх хүрээнд зардал нөхөхөд чиглэсэн техник туслалцаа (MCA-M/Proc/009)

зөвшилцөж, тохиролцсон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тарифын хэд хэдэн хувилбарууд, мөн хэрэглэгчдэд үзүүлэх дэмжлэгийн хувилбаруудад үнэлгээ хийнэ.

4. **Ажлын даалгавар 4 – Хэрэгжиж буй Техникийн туслалцаа (төсөвт тусгагдаагүй)-ны** хүрээнд Ажлын даалгавар 2: Худалдан авах чадвар ба хэрэглэгчдэд үзүүлэх дэмжлэгийн судалгаа ба Ажлын даалгавар 3: Тарифын хувилбаруудын судалгаа-ны үр дүнд үндэслэн хувилбаруудын аль нэгийг хэрэгжүүлэх замаар зардлыг бүрэн тусгасан тарифыг тогтвортой байдлаар мөрдөх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн Техникийн туслалцаа (ТТ)-г ХСУХАТАУЗЗ, УСУГ, ОСНААУГ эсвэл Улаанбаатар хотын захиргаанд үзүүлэх юм. Тарифын хувилбаруудыг мөрдөх тохиолдолд хэрэгжүүлэх үйл ажиллагааг Монголын МСС болон гол оролцогч талууд тодорхойлох юм.

Энэхүү даалгаврын үр дүн нь нийгмийн тэгш байдлыг хангах зорилттой уялдуулсан Зардал нөхөх төлөвлөгөөтэй холбоотой шийдвэр гаргахад Монгол Улсын Засгийн газрыг шаардлагатай мэдээллээр хангах зорилготой юм.

3. ТҮҮВРИЙН СТРАТЕГИ, СУДАЛГААНЫ ЦУГЛУУЛАХ ХЭРЭГСЛҮҮД, ЯРИЛЦЛАГА, ФОКУС БҮЛГИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ БОЛОВСРУУЛАЛТ

3.1. Гол оролцогч талуудтай хийх ярилцлага (ГОТХЯ) болон Фокус бүлгийн хэлэлцүүлэг (ФБХ)-ийн зорилго

Гол оролцогч талуудтай хийх ярилцлагууд (ГОТХЯ) болон Фокус бүлгийн хэлэлцүүлэг (ФБХ)-ийн ерөнхий зорилго нь хувилбарт үнийн судалгаа (ХҮС)-нд шаардлагатай чанарын мэдээллээр оршино. ГОТХЯ болон ФБХ-ээр усны хэрэглээний хэв маяг (хүртээмж, хэрэглээ), ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчдийн хандлага, санаа бодлыг судлахад түлхүү анхаарах бөгөөд үр дүнг нь Ажлын даалгавар 2-ын хүрээнд тариф нэмэгдүүлэх хувилбарууд, Хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүд (ХДҮХ)-ийн хувилбаруудыг боловсруулахад ашиглах юм. ГОТХЯ нь дор дурдсан тодорхой зорилттой, үүнд:

ХСУХАТАУЗЗ	Цэвэр/бохир усны үйлчилгээний сайжруулалт, оршин суугчдын янз бүрийн ангиллын тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд, тарифын шинэчлэл болон цэвэр, бохир усны дэд бүтцийг сайжруулахаар төлөвлөсөн ажлын хүрээнд хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийн талаар ярилцах.
ОСНААУГ	ОСНААУГ-ын ашиглалт, засвар үйлчилгээний зардал, орлогын өнөөгийн нөхцөл байдал, үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, орон сууцны болоод гэр хорооллын хэрэглэгчдийн усны тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд болон хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийн талаар ярилцах; ОСНААУГ-ын бизнес төлөвлөгөө болон дараагийн таван жилийн стратеги төлөвлөгөөг сайжруулахтай холбоотой тарифын өсөлтийг судлах.
УСУГ	УСУГ-ын ашиглалт, засвар үйлчилгээний зардал, орлогын өнөөгийн нөхцөл байдал, үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, орон сууцны

	болоод гэр хорооллын хэрэглэгчдийн усны тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд болон хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийн талаар ярилцах; УСУГ-ын бизнес төлөвлөгөө болон дараагийн таван жилийн стратеги төлөвлөгөөг сайжруулахтай холбоотой тарифын өсөлтийг судлах.
Хаусинг Холд ХХК - Хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгч	УБ хотод үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн усан хангамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын ашиглалт, засвар үйлчилгээний зардал, орлогын өнөөгийн нөхцөл байдал, үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, орон сууцны болоод гэр хорооллын хэрэглэгчдийн усны тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд болон хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийн талаар ярилцах; бизнес төлөвлөгөө болон дараагийн таван жилийн стратеги төлөвлөгөөг сайжруулахтай холбоотой тарифын өсөлтийг судлах.
Улаанбаатар хотын захиргаа	Нийслэлийн орон сууцны болон гэр хорооллын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээтэй холбоотой Улаанбаатар хотын захиргааны чиг үүрэг, оролцоо, мөн иргэдийн ойлголт, хандлага, орон сууцны болоод гэр хорооллын хэрэглэгчдийн усны тарифыг нэмэгдүүлэхэд Улаанбаатар хотын захиргааны зүгээс хэрхэн оролцоотой байгаа талаар тодруулах.

3.2. ФБХ-т хамрагдах оролцогчдыг сонгоход анхаарах зүйл

ФБХ-т оролцох иргэдийг сонгоход хэрэглэгчдийн хүйс, нас, тэдний нийгэм, эдийн засгийн байдал, одоо авч байгаа үйлчилгээний төрөл зэргийг харгалзан үзнэ. Тодруулбал, 50-аас доошгүй хувь нь эмэгтэй оролцогчид байхаас гадна янз бүрийн насны ангиллын, нийгэм, эдийн засгийн байдалтай, өрхийн хэмжээ, төрөл, үүнд эмэгтэй, эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрх зэрэг шалгуурыг харгалзан үзэж ФБХ-т оролцох иргэдийг сонгоно. ФБХ-ийг хэрэглэгчдийн таван ангиллаар хийхээр төлөвлөсөн, үүнд: гэр хороололд амьдардаг хэрэглэгчид, гэр хорооллын эмзэг бүлгийн хэрэглэгчид, орон сууцанд амьдардаг хэрэглэгчид, орон сууцанд амьдардаг эмзэг бүлгийн хэрэглэгчид, болон ус хангамжийн компаниудын анхан шатанд ажилладаг ажилтнууд.

ФБХ 5	ОСНААУГ, Гоүлд Компас ХХК болон УСУГ-ын ус түгээх байрны ажилчдын төлөөлөл	-Үйлчилгээ үзүүлдэг орон сууцны хэрэглэгчдийн төрөл, тулгардаг хүндрэл, бэрхшээл, хэрэглэгчдээс ирж буй санал гомдол, түүний шийдвэрлэлт, одоогийн ус хангамжийн үйлчилгээний чанар, тоолуурын бичилт, хэрэглэгчдийн төлбөр төлөлтийн тухай мэдээллийг тодруулах. Хэрэглэгчдэд шаардлагатай сайжруулалт, тариф нэмэгдүүлэх хувилбарууд болон эмзэг бүлгийн хэрэглэгчийн төлбөр төлөлт, амьжиргаа тэтгэх хөтөлбөрүүдийн хувилбарын талаар ярилцах. - Гэр хорооллын хэрэглэгчдийн усны хэрэглээ, зан төлөв, усны төлбөрийн талаарх бодол, ухаалаг болон зөөврийн худаг, шугамд холбогдсон худгуудын үйлчилгээний ялгаа, тулгардаг хүндрэл бэрхшээлүүд, шаардлагатай сайжруулалт, хэрэглэгчээс ирдэг санал гомдлын талаар тодруулах. Түүнчлэн тариф
--------------	--	--

		нэмэгдүүлэх хувилбарууд болон эмзэг бүлгийн хэрэглэгчийн төлбөр төлөлт, амьжиргаа тэтгэх хөтөлбөрүүдийн хувилбарын талаар ярилцах.
ФБХ 1	Гэр хороололд амьдардаг хэрэглэгчид	Гэр хороололд амьдардаг хэрэглэгчдийн усны хэрэглээний хэв маяг (хүртээмж, хэрэглээ), хандлага, өөр өөр байршил дахь ус хангамжтай холбоотой хэрэглэгчид (УСУГ-ын шугамд холбогдсон, усны машинаар ус зөөдөг худгаар үйлчлүүлдэг, ухаалаг болон ус түгээгчтэй худгаар үйлчлүүлдэг хэрэглэгчид)-ийн илүү ач холбогдол өгдөг үйлчилгээний төрлүүдийн талаар ойлголттой болох, мөн орлого, нийгэм, эдийн засгийн янз бүрийн түвшнийг харгалзан үзэх. Үүнээс гадна үйлчилгээний янз бүрийн сайжруулалттай холбоотойгоор тариф нэмэгдүүлэх хувилбаруудын талаар ярилцах.
ФБХ 3	Гэр хорооллын эмзэг бүлгийн хэрэглэгчид	Гэр хороололд амьдардаг эмзэг бүлгийн хэрэглэгчдийн усны хэрэглээний хэв маяг (хүртээмж, хэрэглээ), хандлага, усан хангамж, ариутгах татуургын үйлчилгээтэй холбоотой хэрэглэгч (УСУГ-ын шугамд холбогдсон, усны машинаар ус зөөдөг худгаар үйлчлүүлдэг, ухаалаг болон ус түгээгчтэй худгаар үйлчлүүлдэг хэрэглэгчид)-ийн илүү ач холбогдол өгдөг үйлчилгээний төрлүүд болон нийгмийн халамжид хамрагдсан хэрэглэгчдийн талаар ойлголттой болох. Үүнээс гадна үйлчилгээний төрөл бүрийн сайжруулалттай холбоотойгоор тариф нэмэгдүүлэх хувилбаруудын талаар ярилцах
ФБХ 2	Орон сууцанд амьдардаг хэрэглэгчид	Орон сууцанд амьдардаг хэрэглэгчдийн усны хэрэглээний хэв маяг (хүртээмж, хэрэглээ), хандлага, янз бүрийн дүүргүүдэд (хуучин болон шинэ орон сууц; тоолууртай болон тоолуургүй) үзүүлж буй усан хангамж, ариутгах татуургын үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчдийн илүү таашаадаг үйлчилгээний төрлүүдийн талаар ойлголттой болох, мөн эд хөрөнгө, нийгэм, эдийн засгийн янз бүрийн түвшинг харгалзан үзэх. Үүнээс гадна үйлчилгээний төрөл бүрийн

		сайжруулалттай холбоотойгоор тариф нэмэгдүүлэх хувилбаруудын талаар ярилцах.
ФБХ 4	Орон сууцанд амьдардаг эмзэг бүлгийн хэрэглэгчид <i>Эхний ГОТХЯ / ФБХ-д хийсэн дүн шинжилгээний тайланг урьдчилан хянаж үзсэний үндсэн дээр ММС-аас хойшлуулсан)</i>	Орон сууцанд амьдардаг орлого багатай хэрэглэгчдийн усны хэрэглээний хэв маяг (хүртээмж, хэрэглээ), хандлага, дүүргүүдэд (хуучин болон шинэ орон сууц; тоолууртай болон тоолуургүй) үзүүлж буй усан хангамж, ариутгах татуургын үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчдийн илүү таашаадаг үйлчилгээний төрлүүдийн талаар ойлголттой болох, мөн эд хөрөнгө, нийгэм, эдийн засгийн янз бүрийн түвшнийг харгалзан үзэх. Үүнээс гадна үйлчилгээний төрөл бүрийн сайжруулалттай холбоотойгоор тариф нэмэгдүүлэх хувилбарууд, бага орлоготой хэрэглэгчдэд чиглэсэн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдийн талаар ярилцах

ГОТХЯ хийхэд хөтлөх загвар болон ФБХ-ийн удирдамжийг Хавсралт А, Хавсралт Б-д тус тус оруулав. Хоёр дугаар Ажлын даалгавар 2-ыг хариуцсан Багийн ахлагч Маркус Напуд нь Худалдан авах чадвар ба хэрэглэгчдэд үзүүлэх дэмжлэгийн судалгаа, мөн Тарифын хувилбаруудын судалгаа (Ажлын даалгавар 2 ба 3)-нд тусгах шаардлагатай мэдээллийг хянаж ажилласан. Тухайлбал, Маркус ФБХ-ийн удирдамжийг ерөнхийд нь хянаж үзэхдээ худалдан авах чадварыг үнэлэх судалгааны хүрээнд гарч болох асуудлуудыг үнэлэх зорилгоор ус ашигласны төлбөр төлөх аргууд, тулгарч буй хүндрэлүүдэд (төлбөр төлөх дөхөмтэй хэлбэр, хэрэглээ болон ус ашигласны төлбөрийг нэхэмжлэхэд хэрхэн харуулдаг, нэхэмжлэх нь хэрэглэгчдэд хэр ойлгомжтой байдаг) голлон анхаарсан болно. Дээр дурдсан эхний ФБХ-үүдийг 2019 оны 12-р сарын 26-наас 2020 оны 1-р сарын 6-ны хооронд хийсэн болно.

ХҮС-ны үр дүнд цуглуулсан мэдээлэлд аливаа орхигдол гарсан тохиолдолд зөвлөх баг нэмэлт ФБХ-үүдийг зохион байгуулж гүнзгийрүүлэн судлах шаардлагатай мэдээллийг цуглуулна. Судалгааны асуумжийг боловсруулах явцад тоолуурын заалтаар төлдөг төлбөртэй холбоотой хүмүүсийн ойлголтын нээлттэй хариулт зэрэг орхигдол байгаа нь тодорхой болсон. Хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр (ХДҮХ)-тэй холбоотой асуултууд нь орхигдол гарсан тохиолдлын өөр нэг жишээ болж байна. ХДҮХ боловсруулахад нэмэлт мэдээлэл цуглуулах зорилгоор бага орлоготой хэрэглэгчидтэй нэгээс хоёр ФБХ хийхээр санал болгоод байна. Эдгээр хэлэлцүүлгээр ус хангамжтай холбоотой гарч болзошгүй эдийн засгийн хүндрэл, усны хангалтгүй хэрэглээг шийдэхэд шаардлагатай дэмжлэгийн талаар асуултуудыг хөндөн ярилцах болно. Cowater нь нийгмийн зан төлөв, өөрчлөлтийн талаар олж авсан мэдээллийг баяжуулахын тулд Монголын МСС-аас эхний ээлжийн ГОТХЯ, ФБХ-ын үр дүнд шинжилгээ хийсэн тайланд өгсөн санал шүүмж болон 2019 оны 9/10-р сард МСК-аас зохион байгуулсан 14 ФБХ-т хөндөгдсөн асуудлуудыг тусган дараагийн ээлжийн ФБХ-ийн асуултуудыг сайжруулан боловсруулна.

4. ҮСХ-НЫ БОЛОВСРУУЛСАН ХУВИЛБАРТ ҮНИЙН СУДАЛГААНЫ ТҮҮВРИЙН СТРАТЕГИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

2019 оны 12-р сарын 19-нөөс 2020 оны 1-р сарын 11-ний хооронд зөвлөх баг, ҮСХ, МСК, Монголын МСС-тай түүврийн стратеги, өрхийн судалгааны асуумжийн талаар удаа дараа

ажлын уулзалтуудыг зохион байгуулав. Зөвлөх баг түүврийн стратегийг хянаж үзээд ҮСХ-той ярилцах явцад ХҮС-ны түүвэрлэлтийн стратеги нь хэрэглэгчийн Төлбөр төлөх эрмэлзэл (ТТЭ)-ийн талаарх судалгааны ерөнхий зорилгыг дэмжсэн зөвшилцлийн баримт бичиг байх талаар анхааран дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Төсөл эхлүүлэх уулзалтын дараа төслийн баг ҮСХ-ны боловсруулж Монголын МСС-д хүргэсэн түүврийн стратегийг боловсруулах төсөлтэй танилцаж хянаж үзсэн. Түүврийн стратегийг боловсруулахад баримтлах үндсэн зарчмуудыг тохирч эцэслэх, түүврийн стратегийн төслийг боловсруулах зорилгоор зөвлөх баг ҮСХ-той хэд хэдэн ажлын уулзалт хийсэн бөгөөд эдгээр уулзалтад Монголын МСС, Улаанбаатар хотод ажлаар ирсэн байсан МСК-ын судалгааны зөвлөх ноён Виллиам Мишлер нар оролцсон. Эдгээр ажлын уулзалтууд нь түүврийн стратегийг боловсруулахад шаардлагатай үндсэн элементүүдийн талаар зөвшилцөлд хүрэх, ажлын чанарт сөргөөр нөлөөлөхгүйгээр ҮСХ богино хугацаанд шургуу ажиллан үр дүнг өгч чадах түүврийн тоо, түүврийн бүтийн талаар тохиролцоонд хүрэхэд чухал ач холбогдолтой байсан. Түүврийн стратегийн талаар зөвлөгөө өгөхдөө бид байдлаар ажиллав. Үүнд:

- Судалгаад хамрагдах хүн амын тодорхойлолт, ангилал, шатлал дээр үндэслэн түүврийн хэмжээг тооцоолох.
- Түүврийн загвар нь ядуурал/хөрөнгө/нийгэм, эдийн засгийн байдал/жендэр зэрэг дээр үндэслэн хүн амын төлөөллийг бүрэн тусгасан байхын зэрэгцээ Ажлын даалгавар 2-ын хүрээнд худалдан авах чадварыг үнэлэх зорилттой уялдсан байгаа эсэхийг баталгаажуулахад анхаарсан болно.
- Дэд бүлгүүд нь хэрэглэгчдийн янз бүрийн бүлгүүдийг хамарсан байхын (жишээ нь, орон сууцанд амьдардаг хэрэглэгчид, гэр хороололд амьдардаг хэрэглэгчид) зэрэгцээ эдгээр хэрэглэгчдийн усны хэрэглээний хэв маягийг тусгасан байхыг анхаарах
- Хороодын өрхийн хуваарилалт нь аль болох тэнцүү байхад анхаарах.
- Өрхүүдийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгоход анхаарч гэр хорооллын гудамжны эхний айлаас эхлэх.

ҮСХ-ны санал болгосон түүврийн загварын хувьд дараах зүйл дээр тохиролцсон болно:

- Түүврийн хэмжээ: 4,930 өрх судалгаанд хамрагдана.
- Зорилтот өрхүүдийг зөвхөн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгоно.
- Түүвэр нь орон сууцанд (45%) болон гэр хороололд (55%) амьдардаг оршин суугчид, мөн цэвэр, бохир усны гол шугамд холбогдсон, УТБ-аар үйлчлүүлдэг, нүхэн жорлонтой хэрэглэгчдийг тэнцүү хамарсан байгаа тул нэмэлт шатлал хийх шаардлагагүй.
- Орон сууц болон гэр хороолол амьдардаг өрхийн ам бүлийн тоо ижил төстэй (өрхийн ам бүлийн дундаж тоо 3.7) байна. Гэр хороололд сууцанд амьдардаг өрхүүдийн тоотой холбоотой асуудал байхгүй: бүх өрхийг тооцож, түүврийн хуваарилалтад оруулсан болно.
- Эмзэг бүлгийн өрхүүд: санал болгож буй түүвэрлэлтийн аргачлал болон түүвэр нь орон сууцанд болон гэр хороололд амьдардаг өрхүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг бүрэн тусгаж байгаа бөгөөд эмзэг бүлгийн өрхүүдийг цаашид кластерт хуваах, эсвэл бүлэглэх шаардлагагүй гэж тохиролцсон болно. Судалгааны хэрэгслүүдэд өрхийн нийгэм, эдийн засгийн байдал болоод эмзэг байдалтай холбоотой асуултууд мөн орно. ҮСХ нь нийслэлийн хэмжээнд болоод гэр хорооллын ядуурлын түвшний талаарх хамгийн сүүлийн үеийн тоо баримтуудыг зөвлөх багт

гаргаж өгнө. Ядуурал, эмзэг байдал, төлбөр төлөх эрмэлзэл, төлбөрийн чадвартай холбоотой асуултуудыг эмзэг өрхүүдийн янз бүрийн бүлгүүдтэй хийх ФБХ-т зориулан боловсруулах болно.

- Жендэр: өрхийн судалгаанд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алиныг хамруулахаар тохиролцсон. ҮСХ-ны мэдээгээр (ҮСХ үүнийг баталгаажуулна), өрхийн тэргүүний одоогийн харьцааны хувьд өрхүүдийн гуравны хоёр нь эрэгтэй өрхийн тэргүүнтэй, гуравны нэг нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй байгаа бөгөөд судалгааны түүвэрт энэ харьцааг мөрдөх болно. Төлбөр төлөх эрмэлзлийн талаарх судалгааны үр дүнг илүү жендэрийн тэнцвэртэй болгохын тулд эхнэрүүдээс түлхүү судалгаа авч улмаар эмэгтэй оролцогчдын (эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн 66 хувиас 15 хувьд нь эхнэрүүдээс судалгаа авах) тоог нэмэгдүүлэхээр шийдсэн.

Түүврийн стратегийг 2020 оны 1-р сарын 31-нд эцэслэн боловсруулсан бөгөөд үүнийг Хавсралт С-д хавсаргав.

5. ХУВИЛБАРТ ҮНИЙН СУДАЛГААНД АШИГЛАХ СУДАЛГААНЫ ХЭРЭГСЛҮҮД БОЛОН СУДАЛГААНЫ УДИРДАМЖИЙН БОЛОВСРУУЛАЛТ, САЙЖРУУЛАЛТ

Зөвлөх баг нь ХҮС-ны хэрэгслүүдийг боловсруулахад ҮСХ, МСК, Монголын МСС-тай нягт хамтран ажилласан. Судалгааны асуулгыг сайжруулж, санал авах хэлэлцүүлгийг 2020 оны 1-р сарын 22-нд зохион байгуулсан. Семинарын үеэр оролцогчдоос гаргасан саналууд болоод санал болгосон өөрчлөлтийг багтаасан тэмдэглэлийг Монголын МСС, ҮСХ-нд тус тус хүргүүлж судалгааны асуумжийн төсөлд тусгасан.

Судалгааны хэрэгслүүд болон удирдамжийг боловсруулахад Ажлын даалгавар 1-ийг хариуцсан Багийн ахлагч Габриэл Регаллет голлох үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Ажлын даалгавар 2-ыг хариуцсан Багийн ахлагч Маркус Напуд судалгаанд оролцогчдын ядуурлын түвшин/ нийгэм-эдийн засгийн байдлыг тооцоолоход шаардагдах мэдээллийн хэрэгцээнд тулгуурласан асуултууд, 2-р даалгаврыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад өрхийн түвшний мэдээлэл зэргийг багтаасан CV судалгааг боловсруулахад дэмжлэг үзүүлэв. Өрхийн орлогыг (тэр дундаа нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж) тодруулсан асуултуудаас гадна өрхийн асуумжид өрхийн нийгэм, эдийн засгийн байдалтай (өрхийн ам бүлийн тоо, сууцны төрөл, чанар) холбоотой асуултууд, мөн өрхийн орлогыг баталгаажуулах, Хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийн агуулга, зорилтот бүлгүүдэд чиглэсэн арга хэмжээг тодорхойлох үүднээс өрхийн орлого зарлагыг (өрхийн зарлага) тодруулах асуултуудыг багтаасан болно.

Гүрбадамын Цэрэнханд, жендэр ба нийгмийн оролцооны асуудал хариуцсан мэргэжилтэн, жендэртэй холбоотой асуултуудыг орчуулахад агуулгыг нь сайтар буулгах үүднээс монгол хэл рүү орчуулсан асуулгын хуудсыг хянахын зэрэгцээ цуглуулах мэдээллийн чанарыг хангаж байгаа эсэхийг хянан судалгааг боловсруулж төлөвлөх ажлын хүрээнд гарсан саналыг тусгасан байдалд анхааран ажилласан. Цэрэнханд нь Өрхийн асуумжийн хуудсыг хянахад өрхийн бүтэц, гэр бүлийн гишүүдийн талаар тодорхой асуултууд, жишээ нь, өрхийн ам бүлийн тоо, тухайн гэр бүл өндөр настай эцэг эхтэйгээ хамт амьдардаг эсэх, бага насны хүүхдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнтэй эсэх зэрэг асуулт хэр

тусгагдсаныг хянаж үзсэн. Эдгээр бүх хувьсагчууд нь өрхийн усны хэрэгцээг (өндөр настай өвчтэй эцэг эх, эсвэл олон жаахан хүүхдийг харах, хоол унд бэлтгэх, эсвэл эрүүл ахуйн үндсэн шаардлага хангах гэх зэргээр) нэмэгдүүлж болзошгүй бөгөөд улмаар тариф нэмсэн тохиолдолд бага орлоготой өрхөд нөлөөлөх магадлалтай. Цэрэнханд нь мөн өрхийн асуумжид тарифын өсөлт, тариф нэмэгдүүлэх хувилбаруудад дүн шинжилгээ хийхэд хүйсээр ангилж болохуйц мэдээллийг цуглуулах боломжтой эсэхэд анхаарахын сацуу гэр бүлийн гишүүдийн хэн голдуу усаа авдаг (тодруулбал, насанд хүрсэн эрэгтэй эсвэл эмэгтэй хүн, эрэгтэй эсвэл эмэгтэй хүүхэд), хэдэн удаа ус авдаг, ус авахад зарцуулдаг цаг гэх мэт асуултуудыг түлхүү тусгахад анхаарсан, учир нь гэрийн ажил, гэр бүлийн бусад гишүүдээ харах, асрах зэрэг үүрэг гол төлөв эмэгтэй хүмүүст ногдож байдаг билээ. Эдгээр бүх мэдээлэл нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, тусгай хэрэгцээтэй, бага орлоготой өрхүүдэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг боловсруулж, зорилтот бүлгүүдэд чиглүүлэхэд тус дэмтэй байх болно.

Өрхийн судалгааны асуумж (3-р сарын 13-ны хувилбар)-ийг Хавсралт D-д, ҮСХ, Монголын МСС-тай нягт хамтран ажиллаж боловсруулсан “Судлаач нарт зориулсан гарын авлага”-ыг Хавсралт E-д тус тус оруулав.

6. МЭДЭЭЛЛИЙН ЧАНАРТ ХЯНАЛТ ТАВИХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зөвлөх баг нь Монголын МСС-д ХҮС-ны хэрэгжилтэд хяналт тавих, туршилтын судалгаа хийхээс эхлэн судалгааны ажлын үр дүнг танилцуулах семинар зохион байгуулах хүртэл судалгааны бүхий л үе шатанд чанарыг хянах, судалгааны үр ашгийг хангахад нь дэмжлэг үзүүлэн ажиллах болно. Хувилбарт үнийн судалгааны хүрээнд техникийн/нарийн мэргэжлийн туслалцааг дор дурдсан үе шатуудад үзүүлнэ, үүнд:

Бэлтгэл үе шат:

- Туршилтын судалгааны үеэр үзүүлэх техник туслалцаа (ТТ) нь судалгааны асуулга зэрэг ХҮС-ны судалгааны хэрэгслүүд, ТТЭ-ийн хувилбаруудыг турших, ярилцлага хийх боломжтой байдал зэргийг тандах зорилготой. Туршилт судалгааны үеийн ТТ-ны хүрээнд сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх, судалгаа авах үеэр ажиглалт хийх зэргээр дэмжлэг үзүүлнэ. Судалгааны 2 ахлагч, 10 судлаачаас бүрдсэн судалгааны мэдээлэл цуглуулах ҮСХ-ны 2 баг сургалт орох бөгөөд уг сургалтаар судалгааны асуулга, асуултууд, эдгээрийн зорилго, хэрхэн асуулт асуух талаар зааварчилгаа өгөхийн зэрэгцээ ТТЭ-ийн судалгааны талаар танилцуулга хийх болно. Туршилтын судалгааны хоёр багийг аль альныг нь талбарын судалгааны ажиглалтад хамруулна. Туршилт судалгааг авч дууссаны дараа үр дүнг ҮСХ, Монголын МСС-тай цаашид хэрхэн сайжруулах талаар хэлэлцэж зөвлөлдөнө. Ийнхүү зөвлөлдсөний дараагаар туршилтын судалгааны үр дүнд үндэслэн зөвлөх баг судалгааны хэрэгслүүд, мэдээлэл цуглуулах протоколыг эргэн харж сайжруулан санал, тайлбаруудыг нэгтгэн хүргүүлэх болно.
- ҮСХ-ны Арга зүйн болон Даргын зөвлөлөөр батлуулах. ҮСХ-ны Арга зүйн зөвлөлд зориулж ТТЭ-ийн судалгаа, ХҮС-ны арга зүйн талаар танилцуулга дагалдах материалын хамт бэлтгэн боловсруулна. Арга зүйн зөвлөлөөс гарах санал дээр үндэслэн зөвлөх баг нь судалгааны хэрэгслүүдийг боловсронгуй болгож, Даргын зөвлөлөөр оруулж зөвшөөрөл батлуулна. Хоёр зөвлөлөөр орж судалгааг батлуулсны дараа эцэслэсэн судалгааны хэрэгслүүдийг хүргүүлэх болно.
- Үндсэн судалгааны ажлын төлөвлөгөө. Туршилтын судалгаа хийсний дараа үндсэн судалгааны ажлын төлөвлөгөөг шинэчлэхэд зөвлөх багийн зүгээс дэмжлэг үзүүлэн ажиллана.

Судалгаа авах үе шат:

- Судлаач нарын сургалтын үеэр үзүүлэх техник туслалцаа. Судалгааны ахлагч, судлаач нарт зориулсан сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, асуулгын дагуу нарийн заавар өгөх болно. Сургалтын үеэр судалгааны ахлагч, судлаач нарын шалгалтын онооны дүн, судалгааны ахлагч, судлаач нарыг эцэслэн сонгон шалгаруулахад мониторинг хийнэ.
- Судалгаа авч буй явц, мэдээллийн чанарт мониторинг хийх. Ерөнхийдөө ХҮС-нд хийх мониторинг нь техникийн асуудал, мөн логик алдаанаас үүдэлтэй алдаанаас урьдчилан сэргийлэхэд чиглэх юм. ХҮС-нд хийх мониторинг 2 үе шаттай байна, тухайлбал талбарын мониторинг болоод мэдээллийн санд тавих хяналт. Судалгааны хэрэгслүүдийг шинэчлэн боловсруулж үндсэн судалгаа авахад дэмжлэг үзүүлж, боловсруулсан удирдамж, протоколуудтай нийцүүлэхэд анхаарах болно.

Талбарын мониторинг: Судлаач тус бүрийн судалгаа авах 3 өрх буюу баг тус бүрээс судалгаа авах 15 өрхийг хамруулж мониторинг хийхэд зөвлөх багийн зүгээс анхааран ажиллана, өөрөөр хэлбэл нийт 150 өрх түүврийн 3 хувьд мониторинг хийнэ. Чанарын баталгаажуулалтын хувьд, судлаач нар сонгосон/тодорхойлсон өрхөөс судалгаа авч байгаа эсэх, хариулагч нь гэр бүлийн зорилтот гишүүн мөн (өрхийн тэргүүн, өрхийн тэргүүний эхнэр эсвэл төлбөр төлдөг өрхийн гэр бүлийн гишүүн) эсэх, гарын авлагад заасны дагуу судалгааг тухайн өрхөд танилцуулж байгаа эсэх, өрхүүд үнэн зөв мэдээл өгч байгаа эсэх, бүх асуултыг бүрэн дүүрэн асууж байгаа эсэх, мөн тарифын өсөлтийн хувилбарын тухай асуултыг гарын авлагад заасны дагуу зөв тавьж байгаа эсэхэд зөвлөх багийн зүгээс хяналт тавина. Талбарын мониторингийн явцад аливаа алдаа, дутагдал илэрсэн тохиолдолд энэ тухай нэн даруй мэдээлж, судалгааны ахлагч, судлаач нарт талаар анхааруулан зохих ёсоор тэмдэглэнэ.


Талбарын мониторингийн давтамж: Мониторингийн давтамжийн хувьд бид үндсэн судалгааны хэрэгжилтийг харгалзан үзэх болно. Ерөнхийдөө долоо хоногт 3 удаа газар дээрх мониторинг хийх шаардлага гарч болзошгүй. ҮСХ нь одоогийн байдлаар 50 судлаачаас бүрдсэн 10 багаар таван долоо хоногт багтаан судалгаа авахаар төлөвлөөд байна. Зөвлөх багийн хувьд эхний 2 долоо хоногт дийлэнх өрхөд мониторинг хийж, үлдсэн 2 долоо хоногт үлдсэн хэсгийг нь хийхээр төлөвлөсөн. Үүний тулд эхний хоёр долоо хоногт 96 өрх буюу мониторинг хийх түүврийн хэмжээний 64 хувьд нь талбарын мониторинг хийх болно. Энэ нь эхний хоёр долоо хоногийн хугацаанд долоо хоногт 3 удаа 48 өрхийн судалгаанд талбарын хяналт тавина гэсэн үг юм. Дараагийн хоёр долоо хоногт 54 өрх буюу мониторингийн түүврийн хэмжээний 36 хувьд нь долоо хоногт 3 удаа талбарын мониторинг хийнэ, энэ нь долоо хоногт 27 өрхөөр орж судалгаа хэрхэн авч байгааг ажиглана гэсэн үг юм. Харин тав дахь долоо хоногт талбарын мониторинг хийхгүй байхаар төлөвлөсөн болно.

	Долоо хоног 1	Долоо хоног 2	Долоо хоног 3	Долоо хоног 4	Долоо хоног 5
Талбарын мониторинг	7 хоногт 3 удаа. Нийт 48 өрхөөр орох	7 хоногт 3 удаа. Нийт 48 өрхөөр орох	7 хоногт 3 удаа. Нийт 27 өрхөөр орох	7 хоногт 3 удаа. Нийт 27 өрхөөр орох	байхгүй

Мэдээллийн хяналт: Мэдээллийн чанарыг хянах зорилгоор судалгаа авсан өдөр бүрийн маргааш нь цуглуулсан мэдээллийг компьютерт суурилсан судалгаа авах (CAPI) аргачлалыг ашиглаж шалгаж байх болно (Зураг 1: the CAPI үйл явц-ыг үзнэ үү). Монголын МСС-аас мэдээллийн чанарт хяналт тавихад дэмжлэг үзүүлэхийн тулд судалгаа авсан өдөр бүрийн маргааш нь сервер рүү нэвтрэх замаар эсвэл CsPro программаар Монголын МСС болон ҮСХ-ноос тухай бүр хүлээн авч байх болно. Өгөгдлийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор хүлээн авсан өгөгдлийн логик алдааг өдөр бүр Run batch программаар шалгана.

Зураг 1: CAPI үйл явц

CAPI OPERAT



Дараа нь зөвлөх баг долоо хоногт 20 өрх буюу нийт түүврийн 2 хувь болох 100 өрхийн мэдээлэлд CsPro программын тусламжтайгаар хяналт хийнэ. Энэ нь судлаач тус бүрийн асуулга авсан 2 өрхийг хянана гэсэн үг юм. Ингэхдээ өрхийн нийгэм, эдийн засгийн мэдээлэл бүрэн байгаа эсэх, өрхийн орлого, зарлагын тухай мэдээллийг логик алдаагүй оруулсан эсэх, усны эх үүсвэрийн мэдээлэл үнэн зөв эсэх, худгийн төрөл, төлбөр, усны хэрэглээтэй холбоотой нээлттэй асуултын хамгийн бага ба дээд хэмжээ\утга, алхмын логик, хариулаагүй асуултын алдаа, хоосон утгууд зэргийг хянаж шалгана. Хүйс, нас, орлого, усан хангамжийн эх үүсвэр, тоолууртай, тоолуургүй өрх, худгийн төрөл зэрэг мэдээллээр судалгаа өгсөн хариулагчийн хуваарилалтад тавих хяналтыг долоо хоног бүр хийх болно. Үүнээс гадна өрхийн GPS байршилд үндэслэн судалгааг Google Earth-ийг ашиглан түүврийн стратегийн нийцүүлэн сонгосон өрхүүдээс судалгаа авсан эсэхийг мөн шалгана. Доорх Хүснэгт 4-т Судалгааны явцад хяналт мониторинг хийх төлөвлөгөө, өгөгдлийн хяналтыг харуулав.

Хүснэгт 4 – Судалгааны явцад мониторинг хийх төлөвлөгөө болон өгөгдлийн хяналт

Үйл ажиллагаа	2-р сарын 7-12	2-р сарын 14-19	3-р сарын 4	3-р сарын 12- 4-р сарын 17
I. БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ				
1.1. Туршилт судалгаа				
Судалгааны ахлагч, судлаач нарт зориулсан сургалт				
Туршилт судалгааны талбарын мониторинг				
1.2. Судалгааны хэрэгслүүдийг батлуулах				
ҮСХ-ны 2 зөвлөл, тухайлбал Арга зүйн болон Даргын зөвлөлөөр батлуулах				
II. СУДАЛГАА АВАХ ҮЕ ШАТ				
2.1. Судалгааны ахлагч, судлаач нарт зориулсан сургалт				
2.2. Судалгааны талбарын мониторинг, ажиглалт				
2.3. Мэдээлэл цуглуулсан өдрийн дараагийн өдөр бүр хийх мэдээллийн мониторинг, долоо хоног тутмын мониторинг				

ХАВСРАЛТУУД:

Хавсралт А – Гол оролцогч талуудтай хийх ярилцагын үндсэн асуудлууд

1. ХСУХАТАҮЗЗ, БХБЯ, БОАЖЯ:

Уулзалтын зорилго:

Цэвэр болон бохир усны тарифын шинэчлэл, цэвэр болон бохир усны дэд бүтцийг сайжруулахаар төлөвлөсөн ажлын хүрээнд үйлчилгээг сайжруулах, хэрэглэгчийн төрлөөр тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд, төлбөр төлөх эрмэлзлийн талаар ярилцаж санал солилцох.

Хэлэлцэх асуудлууд:

Одоо хэрэгжүүлж буй болон төлөвлөсөн дэд бүтцийн бүтээн байгуулалтууд, мөн орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүд (БХБЯ болон БОАЖЯ)

Тариф тогтоох болон зохицуулахад БХБЯ, БОАЖЯ-ны оролцоо, чиг үүрэг

Орон сууцны болоод гэр хорооллын хэрэглэгчдийн бүлгүүдийн хувьд мөрдөх тарифын боломжит хувилбарууд (төлбөр төлөх эрмэлзэл, худалдан авах чадварыг илүү сайн үнэлэх үүднээс): тоолууртай болон тоолуургүй; орон сууц өмчлөгч болон түрээслэгч; ахмад настан, тэтгэвэр авагч, бэлэвсэн эхнэр/нөхөр, бага орлоготой иргэн гэх мэт эмзэг бүлгийн хэрэглэгчид; шугамд холбогдсон худаг, зөөврийн усан хангамжтай худгаас ус авдаг гэр хорооллын хэрэглэгчид...

Эмзэг бүлгийн хэрэглэгчдэд олгох татаасын хувилбарууд

УСУГ болон ОСНААУГ-ын нийтийн аж ахуй, үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, тэдгээрийн хяналт/мониторинг (үйлчилгээний чанарын гүйцэтгэлийг үнэлэх үүднээс)

2. ОСНААУГ

Уулзалтын зорилго:

ОСНААУГ-ын ашиглалт, засвар үйлчилгээний зардал, орлогын өнөөгийн нөхцөл байдал, үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, орон сууцны болоод гэр хорооллын хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд, эдгээр хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийн талаар ярилцах

Хэлэлцэх асуудлууд:

Орон сууцны хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээ зардлаа нөхөж байгаа эсэх; Орлого болоогүй ус; төлбөрийн нэхэмжлэл, төлбөр төлөлттэй холбоотой асуудлууд, мөн хэрэглэгчийн сэтгэл ханамж (төлбөр төлөх эрмэлзэл, худалдан авах чадварыг илүү сайн үнэлэх үүднээс)

Үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанарын гүйцэтгэл, эдгээрийг сайжруулах хувилбарууд: өнөөгийн үйлчилгээний хүртээмжтэй байдал, хамрах хүрээ, оршин суугчдыг ундны усаар

хангах үйлчилгээний хүртээмжийг сайжруулах / үйлчилгээний чанарыг сайжруулах, тоолууржуулалтыг нэмэгдүүлэх таван жилийн төлөвлөгөө

Зардал нөхөх зорилгоор орон сууцны хэрэглэгчдийн янз бүрийн бүлгүүдэд мөрдөгдөх тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд

ОСНААУГ-ын 2017, 2018 оны гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд

3. УСУГ

Уулзалтын зорилго:

УСУГ-ын ашиглалт, засвар үйлчилгээний зардал, орлогын өнөөгийн нөхцөл байдал, үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, гэр хорооллын хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд, эдгээр хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийн талаар ярилцах

Хэлэлцэх асуудлууд:

Гэр хорооллын хэрэглэгчдийн нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн байдал

Усны хүртээмжтэй холбоотой мэдээлэл (үндсэн болон хамгийн бага стандарт -20л.хүн/хон ялангуяа ус авахад зарцуулдаг цаг)

Орон сууцны болон гэр хорооллын хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээ зардлаа нөхөж байгаа эсэх; Орлого болоогүй ус; төвийн шугамд холбогдсон худаг, зөөврийн усан хангамжтай худаг, гар ажиллагаатай болон ухаалаг худгаас ус авдаг хэрэглэгчдийн төлбөр төлөлттэй холбоотой асуудлууд

Гэр хорооллын хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний чанарын гүйцэтгэл, эдгээрийг сайжруулах хувилбарууд: өнөөгийн үйлчилгээний хүртээмжтэй байдал, хамрах хүрээ, зөөврийн ундны ус, усны цистерн, худаг (гар ажиллагаатай болон ухаалаг худаг)-аас ундны усаар хангах үйлчилгээний хүртээмж/ үйлчилгээний чанарыг сайжруулах таван жилийн төлөвлөгөө: өдөр тутмын усан хангамж, усны хүртээмжийг сайжруулах (ус авахад зарцуулдаг цаг), усны чанар (2019 оны бизнес төлөвлөгөө ба хамгийн сүүлийн үеийн стратеги төлөвлөгөө).

Зардал нөхөх зорилгоор гэр хорооллын хэрэглэгчдийн янз бүрийн бүлгүүдэд үзүүлэх үйлчилгээний тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд

Үйлчилгээний чанарын талаарх хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа (төлбөр төлөх эрмэлзэл, худалдан авах чадварыг илүү сайн үнэлэх үүднээс); санал гомдол шийдвэрлэдэг байдал

2017, 2018 оны гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд

4. Хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд /конторууд (2 холбоо)

Уулзалтын зорилго:

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг хувийн конторуудын хоёр гол\томоохон холбоотой ашиглалт, засвар үйлчилгээний зардал, орлогын өнөөгийн нөхцөл байдал, үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, төрөл бүрийн оршин суугчдын ангилалд үзүүлэх

үйлчилгээний тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд, эдгээр хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзлийн талаар ярилцах

Хэлэлцэх асуудлууд:

Орон сууцны хэрэглэгчдийн нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн байдал

Орон сууцны хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний зардлаа нөхөж байгаа эсэх өнөөгийн байдал; орлого болоогүй ус; төлбөрийн нэхэмжлэл, төлбөр төлөлттэй холбоотой асуудлууд

Хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний чанарын гүйцэтгэл, эдгээрийг сайжруулах хувилбарууд: өнөөгийн үйлчилгээний хүртээмжтэй байдал, хамрах хүрээ, оршин суугчдыг ундны усаар хангах үйлчилгээний хүртээмж/үйлчилгээний чанарыг сайжруулах, тоолууржуулалтыг нэмэгдүүлэх таван жилийн төлөвлөгөө (хамгийн сүүлийн үеийн бизнес болон стратеги төлөвлөгөө); төлбөр төлөх хэлбэрийг сайжруулах (хувийн хэвшлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаар дамжуулан онлайн төлбөр хийх): 2019 оны бизнес төлөвлөгөө ба хамгийн сүүлийн үеийн стратеги төлөвлөгөө.

Зардал нөхөх зорилгоор орон сууцны хэрэглэгчдийн янз бүрийн бүлгүүдэд үзүүлэх үйлчилгээний тарифыг нэмэгдүүлэх хувилбарууд

Үйлчилгээний чанарын талаарх хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа (төлбөр төлөх эрмэлзэл, худалдан авах чадварыг илүү сайн үнэлэх үүднээс); санал гомдол шийдвэрлэдэг байдал

2017, 2018 оны гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүд

5. Улаанбаатар хотын захиргаа

Уулзалтын зорилго:

Нийслэлийн орон сууцны болон гэр хорооллын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээтэй холбоотой Улаанбаатар хотын захиргааны чиг үүрэг, оролцоо, мөн иргэдийн ойлголт, төлөв байдлын талаар илүү ойлголттой болох. Орон сууцны болоод гэр хорооллын хэрэглэгчдийн усны тарифын өсөлтийг Улаанбаатар хотын захиргааны зүгээс хэрхэн оролцож талаар ярилцах

Хэлэлцэх асуудлууд:

Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээтэй холбоотой Улаанбаатар хотын захиргааны үүрэг, хороо, хэсгийн ахлагч нар болон холбогдох байгууллагуудтай харилцах харилцаа; ХСУХАТАҮЗЗ-тэй чиг үүргийн дагуу харилцах харилцаа

Иргэдэд үзүүлж буй ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ, эдгээр үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын (УСУГ; ОСНААУГ; хувийн конторууд) ажлыг Улаанбаатар хотын захиргааны зүгээс хэрхэн үзэж буй тухай: хэрэглэгчдэд түгээсэн усны чанар/хэмжээ; худгууд дахь усны өдөр тутмын хүрэлцээ; үйлчилгээ тасалдах, эвдрэл гарах; нэхэмжлэл гаргах, үйлчилгээний төлбөр төлөлт (тоолууржуулалтыг нэмэгдүүлэх; онлайн банкаар төлбөр төлөх; ухаалаг карт ашиглах)

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн жил бүрийн судалгаа

Ус хангамж, ариутгах татуургатай холбоотой гэр хорооллын оршин суугчид, шилжин суурьшиж буй хүн амын нөхцөл байдал

Тариф нэмэгдүүлэх хувилбарууд, үүнтэй холбоотойгоор хэрэглэгчдийн төлбөр төлөх эрмэлзэл, худалдан авах чадвар

Эмзэг бүлгийн хүмүүст олгох татаас: хүүхэд асрах, нийгмийн хамгааллын тэтгэмжид оролцуулан олгох; эрхийн бичиг, татаас/хөнгөлөлттэй үнэ бүхий ухаалаг карт.

Хавсралт Б – ФБХ-ийн удирдамж

Хэлэлцүүлэх байршил:	хийсэн	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-24, "Парк Плэйс" оффис, 602 тоот-Хурлын танхим	
Огноо:			
Эхэлсэн цаг:		Дууссан цаг	
Чиглүүлэгч:			
Тэмдэглэл хөтлөгч:			
Ажиглагч:			

Урилга

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Таныг Мянганы Сорилтын Корпорац болон Монголын Мянганы Сорилтын Сангийн зүгээс хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын усан хангамжийн тогтвортой байдлыг хангах” төслийн “Зардал нөхөхөд чиглэсэн техник туслалцаа”-ны зөвлөх үйлчилгээний хүрээнд зохион байгуулж буй усны үйлчилгээ, төлбөрийн талаарх хэлэлцүүлэгт оролцохыг урьж байна.

Энэхүү хэлэлцүүлэг нь Улаанбаатар хотод оршин сууж буй иргэдийн усны хэрэглээ, хэрэгцээ, усны эх үүсвэр, үйлчилгээний чанар, төлбөр төлөлтийн талаарх иргэдийн санал бодлыг сонсох зорилготой юм.

Хэлэлцүүлэгт 10-12 хүн нэг бүлэг болж оролцох бөгөөд хэлэлцүүлэгт 1.5-2 цаг үргэлжилнэ. Таны өгсөн мэдээлэл Улаанбаатар хотын усны үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, усны салбарт өөрчлөлт, шинэчлэлт хийхэд хувь нэмэр оруулах болно.

Бид энэхүү судалгаагаар авсан мэдээллийн нууцыг Монгол Улсын "Хувь хүний нууцын тухай хууль" болон "Статистикийн тухай" хуулийн дагуу чандлан хамгаалж, зөвхөн судалгаа, шинжилгээний зорилгоор ашиглах болно. Бидний урилгыг хүлээн авсан танд баярлалаа.

Оршил

Та бүхэнд өглөө/өдөр/оройн мэнд хүргэе. Цаг зав гарган энэ удаагийн бүлгийн хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа.

Монголын Мянганы Сорилтын Сангаас Улаанбаатар хотын усан хангамжийг сайжруулах, усан хангамжийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь хэрэглэгчдийн усны төлбөр тооцоог сайжруулах нөхцөл байдлыг бий болгож байгаа тул усны төлбөр тооцоо, хэрэглээний талаар энэхүү судалгааны ажлыг хийж эхлүүлээд байгаа юм. Үүнтэй холбоотойгоор өнөөдөр та бүхнийг урин ирүүлж ярилцлага, хэлэлцүүлэг хийхээр бэлэн болоод байна. Намайг Эрдэнэчимэг гэдэг, энэхүү судалгааны ажлын ахлагч, миний хамтран ажиллаж буй судлаачдыг ... гэдэг.

Улаанбаатар хотын оршин суугчид, айл өрхийн төлөөллийн хувьд та бүхний бодол, санал зөвлөмж бидэнд маш чухал юм. Энд зөв эсвэл буруу хариулт гэж байхгүй тул та бүхэн өөрийн бодол, санаагаа чөлөөтэй хуваалцахыг хүсэж байна. Эерэг, сөрөг санал, тайлбарын аль аль нь бидэнд хэрэгтэй мэдээлэл болох болно. Бүлгийн хэлэлцүүлгийн үеэр хүмүүс маш чухал зүйлс хэлж өгдөг. Бид тэр бүр бүгдийг нь буулган бичиж, санаа, бодлыг алдалгүй тэмдэглэхийн хажуугаар дуу хураагч ажиллуулж байна. Чанартай дуу бичлэг хийхэд тусалж та бүхэн сонсогдохуйц тод ярихыг хүсье.

Оролцогч таны нэрийг дурдахгүй, та бүхний өмнө тавьсан дугаарын дагуу асуулт тавина. Мөн бид хувийн нууцлалыг бүрэн хангах болно.

ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

Бүлгийн хэлэлцүүлгийн зохион байгуулалт, дүрэм :

- Бүлгийн хэлэлцүүлэг 1 цаг 30 минут орчим үргэлжилнэ
- Ариун цэврийн өрөө хурлын танхимаас зүүн гар талд байрлаж байна
- Цайны завсарлагатай
- Оролцогчийн ерөнхий мэдээллийн хуудас бөглөнө үү
- Хүн бүр жигд оролцоно, хэн нэгнийгээ ярьж байхад яриаг нь таслахгүй байхад анхаарна уу
- Зөвхөн чиглүүлэгчийн асуултад хариулахгүйгээр бие биетэйгээ ярилцлага хэлбэрээр санал бодлоо солилцох
- Гар утасныхаа дууг хаах юм уу унтраах
- Ярилцлагад идэвхтэй оролцох
- Тийм, үгүй гэж хариулах асуултад гар өргөн хариулах

ОРОЛЦОГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

Бүлэг №1 /гэр хорооллын оршин суугчид/

1	Хүйс	эрэгтэй
		эмэгтэй
2	Нас	
3	Дүүрэг	
4	Хороо	
5	Нийт ам бүлийн тоо	
6	Ам бүлийн тоо /18-аас доош настай/	
7	Боловсролын түвшин	
8	Ажил эрхлэлт	Бүтэн цагийн ажил
		Цагийн ажил
		Цагийн ажил /хааяа/
		Хувийн бизнес эрхлэгч
		Бусад...
9	Таны үйлчлүүлдэг УТБ-ны төрөл	Шугамд холбогдсон УТБ
		Зөөврийн усан хангамжтай УТБ

10	Ус авдаг бусад эх үүсвэр	Бүлаг шанд, горхи
		Хувийн худаг
		Бэлэн савласан ус
		Бусад...
11	Ус авахад хэрэглэдэг төлбөр төлөлтийн арга	Ухаалаг карт
		Бэлэн мөнгө
12	Өрхийн орлого	500,000 төгрөгөөс доош 500,001-750,000 750,001-1,000,000 1,000,001-1,500,000 1,500,001 төгрөгөөс дээш
13	Оролцогчийн дугаар:	_____

/Та хариултын дагуу тэмдэглэгээ хийнэ үү/

Бүлэг №2 /орон сууцны оршин суугчид/

1	Хүйс	эрэгтэй	
		эмэгтэй	
2	Нас		
3	Дүүрэг		
4	Хороо		
5	Хотхоны нэр		
6	Байрны тоот		
7	Нийт ам бүлийн тоо		
8	Ам бүлийн тоо /18-аас доош настай/		
9	Боловсролын түвшин		
10	Ажил эрхлэлт	Бүтэн цагийн ажил	
		Цагийн ажил	
		Цагийн ажил /хааяа/	
		Тэтгэвэрт	
		Бусад.....	
11	Гэр бүлийн гишүүдийн нийгмийн халамжид хамрагдсан байдал		Гэр бүлийн гишүүдийн нийгмийн халамжид хамрагдсан байдал
		Өндөр насны тэтгэвэр	
		Цалинтай ээж	
		Хүүхдийн мөнгө	
		Хүүхэд асаргаа	
		Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэмж	
		Бусад.....	
12	Хүнсний талон авдаг эсэх		

13	Таны үйлчлүүлдэг компанийн нэр	1.Ус сувгийн удирдах газар 2.ОСНААУГ 3.Хувийн контор
14	Та савласан цэвэр ус авдаг уу?	1.Тийм 2.Үгүй
15	Ус авахад хэрэглэдэг төлбөр төлөлтийн арга	Бэлнээр кассанд тушаах Цахимаар
16	Өрхийн орлого	200,000 төгрөгөөс доош 200,001-300,000 300,001-400,000 400,001-500,000 500,001-700,000 700,001 төгрөгөөс дээш
17	Оролцогчийн дугаар:	_____

/Та хариултын дагуу тэмдэглэгээ хийнэ үү/

Бүлэг №3 /гэр хороололд амьдардаг эмзэг бүлгийн иргэд/

1	Хүйс	эрэгтэй
		эмэгтэй
2	Нас	
3	Дүүрэг	
4	Хороо	
5	Нийт ам бүлийн тоо	
6	Ам бүлийн тоо /18-аас доош настай/	
7	Боловсролын түвшин	
8	Ажил эрхлэлт	Бүтэн цагийн ажил
		Цагийн ажил
		Цагийн ажил /хааяа/

		Хувийн бизнес эрхлэгч	
		Бусад.....	
9	Гэр бүлийн гишүүдийн нийгмийн халамжид хамрагдсан байдал		Гэр бүлийн гишүүдийн тоо
		Өндөр насны тэтгэвэр	
		Цалинтай ээж	
		Хүүхдийн мөнгө	
		Хүүхэд асаргаа	
		Хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэмж	
		Бусад.....	
10	Хүнсний талон авдаг эсэх	Тийм	
		Үгүй	
11	Таны үйлчлүүлдэг УТБ-ны төрөл	Шугамд холбогдсон УТБ	
		Зөөврийн усан хангамжтай УТБ	
12	Таны ус авдаг бусад эх үүсвэр	Булаг шанд, горхи	
		Хувийн худаг	
		Бэлэн савласан ус	
		Бусад...	
13	Ус авахад хэрэглэдэг төлбөр төлөлтийн арга	Ухаалаг карт	
		Бэлэн мөнгө	
14	Өрхийн орлого	200,000 төгрөгөөс доош 200,001-300,000 300,001-400,000 400,001-500,000 500,001-700,000 700,001 төгрөгөөс дээш	

15	Таны үйлчлүүлдэг халуун усны газрын нэр, байршил	
16	Оролцогчийн дугаар:	_____

/Та хариултын дагуу тэмдэглэгээ хийнэ үү/

Бүлэг №5 /УСУГ, ОСНААУГ болон хувийн конторын ажилчид /

1	Хүйс	эрэгтэй
		эмэгтэй
2	Байгууллага	
3	Дүүрэг	
4	УТБ/ХҮТ №	
5	УТБ-ны ажилчдын хувьд	ухаалаг худаг
		гар ажиллагаатай худаг
	ХҮТ-ийн ажилчдын хувьд	тоолууртай
		тоолуургүй
6	Оролцогчийн дугаар:	_____

/Та хариултын дагуу тэмдэглэгээ хийнэ үү/

ЧИГЛҮҮЛЭХ АСУУЛТУУД

12 дугаар сарын 26. Бүлэг №5. / УСУГ, ОСНААУГ болон хувийн конторын ажилчид /

Ерөнхий мэдээлэл /усны хэрэглээ/:

1. Танай байгууллага ямар төрлийн хэрэглэгчдэд үйлчилдэг вэ? (ус түгээлтийн төрөл, тоолууртай эсэх? Тоолуургүй хэрэглэгчийн тоо хэд вэ? Тоолуургүй байх шалтгаан? Техникийн асуудалтай холбоотой юу эсвэл хэрэглэгч хүсдэггүй болохоор уу?)
2. Танай хэрэглэгчдийн усны хэрэглээний төвшин ямар хэмжээнд байдаг вэ? / литр эсвэл метр куб/, /усны хэрэглээний доод, дунд, дээд түвшин гэх мэт/

Усны төлбөр:

3. Танай хэсгийн хэрэглэгчид сард усны төлбөрт хэдэн төгрөг төлдөг вэ? /доод, дунд, болон дээд/
4. Танай хэрэглэгчдийн төлбөр төлөлт хэр байгаа вэ? /хэдэн хэрэглэгч хугацаандаа төлбөрөө төлдөг вэ? Хэдэн хэрэглэгч хоцорч төлдөг вэ? Хоцролтын хугацаа, хэн (ямар төрлийн хэрэглэгч) хоцорч төлдөг вэ? Хэн (ямар төрлийн хэрэглэгч) тогтмол

сарын усны төлбөрийн асуудалтай байдаг вэ? Тариф өссөн тохиолдолд хэрэглэгчийн төлөлт яах вэ, өр нэмэгдэх үү, хэр удаан хугацаанд?

5. Төлбөр барагдуулах механизм?/хоцрогдолтой хэрэглэгчдэд авах арга хэмжээ?/
6. Танай байгууллага УСУГ-т өр төлбөртэй юу?
7. Орлого болоогүй ус хэр зэрэг байдаг вэ?

Усны үйлчилгээ:

8. Усны үйлчилгээний тал дээр ямар төрлийн асуудал, хүндрэлүүдтэй тулгардаг вэ? / төлбөр, УСУГ-ын усны даралт, УСУГ-аас ирж буй усны чанар (амт, үнэр болон өнгө), усны алдагдал эсвэл тасралт/
9. Хэрэглэгчдээс усны талаар ямар санал, гомдол ирдэг вэ? Санал, гомдлыг хэрхэн шийдвэрлэдэг вэ?
10. Та өөрийн туршлага дээр үндэслэн харахад хэрэглэгчдэд хүргэх цэвэр, бохир усны үйлчилгээг сайжруулах зөвлөмж болон санал байна уу? Ямар төрлийн сайжруулалт хэрэгтэй вэ?
11. Хэрэглэгчдийн усны тоолуурын заалтыг хэрхэн бүртгэдэг вэ?
12. Төлбөр цуглуулах механизмыг сайжруулах тал дээр ямар бодолтой байдаг вэ? Цахим банк (цахилгааны хураамж шиг төлбөрийн баримтыг сайжруулах) эсвэл гэр хорооллын худгуудад ухаалаг картыг өргөнөөр нэвтрүүлэх?

Цэвэр ус болон бохир усны тариф нэмэгдүүлэхтэй холбоотой үйлчилгээний сайжруулалтын тухай санал сэтгэгдэл:

13. Ирэх 5 жилийн хугацаанд 2018 оны усны тариф дээр жилийн 10%, 15% болон 20%-иар нэмэгдүүлсэн тариф төлөх эрмэлзэл болон чадамж. Дараах өсөлтийг хэрэглэгчдээр зөвшөөрүүлэхийн тулд ямар төрлийн үйлчилгээний сайжруулалт хийх шаардлагатай вэ?
14. Эмзэг бүлгийн хэрэглэгчдийн (тоолууртай) амьжиргаа тэтгэх усны тариф болон бусад татаас үзүүлэх боломжууд:
 - Нийгмийн хамгааллын шалгуур үзүүлэлтийн (хүүхдийн халамж; тэтгэвэр...) дагуу хэрэглэгчдийн зорилтот бүлгүүдийг хэрхэн зөв тодорхойлох талаар таны санал юу байна?
 - Татаасын хэмжээ
 - Гэр хороололд усны мөнгөө төлж чаддаггүй эмзэг бүлгийн, хүнд хэцүү амьдралтай хэрэглэгчид хэр олон байдаг вэ? Эдгээр хэрэглэгчдэд ус авахад нь хөнгөлөлт/хүнсний талон шиг/ үзүүлэх боломж байгаа гэж та бодож байна уу?
 - Шатлан нэмэгдүүлэх тарифын бүтцийг та юу гэж ойлгож байна вэ?

1 дүгээр сарын 2. Бүлэг №1. / Гэр хорооллын хэрэглэгчид /

Ерөнхий мэдээлэл/Усны хэрэглээ:

1. Та ямар төрлийн УТБ-аар үйлчлүүлдэг вэ?/Шугамд холбогдсон болон холбогдоогүй зөөврийн, ухаалаг карт/ худаг / булаг шанд
2. Та ямар, ямар хэрэгцээндээ зориулж ус авдаг вэ? /Өрхийн хэрэгцээнд зориулж авдаг бол гараа өргөнө үү, өрхийн үйлдвэрлэлд зориулж ус авдаг бол гараа өргөнө үү/
3. Та ундны болон бусад хэрэгцээндээ зориулж (УТБ-аас өөр) бусад усны эх үүсвэрээс ус авдаг уу?

/Бусад хэрэгцээнд: ногоо тарих, цэвэрлэгээ, усанд орох, арилжааны зориулалтаар гэх мэт/

4. Танай гэр бүл өдөрт хэдэн литр ус хэрэглэдэг вэ?
5. Танай гэр бүл 7 хоногт хэдэн удаа УТБ-аас ус авдаг вэ?
6. Та УТБ-аас нэг удаа ус авахдаа хэдэн литр ус авдаг вэ?
7. Та яагаад ийм хэмжээний ус авдаг вэ?/ Оролцогчдын хариултуудыг сонсоод, дурдаагүй бол дараах шалтгааныг хэлнэ үү/
 - УТБ хүртэлх зай хол тул
 - Ус хадгалах савны хэмжээнээс хамаарч
 - Ус зөөх савны багтаамжаас шалтгаалж
 - Бохир ус зайлуулах системгүй тул
 - Ус зөөх бэрхшээлтэй байдаг тул
8. Таны өдөрт хэрэглэж буй усны хэмжээг та хангалттай гэж үзэж байна уу?(Гар өргөх)
9. Өдөр тутмын усны хэрэглээгээ та дараах төрлөөр хувиар хэлнэ үү.
 - Хоол унданд
 - Хувийн ариун цэвэрт
 - Хувцас угаахад
 - Аяга угаахад
 - Бусад /гэр цэвэрлэх, машин угаах.../

Усны төлбөр:

10. Та 7 хоногт хэдэн төгрөгийг усандаа зарцуулдаг вэ?
 - Өвлийн улиралд
 - Бусад улиралд
11. Та усанд төлдөг энэ төлбөрөө хэр их гэж бодож вэ?
 - Их
 - Дунд
 - Бага

Усны үйлчилгээ:

12. Та УТБ-аас ус авахад хэр хугацаа зарцуулдаг вэ? Энэ хугацаанд: ус авахад дугаарлан хүлээдэг хугацаа, гэрээсээ УТБ хүртэл явж очих, мөн буцахад зарцуулдаг хугацаа. /Хэрэв 40 минутаас их хугацаа зарцуулдаг бол шалтгааныг асуух/
13. Та УТБ-ны үзүүлдэг үйлчилгээ, усны чанарт хэр сэтгэл ханамжтай байдаг вэ? 1-5 оноогоор үнэлнэ үү. (1 нь маш сэтгэл ханамжгүй, 5 нь маш их сэтгэл ханамжтай)

Сэтгэл үнэлгээ	ханамжийн	1 Маш сэтгэл ханамжгү й	2 Бага сэтгэл ханамжта й	3 Дунд сэтгэл ханамжта й	4 Их сэтгэл ханамжта й	5 Маш их сэтгэл ханамжта й
-------------------	-----------	----------------------------------	-----------------------------------	-----------------------------------	---------------------------------	-------------------------------------

УТБ-ны ажиллах цагийн хуваарь					
Ус авахад хүлээдэг хугацаа					
УТБ-аас авдаг усны хэмжээ					
Усны чанар/ амт, үнэр, ариун цэвэр/					
Тасалдалт					
Төлбөр төлөх арга, хэлбэр					
Харилцагчийн үйлчилгээний хүртээмжтэй байдал					
Санал, гомдол шийдвэрлэх байдал					

14. Ус авахад танд ямар бэрхшээл тулгардаг вэ?/Ямар хүндрэл бэрхшээл/
 15. Ямар төрлийн жорлонтой вэ? / -соруулдаг эсэхийг лавлах /
 16. Бохир соруулах машин дууддаг бол жилд хэдэн удаа? Нэг удаа бохир соруулахад хэдэн төгрөг төлдөг вэ?
 17. Усны үйлчилгээ, чанар, хүртээмжтэй холбоотой ямар сайжруулалт шаардлагатай вэ? Нэн тэргүүнд ямар арга хэмжээг дурдах вэ?

Оролцогчид дараах саналуудыг дурдахгүй бол:

- УТБ-ны ус түгээх цагийг уртасгах
- УТБ-ыг өдөр болгон нээлттэй байлгах
- Ухаалаг картаар төлбөр хийдэг болох
- Ундны усны шугамыг гэртээ холбуулах
- Бусад сайжруулалт: Тайлбар_____

Үйлчилгээний сайжруулалттай холбоотой цэвэр, бохир усны тарифын талаарх санал бодол:

18. Өмнөх асуулт 17-д тодорхойлсон зарим арга хэмжээг танай хороо\хэсэгт хэрэгжүүлж усны үйлчилгээг сайжруулбал та үүнд мөнгө төлөхөд бэлэн үү?
 19. Хэрэв ТИЙМ гэж хариулсан бол, нэг литр ус 3 төгрөг болбол та төлөх үү? Өрхийн сарын зарлага дээр тань нэмэгдэх болно гэдгийг анхаарна уу. УТБ-аар үйлчлүүлдэг гэр хорооллын хэрэглэгчдийн усны тарифыг 2019 оны тарифтай харьцуулбал ирэх таван жилийн хугацаанд жилд нэг литр тутамд 1 төгрөгөөр,

жилд 2 төгрөгөөр, жилд 3 төгрөгөөр нэмэгдүүлбэл та төлөх үү? Төлөх боломжтой юу? Ийм хэмжээгээр тарифыг нэмэгдүүлсэн тохиолдолд та ямар сайжруулалт хийхийг хүсэж байна вэ?

20. Танайх ямар төрлийн бие засах газартай вэ?

- Хамгаалалттай ханагүй модон жорлон
- Септик савтай жорлон
- Бохир усны шугамд холбогдсон бие засах газар
- Би хашааны гаднах, нийтийн бие засах газар ашигладаг
- Бусад систем: Тайлбар_____

21. Танайх угаалга цэвэрлэгээнд ашигласан усыг (угаадас) хэрхэн яаж зайлуулдаг вэ?

- Модон жорлон руу
- Угаадасны нүхэнд
- Бохирын системд
- Гудамд

22. Одоогийн ашиглаж байгаа бие засах газар, мөн бохир ус зайлуулалтыг сайжруулах шаардлагатай гэдэгтэй та санал нийлж байна уу?

23. Одоогийн ашиглаж байгаа бие засах газар, мөн бохир ус зайлуулалтыг сайжруулбал та үүнд төлбөр төлөхөд бэлэн үү? Та төлбөр төлөх үү?

24. Бие засах газар, ахуйн бохир ус, муу ус зайлуулалтыг сайжруулахын тулд ямар арга хэмжээ авах боломжтой вэ? Дараах арга хэмжээнүүдийг чухал байдлаар 1-ээс 4-р эрэмбэлнэ үү.)

- Септик сав бүхий сайжруулсан жорлонтой болох
- Бохир усны шугамд холбогдох
- Бохир соруулах, зайлуулах үйлчилгээ авах боломжтой болох
- Бусад сайжруулалт: Тайлбарлуулах_____

25. Хэрэв асуулт 23-д ТИЙМ гэж хариулсан бол дараах сайжруулалтуудад нэг долоо хоногт (эсвэл сардаа) хамгийн ихдээ хэдэн төгрөгийг бохир усны төлбөрт төлөх боломжтой вэ?

- Септик сав бүхий сайжруулсан жорлонтой болох
- Бохир усны шугамд холбогдох
- Бохир соруулах, зайлуулах үйлчилгээ авах боломжтой болох
- Бусад сайжруулалт: Тайлбарлуулах_____

26. Хэрэв асуулт 23-д ҮГҮЙ гэж хариулсан бол шалтгааныг хэлнэ үү.

27. Бохир ус ба / эсвэл ариутгах татуургын үйлчилгээний төлбөрт сард дунджаар хэдэн төгрөг төлдөг вэ?

28. Хэрэв асуулт 23-д ТИЙМ гэж хариулсан бол та бохир усны төлбөр төлөхөд бэлэн үү? Төлбөр төлөх боломжтой юу?

29. Хэрэв асуулт 28-д ТИЙМ гэж хариулсан бол нэг сард бохир усны төлбөрт хэдэн төгрөг төлөх боломжтой вэ?

- 10000 төгрөг
- 20000 төгрөг
- 30000 төгрөг
- 30000 төгрөгөөс дээш

1 дүгээр сарын 3. Бүлэг №3. / Гэр хорооллын хэрэглэгчид (Эмзэг бүлэг)/

Ерөнхий мэдээлэл/Усны хэрэглээ:

1. Та ямар төрлийн УТБ-аар үйлчлүүлдэг вэ?/Шугамд холбогдсон болон холбогдоогүй зөөврийн, ухаалаг карт/ булаг шанд
2. Та савласан усыг хоол, ундандаа хэрэглэдэг үү?
3. Та ундны болон бусад хэрэгцээндээ зориулж бусад усны эх үүсвэрээс ус авдаг уу?
/Бусад хэрэгцээнд: ногоо тарих, цэвэрлэгээ, усанд орох гэх мэт/
4. Танай гэр бүл өдөрт хэдэн литр ус хэрэглэдэг вэ?
5. Танай гэр бүл 7 хоногт хэдэн удаа УТБ-аас ус авдаг вэ?
6. Та УТБ-аас нэг удаа ус авахдаа хэдэн литр ус авдаг вэ?
